MONGOLIAN ECONOMY

| Тавантолгой Монголын эмгэнэл | Бидний алдааг битгий давтаарай | | Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх | "Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг" | Модоо барьсан зуун жил | Төр гэдэг бизнес |

# СОРИЛТ ГАРЦ ХӨГЖИЛ


**(2011-2014 ЭМХЭТГЭЛ)**




















8165800016794 16

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

# БОРЛУУЛАЛТАА ӨСГӨХ ШИЛДЭГ АРГА



Хүргэлт, түгээлтийн үйлчилгээ



Зочид буудал, зоогийн газар



Шатахуун түгээгүүр, дуудлагын такси



Гадаа үйлчилгээ эрхлэгчид




# МОБАЙЛ ПОС МОНГОЛД

Утас: 1900-1977 | Мессэж: 133133 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn | Facebook: www.tdbm.mn/facebook
Twitter: www.tdbm.mn/twitter | Viber: +976 99001977 | Skype: tdb_info | Yahoo: info_tdb@yahoo.com

*Монголын сэтгүүлдийн эвлэлийн "2013 оны Шилдэг сэтгүүл"*

*Монголын бизнесийн зөвлөлийн*

*"Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл мэдээллийн байгууллага - 2012"*

*МУХАҮТ-ын "2011 Оны Онцлох Хэвлэл"*




# Борлуулалтын үнэ 18.000₮

## Захиалгын үнэ

| | |
|---|---|
| НЭГ ДУГААР | 15.000₮ |
| УЛИРАЛ /6 дугаар/ | 90,000₮ |
| ХАГАС ЖИЛ /12 дугаар/ | 180.000₮ |
| ЖИЛ /24 дугаар/ | 360.000₮ |

РЕДАКЦИД ЗАХИАЛБАЛ ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ


**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:**
Д.Бэхбаяр
**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:**
И.Отгонжаргал
**СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:**
Б.Үүрийнтуяа
**АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:**
Ийланд Роберт Мэн
**ВЭБ РЕДАКТОР:**
Б.Энхцэцэг
**СЭТГҮҮЛЧИД:**
Б.Баяртогтох
Э.Зоригт
С.Батзаяа
**ДИЗАЙНЕР:**
Ш.Оюундарь
**МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:**
Д.Барианжав / 9409 2904

**Борлуулах цэгүүд:**
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр
"Max mall" дэх салбарууд

**ХАЯГ:**
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.
VI хороо, Их сургуулийн гудамж.
AB center. 504 тоот
15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn
Утас/Факс: 976 - 7011 5476
"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

The Banker
Bank of the Year 2014
MONGOLIA

# МОНГОЛ УЛСЫН **ШИЛДЭГ БАНК**

*Бидний амжилтын хөтөч болсон эрхэм* ***харилцагч танд баярлалаа***

www.golomtbank.com

# АГУУЛГА



## ГАРЦ


12 Д.Бямбасүрэн: Тавантолгой бол Монголын нэг эмгэнэл

16 “Голланд өвчнийг анагаагч”

20 Вим Кок: Бидний алдааг битгий давтаарай

22 Төрийн бодлого дахь бизнесийн санаархал байдлыг бүр дордуулж байна

28 Ч.Ганхуяг: Бид Африкийн замаар орчихлоо. Үүний гарц нь улс төрийн шийдэл

32 Р.Амаржаргал: Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх





## БИЗНЕС


42 Зайрмагны борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл

45 Бизнесмэнүүд бол үнэндээ нийгмийн зарц шүү дээ

48 Т.Лхагвадорж: Эдийн засгийн хямрал илүү ухаарал авчирна

52 Увидаст Маестро

56 Олон улсыг Монголоор “цэнэглэ”

58 Бидний өмнө гурван тэрбумын зах зээл байна

60 Ц.Дашцэрэн: Хөгжлийн хоёр дахь шатанд олон барилга сүндэрлэнэ

64 Компанийн нийгмийн хариуцлага үнэт чанарын тусгал юм

## ЗОЧИН

68 “Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг”
70 Оюутолгой бол шалгалт
73 Салхи хагалагчдаас итгэлэхэлнэ

## ХӨГЖИЛ

78 С.Батболд: Нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой засаглалтай оронд хөгжил ирдэг
80 Бид өсөлтийг хөгжил гэж андуураад байна
85 Н.Энхбаяр: Уналтыг сааруулж буй салбарыг бодлогоор дэмжих ёстой
90 Б.Дэлгэрмаа: Сингапурын сайн туршлагуудыг нэвтрүүлмээр байна
94 Нялх хотын төрх
96 Б.Төмөрчулуун: Манай төр ёолкны мод шиг байна
101 Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр



## БАНК, САНХҮҮ

108 90 жилийн түүх ололт амжилт, бэрхшээлтэй нүүр тулсан цаг хугацаа
113 Д.Баярсайхан: Олон улсад манай эрх зүйн орныг хүлээн зөвшөөрсөн
116 Д.Цэвээнжав: Жолоочийн даатгал санхүүгийн эрсдэлээс
бүрэн хамгаалсан хохирогчгүй даатгал

## НИЙТЛЭЛ

122 Модоо барьсан зуун жил
124 Монгол нүүрсний баялгаа “ногоон” нүүрс болгох боломжтой
125 Төр гэдэг бизнес
127 Монголын төр хаанаас эхэлдэг вэ
128 “Монголыг нөмөрч буй төсвийн хямрал”
130 Герман-Монголын эдийн засгийн харилцааны боломж
131 Бухимдуулсан параллель
134 Герман-Монголын эдийн засгийн харилцааны боломж
138 Шинэ соёл иргэншил

# ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Mongolian Economy” сэтгүүлийн 2011-2014 оны бүх дугаарын шилдэг ярилцлага, нийтлэлээс бүтсэн тусгай дугаарыг таны өмнө дэлгэж байна. Нийтдээ 70 гаруй дугаараас ярилцлага, нийтлэлүүдийг шүүн сонгосон, уншигч танд дуртай үедээ нэхэн санаж, нээн хардаг, урт настай, удаан хадгалагдах зузаанаас зузаан дугаар эмхтгэн хүргэж байгааг таалан сонирхоно уу.

Бид нийгмийн олон талын байр суурь, дуу хоолойг хүргэж, гадна, дотнын олон томоохон зочин төлөөлөгчтэй тогтвортой хөгжил, байгалийн баялагт суурилсан хөгжлийн туршлага, алдаа оноо, хамтын ажиллагаа, эдийн засаг, бизнесийн өмнө тулгарч байгаа томоохон сорилтыг боломж болгон ашиглах талаар ярилцсан байна.

Бид Монголын эдийн засаг, бизнесийн мэдээллийг дотоодод төдийгүй дэлхийд түгээх тэргүүлэх үйлчилгээг хүргэдэг шилдэг сэтгүүл болох эрхэм зорилгынхоо төлөө ийн хичээн ажиллажээ.

Энэхүү дугаарт, Киргизстан улсын анхны эмэгтэй ерөнхийлөгч Роза Отунбаева, “Голланд өвчнийг” “Голланд гайхамшиг” болгож чадсан Нидарланд улсын Ерөнхий сайд асан Вим Кок, дэлхийд усны чиглэлээр бодитой ажил хийж яваа Nestle-ийн ТУЗ-ийн дарга Петер Брабек нарыг Монголд айлчлахад нь манай сэтгүүлчид тусгай эрхтэйгээр хийсэн ярилцлагуудыг оруулаа. Мөн манай сэтгүүлийн баг 2013 оны долдугаар сард Лондонд ажиллах үеэрээ Лондоны хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн газрын орлогч дарга Жон Эдвард, “Рио Тинто” компанийн Зэсийн группийн гүйцэтгэх ерөнхий захирал Жан-Себастьен нараас ярилцлага авсан юм.

Түүнчэн Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном, Ш.Гунгаадорж, Д.Бямбасүрэн нарыг сэтгүүлийнхээ редакцид урьж, тэдний санаа бодол, шүүмж, зөвлөгөөг нэг дор сонссон нь шинэлэг санаа байлаа. Монголын топ банкуудын гүйцэтгэх захирлуудтай “Economy” студидээ ярилцсан нь бас л нэгэн түүх болсон юм.

Төр, хувийн хэвшлийн хоорондын мэдээллийн гүүр болох зорилготой манай сэтгүүл бизнесмэнүүдийн дуу хоолойг түлхүү хүргэхийг хичээж ирсэн. Энэ хүрээнд эдийн засаг, улс орны хөгжлийн талаарх дотоод, гадаадын мэргэжилтнүүд болон бизнесмэнүүдийн цөөнгүй ярилцлагыг багтаалаа. Хэдийгээр өнгөрсөн жилүүдэд хийсэн ярилцлагууд боловч мэдлэг, мэдээлэл өгсөн, хөгжлийн гарц хайсан ярилцлага, нийтлэлүүд байгаа болно.

Бид цаашид жил бүрийн эцэст тухайн жилийн сэтгүүлүүдийнхээ шилдэг ярилцлага, нийтлэлээр тусгай дугаар бэлтгэн та бүхэндээ шинэ оны бэлэг барих уламжлал тогтоох болсноо дуулгахад таатай байна.

ЭРХЛЭГЧ Д.БЭХБАЯР

**Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай. MongolianEconomy.mn/ дээр доорх улаанаар тодруулсан тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.**



### Дэд сайдуудын төлөөх тэмцэл эхэллээ

Ч.Сайханбилэгийн танхим бүрдлээ. Шийдлийн Засгийн газарт ажиллах сайдууд тодорч, тэдний хийх ажил ар араасаа хөвөрсөөр байна. Төсөвт тодотгол хийж, хүндэрсэн эдийн засгийг сайжруулахын тулд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, мега төслүүдээ урагшлуулах гээд түүний толгойлсон - **/mn/i/7073**



### Эдийн засагт 500 сая ам.доллар орж ирнэ

Монголбанкны зарласан ханшаар ам.доллар 1897 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь ханшийн одоогийн зах зээл дээрх хамгийн бага үнэ. Ханш чангарч байгаа нь эдийн засгийн хүндрэлийн нэг шалтгаан гэдгийг СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш Б.Мөнхзаяа тодорхойлсон - **mn/e/7109**



### Их гүрнүүдийн хагарал Монголд хожил авчирна

Их гүрнүүдийн хоорондын зөрчил нь дэлхийн эдийн засагт таагүй нөлөөг үзүүлж байгаа ч манай улсын хувьд шинэ боломжийг нээн өгсөн гэдгийг “Мандал женерал даатгал” компанийн Эрсдэлийн шинжээчдийн гаргасан гурав дахь удаагийн “Монгол Улсын эрсдэлийн тайлан”-д онцолжээ - **/mn/e/6988**

## ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН

**MongolianEconomy.mn/ дээр доорх улаанаар тодруулсан тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.**



**Д.Жаргалсайхан**

### Эрүүл мэнд, бас спортын яам гэнэ үү?

Ч.Сайханбилэгийн Засгийн газар ийм нэртэй яам бий болгож МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Шийлэгдамбыг сайдаар нь томиллоо. Аль нам нь ч бай, сайд нь өөрөө амин хувиа бага бодож, ажил төрлөө сайн хийж, айл бүр - **mn/p/7099**



**Ө.Ганзориг**

### Төрийн хар хүн (statesman)

Миний сууж байсан курсэд Бутаны оюутан байв. Бутан бол Төвд ба Энэтхэгтэй хил залгаа жижигхэн улс гэдгийг мэдэх байх. Анх тэр хүнээс Үндэстэний Аз Жаргал (Gross National Happiness) хэмээх албан ёсны хэмжүүрийн тухай сонсож билээ - **mn/p/6867**



**Ян Хансэн**

### Улсын баялгийн сан байгуулах ба олон улсын түлхүүр зарчим

Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн бодлогын үр өгөөжийг сайжруулах үүднээс Улсын баялгийн сан (УБС) байгуулах асуудал дээр ажиллаж байгаа билээ. Тус нийтлэлд УБС байгуулахад мөрдвөл зохих, олон улсын туршлагад үндэслэсэн зарим чухал зарчим, загварыг - **mn/b/4544**



**Л.Бямбаа**

### Бодлогын үр нөлөөгүй мөнгөний бодлого

Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барилаа. Төрөөс баримтлах аливаа бодлого нь зорьсон үр дүндээ хүрдэг байх нь чухал. Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхгүй, эсвэл зарим тохиолдолд бүр эсрэг үр дүнд - **mn/b/6948**



**Р.Амаржаргал**

### Хууль баталж байгаа байдлыг өөрчлөх тухай

***Peer review*** – гэж сонссон байх. Академик чанартай сэтгүүлд тогтмол хэрэглэдэг. Жишээ нь: би нэг сэтгүүлд эрдэм шинжилгээний материал өгсөн бол миний нэрийг даран хэн бичсэнийг мэдэх аргагүйгээр гурван шүүмжлэгчдэд илгээнэ. Чухам хэнд илгээсэн болохыг би мэдэхгүй - **mn/b/6461**



**Б.Эрдэнэбат**

### Монгол Улс хэзээ хөгжих вэ?

Косово улсад болсон моно жүжгийн фестивальд амжилттай оролцож, эх орныхоо нэрийг гаргаж чадсан жүжигчинд Монгол улсын Засгийн газрын 120-р тогтоолоор 65 сая төгрөгийн шагнал олгов гэсэн мэдээ уншлаа. Уг мэдээ Олимпийн наадмын алтан медальтныг 4 сая - **mn/p/6216**

**Твиттер дээр биднийг дагаарай**
**@MN_Economy**

**Фэйсбүүк дээр бидэнтэй нэгдээрэй**
**Facebook.com/Mongolian.Economy**

**Онлайн захиалга өгөхдөө http://goo.gl/KVV50W линкээр орох буюу энэ кодыг сканнердаарай:**

# ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хөрөнгө оруулалттай компаниуд:

ARD ДААТГАЛ КОМПАНИ

Ердийн даатгал

ARD КРЕДИТ ББСБ

Банк бус санхүүгийн байгууллага

ARD АКТИВ ХЗХ

Хадгаламж зээлийн хоршоо

TENGER FINANCIAL GROUP LLC

Санхүүгийн цогц үйлчилгээ

IET Техник Технологийн Дээд сургууль

Техникийн дээд боловсрол, Коосэн сургууль

MONET CAPITAL INVESTMENT BANK

Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх

WILD

Вэб сайт, маркетинг, брэндинг хөгжүүлэлт

TENGER SYSTEMS

Санхүүгийн програм хангамж

Номын Хишиг

Үл хөдлөх хөрөнгийн түрээс

Хүчтэй. Хамтдаа.

www.ardholdings.com

# ГАРЦ

*Хөдөө аж ахуйд суурилсан нүүдэлчин соёл иргэншлээс уул уурхайг түшиглэсэн хөгжилтэй орон болох замаар замнаж буй Монгол Улс өдгөө хөгжлийн гарцын өмнө түр зогсолт хийгээд байна. Ямар гарц байж болох талаар манай сэтгүүл эрэлхийлдэг.*




*Өмнөговь аймгийн Цогтцэцийн сумын Цагаан-Овоо багт байрлах Тавантолгойн уурхайн нүүрсний нийт нөөц 6.0 тэрбум гаруй тонн. Үүнээс хоёр тэрбум гаруй нь коксжсон, өндөр чанартайд тооцогддог.*



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

# Д.Бямбасүрэн: Тавантолгой бол Монголын нэг эмгэнэл

*Монголын төр нийгмийн нэрт зүтгэлтэн Монгол Улсын 17 дахь Ерөнхий сайд Дашийн Бямбасүрэнтэй манай сэтгүүлч Монголын эдийн засгийн талаар ярилцлаа.*



**-Та Монгол оронд болж байгаа уул уурхай, эдийн засаг, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг байнга авч, анализ дүгнэлт хийж суудаг юм шиг санагдсан. Саяхан Японы Ерөнхий сайд Шинзэ Абэ Монголд айлчиллаа. Айлчлалыг эдийн засаг талаас нь авч үзвэл Тавантолгойн Баруун Цанхи дээрх сонгон шалгаруулалтад Японы байр суурь хүчтэй орж ирэх нь ээ гэж хүмүүс харж байна. Хятад, Япон, Америк гэсэн гурван том гүрний дунд өрсөлдөөн явагдах хандлагатай байна. Та үүнийг хэрхэн харж байгаа вэ?**

-Японы Ерөнхий сайдын айлчлал өндөр ач холбогдолтой. Хэлэлцэж ярьсан зүйл нь Монгол Японы харилцаа хамтын ажиллагааг эдийн засгийн стратегийн түншлэлийн хэмжээнд гаргаж байгаа нь чухал. Баруун Цанхийн хувьд манайхан олон ч жил ярилаа. Энэ бол Монголын нэг эмгэнэл юм шүү дээ. Тавантолгой нэг цогцолбор орд байсан. Гэтэл тав хуваачихаад, ийш тийш нь барьж гүйгээд, ганзагын наймаачин шиг “чамтай ч хамтарна, чамтай ч хамтарна” гэж хүн бүрт амлаад, сүүлдээ гацаанд орлоо. “Чалко”-той байгуулсан гэрээг харах юм бол эдийн засгийг улс төрийн барьцаанд өгөх нь ямар хор холбогдолтой байдаг вэ гэдгийг харж болох юм. Тавантолгойн асуудал олон талаараа бүдгэрэх эргэлзээ төрүүлэх байдалд орчихоод байна. Ер нь тус орд газрыг ашиглахдаа дан ганц эрчим хүчний нүүрс юм уу, коксжсон нүүрс гаргана гэх биш, коксоо дотооддоо үйлдвэрлээд гаргавал тээврийн зардал ч бага гарна, үнэ нь ч өндөр болж, эдийн засаг дээшилнэ шүү дээ. Хэрвээ Тавантолгойд Японы тал оролцъё гэж байгаа бол кокс, хагас кокс үйлдвэрлээд, тэрийгээ БНСУ, Японы зах зээлд борлуулах чиглэлд хамтарч ажиллах юм бол өндөр ач холбогдолтой. Тэр тусмаа манай урд хөрш Тавантолгойн нүүрсийг

авна, авахгүй дээрээ тулчихаад сууж байгаа нөхцөлд коксоо гаргасан нь ашигтай.

**-“Үйлдвэржилтийн шинэ эрин” гээд шинэчлэлийн Засгийн газар нэлээд ярьж байгаа. Гэхдээ эхлүүлсэн зүйл алга байна. Үйлдвэржилтийг хөгжүүлэх тал дээр таны бодлыг сонсоё.**

-Үйлдвэржилт гэдгийг манайхан олон удаа, олон янзаар ярьж үзлээ. Манайд энэ талын үндсэн ойлголт философи жаахан дутуу юм уу даа гэж боддог. Барууны орнуудын үйлдвэржилтийн үе шатыг аваад үзвэл үйлдвэржилт нь байгалийн түүхий эдийг боловсруулж, хүний оюун ухаан шингээсэн буюу инженерийн ухаан орсон бүтээгдэхүүн гаргахыг хэлмээр санагддаг. Гэтэл манайд үйлдвэржилт гэдэг нь гаднын техник худалдаж аваад юм уу, гадаадын хөрөнгө оруулагчдыг оруулаад, газраа онгичоод, хүдрээ шороо чигээр нь зөөж, гаргах гэж ойлгоод байна. Энэ хоёрын хооронд асар их зөрүү бий. Ер нь үйлдвэржилтийг зөвхөн уул уурхайтай холбоод эрдэс баялгаа гадагш нь зөөх арга хэрэгсэл гэж ойлгох юм бол нэг талаас энэ нь богино хугацаанд асар их хэмжээний ашиг хуримтлал өгөх боловч нөгөө талдаа хойч үедээ хэдэн зуун жилээр нөхөгдөшгүй гарз хохирол үлдээж, сүйрэлд хүргэх аюултай. Орчин үед дэлхийн улсууд үйлдвэржилтийн хөгжлийн дараагийн замдаа орлоо гэж ярьдаг. Гэтэл манайх үүнийг уул уурхайгаар төсөөлөөд сууж байгаа нь их л өрөөсгөл ойлголт. Манайх Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглаж эхэлснээс хойш 35 жил болж байна. Эрдэнэтийнхээ зэсийг бүрэн үйлдвэрлээд кабель хийгээд юм уу, кабелиараа цахилгаан хөдөлгүүр хийгээд гаргасан бол хангалттай хугацаа өнгөрлөө шүү дээ. Тэгж чадсангүй. Хэрэв Эрдэнэтийн зэсийг кабель болгох юм бол үнэ нь хоёр дахин өснө. Цахилгаан хөдөлгүүр хийгээд гаргавал бүр ашигтай. Ингэсэн тохиолдолд жинхэнэ үйлдвэржилтийн үйл ажиллагаа явж байна гэж ойлгож болно. Монгол Оюутолгой, Тавантолгой гээд хоёр том эх үүсвэрээ нээчихлээ. Үүн дээрээ хүний оюун ухаан, технологи шингээсэн үйлдвэрлэл эрхлэнэ гэсэн зорилттой ажиллавал дээрх ордууд Монголын эдийн засгийг, монголчуудын амьдралыг хангалттай түвшинд тэтгэх боломжтой. Гэтэл дээр нь нэмж уурхай нээх гээд гаднын хүмүүсийн мөнгө харсан хэдэн эрх мэдэлтнүүдийн уриа лоозонгоор хөдлөөд байх шиг.

## Монголчуудыг төмөргүй байлгах нь хоёр хөршийн төрийн бодлого

**-Түүхий эдэд суурилсан үйлдвэрлэл бий болгоход бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдын зүгээс юу дутаад байна вэ. Сэтгэл үү, хөрөнгө мөнгө үү?**

-Хоёр зүйл дутаж байна. Нэгдүгээрт, төрийн өөрийн бодлого, хүсэл зориг байх ёстой. Жишээ нь металлургийн үйлдвэрийг аваад үзье. Ер нь Их Монгол гүрнээс хойших түүхэн бүх үед монголчуудыг төмөргүй байлгана гэдэг манай хоёр хөршийн төрийн бодлого байсан. Батмөнх даян хаан, Алтан хааны үед ч монголчууд Мин улстай ширмэн тогоо Монголд худалдахыг зөвшөөрүүлэх гэж дайтаж байсан үе бий шүү дээ. Тэр үед монголчуудыг төмөргүй байлгавал сэлэм, зэвээ хийж чадахгүй гэдэг утгаар хандаж байсан. Ийм зүйл социализмын үед хүртэл монголчуудыг металлургийн үйлдвэргүй байлгана гэдэг бодлогоор дамжиж ирлээ. Гэтэл одоо төр ийм сайхан эрх чөлөөтэй хувь заяаны жолоогоо гартаа авсан үедээ металлургийн үйлдвэр хөгжүүлье гэсэн өөрийн ухаан бодолгүй явна. Дарханы металлургийн үйлдвэрийг анх 71 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэсэн хэлэлцээр хийж барьсан. Тэгэхэд арматур, ирисийн төмрөөс гадна автоматын ган гаргах ёстой байсан. Гэтэл технологийн үе шатыг нь таслаад өөрсдөө дундуур нь баахан хувийн эрх ашиг шургуулсаар байгаад технологийн ноу-хау авч чадаагүй шүү дээ. Үүнээс болоод энэ үйлдвэр өнөөдөр хагас бүтээгдэхүүн гаргах байдалд зогслоо. Тэгвэл төр үүнийг тууштай явуулах хэрэгтэй. Нөгөө талд нь хүнээ бэлтгэх. Гаднаас машин техник авна гэдэг зөвхөн мөнгө зарах тухай асуудал юм. Хээ ч машин техник авч болно. Тэрийг эзэмших хүн хэрэгтэй. Хүнээ бэлтгэх тал дээр анхаарахгүй явж ирснээс өнөөдөр бусдын гар харах байдалд ороод байгаа.

**-Хүнээ хэрхэн зөв бэлтгэх вэ?**

-Металлургийн чиглэлийн хүн бэлтгэнэ гэвэл металлургийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн оронд хүнээ явуулах ёстой. Төмөр гэхэд л маш олон янз байна. Зөвхөн болд төмөр гэхэд л 300-гаад төрөл бий. Үүнийг мэддэг чаддаг газарт нь хүнээ явуулж сургах нь зайлшгүй. Миний бодоход энэ чиглэлээр төрийн бодлого дутагдаж байна. Дунд сургуулиа сайн төгсөж байгаа авьяаслаг залуусаа шилж сонгоод Засгийн газрын тэтгэлгээр гадаадын их, дээд сургуульд сургах. Харин ирсэн хойно нь тэр хүмүүстээ үйлдвэрээ өөрөө аваад явахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

**-Хүмүүсээ сургаад, тэд эргэж ирээд үйлдвэр байгуулна гэхээр нэлээд цаг орох юм биш үү?**

-Бид энэ тухай ярьсаар байгаад 22 жил өнгөрөөлөө. Энэ хооронд инженер техникчдийн 3-4 үеийг бэлтгэх боломж байсан. Алдаад л байна. Цаг их шаардана гэдэг дээр нэг жишээ бий л дээ. АНУ-ын Ерөнхийлөгч асан Жэффэрсон цэцэрлэгчдээ хэлж л дээ. “Энд нэг алимны мод тарьчихвал зүгээр юм даа” гэж. Нөгөөх нь цаг их шаардана шүү дээ гэсэн байна. Ерөнхийлөгч тэгвэл өнөөдөр тарь гэсэн гэнэ лээ. Тэр технологиор л бид ажиллах ёстой. Хүнээ бэлтгээгүй цагт хэн ч бидэнд ирж нарийн сайн зөвлөж, хийж өгөхгүй шүү дээ. Бүгд өрсөлдөгч гэж харна.

**-Оюутолгойн гэрээг өөрчлөх тал дээр Та нэлээд тодорхой байр суурь илэрхийлсэн байсан. Хувь нийлүүлэгчдийн хурал хойшлоод, тодорхойгүй байдал үргэлжилсээр. Ийм нөхцөлд хөрөнгө оруулалтын гэрээ өөрчлөгдөх болов уу?**

-Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий. Гэхдээ өөрчлөлтийн тухай ярихынхаа өмнө бид ямар өөрчлөлт хийх гэж байна вэ, юу хэрэгтэй вэ гэдгээ дотроо эхлээд ойлгох хэрэгтэй. Миний харж байгаагаар тавьж буй зарим асуудлаа манайхан

өөрсдөө ойлгоогүй байна. Ганцхан жишээ хэлье. Норвегит уул уурхайн салбарт ашгийн 78 хувь хүртэл татвар авдаг. Манайх 2006 онд Татварын тухай хуулиа өөрчлөхдөө 35 хувь байсныг 25 хувь болгоод ганц шатлалтай болгож бууруулсан. Одоо ашиг орлогоо олж чадахгүй болохоороо Оюутолгойд оролцох хөрөнгийн оролцоогоо нэмнэ гэж зүтгээд байгаа. Үүний оронд өөрсдөө татварын хуулиа шатлалтай зөв болгочихоод асуудлаа тавибал цаад тал хүлээж авах магадлал нэмэгдэнэ шүү дээ. Миний бодоход өөрийгөө бэлтгээгүй, өөрсдөө сайн ойлгоогүй байж гэрээг өөрчлөх асуудал руу гэнэт үсрэн орох нь өмнөхөө улам дордуулахыг ч үгүйсгэхгүй. Гэхдээ Оюутолгойн гэрээг өөрчлөх шаардлагатай гэдэг дээр хувилбар байхгүй.

## Манай эдийн засгийн олон салбар ил далд монополиудын гарт байна

**-Монголбанк инфляцийг нэг оронтой тоонд аваачих, дундаж давхаргын чанарыг сайжруулах зорилт тавьсан. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд мах, гурил, нефтийн бүтээгдэхүүнд Засгийн газраас хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Үүний үр дүн хэрхэн гарна гэж Та бодож байна?**

-Одоогийн инфляцийн мөн чанарыг бид зөв ойлгох хэрэгтэй. УИХ-ын болон орон нутгийн сонгууль болоод жил болоогүй байна. Сонгууль угтаж баахан мөнгө тараасан. Үүний цохилт инфляциар ирлээ. Монголын эдийн засгийг хараад байхад инфляцийн нэг түлхэлт бий болоход түүнийг зургаан сарын дараа эдийн засаг шингээдэг. Жишээ нь махны үнэ байна. Өнгөрсөн жил сонгуулийн өмнө нэг кг нь 6000-7000 төгрөгийн үнэтэй байсан бол өнөөдөр 10000 гаруй мянган төгрөг боллоо. Нөгөө талд инфляци яагаад өсөж байна гэхээр Монголын эдийн засаг чөлөөт өрсөлдөөнтэй эдийн засаг болж чадаагүй байна. Манай эдийн засгийн олон салбар ил далд монополиудын гарт байна. Гуравдугаарт, инфляцийг хөөрөгдөж байгаа зүйл гэвэл манайхан бүтээн байгуулалт гэж сонин лоозон гаргаад түүнийгээ туг болгоод явж байгаа. Бүтээн байгуулалт гэж жишээ нь нэг эрдэмтэн хүн шинэ технологи боловсруулаад, үйлдвэрт нэвтрүүлбэл тэр нь хамгийн үнэтэй бүтээн байгуулалт байх ёстой. Гэтэл бид төсөвт их хөрөнгө хураагаад тэрүүгээрээ шавар овоолоод сумын төвд байшин барихыг бүтээн байгуулалт гэж ойлгодог. Нийлүүлэлтээ зохицуулж чадаагүй учраас инфляци үүсдэг. Дөрөв дэх шалтгаан нь манай төрийн бодлоготой холбоотой. Төсөв батлах үед юм уу, эсвэл сонгууль ойртоод ирэхээр Засгийн газар цалин тэтгэвэр тэтгэмжийг төдөн хувиар нэмнэ гээд л жилийн өмнөөс зарладаг. Энэ сургаар наймаачид барааныхаа үнийг өсгөдөг. Үндсэндээ төрийн бодлого инфляцийг хөөрөгддөг уриа лоозон болж хувирдаг. Ийм үед мөнгөний бодлого барьж байгаа Монголбанкны зүгээс нарийн зохицуулалт хийх шаардлагатай.

**-Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай хууль, Оюутолгойн тодорхойгүй байдлаас болоод Монголд хөрөнгө оруулалт буурлаа гэж ярих боллоо. Та энэ тал дээр ямар байр суурьтай байна вэ?**

-Бид нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй. Оюутолгой гэдэг бол том объект. Үүний анхны хөрөнгө оруулалтын оргил үед эдийн засагт хөөс бий болсон. Энэ үед манай эдийн засаг 17 гаруй хувиар өслөө шүү дээ. Түүнээс биш, эрүүл эдийн засаг бол ийм өндөр өсөлт гарахгүй. Хамгийн гол нь дээрх өсөлтийг тасралтгүй үргэлжлэх юм шиг бодно гэдэг бол дэндүү гэнэн юм. Монголын эдийн засаг жилдээ 8-10 хувийн өсөлттэй явахад хэвийн байна гэж ойлгож болно.

Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг сонин зүйл л дээ. Хэрэв гадаадын хөрөнгө оруулалтыг дагуулаад дотооддоо түүхий эдийн баазаа босгоод, өөрсдөө ажиллана, хүнээ сургана гэх юм бол шинэ технологи авчрах, хүмүүсийг мэргэшүүлэх, менежмент талаасаа үр ашигтай арга зам юм. Харин гадаадын хөрөнгө оруулалтыг манай баялгийг ухаад бай, дээрээс нь би хэдэн зүйл дамлаж худалдаад ашиг олно гэсэн өнцгөөс харвал энэ нь улсыг сүйрэлд хүргэнэ. Энд эрүүл бодлого хэрэгтэй. Уул уурхайн салбарт зогсонги байдал үүслээ.

Гаднын хөрөнгө оруулалтын зарим нь гарах шинжтэй байна гээд яриад байгаа. Гарвал гараг. Хууль бус лиценз авсан хүн байвал орхиод явахад муу юм байхгүй. Нөгөө талаас Оюутолгой, Тавантолгой дээрээ боловсруулах үйлдвэрүүд бариад явахад эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах нөхцөл бүрдэж байгаа. Ер нь гаднын хөрөнгө оруулалтыг манайхан эдийн засгийн зайлшгүй хөшүүрэг гэж ойлгоод байх шиг.



Хөрөнгө мөнгө дутагдаад өөрсдийнхөө хөгжлийн асуудлыг шийдэхэд гаднын хөрөнгийг ашиглаж болно. Түүнээс биш, “Али баба ба 40 дээрэмчин” гэдэг шиг Монгол гэж агуулах сав байна. Энд байгаа зүйлийг гадагшаа зөөгөөд бай, би дундаас нь ашиг хонжоо олоод байя гэдэг сэтгэхүйгээр хандах юм бол бүтэхгүй. Энэ удаа бид жолоогоо татсан нь дээр.

**-Монголчууд нэг үеэ бодоход мөнгөтэй болсонтой ч холбоотой байх. Хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй болсон. “Монголын эдийн засгийн чуулган-2013” монгол брэнд хэрхэн бий болгох вэ сэдэвтэй болсон. Таны бодлоор монголчууд юу үйлдвэрлэж, хийж чадах вэ?**

-Зэрэгцүүлж л харах хэрэгтэй. Сингапур улс манайхтай адил 3.0 сая хүн амтай. Израиль мөн тооны хүн амтай. Тэр улс юу хийж чадаж байна. Израильчууд элсэн цөлд хамтаараа хооллож, хамтаараа нэг майханд унтаж байгаад улсаа байгуулсан. Тэд өнөөдөр онгоц хийж чаддаг болоод байна. Бусад зүйлийг хийгээд дэлхийд нэр төртэй амьдарч болоод байна шүү дээ. Тэгэхээр хүн цөөдөхгүй ээ. Хийж бүтээхийн тулд улс үндэстэнд хоёр зүйл чухал байдаг. Нэгдүгээрт, технологийн мэдлэг. Нөгөөх нь зохион бүтээлт. Гэтэл манай аль ч үйлдвэр аж ахуйн газарт зохион бүтээж, туршилт нэвтрүүлдэг шат дамжлага байхгүй. Манай компаниуд гаднаас юм оруулж ирээд, олон түмэнд худалдаж мөнгө олдог юм уу, эсвэл дотроо байгаа зүйлийг гадагш нь худалдах чиглэлд л ажиллаж байна. Үндэснийхээ бүтээх чадавхыг бий болгох төвүүдээ байгуулах хэрэгтэй. Арьс шир гэхэд үйлдвэрлэл эрдэм шинжилгээний төв ажиллаж, төрөл бүрийн технологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ёстой. Манай шинжлэх ухааны салбарын санхүүжилт ДНБ-ий 0.25 хувь хүрэхгүй шахам байдаг. Бусад орон үйлдвэрлэлээ хөгжүүлье гэвэл судалгаа, шинжилгээнийхээ салбарт ДНБ-ийхээ ес хүртэлх хувийг зарцуулж байж тодорхой үр дүнд хүрдэг. Тийм болохоор Монголд өнөөдөр оюуны цөм бүрдэж чадахгүй байна.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

## Эдийн засгаа улс төрийн барьцаанаас чөлөөлөх хэрэгтэй

**-Төсвийн мөнгийг танил тал, хэсэг бүлгээрээ хувааж иддэг байдал нэг хэсэгтээ амь бөхтэй орших юм шиг байна. Авлига хээл хахуулийн асуудал ард түмний санааг улам бүр зовоох боллоо.**

-Нэг жишээ авъя. Би саяхан цахим хуудаснаас уншсан. Хөдөө аж ахуйн есөн бирж эрхээ авч, туршилтын арилжаа хийжээ. Малчид нэг кг ноолуурыг 64.000-72.000 төгрөгөөр өгье гэж байгаа юм байна. Миний бодоход ноолуураа ийм үнээр өгч байгаа малчид төрөөс хэзээ ч юм гуйхгүй. Гэтэл улстөрчид эдийн засаг хямрахаар ямаанд мөнгө өгч байна гэдэг нь өөр сонирхолд хөтлөгдөөд байгаа. Энэ нь төр цэвэршээгүй байхад эдийн засгийн бодлого бохирдоод байгааг харуулаад байна.

**-Төр хэзээ цэвэрших вэ. Хүлээхээс өөр сонголт алга байна. Та юу гэж боддог вэ?**

-Энэ тухай ярьсаар бид удаж байна. Миний мэдэхийн төрийн ялзарлын тухай Монгол Улсын сүүлийн гурван Ерөнхийлөгч ярилаа. Ямар ч байсан олон түмний анхааралд орно гэдэг бол нэг шат. Хэр зөв явах вэ, хэр цаг хугацаа шаардах вэ гэдэг өөр асуудал л даа. Ер нь Оюутолгойн гэрээг будилаантай хийгээд түүнийгээ магтан дуулж байсан үе бий. Тавантолгойг тараачихаад будилж байсан үе ч байгаа. Энд гол зүйл нь эдийн засгаа улс төрийн барьцаанаас чөлөөлөх хэрэгтэй. Улс төрийн намууд эдийн засгаа барьцаалж амлалт өгдөг байдлыг өөрчлөх ёстой. Авлигачдын явсан замыг товчхон харъя. Өмчийг хялбархнаар олж авах гэж өмч хувьчлал явуулсан. Дараа нь төсвийн ам тоссон баячууд бий болсон. Гурав дахь шат төрийн албыг худалдаж авсан. Үүнтэй зэрэгцээд газар, байгалийн баялгаа худалдсан. Байгаль гомдол нэхдэггүй юм байна. Тийм болохоор төр би мэднэ гээд нийт нутгийнхаа 60 хувийг гадныханд өгчихөөд сууж байсан үе байлаа шүү дээ. Одоо тав дахь үе эхэлж байна. Монголынхоо ирээдүйг барьцаалж бонд юм уу, зээл аваад төрд байгаа эрх мэдэлтнүүд нь өөрийнхөө бизнесийн төслийг намын хөтөлбөр санхүүжүүлж байна гэж алга болгох. Эдийн засгаа улс төрийн барьцаанаас салгахын тулд дээрх таван хаалгыг хаах ёстой. Үүнд л төрийн чанд бодлого хэрэгтэй. ■

2013 ОНЫ 04 САР.



*тайлбар*

ЗОЧИН

# “Голланд өвчнийг анагаагч”

*“Голланд өвччин”-ийг “Голланд гайхамшиг” болгож чадсан тус улсын Ерөнхий сайд асан Вим Кок энэ жил Монголын эдийн засгийн чуулганд урилгаар хүрэлцэн ирж илтгэл тавьсан билээ. Түүний хэрэгжүүлсэн “Polder model” хэмээх загварчлал Голланд улсад 10 гаруй жил үргэлжилсэн уул уурхайн орлогод хэт дулдуйдаж бусад салбараа шахах үзэгдлийг “номхотгож” чадсан байдаг. Энэ үед АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтон хүртэл баяр хүргэж “Вим, Та анхных нь байсан шүү” хэмээн хэлж байсан удаатай. Монголын эдийн засгийн чуулганы үеэр тэрбээр “Mongolian Econoty” сэтгүүлийг онцлон ярилцлага өгсөн юм.*

**-“Голланд өвчин” үүсэх болсон шалтгааны талаар ярилцлагаа эхлэх үү?**

-Байгалийн баялгийн орлогодоо хэт хөтлөгдөж, өндөр хөгжсөн аж үйлдвэрлэлийн салбараа ганхахад хүргэснээс үүдэлтэй. Байгалийн хийн олборлолт, нөөцөөс орж ирж буй нэмэлт орлогыг боловсрол тэргүүтэй өндөр үр ашигтай салбарт хөрөнгө оруулалт болгож хангалттай зараагүй. Тухайн үеийн төсвийн зарцуулалтад нэлээд ашигласан. 40 жилийн өмнө Нидерланд төдийгүй Европ тэр аяараа эдийн засгийн хямралд бүдчиж байсан үе юм. Үүнээс үүдэн бид үнийн өсөлт, өндөр инфляци, төсвийн алдагдал руу халтирсан.

Голланд өвчнийг давахын тулд шинэ шийдэл олох хэрэг гарсан юм. Эцэст нь, Голланд өвчин амжилтын түүх болон хувирч, бид өдийг хүртэл Евро бүсийн хүчирхэг эдийн засагтай орнуудын нэг хэвээр байна. Үүгээр бид өвчин тусах нь ноцтой асуудал боловч түүнээс ангижирч болно гэдгийг харуулсан. Гэвч нэн тэргүүнд ашигт малтмалын орлогоо дэд бүтэц, боловсрол гэсэн бүтээмж өндөртэй салбарт зарцуулж, түүнээс сэргийлэх нь зүйтэй. Ашигт малтмалын үйл ажиллагаанаас орж ирж буй нэмэлт орлогоор хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж болдог.

**-Нидерланд улсын өндөр хөгжсөн аж үйлдвэрлэлийн салбар байгалийн баялгийн нээлт, олборлолтоос үүдэн шахагдаж, уналтад орсон гэдэг. Голланд өвчний өмнө болон дараа аж үйлдвэрийн салбарын байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?**

-Аж үйлдвэрийн салбар үргэлж л хүчирхэг байсан. Яагаад гэж үү. Учир нь бидэнд байгалийн хийгээс өөр баялаг байгаагүй. Мөн олон улсын худалдаа, экспорт, импортоос дэндүү хамааралтай улс. Экспорт манай улсын ДНБ-ий 50 хувийг эзэлж байна. Тиймээс бид хүчирхэг аж үйлдвэрийн суурь салбараар өрсөлдөх чадвараа хадгалах хэрэг гардаг. Гэвч тэр үед Голланд өвчинд нэрвэгдэж, манай улсын эдийн засаг тэр дундаа үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа уруудаж эхэлсэн юм. Тодорхой тооны компани цаашлаад бөс бараа, усан онгоцны үйлдвэрүүд хүртэл хаагдахад хүрч, олон хүн ажилгүй болж эхэлсэн. Аж үйлдвэрийн салбар сэргэхэд удаан хугацаа шаардсан. Гэсэн ч уг салбар өнөөдөр дахин цэцэглэн хөгжиж байна. Манай улсын хувьд хүн амын насжилт, бусад улсын дэлхийн

зах зээл дэх өрсөлдөх чадварын өсөлт гэхчлэн амаргүй асуудал олон байгаа ч аж үйлдвэрлэлийн салбарын хөгжил өндөр түвшинд явж байна.

Юу хэрэгтэй вэ гэвэл, өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, чадвартай боловсон хүчин. Боловсролын чанар онцгой сайн байх нь олон улсад өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн өндөр ур чадвартай иргэдтэй болж чадна гэсэн үг.

**-Нидерланд евро бүсийн хямралаас хэрхэн зайлсхийж байна вэ?**

-Уг хямралд бүгд өртөж байна. Одоо ч Европ шигүү ой дундаас хараахан гараагүй. Гэвч евро бүсийн “цаг агаар” хагас жилийн өмнөхөөсөө өнөөдөр харьцангуй дээрдчихээд байна. Хүн бүр энэ үйл явцыг гутранги өнгөөр харж байв. Харин сэргэж буй энэхүү өөдрөг төсөөлөл биднийг хямралаас авч гарах гарц болно.

Нидерланд Скандиновын орнууд болон Германтай мөр зэрэгцэж, өдийг хүртэл гурван А (ААА) зээлжих зэрэглэлтэй цөөхөн орнуудын нэг байсаар ирлээ. Тогтвортой байдал, санхүүгийн эрүүл мэндийн хувьд Нидерландын нэр хүнд өндөрт яваа. Энэ бол сайн мэдээ.

**-Эдийн засагт туссан хүнд өвчнийг гайхамшиг болгож чадсан аргаас жаахан тодорхой тайларлахгүй юу?**

-“Polder model” хэмээх загварчлалын үрээр бид энэ бүгдийг бүтээсэн. Улсынхаа төлөө нэгдэж, нэг зорилгын төлөө бие биенийгээ сонсож чаддаг ТББ, холбоод, ажил олгогчид, нийгмийн зүтгэлтнүүд байсан учраас тэнд хүрч чадсан. Энэ бол Нидерланд улсын хувьд төдийгүй Монголын хувьд маш чухал гэдгийг хэлье. Төр, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудыг огтлолцуулж байдаг нийтлэг эрх ашгийн нэг талбартай байх нь маш чухал юм шүү. Тэд үргэлж санал нэгдэж байх албагүй. Зарим үед зөрчилдөж, биенээ сонсч, ятгаж, нэн тэргүүнд тавигдах нийтлэг зорилтуудаа тодорхойлох нь улс бүрийн хувьд туйлын чухал.

**-“Polder model” загварчлал Нидерланд улсын бодлогын нэг хэсэг одоо ч байсаар байгаа юу. Эсвэл үеэ өнгөрөөсөн стратеги уу?**

-Хуучин загварчлал гэдэг экспортын бүтээгдэхүүнтэй адилгүй гэдэг нь мэдээж. Солонгос, Монголд авчирч болно. Гэхдээ тухайн улс орны нөхцөл байдалд тохируулан хөгжүүлэх хэрэгтэй. Одоо үе болон ирээдүйн нөхцөлд тохирохгүй хуучирсан гэдэгтэй санал нэгддэггүй. Нийтлэг эрх ашигт тулгуурласан чиг хандлага, нийгмийн харилцаа бүх улс орны ирээдүйн хувьд маш чухал гэж боддог. Хэрхэн хийх нь тэдний л хэрэг. Хүн бүр өөр, өөрсдийн арга барилаар асуудалд хандаж шийдвэрлэж болно. Гэхдээ бидний загварчлалыг харахад гэмгүй л гэж боддог.

Жишээ татья. Уул уурхайн салбараас та нарт орлого орж ирж буй. Бид үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдээ хэрхэн тодорхойлж, эдийн засгаа төрөлжүүлэх талаар ярьдаг. Одоогоос таван жилийн дараа бид хаана хүчирхэг байх вэ. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд юуг хийх ёстой вэ гэх зэрэг. Нийгэмд хүн бүрийн оролцоог татаж чадах нь нэн чухал. Гэвч үүнийг зөвхөн Засгийн газар, хувийн хэвшлийнхний гар гэж ойлгож болохгүй. Энэ бол Засгийн газар, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагууд юм. Хүн бүрт тус дэм болох оролцоо гэж бий. Тиймээс нийтлэг зорилтуудаа тодорхойлдог. Хүн бүр нэг зүгт харцаа чиглүүлнэ гэдэг суурь бат байна гэсэн үг. Энэ л хамгийн том тус.

**-Зарим мэргэжилтэн болоод олон улсын байгууллага Монгол Улсыг аль хэдийнэ Голланд өвчинд нэрвэгдчихсэн гэж дүгнэж буй. Ийм нөхцөлд тулаад ирчихсэн орны хувьд дараагийн авах алхам юу байх вэ. Мөн ямар замаар эдийн засгаа төрөлжүүлж болох вэ?**

-Нэн тэргүүнд уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас орж ирж буй нэмэлт орлогыг үр дүнтэй хөрөнгө оруулалтад зарцуулах хэрэгтэй. Өнгөрсөн хугацаанд баталчихсан олон хууль, төсвийн дүрэм журмууд байна. Тэднээс хазайлгүй, чанд дагаж мөрд. Бүх төсөл нэг түвшний ач холбогдолтой бишээс хойш тэргүүлэх чиглэлүүдээ юу вэ гэдгийг сайн бодох хэрэгтэй. Хамгийн түрүүнд тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлох ёстой. Боловсрол мэдлэг, инноваци, судалгаа шинжилгээ хамгийн чухал нь гэж би хувьдаа хэлнэ. Битгий мартаарай. Дан ганц зам, барилга, төмөр замын бүтээн байгуулалтыг бодохын оронд хүмүүсээ яаж чадавхжуулж, шинэ түвшинд гаргах вэ гэдгийг бод. Учир нь, Монгол шиг орны хувьд өндөр чадавхитай боловсон хүчинтэй байж гэмээнэ удаан хугацаанд олон улсын тавцанд өрсөлдөж чадна.

Мөн хөрөнгө оруулалтын орчин, түүнийг гаднын хөрөнгө оруулагчид урьдчилж таамаглаж болохуйц байхад анхаарах хэрэгтэй. Тийм байж чадваас тэд энэ улсад ирэхдээ мөнгө, санхүүгийн орчин ямар болох, гэнэтийн бэлгээр гайхшруулах эсэхийг эргэлзэх зүйлгүй мэднэ. Тодорхой байдал гэдэг асар чухал агаад бизнес эрхлэлтийг дэмждэг гол хүчин зүйл. Жижиг, дунд үйлдвэрлэлийн аз сорьсон үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нь мөн зүйтэй. Тэдгээр компаниудын үйл ажиллагаа явуулах боломжийг хангаж, санхүүгийн байгууллагуудаар зээл олгуулах зэргээр санхүүгийн системээр нь зохицуулалт хийж өгөх хэрэгтэй. Үйлдвэрлэл, санхүүгийн салбар хоёр хамтдаа байсан тохиолдолд хөл дээрээ зэрэг босдог учир нэг нь ганцаараа өөдөлнө гэж байхгүй. Санаа оноогоо уралдуулан нэгтгээд эдийн засгаа хүчирхэг болгоход ашигла.

Төрөлжилтийн хувьд одоогоор аль хэдийнэ бүрдчихсэн байгаа хүчин чадлаа л ашиглах нь зүйтэй. Монголын эдийн засгийн хувьд




GOBI ORGANIC
MONGOLIAN CASHMERE

ШИНЭ КОЛЛЕКЦИ
ХУДАЛДААНД ГАРЛАА

organic.gobi.mn

мэргэжилтэн шиг мэдлэггүй ч олон янзын үйл ажиллагааны цуглуулга, экспортын дэмжлэг ихээхэн тус болно гэж бодож байна. Шууд бүтчихдэг зүйл биш л дээ. Хугацаа хэрэгтэй. Нидерландчууд ч цэцэгсээ ургуулж, олон улсад түүнийгээ таниулахын тулд урт удаан хугацаанд хөдөлмөрлөсөн. Монголын тодорхой салбаруудын тухайд ч ийм л замналыг туулна.

**-Монгол тэргүүтэй байгалийн баялаг ихтэй орнууд сангийн бодлогодоо ямар тэргүүлэх зарчмуудыг баримтлах нь зүйтэй вэ?**

-Төсөв сангийн хуучинсаг (консерватив) үзэл баримтлалд тулгуурлах гэж хэлнэ. Энэ нь байхгүйгээ үрэхгүй гэсэн үг. Орлогын энгийн эх үүсвэрт суурилан юунд зарцуулах вэ гэдэгт маш нарийн хандах хэрэгтэй. Мөнгөө зүгээр нэг гарынхаа салаагаар урсгачихаж болохгүй. Яагаад хэрэгтэй юм, ямар үр дүнг үзэх юм гэдэг нарийн тодорхойлолтгүйгээр төсөл битгий сонго.

**-Аль хэдийнэ Голланд өвчинд нэрвэгдчихсэн Монгол Улс хэрхэн илааршиж болох вэ?**

-Монгол Улс зөв зам дээр зогсож байна. Ядуурлын түвшин дээгүүр, орлогын хэмжээ доогуур ч хөгжингүй орон болох шатаар алхаж байна. Гэвч тус өсөлтийг нийтэд хүртээмжтэй байлгах тал дээр маш их ажил хийх хэрэгтэй.

Монгол өндөр инфляцийн эрсдэлийг маш сайн тооцоолж, түүнээс болгоомжлох нь зүйтэй. Танай улсын Төвбанкны Ерөнхийлөгч инфляци буурч байгаа гэж хэлсэн. Хэдийгээр инфляци доошилж байгаа ч өндөр түвшинд байсаар байна. Энэ бол мэдээж асуудал. Замаасаа хазайчихгүй урагшлах арга бол удаан хугацаанд нийт иргэнд болоод эдийн засагт өгөөжтэй тэргүүлэх ач холбогдолтой эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулах юм.

**-Аливаа улс орны халамжийн бодлого ямар байвал хамгийн зохист хувилбарт тооцогддог вэ?**

-Энэ бол ард иргэдийн хүслээс л шалтгаална. Азийн орнуудад хуучнаа бодвол илүүтэйгээр хөгжил, хөрөнгийг халамжийн системтэй холбох хандлага ажиглагдах болж. Тухайлбал, Хятад, Солонгост өрнөж буй мэтгэлцээнээс харж болох. Гэвч халамж гэдэг үнэгүй олддог зүйл биш гэдгийг санах ёстой. Хэн нэгэн түүнийг төлөх л ёстой. Халамжийн бодлогыг тэд л авч яваа. Тухайлбал, ажлаа алдсан нэгэнд ажилгүйдлийн тэтгэмж ямар чухлыг ойлгоно гэдэг орлогынхоо тодорхой хувийг цааш нь хийнэ гэсэн үг. Ийм л учраас нийгмийн даатгал, бусад татвараас халамжийн мөнгийг бүрдүүлж байдаг. Энэ бол диваажингаас буугаад ирдэг үнэгүй бэлэг биш.

Халамжийн системийг мэдээж хүлээн зөвшөөрдөг. Европ болон манай улсын бий болгож чадсан халамжийн системээр би их бахархдаг. Гэвч та бүхэн энэ мөнгө бусдын хөлс, хүч гэдгийг ямагт санах нь зүйтэй. Тодорхой зорилгоор хадгалж буй энэ мөнгийг зүгээр нэг цалин хөлс нэмэгдүүлэхэд ашиглаж огт болохгүй.

**-Халамжийн хэт тэлсэн бодлого Монгол Улсыг хааш нь аваачих бол ?**

-Монгол Улсын халамжийн бодлого тэгж их тэлээд байна гэж бодохгүй байна. Халамжийн бодлогыг хазаарлаж, зөв зүгт залах гэж хичээж буй одоогийн оролдлогыг “халамж бол бэлэг биш” гэдгийг ойлгож буйн үр дүн гэж харж байна. Халамжийн бодлогын одоогийн харагдаж буй дүр зургийг цаашид хөгжүүлэх нь тийм өндөр эрсдэлтэй алхам гэж бодохгүй байна.

**-Уул уурхайн салбарын бүтээгдэхүүнүүдтэй эн зэрэгцэх бусад төрлийн брэнд бүтээгдэхүүн гаргаж ирэхийг зорьж буй монголчуудад Та юу гэж зөвлөх вэ?**

-Гаднын хүний нүдээр харахад ашигт малтмалын бүтээгдэхүүнээ зөвхөн түүхийгээр нь экспортлоод байхын оронд үйлдвэрлэлд татах хэрэгтэй л гэж хэлмээр байна. Хөдөө аж ахуйн салбарыг тухайлбал, түүнээс гаргаж авч болох бүтээгдэхүүнтэй нь сайн холбож өгч болно. Тухайлбал, Нидерландад улсынхаа хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг өсгөөд зогсохгүй эдийн засгийн өсөлтөд голлох байр суурь эзлэх хэмжээнд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг чадварлаг компаниуд байдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ төрийн албаныхны хандлага, ёс зүйг чухалчилж байсан. Дүрэм, журам түүний хэрэгжилтэд зөвхөн сэтгэл ханаж болохгүй. Энэ бол их чухал.

**-Монгол Улс ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг зорьж байна. Урт хугацаанд ногоон гэдэг тодотгол эдийн засагт хэр өгөөжтэй байх вэ?**

-Бидний хэн хэн нь байгаль орчны тогтвортой байдалд онцгой анхаарал тавих хэрэгтэй. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үндэстэн дамнасан хувийн компаниуд нэн ялангуяа үүнийг маш сайн анхаарах нь зүйн хэрэг. Эцэстээ энэ бол тухайн компанийн зөвшөөрөл урт хугацаанд үйл ажиллагаа явуулж чадах эсэхтэй холбоотой асуудал. Хүрээлэн буй орчин, агаарын чанарыг муутгах нь компаниудад ч ашиггүй. Төр, хувийн хэвшлийнхний зүгээс уул уурхайг илүү хариуцлагатай, байгаль орчны хувьд тогтвортой байлгахад хамтарч ажиллах ёстой. Олон улсын гэрээ хэлэлцээрт тулгуурлан стандарт тогтоож өгөх нь нэн чухал. Ашигт малтмалын орлого чухал ч илүү тогтвортой, байгаль орчинд ээлтэй замаар уул уурхайн үйл ажиллагаа өрнөх ёстой. Алс хэтдээ энэ л бидэнд хамгийн ашигтай хэлбэр юм. ■

2013 ОНЫ 04 САР.



ИЛТГЭЛ

# Вим Кок: Бидний алдааг битгий давтаарай

Монголын эдийн засгийн чуулган-2013”-ын хүндэт зочин Голландын Ерөнхий сайд асан Вим Кокын илтгэлийг орчуулан хүргэж байна.

Ашигт малтмалын арвин нөөцтэй дэлхийн бусад улсыг тойролгүй дайрч өнгөрсөн эрсдэлүүдтэй монголчууд ч тулгараад байна. Гадаадын хөрөнгө оруулалт, валютын урсгал нь валютын ханш, бараа үйлчилгээ, инфляци, цалин хөлсний хувьд зайлшгүй өсөлтийн давалгааг үүсгэнэ. Нөгөө талаас амьдралын өртөг нэмэгдэж, экспорт, импортын компаниудын өрсөлдөх чадвар суларч хүнд байдалд орж эхэлдэг. Бусад улсын туршлага аливаа орон хэчнээн хүчирхэг байгууллагуудтай байсан ч байгалийн баялгаа олборлоод ирэхээр тэдгээр компаниуд “Голланд өвчинд” нэрвэгдэх менежментийн эрсдэлүүдтэй тулгардагийг харуулж байна.

1960 оны эхэн үед байгалийн хийн баялгийн нээлт нь Нидерландад юу авчирсныг хувийн туршлагаасаа хуваалцах нь зүйтэй болов уу. 1973 болон 1979 онд газрын тосны нийлүүлэлт зогсож, үнийн “шок” үүсэх үеэр Голланд халамжийн мөнгө ихээр тарааж, цалингийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр амьдралын өртөг ч өсч эхэлсэн. Улмаар энэ нь экспортын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын өрсөлдөх чадвар суларч, ашиг орлого багасахад нөлөөлсөн юм. Аж үйлдвэрлэлийн салбарын жилийн дундаж өсөлт 1970 оны эхний хагасаас хоёрдугаар хагаст шилжих үест 4.2 хувиас 0.7 хувь болтлоо буурсан. Түүнчлэн тус салбарын нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх орлого 1970 онд 17 хувь байсан бол түүнээс хойш арван жилийн дараа зургаан хувь болж багассан.

Энэ бүхэн манай улсын байгалийн хийн нээлт, олборлолтоос үүдэлтэй гэж буруугаар битгий ойлгоорой. Тэр үед дэлхийн бусад улс хэцүү үеийг туулж байсан. 1970 оны сүүл гэхэд бид бүгд дэлхийн эдийн засгийн хахир хатуу хямралыг амсаж байсан. Гэсэн ч нийгмийн халамжийн мөнгөөр дамжуулан төсвийн зарцуулалтыг өсгөсөөр байв. Байгалийн баялгийн орлого нэмэгдэх тусам халамжийн мөнгө өсөх хүлээлт байсан. Энэ нь ч чадлаасаа давсан их мөнгө зарцуулах шаардлага гарсан нөхцөл байдлын эсрэг зогсох ямар хэцүү байдгийг Голландын Засгийн газарт амсуулсан билээ.

Төрийн зардал 1970-аас 1982 оны хооронд ДНБ-ий 45 хувиас 66 хувь болтлоо өсч, төсвийн алдагдал огцом цойлсон. Засгийн газар тэр үеийн болон ирээдүйд орж ирэх байгалийн хийн орлогоо тооцоолон, зарлагаа нэмэгдүүлсээр байсан юм. Улмаар богино хугацаанд, инфляцийн өсөлт, цалингийн нэмэгдэл хоёр хавсарч, дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг илт муутгаж, төсвийн алдагдал асар хурдацтай ихэссэн билээ. Үүнийг л Голланд өвчин гэдэг байгаа юм.

Манай улсын олон үйлдвэр давжаарч эс бөгөөс хаалга барихад хүрсэн. Нийт ажилгүйдлийн түвшин тэр дундаа ажилгүй залуусын тоо огцом нэмэгдсэн юм. Уруугаа чиглэсэн уг хандлагыг зөвхөн урьд нь хэрэглэж байгаагүй шинэ санаачилга л зогсоож чадахаар байв. Энэ хэсгээс хойш миний түүх эхэлсэн гэж хэлж болно.

Тэр үед буюу 1980 оны эхэнд би Нидерландын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга байсан юм. Тиймээс ч ажил эрхлэгч болоод тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах нь миний тэргүүн үүрэг байв. Тухайн үед тэдний дийлэнх нь ажлаа алдахад хүрсэн эсвэл аль хэдийнэ ажилгүй болчихсон байсан. Цаашлаад манай улсын халамжийн системийн тогтвортой байдал ганхаж, аюулд орсон гэсэн үг.

Олон арван жил ноёрхож буй улсынхаа нийгэм хамгааллын тогтолцоо, халамжийн системээр би их бахархдаг. Ямартай ч тус систем нь Швед, Дани, Норвеги, Финлянд, Герман зэрэг улсад их бага хэмжээгээр нөлөөлөөд явж байна. Тус хямралын үед зогсонги эсвэл хасах чиглэлд явж буй эдийн засаг ямар ч боловсронгуй нийгмийн халамжийн системтэй байлаа гэсэн түүнийгээ эрсдэлд оруулдаг гэдэг нь маш тодорхой болсон. Далайн түрлэгийг эргүүлэхийн тулд Засгийн газар хуулиар цалингийн хоригийг ногдуулсан юм. Хуулийн дагуу энэхүү арга хэмжээг эсэргүүцэж хүчтэй бослого хөдөлгөөнийг хөдөлмөрийн холбоод зохион байгуулж байлаа. Гэсэн ч ямар ч үр дүнд хүрээгүй л дээ. Харин хариуд нь нийгмээрээ догширч, таагүй уур амьсгал зонхилох болсон юм. Гарц гэдэг нь ч хүрэхэд асар хол санагдаж байсан үе. Засгийн газар 1982 оны эцсээр цалин хөлс, нийгмийн халамжийн хэмжээг царцааж, хөдөлгөөнгүй барих бодлогоо үргэлжлүүлэхийн тулд дараагийн шатны хуулийн арга хэмжээгээ зарласан юм. Үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгчийн хувьд би Ажил олгогчдын холбоотой шууд хэлэлцээр хийхийг санал болгосон. Нэг талаас цалинг барих бодлогыг үргэлжлүүлэхэд сайн дураараа хүлээцтэй хандаж, нөгөө талаас ажлын цагийг багасгаж, залуус болон ажилгүй иргэдийг ажиллуулах, тэдэнд боломж өгөх урт хугацааны тохиролцоог хоёр талаас хийхийг хүссэн юм. Тус гэрээний тохиролцоонууд нь үйлдвэрчний эвлэл болон ажилчдын хувьд сайшааж хүлээж авахаар дөхөм байгаагүй. Богино хугацаанд өндөр үнэ төлж, худалдан авах чадвараа алдах ч хариуд нь урт хугацааны өндөр үр ашиг, ажилгүй иргэд ажилтай болохоор байсан юм. Тэр үед бидэнд итгэж, эерэг үр дүн хүлээхээс өөр арга байгаагүй. Ард иргэд намайг яагаад дэмжсэн бэ гэвэл эдийн засаг болон нийгмийн нөхцөл байдал өдөр ирэх тусам дордож байсан учир юу ч хийхгүй байх нь сонголт биш байсан.

Олон жилийн дараа гэрээ аажмаар үр дүнгээ өгч байгаа нь хүмүүст тодорхой мэдрэгдэж эхэлсэн. Ажлын байр нэмэгдэж, бодит орлого өсөхийн хажуугаар өртөг өндөртэй ч гаднын хүчин зүйлд өртөмтгий бус нийгмийн байгууллаа хадгалсаар байсан юм. Нийгэмд амгалан тайван байдал тогтож, ажилчид илүү урам зориг дүүрэн урагшилж эхэлснээр компаниудын ашиг орлого нэмэгдэж, өрсөлдөх чадвар өсөх болсон юм. Хэдийгээр 1990-ээд оны дунд үе хүртэл энэ үйл явц үргэлжилсэн ч эцэст нь манай улсын эдийн засаг бүхэлдээ Голланд өвчнөөс илааршиж, Европ амжилт “Polder model” хэмээн алдаршсан юм. Энэ загвар нь төсөв сангийн консерватив үзэл баримтлал дээр суурилан валют болон цалингийн хязгаарлалтыг зохицуулж, шаардлагатай нэгнийг өндөр түвшний нийгмийн хамгаалалд багтаахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлийг хийж чадсан үйл явц юм.

Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байсан эхэн үе буюу 1995 онд манай улс “Flex security” хэмээх хувьсгалын шинжтэй бодлогыг хөдөлмөрийн зах зээлдээ танилцуулж,

нийгмийн аюулгүй байдал, уян хатан чанарыг тэнцүүлэхийг зорьсон юм. Хөдөлмөрийн зах зээлийн оролцоо, ажил эрхлэлтийн түвшний хувьд Европын тэргүүлэх орнуудын нэг болоход энэ л хамгийн их хувь нэмэр оруулсан. Гэвч ажил олгогч, хөдөлмөр эрхлэгч гэсэн үйлдвэрлэлийн салбарын тулгуур талуудын идэвхтэй оролцоо байгаа нөхцөлд л дээрх амжилт боломжтой гэдгийг дахин хэлье.

Миний хувьд Нидерландын энэхүү түүх нь Монголтой зарим талаараа холбоотой санагдаж байна. Нэн тэргүүнд танай улсын хувьд Нидерланд гэгч улсын хэдэн арван жилийн өмнө амссан өвчнөөс зайлсхийх нь хэчнээн чухал болохыг манай улсын түүх гэрчлэн харуулна. Эдийн засаг уул уурхайгаас дэндүү их хамааралтай. Орлогынхоо дийлэнх хувийг үр ашиг багатай чиглэлд зарцуулсан Нидерландын алдааг битгий давтаарай гэж чин сэтгэлээсээ зөвлөж байна.

Хэрвээ би зөв ойлгосон бол, танай улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд гурван чухал зүйлийг тусгасан юм билээ. Өр, зарлага, төсвийн алдагдлыг тодорхой хэмжээнд зааж өгсөн дээд хэмжээ, хязгаарлалт. Дээрх гурав нь Голланд өвчинд нэрвэгдэх эрсдэлийг хязгаарлах хүчтэй. Монгол Улсыг өвчлөхөөс сэргийлэх энэ санаачлагыг гаргасан тэдгээр хүнд тусгайлан баяр хүргье.

Гэвч өрсөлдөх чадвар бүхий, төрөлжсөн хүчирхэг эдийн засгийн суурийг бий болгохын тулд ихийг хийх хэрэгтэй нь мэдээж. Монголчуудад сайхан амьдрах өнөөдөр, маргаашийн боломжийг нээж өгөх гэж байгаа бол одоогийн эдийн засгийн шилжилт бүгдийг хамарсан эрх тэгш, тогтвортой байгаа эсэхэд хяналттай ажилла.

Хоёрт, Өвчнийхөө хамгийн зовиуртай хэсгийг авч, ардаа орхиж чадсан Нидерланд улсын арга барил Монголд хамааралтай.

Макро эдийн засгийн өсөлт гэдэг зүгээр гайхуулах тоо бус ард түмний аз жаргал, амьжиргаа хэрхэн өсч, хүмүүс үнэлж, хүсч буй зүйлдээ хүрч чадаж буй эсэхийг илтгэх чухал үзүүлэлт юм. Ийм л учраас эдийн засгийн өсөлтийг нийгмийн оролцоо, халамжийн бодлого, нийгэм хамгаалалтай хамтатгах нь амин чухал юм.

Дэлхий нийтээрээ илүү ихийг хийж, хичээх ёстой цаг үед орж байна. Оюун санааны шилжилт бидэнд хэрэгтэй. Үйлдвэрлэх, хэрэглэх, амьдрах шинэ хэв маягийг сонгох шийдлийн нэг хэсэг нь байгаль орчны тогтвортой байдал байх ёстой. Миний амьдралаараа сурсан чухал хичээлүүдийн нэг нь бүх хувьцаа эзэмшигчид нийтлэг эрх ашгийг хөндсөн нэг зорилгын төлөө бодож, хөдөлж чаддаг нийгэмтэй улс орон л хамгийн амжилттай, эв нэгдэлтэй байдгийг ойлгосон явдал юм. Энэ нь нийгэм болоод экологийн талын өргөн хүрээний оролцоог хамтын ажиллагааны нэг хэсэг болгох замаар шударга ашгийн хуваарлалт хийнэ гэсэн үг. Байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн оролцоо хоёул сайхан амьдралыг цогцлоох салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд. Эдийн засгийн өсөлт, нийгмийн уялдаа холбоо, орчны тогтвортой байдлын хоорондын тэнцвэрийг зөв олох, хадгалах гол хариуцлагыг Засгийн газар үүрэх учиртай. Энэ бол хэзээ ч амар байгаагүй бөгөөд хойшид ч тийм байхгүй.

Аливаа улсын Засгийн газрын хувьд мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийг байгуулна гэдэг тэргүүний үүрэг. Боловсрол, судалгаа, шинэ санаачилгын гурвалжин бол эдийн засгийг төрөлжүүлж, бүтээмжийг дээшлүүлэх улмаар иргэдээ сайхан амьдруулах түлхүүр юм. Дэлхийн түвшинд амжилт гаргах, олон улсад өрсөлдөх чадвартай иргэдтэй болох гарцыг нээхэд тэргүүн ач холбогдол өгч, хөрөнгө оруулах нь Засгийн газруудын хийх ёстой ажил. Улсаас компани, их сургууль, судалгааны байгууллагуудын хоорондох төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж болно. Боловсролын салбарт хуваарилсан төсөв мэдээж томоохон үүрэг гүйцэтгэх ч энэ бол зөвхөн мөнгөөр шийдэгддэг асуудал биш.

Засгийн газар мөнгө өгөхөөс илүүг хийх хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд Засгийн газар хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Энэ бол тааварлаж болохуйц, ил тод сангийн бодлого, чанга гэрээ түүнчлэн эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах ба авлигын эсрэг сайн засаглал гэсэн үг. Энэ Монголд ч хамаатай. Танай улсын нөхцөл байдалд дэд бүтцийн сайн төслүүдэд хөрөнгө оруулах, үйлдвэрлэлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, сайн санхүүгийн салбартай байх мөн уул уурхайн салбарыг зөв зохицуулсан хуультай байх шаардлагатай байна. Уул уурхайн салбарын хуулиндаа байгаль орчны болон хүмүүсийн ахуй амьдрал дахь нөлөөллийг сайн тусгаж өгөх нь зүйтэй. Ингэснээр монголчуудад уул уурхайн ашиг, нөлөөлөл ил тод болж ирэх юм.

Хэрэв засаглалын зүгээс зөв хуулийн орчинг бүрдүүлж чадвал хувийн хэвшлийнхэн улсынхаа хөгжлийг дэмжих гол хүч байж чадна. Эхний ээлжинд компаниуд гадаадын шууд хөрөнгө оруулалт болоод технологийг авчирдаг. Туршлагаас үзэхэд нээлттэй хаалга бүхий бодлоготой орнууд гадаадын хөрөнгө оруулалтыг илүү татахын зэрэгцээ компаниуд нь ч гадаад түншлэлээ амархан өргөжүүлж чаддаг.

Байгаль орчны тогтвортой байдлын тухайд Засгийн газар компаниудад хөнгөлөлт урамшуулал үзүүлж, өртөг багатай цэвэр технологиор үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Засгийн газар байгаль орчны стандарт тогтоож, хувийн хэвшлийнхнийг зөв зүгт залах гол хүч нь.

Монгол яг одоо зөв зам дээр байна. Харин одоо унтах нойроо хугаслан шургуу хөдөлмөрлөх цаг чинь ирлээ. Энэ бол хамгийн хэцүү үе. Боломжоос зуурахын зэрэгцээ эрсдэлийг нь үнэлнэ гэдэг хамгийн чухал. Дэлхийн эдийн засаг болон хөрш гүрний эдийн засгийн болзошгүй удаашралаас үүдэлтэй эрсдэлүүдийг хэрхэн давахаа сайн тооцоол. Танай улсын эдийн засагт би гурван бодлогын хүчин зүйлд онцгой анхаарал тавихыг зөвлөж байна. Нэгт, Уул уурхайн салбараар удирдуулсан эдийн засгийн чадамжаа хэрхэн ил тод, тогтвортойгоор хөгжүүлж болох. Хоёрт, Эдийн засгийн өсөлтөө хэрхэн төрөлжсөн суурь салбаруудаар чадавхжуулж, хотын болон орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих. Гуравт, үйлчилгээний салбар, боловсрол, эрүүл мэндийн салбарын хамрах хүртээмжийг хэрхэн дээшлүүлж, ядуурлыг багасгах вэ гэдэг юм. Монгол Улс дээрх гурван сорилтод маш шийдэмгий хандах хэрэгтэй. Байгалийн баялгаа нээж, ашиглана гэдэг улсын хувьд асар их хөрөнгө. Бусдын туршлагаас суралцана гэдэг болзошгүй эрсдэлээ хязгаарлаж, хишгийг нь иргэддээ эн тэнцүү хүртээх боломжийг бүрдүүлэх сонголт юм. Энэ бол сорилт. ■

2013 оны 04 сар.



Д.Содном



Ш.Гунгаадорж



Д.Бямбасүрэн

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

# Төрийн бодлого дахь бизнесийн санаархал байдлыг бүр дордуулж байна

*“Mongolian Econoty” сэтгүүл Монголын эдийн засгийн хөгжлийн түүхийг хэвлэлийн хуудаснаа буулгаж яваа мэргэжлийн сэтгүүлийн хувьд Монгол Улсын нэгэн үеийн хөгжлийг жолоодоход өөрсдийн хөдөлмөр, тэмцлээ зориулсан Ерөнхий сайд асан эрхэм гурван хүнийг редакцидаа урьж, уулзалт зохион байгууллаа. Тэд бол Думаагийн Содном/1984.12.12-1990.3.21/, Шаравын Гунгаадорж /1990.3.21-1990.9.11/, Дашийн Бямбасүрэн /1990.9.11-1992.7.21/ нар.*

*Ерөнхий сайдын өндөр албан тушаалыг нэгнээсээ ээлжлэн хүлээн авч байсан түүхтэй энэ эрхмүүд өнөө болтол нэг дор гурвуулаа зэрэгцэж суугаад ярилцлага өгч байсан түүхгүй билээ. Тиймээс манай сэтгүүл эдийн засгийн өнөөгийн байдал, улсын хөгжлийн талаарх тэдний санаа бодлыг нэгэн зэрэг сонсож дуулгах, мөн сэтгүүл болон “Econoty” ТВ студидээ он цагийн уртад улам бүр үнэ цэнэтэй болдог баримт, үйл явдлыг үлдээх зорилгоор ийнхүү редакцийн уулзалт хийлээ.*

**-Өнгөрсөн оны гол тоон үзүүлэлт дээр үндэслэн Д.Жаргалсайхан нийтлэлч “Нинжа эдийн засаг” гэж тодорхойлсон байна. Ингэж тодорхойлох болсон шалтгаан нь монголчууд уул уурхайгаа ухдаг, архи, тамхины үйлдвэрлэлээс татварын ихэнх хэсгийг бүрдүүлдэгтэй холбон тайлбарласан байсан. Энэ байдлыг өөрчлөхийн тулд юу хийх ёстой вэ?**

**Д.Содном:** Монголчуудын хувьд анхаарал хандуулахаас аргагүй эдийн засгийн чухал салбар бол уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал юм. Мөн технологийн салбарыг орхигдуулж болохгүй. Цаашдаа энэ дөрвөн замаар л явж таарна. Тиймээс уул уурхайгаа яаж зөв хөгжүүлэх вэ, хөрөнгө оруулагчидтай хэрхэн харьцах вэ, тэднийг аль талаар нь дэмжих вэ, аль зүйл дээр нь хяналт тавих вэ гэдэгт төрийн зөв бодлого чухал. Үүнтэй холбоотой Ерөнхийлөгчийн санаачилсан “Ухаалаг төр” гэх санаачилгыг улам сайжруулж, авч явах учиртай. Ингэж чадвал манай эдийн засаг зөв хөгжнө.

**Ш.Гунгаадорж:** Уул уурхай, эрчим хүчгүйгээр улс орныхоо хөгжлийг бий болгоход хэцүү. Тийм ч учраас сүүлийн 10 гаруй жил энэ талаар ярьсан. Уул уурхай тэргүүлэх салбар мөн боловч угсруулаад дагалдах бусад бие даасан томоохон салбарын хөгжлийг дэмжих хэрэгтэй. Тэр дундаа хөдөө аж ахуйг дэмжих цаг болсон. Ер нь хөдөөгийн хөгжилгүйгээр Монгол Улсыг төсөөлөхөд бэрх шүү дээ. Хэрвээ хөдөө, орон нутаг хөгжөөгүй бол манай улс хөгжиж байна гэж хэлэх үндэслэл муутай. Энэ утгаар нь харвал манай төр засаг, хөдөө орон нутгийн хөгжилд тун муу анхаарсан. Манайх хот улс болчих гээд байна. Монгол Улсыг өмнө нь ч одоо ч малгүйгээр, хөдөөгүйгээр төсөөлж байгаагүй. Энэ нь ч учиртай. Тиймээс өнөөгийн төр, засаг уул уурхайгаас гадна хөдөөгийн хөгжлийн талаар ярих, хийх цаг нь болсон. Мал, газар хоёр бол монголчуудын ширгэшгүй баялаг юм. Уул уурхайн шавхагдах баялгаас олсон орлогыг юунд зарцуулах тал дээр ухаан жаахан дутаад байна уу даа.

**Д.Бямбасүрэн:** Монголын эдийн засгийг маш хүнд өвчтэй бараг хэвтрийн эдийн засаг гэж хэлж болно. Нэг хэсэг Голлонд өвчин гэж ярьдаг байсан. Гэтэл ярьсаар байгаад л түүн рүү яваад орчихлоо. Тэжээлгэн тэтгүүлэх, бэлэнчлэх сэтгэхүй Монголд давамгайлж байна. Уг нь хөгжинө гэдгийг өөрсдөө баялаг бүтээх гэж ойлгож болно. Гэтэл сүүлийн үед байгаа баялгаа ухаж аваад, үрэн таран хийчихээд сайхан амьдарч байна гэх хандлага их боллоо. Уул уурхайн баялаг бол бидний бүтээсэн бус өвөг дээдсээс уламжилж ирсэн. Түүнийг нь бид зохистой түвшинд ашиглаж байгаад ирээдүй хойчдоо үлдээх учиртай. Гэтэл өнөөдөр баруун солгойгүй цацаад л байна. Энэ талаас нь харвал манай эдийн засаг хүнд өвчтэй байгаа.

**-Та монгол төрийн бодлогод томоохон хэлбийлт гарлаа гэсэн байсан. Түүнийгээ жаахан тодруулахгүй юу?**

-Гурван зүйлийг дурдахгүй бол болохгүй нь. Нэгдүгээрт, монголчуудын дунд өр зээлээр баяжина гэдэг ойлголт газар авч байна. Энэ бол ирээдүйнхээ амьдралыг өнөөдөр барьцаанд тавьчихаад сайн сайхан амьдарна гэдэг итгэмээргүй төрийн бодлого. Хоёрдугаарт, хямралыг далимдуулж Хөрөнгө оруулалтын тухай хууль гэж шинээр гаргалаа. Ерөнхийд нь бодоход хөрөнгө оруулагчдыг татахад болохгүй зүйлгүй. Гэтэл энэ нь өөрөө гурван том сөрөг үр дагаварыг дагуулж байна. Эхнийх нь манай эдийн засгийн орон зай задарчихлаа.

Хуулиар хамгаалагдсан тогтвортой нөхцөлийн чинээлэг хэсэг. Хажууд нь чадан ядан явж байгаа аж ахуйн нэгж гээд дотор нь хуваачихлаа. Мөн тус хуулийн 12.1.1-д зааснаар... “Гадаадын хөрөнгө оруулагчдад Монголын газрыг 60 жилээр эзэмшүүлнэ. 40 жилээр сунгана” гээд заачихсан. Энэ чинь манай улс газар нутгаа худалдаж амьдрах зам руу орлоо гэсэн үг. Энэ бол сэтгэл хиртхийлгэм мэдээ юм. Түүнчлэн Оюутолгой гэж нэг том асуудал байна. Оюутолгойн гэрээнд зааснаар ашгаа гадагш нь зөөж байгаа гадаадын хөрөнгө оруулагчид өмнөх хуулиар 20 хувийн шимтгэл төлөхөөр байсан. Гэтэл саяын шинэ хуулиар гадаадын хөрөнгө оруулагч ашгаа гадагш нь зөөх нь чөлөөтэй гээд заачихлаа. Ингээд манай эдийн засгийн эрх зүйн асуудал орвонгоороо эргэж жолоодоход тун бэрхтэй боллоо.

Гурав дахь асуудал нь намрын чуулганаар алтны татварыг бууруулах тухай асуудал яригдаж байна. Богд хаант улсын Засгийн газрын үеэс л эрдэс баялгийн татвартай байсан. Алтнаас 16 хувийн татвар авдаг байлаа. Гэтэл манайхан 2.5 болгоно гээд байгаа. Товчхондоо хэн дуртай нь ирээд Монголын баялгийг ухаад аваад яв л гээд байх шиг байна. Ийм өр зээл тавьж, эдийн засгаа жолоодох чадваргүй болж, өөрийн өв баялгийг үнэгүйдүүлэх нь сүүлийн 20 гаруй жилд Монголд орж ирсэн эдийн засгийн алуурчдын номлол юм. Үүнийг нь харвал өнөөгийн Монголын эдийн засгийг “Hitman”-ий эдийн засаг гэж хэлж болно. Ийм л гажуудал руу бид явж байна. Үүнийгээ засах ухаан, тэнхээ байгаа үгүйг мэдэхгүй. Уул уурхай бол анхны хуримтлал үүсгэх салбар учраас бид түших ёстой. Гэхдээ хүнсээ бэлдэж чадахгүй байж бид хөгжиж байна гэж яриад яах вэ дээ.

**-Монгол Улс Чингис бондоо зарцуулж байгаа. Самурай бонд гаргалаа. Тиймээс энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байна вэ?**

**Д.Содном:** Гол учир нь тэр мөнгийг хэрхэн ашиглах вэ гэдэгт л байгаа юм. Түүнээс биш, бонд гаргах нь буруу биш. Харин тэр бондын мөнгийг буруу ашиглавал ирээдүй хойчдоо гай болно.Тиймээс энэ мөнгийг хариуцаж байгаа Засгийн газар, УИХ-ын гишүүн, яам тамгын газрын ажилчид хоноцын маягийн сэтгэлгээтэй байж таарахгүй. Өөрийнхөө мөнгө шиг сэтгэлээр төлөвлөж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй. Үүн дээр л сэтгэл дутаад байна. Жишээ нь миний бие Чингис бондын мөнгийг үр ашиггүй зүйлд хөрөнгө оруулж байхаар Тавантолгойд хөрөнгө дутаад байгаа юм бол тэнд хөрөнгө оруулж болохгүй юм уу гэж саналаа хэлж л байлаа. Бүр болохгүй бол Оюутолгойд тийм их зээлийн өртэй суухын оронд зээлээ эртхэн төлж ч болох л байсан. Гэхдээ одооноос төр үр ашигтай төслийн эрэлд гарлаа. Эндээс харахад зөв зам руугаа явж байгаа юм болов уу даа. Гэхдээ энэ богинохон хугацаанд шинээр төсөл боловсруулна гэдэг хэцүү. Тиймээс шинээр төсөл боловсруулах биш, нэгэнт боловсруулчихсан бүр болдог бол хэрэгжээд эхэлсэн тийм төсөлд бондын мөнгийг өгөх хэрэгтэй. Би “Монголын алт” компанид ажиллаж байгаа. Тэнд хоёр ч том төсөл хэрэгжээд явж байна. Тухайлбал, нэг сая тонн цемент үйлдвэрлэх төслийн ТЭЗҮ бэлэн. Одоогоор тоног төхөөрөмжийн суурилуулалт бэлэн болчихсон. Барилгын ажил нь эхэлчихсэн. Энэ оны сүүл гэхэд ашиглалтад орохоор байгаа. Тиймээс ийм үндэсний компанийн томоохон төсөлд хөрөнгө оруулж болдоггүй юм уу. Ийм төсөл чинь бондын өрийг маш түргэн төлөх боломжийг бүрдүүлнэ. Ер нь бонд гаргаж байгаа бол дотоодын бизнесийн сайн компани Монголын төр хоёр харилцан уялдаатай л ажиллах хэрэгтэй.

**Ш.Гунгаадорж:** Монголчууд бондыг хэрхэн чулуу болгох ухаанаа олоогүй л байна. Хэрвээ байдал энэ чигээрээ яваад байвал хэдэн үеэрээ өртэй явах болно. Сая гэнэт ухаан оров уу гэлтэй импортыг орлох төсөл хайж эхэллээ. Одоо Чингис бондоос үлдсэн мөнгийг үр ашгаа түргэн өгөх төсөлд зарцуулах ёстой. Тэгэх байх гэж найдаж байна. Нөгөө талдаа Самурай бондын талаар их сайн судлахгүй бол горьгүй. Яагаад дэлхийн улс орнууд Самурай бондыг сонирхохгүй байна вэ. Франц нэг удаа орсон юм гэсэн. Тэгээд төдөлгүй больчихсон байдаг. Тиймээс Самурай бонд аваад, хавханд орчихож магадгүй гэдгийг анхааралтай. Хэрвээ судлаад бондоо авахаар болж байгаа бол аль болох дотоодын үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй. Монголд байгаа бэлэн зүйл бол бэлчээрийн мал аж ахуй. Энэ нь нэг ёсондоо мах үйлдвэрлэл гэсэн үг.

Ер нь хараад байхад өнөөгийн төр, засагт улс орноо хэрхэн хөгжүүлэх талаар дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө алга. Тийм болохоор нэг л төөрсөн бодлоготой хүмүүс яваад байна. Тиймгүйсэн бол өдийд уул уурхайгаа хэрхэн хөгжүүлэх, аль салбараа илүү дэмжих, бондын мөнгөө хаана зарцуулах вэ гээд бүх асуултын хариу гарчихсан байх учиртай. Гэтэл тэмтрүүлийн маягтай дайралдсаныг нь аваад л яваад байх шиг.

## Д.Бямбасүрэн: Нефтийн жижиг үйлдвэр яагаад барьж болдоггүй юм бол

**Д.Бямбасүрэн:** Энэ бол их ноцтой асуудал. Шуудхан хэлэхэд бондын асуудалд өнөөгийн төр маш хариуцлагагүй хандлаа. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монголд хийж байгаа хөрөнгө оруулалтыг судалж үзэхэд нэмэгдсэн өртгөөрөө таван жилийн хугацаанд, ашгаар нь тооцвол 12 жилд нөхөгдөх тийм л хөрөнгө оруулалтыг хийж байгаа. Энэ бол маш муу хөрөнгө оруулалт гэж хэлж болно. Ийм нөхцөлд импортыг орлох валютын зардлыг хэмнэх чиглэлд бондын мөнгийг зарцуулах хэрэгтэй байсан юм. Тэр дундаа металлургийн үйлдвэрийг дэмжих. Мөн цемент, мах боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан бол хэдэн жилийн дараагаас валютын орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг багасгах эерэг нөлөөтэй байсан. Гэтэл одоогийн хөрөнгө оруулалтыг харахад бизнесийн чиглэлд хөрөнгө оруулаад байна. Энэ бол маш үр ашиггүй зарцуулалт. Мөн нөгөө талдаа төгрөгийн ханшийг тэтгэх, интервенц хийхэд ашиглаж байна. Самурай бонд ороод ирэхээр ам.долларын ханш суларна гээд л шуугиад байх юм. Ингэж зарцуулах нь бас л үр ашиггүй. Хэрвээ байдал цаашдаа ингэж явбал маш том хариуцлагын асуудал босч ирнэ.

**-Сүүлийн үед шатахуун болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах тал дээр Засгийн газар, Монголбанк хамтран ажиллаж байна. Энэ хэр үр дүнтэй арга хэмжээ вэ?**

**Д.Бямбасүрэн:** -Нефть урагшаа гаргаж байхаар яагаад өөрсдөө үйлдвэр барихгүй байгаа юм бэ. Нэг сонин юм яриад байна. 2015 онд нэг сая тонн нефть олборлох үйлдвэр барина гэж. Гэтэл өнгөрсөн жил 1.5 сая тонн нефть гадагш нь гаргалаа. 300 мянган тонныг олборлосон ч

PC mall
АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

DELL
The power to do more





OptiPlex 3020 Micro

Windows 8.1

Intel® Core™ i3-4150T 3.0GHz
1600MHz DDR3
4GB RAM
500GB
DisplayPort and VGA, 6 USB
7.25" x 7" x 1.3"
1.36 kg
Wi Fi

## ОФФИСЫН ТӨГС ЗОХИЦОЛ







7575-3735

Онлайн худалдаа:
www.pc-mall.mn

Join us on Facebook
http://www.facebook.com/PCmallOfficial

гэсэн жижиг үйлдвэр яагаад барьж болдоггүй юм бэ. Яагаад нефтийн үйлдвэрээ Дарханд барих ёстой юм бэ. Дорнодоос олборлож байгаа шүү дээ. Сонин байгаа биз. Эндээс юу гэж дүгнэж болох вэ гэхээр улс төрийн бодлогод бизнесийн ашиг сонирхол хутгалдаад байгаа хэрэг юм. Ер нь төрийн бодлогод байгаа бизнесийн санаархал хүндрэл дээр хүндрэл, ядуурал дээр ядуурал нэмж байна. Дэлхий дээр эдийн засаг нь 10 гаруй хувиар өсч байхад ядуурал буурахгүй байгаа нь их ховор тохиолдол. Манайд л ийм дүр зураг байна.

**Д.Содном:** Бидний яриаг сонсож байгаа хүмүүс бодож магадгүй. Энэ гурав баахан л шүүмжлээд байх юм. Гарах гарцыг нь зааж өгсөнгүй гэж. Би яригдсан зүйлүүд дээр хэдэн гарц хэлье. Цэвэр агаарт өөрийн дураар явж, байгалиасаа хоол хүнсээ өөрөө олж иддэг бэлчээрийн монгол малын мах бол аз жаргалтай малын мах. Эмчилгээний ч чанартай. Ингэж үнэлэгдэж байгаа махыг экспортод гаргах хэрэгтэй биз дээ. Үүний тулд ганц л асуудал шийдэхэд болно. Бүх аймагт мал нядлах, мах боловсруулах олон улсын стандартад нийцсэн үйлдвэр байгуулах шаардлагатай. Мөн малчдаас малыг зах зээлийн дундаж ханшаар тухайн үйлдвэрт авдаг зохицуулалт байх учиртай. Ингэж чадвал малчид мөнгөжинө. Ажлын байр нэмэгдэнэ. Нөгөө талаар жилдээ 10-12 сая толгойгоор нядалж байгаа малын арьс, ширийг боловсруулж болно. Нэг үхрийн ширнээс хамгийн багадаа сайн чанарын 20 тэлээ гарна. Гаднын нөлөөллөөс гарах гээд байгаа л юм бол боловсруулах үйлдвэртэй болох учиртай. Газрын тосны хайгуулыг сайжруулмаар байна. Газрын тосны газар гэж бий. Тэр байгууллага бол газрын тос хайхад биш, газрын тос хайж байгаа нэгэндээ төлбөрийн болон бусад төрлийн дарамт үзүүлдэг газар болчихсон байна. Тухайлбал, гэрээ байгуулахад 300-500 мянган ам.доллар нэхдэг. Байцаагч ажилласны зардлыг ч бас төлүүлнэ гээд бод доо. Цаашлаад газрын тосны мэргэжилтэн бэлтгэсний төлбөр гэж авна. Ямар нь мэдэгдэхгүй баахан татаас авдаг газар нэг бий. Гэтэл тэр татаас нь хуулинд байдаггүй. Товчхондоо энэ салбарт буруу харсан бодлого яваад байгаа юм. Үүнийхээ оронд олсон ашгаа хэрхэн хуваах вэ гэдгээ л тохирох хэрэгтэй баймаар. Түүнчлэн нүүрснээс метан хий, шатахуун боловсруулан гаргаж авах тал дээр анхаарах цаг болсон байх. Ийм гурван зүйлийг төрөөс хараад, дэмжиж чадвал эхний ээлжинд болчих гээд байгаа юм.

**-Оюутолгой болон Тавантолгойн эдийн засгийн хувь заяа хэрхэн эргэнэ гэж хардаг вэ?**

**Д.Содном:** Оюутолгойн хувьд Монголын тал авах ёстой ашгаа олж чадахгүй юм биш үү гэх хардлага байгаа, магадгүй. Анх гэрээ байгуулахад урдчилсан ТЭЗҮ-ээр манайд гурван замаар Оюутолгойгоос олох ашгийн 50-53 хувь нь орж ирэхээр байсан.Тэр нь байгалийн нөөц ашигласны таван хувь. Нийт ашгийнх нь 25 хувиар орж ирэх ёстой татвар. 34 хувийн ногдол ашиг гурав нэгдээд борлуулалтын орлогоос өртгийг нь хассан нийт ашгаас нь монголчууд дээрх хэмжээний ашиг хүртэхээр гэрээ хийгдсэн. Гэрээ хийснээс хойш хувь нийлүүлэгчдийн нууц гэрээнээс одоо харахад байдал жаахан хүндэн болчихоод байна. Цаашдаа ч ийм хандлага тасрахгүй байх аа. Явсаар байгаад сүүлдээ монголчуудад нөөц ашигласны таван хувь л орж ирэх болчих шиг. Ногдол ашиг болон нийт ашгийнх нь татвар бүрхэг болчихсон. Тэгэхээр яах вэ гэдэг байна. Гэрээ хийж байх үеийн ТЭЗҮ-ийн дагуу борлуулалтын орлогод нөгөө гурван татварын ногдох хэмжээг нийлүүлж тооцох. Мөн борлуулалтын орлогоос нийт ашгийн 53 хувь нь хэд байх ёстой юм бэ гэдгээ тогтоочих хэрэгтэй. Ингэчихвэл хөрөнгө оруулалт яаж хийх вэ энээ тэрээ гэсэн бүх асуудал шийдэгдчихнэ. Зүгээр л борлуулалтын орлогоос авах ашгаа л тодорхой болгочих.

**-Тавантолгойн хувьд?**

Тавантолгойн хувьд хоёр хөрш болон гуравдагч орны төлөөллийг хөрөнгө оруулагчаар сонгох хэрэгтэй. Тухайлбал, Орос, Хятад, Япон гэсэн гурван оронтой тус бүрт нь 16 хувиар хөрөнгө оруулалтыг нь шийдэх нь зөв. Энэ нь нийт дүнгээрээ 48 хувь болно. 52 хувь нь Монголынх гэсэн үг. Үүний цаад учир нь нэгэнт хоёр хөрш маань тодорхой хувийг эзэмшиж байгаа учраас тээвэрлэлтийн болон борлуулалтын үнэ нь ямар байх тал дээр тэд бодно. Зардал чирэгдэл, тээврийн зардалд хүссэн хүсээгүй анхаарч эхэлнэ.

## Ш.Гунгаадорж: Тэр 34 хувиас татгалзчихвал яадаг юм бэ

**Ш.Гунгаадорж:** Оюутолгой нэлээд төвөгтэй болчихлоо. Эхэндээ ойлгомжтой байж байснаа явцын дунд ойлгомжгүй зүйл олон гарчих шиг. Ер нь цаашдаа Оюутолгойн асуудлыг хүндрүүлээд байвал бидэнд л ашиггүй. Тиймээс аль болох гаднын хөрөнгө оруулагч болон манай улсын ашиг сонирхол хаанаа огтлолцох вэ гэдэгт эртхэн тохиролцох нь чухал. Миний бодлоор тэр 34 хувь гэдгээс татгалзчихвал яадаг юм бэ. Энэ бол миний л бодол шүү дээ. Ямар ч байсан Оюутолгойг бид орхиж болохгүй. Тавантолгойн хувьд бол гадаад дотоод олон хүчин зүйл бий. Тиймээс Содном даргын хэлсэн саналыг бас бодолцох хэрэгтэй. Хувь эзэмшүүлэхдээ нэг хувийн ч зөрүү гаргаж болохгүй тэгвэл байдал дордоно.

**Д.Бямбасүрэн: -**Хоёр толгойн хувьд олон зүйлийн тусгал гэж хэлж болно. 2005 оноос хойш л Оюутолгойг ярьсан. Гэтэл Монголын төр өөрийнхөө баялагт эзний ёсоор хандаж чадаагүй. Оюутолгойн өөрсдийнх нь интернетэд тавьсан мэдээллээс би хэд хэдэн тооцоо хийж үзлээ. Хэрвээ одоогийн ярьж байгаагаар бол баялгаа гаднынханд зүгээр өгөөд хариуд нь өртэй л үлдэнэ. Баялгаа хүнд өгчихөөд өөрөө өртэй үлдэхээр гэрээ хийдэг төр өнөөх ухаалгийн чинь эсрэг болчихоод байгаа биз дээ. Миний бодлоор Оюутолгойд ашиг сонирхлын зөрчил, шуналын бүх төрлийн нян цугласан болохоор ийм байдал үүссэн. Хэрвээ энэ гэрээг сайжруулах гэвэл Гунгаадорж гуайн эсвэл Содном гуайн хэлсэн аль аль саналаар нь явж болох л байсан. Товчхондоо асуудал хүнд байгаа. Цаашдаа ч хүндрэх төлөвтэй. Манайхан хэлэлцээрийн ширээний ард суучихсан. Тиймээс одоо Монголын тал худлаа дүнгэнэхээ болиод ярьж эхлэх хэрэгтэй.

Тавантолгой бол нүүрсний л уурхай шүү дээ. Монголчуудын хувьд ил, далд уурхайн аль алийг



нь ашиглах боловсон хүчинтэй. Хөрөнгө мөнгөний л асуудал байсан. Боломж ч их байсан. Бондын мөнгөө хийж болох байлаа. Эсвэл түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр гэрээ хийгээд ашиглаж болох байсан. Гэтэл манай эрх мэдэлтнүүд хэд хэд хуваагаад бизнесийн хэрүүл болгож хувиргасан. Тиймээс Тавантолгойг нийгэм, дэд бүтэц гээд бүх талаас нь авч үзэх хэрэгтэй. Нэг л нүүрсний уурхай байх учиртай. Гэтэл одоо юу ю ч болгочихов. Анхнаас нь хоосон найдвар төрүүлж баахан бэлэн мөнгө, хувьцаа тараагаад. Ийм байдлаасаа эрх биш сургамж авсан байх гэж найдаж байна.

**-Монгол Улсын Ерөнхийлөгч “Том төрөөс ухаалаг төр лүү” гэсэн уриалга гаргаж, тодорхой ажлуудыг хийж эхэллээ. Энэ ажлыг та бүхэн хэрхэн харж, дүгнэж байна вэ?**

**Д.Бямбасүрэн:** -Энэ санаачилга монголчуудын хувь заяаг шийдэх ч зүйл байхыг үгүйсгэхгүй. Ухаалаг төр гэвэл ярихаар одоо ухаалаг биш байгаа юм уу гэсэн асуулт заавал дагалдаад байдаг юм. Миний бодоход төр холч бодлоготой байх ёстой. Бидэнд өнөөдөр хамгийн их үгүйлэгдэж байгаа зүйл нь энэ. Төр бол улс орны амьдралын зохицуулалтын төв нь юм. Гэтэл энэ төв хэрхэн зохицуулахаа мэдэхгүй бол хэцүүднэ шүү дээ. Үүнийг бид сүүлийн таван жилд гарсан эдийн засгийн хоёр удаагийн хямралаас харж болно. Төр шударга байвал ард түмэн төрдөө итгэнэ. Иргэд төрдөө итгэвэл бодлогын хүч нэмэгдэх учиртай. Би бичил судалгаа хийж үзлээ. Монголын насанд хүрсэн хүмүүсээс жилд 20 гаруй мянган хүн мөрдөн байцаалтад сэжиглэгдэж очдог юм байна. Үүнийг УИХ, Засгийн газрын гишүүдийн тоотой харьцуулахад маш сонин тоо гарна. Өөрөөр хэлбэл, нэг жилд хэрэгт сэжиглэгдэж байгаа улс төрийн удирдах албан тушаалтны тоо энгийн иргэдийнхээс 30 дахин их байна. Тэгэхээр бид хэнийг сонгочихоод байна вэ. Би мөнгөтэй хүн гээд улс төрийн намд хандив өгөөд УИХ-ын гишүүн болчихдог. Энэ тогтолцоог өөрчлөх ёстой. Өөрчлөхгүйгээр цаашаа явж чадахгүй.

**Д.Содном:** -Төр иргэн хоёрын харилцаа ухаалаг байх ёстой. Төр-бизнес хоёр яаж түншлэх, бизнесийг дэмжих ухаан төрөөс гарч байх ёстой. Энэ ухаалаг төрийн нэг анхаарах зүйл. Гэхдээ ухаалаг төр гэхээр л УИХ, Засгийн газрын хэдэн гишүүдийн үүрэг мэтээр ойлгож болохгүй. Ерөөсөө Монгол Улсын иргэн бүр, ялангуяа бүх төрийн албан хаагчид зөв ажиллаж чадвал ухаалаг төр сая бүрдэх учиртай. Тэр цагт Монгол орны хөгжил урагшилна.

**Ш.Гунгаадорж:** -Энэ сэдэв өмнө нь яригдаж байсан. Үүнийг Ерөнхийлөгч маань дахин сануулж байна. Төрийн бодлого ард түмнийхтэй уялдахгүй байгааг зохицуулах тухай юм.

**-Та гурвыг нэг дор суулгаад ярилцлага авч байгаагийн хувьд асуухгүй өнгөрч болохгүй нэг сэдэв бол Монгол төрийн гадаад бодлогын тухай. Гадаад харилцаанд анхаарах хамгийн чухал зүйл нь юу вэ?**

**Д.Содном:** -Гадаад харилцаанд бизнесүүдтэй харьцахдаа маш хянуур байх ётой. Манайх гадаадын хөрөнгө оруулалтыг их шүтэж байгаа өнөө үед эдийн засгийн алуурчид ороод ирж магадгүй шүү. Зарим нь хөлөө тавьсан байхыг ч үгүйсгэхгүй. Тиймээс энэ асуудалд болгоомжтой хандах нь чухал. Ерөнхийлөгч “Гадаадынхантай хийж байгаа гэрээнүүдэд сайд нар оролцоод байгаа нь буруу. Хуулийн, эдийн засгийн болоод бусад чиглэлийн бэлтгэгдсэн хүмүүсээр гэрээ хийлгэж бай” гэж хэлсэн байна лээ. Би үүнийг дэмжиж байгаа. Эдийн засгийн алуурчид мэргэжлийн хүн мэтээр орж ирэх нь бий. Тиймээс тэднээс байнга болгоомжлох ёстой. Үүнээс гадна бид хоёр хөрштэйгээ харьцахдаа маш ухаалаг хандахгүй бол болохгүй. Урд хөрштэй эдийн засгийн бүх талын харилцаа хөгжиж байна. Харин хойд хөршид ухаалаг бодлого баримтлахгүй бол болохгүй. Манай улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүний таван

хувь нь ОХУ руу гарч байгаа тоо бий. Гэтэл импортоор авч буй бүтээгдэхүүний 60-70 орчим хувь хойд хөршийнх. Тэр нь нефтийн бүтээгдэхүүн, цахилгаан. Энэ тал дээр эдийн засгийн харилцаагаа хэрхэн идэвхжүүлэх талаар төрийн ухаалаг бодлого үгүйлэгдэж байна. Төр засгийн удирдлагууд тус улсын удирдлагуудтай уулзаж, энэ талаар сайн ярилцах хэрэгтэй байх.

**Ш.Гунгаадорж:** -Бид хоёр хөршгэйгээ стратегийн адил тэгш бодлого явуулахгүй бол горьгүй. 1990 онд намайг Сайд нарын зөвлөлийн дарга байхад АНУ-аас Бэйкер манай улсад айлчилсан. Бид тэр үед танайхыг гурав дахь хөршөө болгоё гэсэн юм. Тэгэхэд "Тэр болно. Гэхдээ та нар хоёр хөршийнхөө хилийг давж гарсны дараа гурав дахь хөрштэй болно шүү дээ" гэж байсан. Бид өнгөрсөн хугацаанд хоёр хөрштэйгээ адил тэгш харилцахад дутуу анхаарсан зүйл бий байх. Үүнийг цаашид ямагт бодож явахгүй бол болохгүй.

**Д.Бямбасүрэн:** -ОХУ Монголын экспортын 1.3 хувийг эзэлж байна. Үүнээс харахад, хойд хөрштэй экспорт зогсонги байдалтай болж буй нь харагдана. Манайхан заримдаа хоёр их хөршөөр хязгаарлагдсан, далайд гарцгүй орон гэж ярьдаг. Энэ буруу ойлголт. Харин ч манайх дэлхийн хязгааргүй том зах зээлийн дунд оршиж буй орон. Хүн амын тоогоор Хятад, газар нутгийн хэмжээгээрээ ОХУ нэгдүгээрт ордог. Эдийн засгийн чадавх ч сайтай. Тиймээс хоёр хөрштэйгээ эдийн засгийн харилцаагаа тэгш явуулж, ойлголцолд хүрвэл амжилтад хүрнэ гэдгийг хэлье. Үүнээс гадна би нэг зүйлийг нэмж хэлэхэд, бид гурван их соёл иргэншлийн уулзвар дээр байгаа улс. Хойд талд Оросоор дамжаад Христосын ертөнц байна. Урд талд Буддын ертөнц байдаг. Баруун талд Баян-Өлгийгөөр дамжаад лалын ертөнц бий. Энэ чинь манай гадаад харилцаанд ямар байр суурьтай байгаа юм бэ. Тиймээс энэ чиглэлээр харилцаа холбоогоо хөгжүүлэх хэрэгтэй. Гадаад харилцааны тал дээр эдийн засгийн бодлого нь жаахан асуудалтай л яваад байна. Ганцхан жишээ хэлье. Монголчууд 2011 онд нүүрсний экспортоо огцом нэмээд дэлхийн нүүрсний зах зээлийг эвдсэн. Тухайн үедээ их өсөлттэй сайхан л байсан байх өнөөдөр яаж байна. Бодох л учиртай. Одоо бид дэлхийн зэсийн зах зээлийг эвдэх гэж байна. Үүндээ ухаалаг хандаачээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг талуудтайгаа харилцаагаа сайжруулж, зохицуулалтаа боловсронгуй болгох хэрэгтэй.

**-Хөгжлийн тухай их ярьж байна. Хөгжлийг бий болгоход юуг анхаарах вэ?**

**Д.Бямбасүрэн:** -Манайхан хөгжлийн тухай яриад байгаа. Хөгжил өсөлт хоёроо ялгаж, салгамаар байна. Энэ бүгдээс Монголын эдийн засгийг дүгнэн харахад, өөрийн гэсэн хөдөлгүүргүй техник юм. Төрийн одоо явуулж буй бодлогыг харахад, Хятадад үйлдвэрлэсэн том тракторын хойноос зүүгдэж байгаа мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл, өмнөд хөршийн эдийн засаг өсөөд байгаа. Хүний тракторын чиргүүл болж зүүгдэлгүй Монгол гэдэг айл өөрийн гэсэн хөдөлгүүртэй болох ёстой. Зэс, нефтиэ боловсруулж, металлургийн салбараа хөгжүүлмээр байна. Хөгжлийг хүний оюун ухаан, технологи авчирна. Бид түүхий эд экспортолж байна. Азийн орнуудад түүхий эдээ нийлүүлээд орхих бус оронд нь технологи авах бодлого байх ёстой. Ингэж байж манай улс хөгжинө. Иргэдийн сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэй. Бүтээгч чадвараасаа илүү сайхан амьдрах шуналыг дэвэргэж ирсэн. Үүнээс болоод бид өр зээл тавьж байна. Бүтээх чадварынхаа хэрээр амьдрах философийг нийгэмд төлөвшүүлэх ёстой. Хүнээс зээлсэн мөнгөөр сайхан амьдарна гэсэн жам хаана ч байхгүй. Өр тавьж өнөө маргаашаа аргацааж байгаа нь ирээдүйгээ идэж буйгаас өөрцгүй. Сүүлийн үед Монголд баялаг бүтээгчдээ хайрлая, дэмжье гэж их ярьж байна. Гаднынхны судалгаагаар Монголын насанд хүрсэн хүн амын 0.01 хувийг эзэлж буй эрх мэдэлтнүүд нь манай орны үндэсний баялгийн 7.6 хувийг эзэмшиж байна гэж гарсан байна. Тэд энэ баялгийг бүтээсэн болж тааруч байна уу. Бид нэгэн гэгээнтний хэлсэн үгийг санах хэрэгтэй юм шиг. Энэ нь "Тэвний сүвээр тэмээг хөтөлж гаргах нь баян хүнийг бурхан болгохоос илүү хялбар" гэж. Баячуудын ашиг сонирхолд хөтлөгдсөн төрийн бодлого зөв явахгүй байгааг эргэж харах ёстой.

**Ш.Гунгаадорж:** -Манай улс хүнээ хөгжүүлэх тал дээр сүүлийн жилүүдэд анхаарч байна. Мэдлэг, боловсролтой хүн бүхэн сайн байдаггүй юм байна. Үүний цаана жинхэнэ хүн байх ёстой юм байна. Өөрөөр хэлбэл, хүмүүжилтэй, эх орноо хайрлах үзэл манайд дутмаг байгаа. Энэ үзлийг цэцэрлэгийн наснаас нь эхлэн заах ёстой. Улс орны өнөөдрийн болохгүй бүтэхгүй байгаа зарим нэг зүйл нь ганц хүнээс хамаарахгүй. Тиймээс Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах ёстой. 20 гаруй жилийн өмнөхөөс одоо тэс өөр болсон байна. Парламентыг сонгодог тогтолцоо руу оруулах цаг болсон. Дээд, доод хоёр танхимтай болох ёстой. Газар нутаг томтой, хүн ам цөөтэй хоёр том гүрний дунд оршиж буй манай орны хувьд ийм парламентын тогтолцоо хэрэгтэй. Үндэсний эв нэгдлийг хангахад энэ байдал маш чухал үүрэг гүйцэтгэнэ.

**Содном:** -Манай ардчилсан засаглалын тухай асуудал. Азидаа төдийгүй дэлхийд ардчиллаар үлгэр жишээ болж байгаа. Энэ нь мэдээж сайн. Гэхдээ бид эргэж харахгүй бол болохгүй болжээ. Ардчиллаа зөв замаар хөгжүүлэхгүй бол дэг журамгүй байдал руу хэт орчих вий гэх болгоомжлол бий. Нөгөө талаар дэлхийн алдартай хүмүүс манайд ирэхдээ хэд хэдэн удаа хэлсэн. Тэр нь дүр эсгэсэн ардчилал маш аюултай гэж. Тэгвэл бид ямар ардчилалтай байна вэ. Дүр эсгээгүй байгаа. Энэ хэдэн зуун жилийн өмнө ардчилал, зах зээлд орсон улсын Ерөнхий сайд, Ерөнхийлөгчид юу гэж хэлж байна вэ гэхээр "Ардчилал хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ улс орны хөгжил дэвшилд сахилга дэг журам хэрэгтэй" гэдгийг айхтар анхааруулж хэлдэг. Тиймээс энэ ч гэсэн манайд хамаатай асуудал.

**Д.Бямбасүрэн:** -Содном дарга ардчиллын талаар хэлж байна. Ардчилал бол замбараагүй байдал биш ээ. Ардчилал гэдэг хэдэн бизнесмэнийг толгой дээрээ гаргах биш. Уг нь манай Үндсэн хуульд иргэний ардчилсан нийгмийг цогцлооно гэж заасан. Гэтэл сүүлийн үед зарим онолчид капитализм байгуулна гэсэн биз дээ. Одоо л тэднийгээ хамгаалах хэрэгтэй ухааны юм яриад байгаа. Энэ бол хүн төрөлхтний сэтгэхүйгээс 100 жил хоцрогдсон үзэл бодол. ■

2014 ОНЫ 01 САР.

Дэлхийн хөгжлийг Монголоо урагдсон

20

# ХУВИЙН БИЗНЕСЭЭС ҮНДЭСНИЙ

## ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨТГӨСӨН ҮЕ

### 1997 он

Тавилгын худалдааны Анун, компьютер, тоног төхөөрөмж борлуулалтын М-Си-Эс Электроникс, хэвлэлийн Интерпресс компаниудыг байгуулж тухайн үед Монголын зах зээлд эрэлт ихтэй ч нийлүүлэлт дутмаг байсан бараа, үйлчилгээг нийлүүлэх болжээ.




### 1998 он

Зах зээлийн жамаар хувьчлагдан М-Си-Эс Группын бүрэлдэхүүнд нэгдсэн СББ компани 1998 оноос хойш улсын төсөвт нийт 230 орчим тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлжээ. Энэ нь хувьчлагдахаас өмнөх үетэй харьцуулахад жилд дунджаар 20 дахин их хэмжээний татвар төлдөг болж өсч, хөгжсөн байна.



### 1993 он

Эрчим хүчний салбарт зөвлөгөө өгөх чиглэлээр "Mongolian Consulting Service" буюу М-Си-Эс компани үүсгэн байгуулагдав.

## БИЗНЕСИЙН ГАРАА БА ИМПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЖ ЭХЭЛСЭН ҮЕ

MCS Group

### 1999 он

Өргөн хэрэглээний барааны зах зээлд дэлхийд алдартай "Procter & Gamble"-ийн бараа бүтээгдэхүүнийг дотоодод нийлүүлэх "Анунгоо" компанийг байгуулжээ.



### 2001 он

М-Си-Эс Кока-Кола компани байгуулагдаж, дэлхийн 200 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг Кока-Колагийн гэр бүлийн албан ёсны гишүүн болов. Өнөөдөр тус компани 650 гаруй ажиллагсадтай, 13 брэндийн 100 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



### 2003 он

Хөвсгөл аймгийн Мөрөн хот, сумдын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг төвлөрсөн эрчим хүчний системд холбож, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор Булган-Мөрөнгийн чиглэлийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг гүйцэтгэв. Энэхүү төслийг 18 сарын дотор гүйцэтгэх даалгавартай байсан ч 14 сард багтаан дуусгаж, мөрөнчүүд 24 цагийн цахилгаан эрчим хүчинд холбогдсон юм.



### 2004 он

Баянхонгор аймгийг төвлөрсөн эрчим хүчний хангамжид холбох Арвайхээр-Баянтээг-Баянхонгор чиглэлийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн үр дүнд дэд бүтэц хөгжиж, соёл, аялжаа, үйлчилгээний салбарууд сэргэж, орон нутагт ажил эрхлэлт нэмэгдэж, иргэдийн амьдралын түвшин дээшлэх нөхцөл бүрдэв.



### 2006 он

Үүрэн холбооны Юнител компани байгуулагдаж, хэрэглэгчдээ чиглэсэн маркетингаараа ялгарч, үнийн оновчтой бодлогыг баримталснаар гар утас "гангараа" биш, ард түмний өргөн хэрэглээ болсон юм. Өнөөдөр орон даяар 1 сая гаруй хэрэглэгч "Юнителизэр ярьж байна". Мөн IPTV, интернет, суурин утасны гурвалсан үйлчилгээний Юнивишн компани өдгөө 110 мянга гаруй өрхийг хамрааж байна.




### 2007 он

Барилга угсралт, үл хөдлөх хөрөнгийн менежментийн салбарт үйл ажиллагаагаа өргөтгөсөн М-Си-Эс Групп барилгын салбарт дэлхийн стандарт, дизайны сүүлийн үеийн хандлагуудыг шингээхийг эрмэлздэг. Өндөр зэрэглэлийн орон сууцны "Виста" брэндийг зах зээлд анхлан нэвтрүүлж барууны маягийн иж бүрэн тохижилттой, оршин суугчдын

### 2006 он

Олон улсын Азиа Пасифик Брюэри компанитай хамтран шар айрагийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх М-Си-Эс Азиа Пасифик Брюэри компанийг байгуулж мөн ондоо шинэ үйлдвэрийн шав тавьсан юм. Нэг жилийн дотор шар айрагийн үйлдвэр баригдаж үйл ажиллагаагаа эхлүүлснээр импортыг орлох бүтээгдэхүүнийг эх орондоо үйлдвэрлэж эхлэв.







### 2007 он

ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн "Белла Виста" хотхоныг барьж байгуулла. М-Си-Эс Проперти компани 2001 онд Монголдоо хамгийн анхны Америк маягийн "Сэлба" орон сууцны хороолллыг ашиглалтанд оруулж байсан билээ.

# БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ-20 ЖИЛ

MCS групп

## 2011 он

Энержи Ресурс компани Монголд анх удаа Нүүрс баяжуулах үйлдвэрийг барьж байгуулснаар түүхий нүүрс бүс нэмүү өртөг шингэсэн баяжуулсан нүүрс экспортлох болов. 3 модуль бүхий энэхүү үйлдвэр жилд нийтдээ 15 сая тонн нүүрс угаах, баяжуулах хүчин чадалтай бөгөөд гадаад зах зээлд Монгол нүүрсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нэн чухал алхам болсон юм.





## 2011 он

Монгол инженерүүдийн мэдлэг туршлага, ур чадвараг тулгуурлан М-Си-Эс Интернэйшнл компани Монгол Улсад анх удаа хувийн хөрөнгө оруулалтай цахилгаан станц барьж байгуулав. Үндэсний 80 гаруй компанийн 1500 гаруй инженер техникийн ажилтнуудын хөдөлмөр, ур ухаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций суманд боссон анхүү цахилгаан станц Ухаа Худаг цогцолбор болон Цогтцэций сумыг нийдвартай эрчим хүчээр хангах болсон юм.

## 2012 он

М-Си-Эс Проперти компани залуусг зориулсан "Шинэ гэр" төслийг санаачлан эхлүүлж, их хотын амьдралын шинэ хэв маягийг нийслэлд нэвтрүүлсэн, бүрэн төвилгтэй 1614 айлын Вива Сити хороолыг ашиглалтанд оруулав. Энэхүү төсөл нь залуусг түлгамдаг орон сууцны бархшээлийг шийдвэрлэхийн хамт эгаарын бохирдлыг бууруулах, хотын төвлөлийг сааруулахад хувь нэмрээ оруулсан юм.



## 2009 он

Улаанбаатар хотын төвд орчин үеийн тохижилт, олон улсын жишигт хүрсэн менежмент бүхий оффис үйлчилгээний цогцолбор болох Сентрал Тауэр ашиглалтанд оров.



## 2009 он

Нийслэлчүүдээ цэвэр агаарт идэвхтэй амрах боломжийг нээж өгсөн Скай Резорт цогцолбор нээгдсэнээр Монголд анх удаа олон улсын стандартын цанын бааз ашиглалтанд орсон юм. Өнөөдөр тус цогцолборт өдөлт хүүлчлалыг дэмжих зорилгоор цанын баазаас гадна олон улсын стандартын 18 нүхтэй гольфын талбайн үйлчилгээ үзүүлж байна.



## 2013 он

Монгол Улсын Засгийн Газраас санаачилсан Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр М-Си-Эс Интернэйшнл компани ажиллав. Монгол инженерүүд анх удаа 2 хэлхээт 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг өөрсдийн эрдэм мэдлэг, ур чадвараг түшиглэн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын дор бүгнө хугацаанд хэрэгжүүлсэн төсөл байв.



## 2008 он

Ухаа Худаг аж үйлдвэрийн цогцолборын суурь тавигдаж улмаар 2010 оны аравдугаар сард Энержи Ресурс компани "Mongolian Mining Corporation" нэрээр Хонг Конгийн хөрөнгийн бирж дээр үндэсний компаниудаас анхлан хувьцаагаа амжилттай гаргасан билээ. Уурхай болон дагалдах дэд бүтцийн төслүүдээс бүрдсэн Ухаа худагийн аж үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалтад 5000 орчим хүн ажлын байртай хангагдаж, нэгдлийн 700 гаруй аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгчээр хамтран ажилласан бөгөөд Энержи ресурс компани өнгөрсөн хугацаанд 500 орчим төрбум төгрөгийн татвар, шимтгэлийг төсөвт төлөрүүлжээ.



## 2014 он

Эдүгээ М-Си-Эс Групп нь инженеринг дэд бүтэц, уул уурхай, мэдээлэл харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, өргөн хэрэглээний барааны гэсэн бизнесийн зургаан салбарт 20 гаруй компани, 8000 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



## ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ

## 2008-2013 он

М-Си-Эс Групп 2008 оноос томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд дэвитой хувь нэмэр оруулахуйц үйл ажиллагаа байсан юм.



## 2014 он

Улсын төсөвт 208 төрбум төгрөгийн татвар, шимтгэл хуримтлуулж, Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТ хамтран зохион байгуулдаг ТОП 150 шалгаруулалтад хүүхийн хэлшээ 8 дахь жилдээ манлайлав. М-Си-Эс Групп сүүлийн 3 жил дараалан улсын төсөвт жил бүр 200 төрбум төгрөгөөс дээш хэмжээний татвар, шимтгэлийг төлөрүүлжээ. Энэхэн 2013 онд улсын төсөвт хуримтлуулсан татвар, шимтгэлийн дүнгээр 500 орчой 10 аймаглаг багихад хүрэлцэх юм.



## 2014 он

Монголчуудын хөрөнгө оруулалттай, америк менежменттэй "United Family Internet" эмнэлэг нээлтээ хийлээ. Интермед эмнэлэг нь Европ стандартын дагуу Монголд бөрдсөн анхны эмнэлэг бөгөөд орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэхэд бодитой хувь нэмэр оруулахыг зорьж байгаа юм.





## 2014 он

Кембрижийн хөтөлбөрийн хүргээмжийг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн сургалтын орчинг бүрдүүлэх зорилгоор Орилон Кембриж Олон Улсын Сургууль, цэцэрлэгийн шинэ цогцолборыг барьж байгуулав.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

*“Хас” банкны үүсгэн байгуулагч нэрээрээ олонд танигдсан Ч.Ганхуягтай ярилцлаа. Тэрбээр өмнөх Засгийн газрын үед Сангийн дэд сайдын албыг хашиж байсан нэгэн. Унгар улсын Эдийн засгийн их сургууль төгссөнөөсөө хойш Монголын банк санхүүгийн салбарт 20 гаруй жил ажиллаж буй манай лидер залуусын нэг.*

# Ч.Ганхуяг: Бид Африкийн замаар орчихлоо. Үүний гарц нь улстөрийн шийдэл

**-Монголын эдийн засаг хүндэрсэн гэдгийг эрх баригчид хүлээн зөвшөөрч, баахан ажил хийхээр төлөвлөлөө. Улиг болсон асуулт ч гэлээ монголчууд ямар бодлого явуулбал энэ хүндрэлээс хурдан гарах бол гэдгийг ярианыхаа эхэнд Таниас асуумаар байна?**

-Төрийн бодлогын залгамж чанар, үргэлжлэл алдагдсаны гор гарч байна. Одоо нэг долларын төгрөгтэй тэнцэх ханш 1830 болсон байна, 1700 хүрч байх үе буюу өнгөрсөн оны есдүгээр сард би талбай дээр гараад буруудсан. Оны эцсээр ханшийг түр тогтоогоод дахиад алдчихлаа. Миний талбай дээр гардаг үйлдэл дохио болох ёстой байсан. Баяр наадам дөхөөд ирсэн үед дахин анхааруулахад, амралтын өдрөө нэмэх бус дарга нар өдөр шөнөгүй ажиллах хэрэгтэй байна. Чих амраа бодоод амралтын өдрийг нэмээд байх шиг. Монголбанкны удирдлагыг улс төрөөс хараат бус байлгах бодлого алдагдсаны гай гарсаар. Миний мэдэхийн шинэ хууль батлагдсанаас хойш /1996 оноос/ Төвбанкны ерөнхийлөгчийг улс төрөөс ангид байлгах зорилгоор зургаан жилээр томилно гэсэн заалт хэзээ ч хэрэгжээгүй. Хуулиа гууль болгож, мөрдөхгүй, өөрийнхөө дураар тайлбарладгийн үр дүн юм даа. Мөнгөний бодлого тогтвортой байх ёстой. Монголбанк мөнгөний бодлогоо урьтал болгохгүйгээр төр засгийн өмнөөс очиж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх байдлаар асуудалд хандсан нь өнөөгийн нөхцөл байдлыг бий болгосон. Төвбанкны өмнөх ерөнхийлөгч нарт улс төрийн томилгоо хийгдэж байсан ч тэд бодлогоо хараат бус байлгаж ирсэн. Энэ нь бидний аз байж. Төрийн залгамж халааг хэт их гудамжны улстөрч, популистуудаар дүүргэсэн учраас мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчин үгээ хэлэх, ажлаа хийх боломжгүй болсон. Популистууд мэдлэг нимгэн, дээр нь эдийн засгийг авч явах гэж алдаж, түүнээсээ суралцаж буй нь бидний амьдралд хүндээр тусч байна. Нэг ёсондоо ажлын дадлага туршлага, мэргэжлийн мэдлэг боловсрол, наад захын энгийн логик сэтгэлгээ, хувь хүний ёс зүй дутмаг байгаагаас алдлаа.

**-Хүндэрсэн эдийн засгаа сэргээх арга байж л тараа. Нэн түрүүнд хийх ажил нь юу байх вэ?**

-Монголбанк, яамдын удирдлагуудыг мэргэжлийн хүмүүсээр удирдуул. Ингэж байж амьдралд ойр бодлого шийдвэр гарна. Эдийн засгийн хөгжлийн яамыг мэргэжлийн хүн удирдах ёстой. Бизнес, эдийн засаг итгэлцэл дээр тулгуурлаж явдаг. Ард түмний итгэлийг төр үгүй хийсэн. Зургаан жил ярьж байгаад зурсан гэрээгээ өнөөдрийн эрх баригчид түүн дотроо УИХ-ын дарга эсэргүүцэж эхэлсэн. Өмнөх Засгийн газрыг ажиллуулахгүй огцруулах талаар байнга ярьж байсан. “Чингис” бондыг гаргах нөхцөлийг өмнөх Засгийн газрууд бий болгосон. Өөрөөр хэлбэл, Монголд мөнгөө зээлдүүлье гэсэн итгэлцэл бий болсон. Энэ боломжийн үзүүрээс атгасан одоогийн Засгийн газар үүнийг зөв ашиглаж чадсангүй. Ганц жишээ дурьдахад, төмөр замын санхүүжилтэд өгсөн 200 сая долларын талаар сураг сонсоход, зөвхөн шороо овоолсон байгаа юм. Бид хэдэн дарга нарын компаниудын том оврын машинаар говийнхоо хөрс шороог талхлаад, иргэд, мал амьтнаа тоос шороон дунд амьдруулсаар баялгаа Хятадын хил рүү машинаар зөөсөөр л байна. Төмөр зам тавих гээд хэрэлдсээр зургаан жил өнгөрлөө.

**-Төвбанк мөнгөний хатуу бодлого явуулбал өнөөгийн нөхцөл байдлаас гарна гэх хүмүүс ч байна.**

-Бодлого дээр илүү анхаарах ёстой. Мөнгөний хатуу бодлого явуулбал бид эдийн засгаа царцаачихна. Одоо Төвбанк мөнгөө хумих гэж оролдож магадгүй. Энэ буруу. Хүндрэлээс гарах нэг горьдлого бол төмөр зам. Нэг үндэстэн, баг шиг урагш зүтгэж, Оюутолгойн гэрээний хоёрдугаар үе шатыг эхлүүлэх ёстой. ТЭЗҮ нь гурав хоногт танилцуулагдахгүй гэдэг нь тодорхой болчихлоо. Яагаад гэвэл, татварын маргаан таслах зөвлөл рүү “Рио Тинто” гомдол гаргасан. Тэгэхээр бид энэ оныг бүсээ чангалаад давахаас өөр аргагүй болж байна. Ирэх есдүгээр сарын 30-нд “Рио Тинто”-гийн санхүүжилтийн хоёр дахь хэсэг орж ирэх ёстой байсан. Дөрвөн тэрбум доллар. Одоо монголчуудаас баталгаа авахгүйгээр тэр мөнгийг оруулж ирэхгүй. Тэд манайд 1.2 тэрбум ам.долларын татвар төлчихөөд буй. Гэтэл нэг татварын байцаагч очоод танайх манайд 130 сая доллар төлөх ёстой гэснээс болоод тэд татварын маргаан таслах зөвлөлд хандсан байна. Иймбайхад дахин зээл авч, өөртөө лай хураахыг хэн ч хүсэхгүй.

**-Дарга, сайдгүй бүсээ чангалах ёстой гэх юм. Нэгэнт доллар орж ирэхгүй байхад хүндэрсэн эдийн засгийг яаж тордох юм бэ?**

-Шаварт унагаачихаад бүсээ чангалъя гэж дарга нар ярих нь буруу. Харин ч хариуцлагын асуудал яригдах ёстой. Нүүрсээ улс төрийн аргаар худалдах гэрээ байгуулах хэрэгтэй. Удахгүй Си Зинпинь айлчлах гэж байна. Зөв угтаад зөв гэрээнүүдээ зуруулах ёстой. Улиг болсон хийн хоолойн “үлгэр”-ийг хаях хэрэгтэй. Манайх төмөр замаа тавъя, нүүрсийг маань таван жил тогтвортой худалдаж ав гэж санал болгон гэрээгээ шамдуул. “Саусгоби сэндс”-ээ танайх худалдаж аваад ажиллуул. Бид алдаа гаргажээ. Та нартаа мөнхийн найрсаг харилцаатай. Манай нүүрсийг ав” гэдэг талаар яриа хэлэлцээр хийх ёстой.

**-Манайд хариуцлагын тогтолцоо алдагдаад удаж байгаа. Зарим сайд алдаагаа ухамсарлаад суудлаасаа буухгүй болох нь УИХ дээр яригдаж буй сандал ширээний хэрүүлээс тодорхой харагдаж байна л даа. Иймүед хариуцлага гэж ярих хэрэг байна уу?**

-Засгийн газар хариуцлагаа хүлээх ёстой. Асуудал эрхэлсэн сайд нартай хариуцлага ярих зайлшгүй шаардлагатай. Тэгэхгүйгээр цааш явахгүй. Алдаа гаргаад байхад “За, одоо өнгөрсөн” гээд өнгөрүүлбэл дараа халааг нь авсан хүн алдаа гаргалаа ч толгойг нь илээд өнгөрдөг гэсэн сэтгэхүйтэйгээр ажиллана. Ингэж болохгүй. Төр цомхон байх ёстой. Хувийн хэвшлээр ажлаа хийлгэх хэрэгтэй. Хувийн хэвшил нь зохион байгуулалттай байх ёстой. Одооных шиг эрээвэр хураавар биш.

**-Та дээр улстөржилт их байна гэлээ. Танай намын бүлэг сөрөг хүчин гэдгээрээ ч тэгдэг үү зарим асуудалд хэт туйлширч, улстөржөөд байна уу даа гэж хардаг. Үүнийг та МАН-ын гишүүн бус иргэн хүний хувиар хэрхэн харж, үнэлэлт дүгнэлт өгөх вэ?**

-Улс төрчид улстөржих ёстой. Бизнес эрхлэгчид ажлаа хий. Би МАН-ын гишүүн гээд УИХ дахь бүлгийнхээ өмнөөс хариуцлага

хүлээхгүй. Би УИХ-д сонгогдох гэж оролдсон, чадаагүй. Хувийн бизнесээ эрхлээд явж байна. Жирийн иргэд дөрвөн жилд нэг удаа улстөржчихөөд бусад үед ажлаа хийдэг байх ёстой. Залуучууд дундаа тэрний энэний гэж хагаралдах нь яав ч сайнаар тусахгүй. Тэр үүднээс би Н.Алтанхуягийн Засгийн газрыг зөв ажил хийвэл дэмждэг. Буруу байдлаар нийгэм рүү дайрвал үзэл бодлоо илэрхийлдэг. Би Монгол Улсын иргэн. Энэ бол миний хамгийн түрүүнд өмсч яваа малгай. Дараа нь нам, бизнес яригдана. Тиймээс би Монгол Улсын эрх ашгийн төлөө нэн тэргүүнд дуугарах ёстой. Засгийн газар буруу зүйл их хийгээд байх юм. Үүнд би МАН-ын байр суурийг илэрхийлээд шүүмжлээд байгаа юм биш. Иргэнийхээ хувьд дуугарах үүрэгтэй. Тиймээс намайг намын малгайтайгаар харах хэрэггүй шүү дээ. Би эгэл жирийн иргэн.

**-Улс төрчид ултөржиж, бизнес эрхлэгчид ажлаа хийх ёстой гэж байна. Тэгэхээр бизнес эрхлэгчдийн хүлээгээд буй хууль эрх зүйн орчин батлагдахгүй хүлээлт үүсч, ажил аль аль талдаа гацах юм биш үү?**

-Сөрөг хүчнийг нөгөө талаас нь бас харах хэрэгтэй. Шинэ парламент бүрдсэний дараа жил гаруй бүлэггүй явуулсан. Одоо УИХ-ын нэг Байнгын хороо 20 орчим гишүүнтэй байхад 1-2 нь л манай намын төлөөлөл байна. Энэ нь ардчилсан нийгмийн төлөөллийн зарчмыг алдагдуулсан. УИХ-ын гишүүдийн гуравны нэг нь ард иргэдээ төлөөлөөд парламентад сууж байхад Байнгын хороодын гишүүдийн намын харьяалал ийм тэнцвэргүй байна. Энэ нь МАН-ын гишүүдийн ард иргэддээ хүргэх дуу хоолойг боогдуулж байна гэж би боддог. Үүнд өширхөл бий болж байна. Үүнийг засч залруулах ёстой. УИХ-ын дарга ухамсартай хүний хувьд засах хэрэгтэй. Тэгэхгүй бол аюултай. Ардчиллыг боомилсон, түүний суурь үндсийг устгасан Монгол Улсыг буруу зам руу түлхсэн үйлдэл болж байна. “Давхар дээл”-ийг тайлуулна, сонирхлын зөрчилтэй байна гэж тухайн үедээ цээжээ дэлдэн батлуулж байсан хүмүүс өнөөдөр бүгдээрээ ярайтал сууж байна.

Асуудалд нухацтай, болгоомжтой хандахгүй бол үндэсний эрх ашиг хөндөгдөнө

**-Засгийн газрын өрийн бодлогод та үнэлэлт дүгнэлт өгөөч. Өрийг ДНБ-ий 90 хувьд хүргэхээр хуулийн төсөл хэлэлцэж байна. Нөгөөтэйгүүр төсвөөс гадуурх мөнгүүд бас бий.**

-Зээл авч болно. Гэхдээ Оюутолгойг эргэлтэд оруулж, төмөр замаа шийдсэн байх ёстой. Монголбанк улс төрөөс хараат бус байж, мөнгөний бодлогоо дангаараа хэрэгжүүлэх хэрэгтэй. Ханш тогтворжсон байх ёстой. Учир нь, бид өнөөдөр зээл нэмж авахгүй байж илүү өрөнд орж буй юм шиг харагдаж байна. Валютын ханшийн өөрчлөлтөөс болоод улсын өр ДНБ-ий 60-аас дээш хувьд хүрсэн. Энэ асуудлуудыг шийдэхгүйгээр нэмж өр тавьж болохгүй. Ард иргэдэд төр “Хүний хөгжил сан”-гаар дамжуулан мөнгө өгнө гэж амласан нь өр мөн үү. Гаднын банкинд өгөх өрөө бүртгэчихээд иргэддээ олгох мөнгөө яагаад тооцдоггүй юм. Итгэлийг олж авч байж олон улсад унаад буй нэр хүндээ сэргээж авна. Үүний тулд шинэ хүмүүс гарч ирэх ёстой.

**-Шинэ хүн томилох нь дор хаяж хоёр жилийн дараах асуудал. Таны ярианаас ойрын 2-3 жилд эдийн засаг сэргэхгүй нь гэж харж болох уу?**

-Сэргээж болно. “ЭЗЭН-100” хөтөлбөр зарлачихаад 100 үйлдвэр хувьчлан нэг нэгээр нь эзэн болоод сууна гэж болохгүй. Хувьчлалыг эдийн засаг хөгжиж, хүмүүс сонирхсон, мөнгөтэй байх үед явуулдаг болохоос үнэгүйдсэн хойно нь хувьчилдаггүй. Энэ бол төрийн өмч, Монголын ард түмэн, ирээдүй хойчийн маань өмч. Үүнийг 1996-2000 оны хооронд АН засаг барьж байх үедээ Төрийн өмчийн хороогоор наадсан шиг болгуулахыг өнөөдөр зөвшөөрч болохгүй. Оюутолгойг урагшлуулахгүйгээр эдийн засаг сэргэхэд хүнд. Улмаар манай улсын зээлжих зэрэглэл одоогийнхоосоо буурна. Гаднаас авсан бонд маань жанк /муу/ бонд болно. Жанк бондоор тоглодог сангууд манай өрийг худалдаж авна. Өөрөөр хэлбэл, нэг долларын өрийг 20 центээр худалдаж авна гэсэн үг. Олон улсын шүүхээс манай бүх гаднын хөрөнгийг царцаана. Тэгээд төлүүлж авна. Бид Африк, Аргентины зээлийн хямралын замаар ороод явж байна. Одоо үлдсэн ганц гарц бол улстөрийн шийдэл.

**-Хямралаас үүдэж олон аж ахуйн нэгж хаалгаа барьж байна. Халагдсан хүмүүс цалингаа барьцаалан хэрэглээний болон орон сууцны зээл авсан нь банкны чанаргүй зээлд нөлөөлж эхэлсэн байх. Эдийн засгийн хүндрэл банкны салбарт хэрхэн тусч байна вэ?**

-Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ хоёр дахин нэмэгдсэн байсан. Эндээс ямар үзүүлэлт гарах нь ойлгомжтой биз дээ. Эдийн засгийн хүндрэлээс болоод өмнө нь хэвийн үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрүүд түүхий эдээ авч чадахгүйд хүрч, улмаар бараа бүтээгдэхүүнээ зарж чадахаа больж байна. Хүмүүсийн худалдан авах чадвар буурлаа. Зарим нэг нь орлогогүй болж эхэллээ. Ихэнх нь банкны зээлтэй.

**-Гадаадын томоохон банкууд манайд төлөөлөгчийн газраа нээж байна. Тухайлбал, Bank of China. Энэ нь Монголын эдийн засаг тэр дундаа банкны салбарт ямар үр дүн авчрах вэ?**

-Хоёр талтай. Bank of China Монголд орж ирэх нь банк хоорондын өрсөлдөөнийг эрчимжүүлж, бидэнд агаар мэт хэрэгтэй байгаа гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэн бизнес эрхлэгчдэд таатай нөхцөл бий болгох замаар хүндрээд буй эдийн засагт сэргээш өгөх талтай. Манай банкуудын үйлчилгээ ч энэ нөлөөгөөр сайжирч, дунд хугацаанд үйл ажиллагаа нь чамбайрч, өрсөлдөх чадвар нь ч нэмэгдэх боломжтой. Харин дунд хугацаанд манай бүх өөдтэй, өнгөтэй бизнесүүдийг бага хүүтэй, их хэмжээний зээлээр тэтгэснээр бид нэг банкны барьцаанд бүхлээрээ орох эрсдэл бий. Өөрөөр хэлбэл, тэдний бидэнд үзүүлэх нөлөө, шахалт ихэсч, манай үндэсний гэх банкууд сайн харилцагчгүй мухардмал байдалд орж бүхлээрээ унах эрсдэл бий. Тэр үед тэдний зүгээс хэрэглэж болох нэг аюултай арга бол зөвхөн Хятадын оролцоотой, хятад эзэнтэй, хятад технологи ашигласан төслүүдийг дэмжиж, манай үндэсний гэх тодотголтой бизнесүүдийн өрсөлдөх чадварыг сулруулах.

Улмаар үгүй хийх бодлого барих боломж үүсэхийг үгүйсгэхгүй. Иймд бид энэ асуудалд туйлын нухацтай, болгоомжтой хандах нь үндэсний эрх ашигт нийцнэ. Би энд заавал хориг тавь гээгүй. Бид зөвшөөрөл өгвөл эдгээр хүчин зүйлсийг тооцоолж, анхнаасаа алсаа харсан зөв хязгаарлалт, нөхцөл бүхий, нарийн хяналтын дор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгон ажиллуулж болно. Манайх жижиг эдийн засагтай орон. Тэгсэн хэр нь дэлхийн хамгийн том хүчтэй хоёр гүрний дунд хавчигдсан өвөрмөц онцлогоо хэзээ ч мартаж болохгүй. Хараат бус бодлого хэрэгжүүлэх арга зам нь эдийн засгаа төрөлжүүлэх, бэхжүүлэх, гаднын хөрөнгө оруулалтыг маш ихээр татах явдал юм. Хятадад банкны салбар нээх эрх өгөх гэж буй бол ОХУ, АНУ-д ч өгөх хэрэгтэй. Үгүй бол гурван саяуулаа тохирох ёстой.

**-Юу гэж?**

-Аль нэг банкаа бүгдээрээ худалдаж авъя. Өөрөөр хэлбэл, гурван сая иргэн бүр 100 мянган төгрөг гаргаад бүгд хувьцаатай болж, ард түмний банк болгочихъё. Тэндээ хадгаламжуудаа нээе. Хятад банкнаас зээл авч бизнесээ явуулж, ашиг олчихоод өөрсдийнхөө банкинд хадгалуулъя.

**-Сүүлийн үед хаа сайгүй хөгжил гэж их ярих болжээ. Та хөгжил гэдгийг юу гэж ойлгодог вэ?**

-Би өмнөх Засгийн газрын үед дэд сайд байхдаа эдийн засаг төдөн хувиар өслөө, инфляцийг ингэж барьж байна, цалин тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүллээ, Маршал, Тэрэлжийн гүүрийг заслаа гэж ярьж байсан. Тэр үед залуус “Амьдралд мэдрэгдэхгүй байна” гэдэг байсан. Төд удалгүй цалин хөлс нэмэгдэж, байшин барилга баригдан гадаад дотоодын хөрөнгийн урсгал сайжирсан. Энэ бол хөгжлийн илрэл байв. Үүнийг зарим залуу МАН-д дургүйдээ ч болсон уу харахыг хүсэхгүй байсан. Гэхдээ энэ бол хөгжил байсан. Эдийн засаг өсч байгааг хүн бүхэн мэдэрч байв. Сайн муу ч бай оюутнууд 70 мянган төгрөг авдаг болсон. Харин энэ Засгийн газар гараагаа сайн хийсэн. Өмнөх Засгийн газрын эхлүүлсэн “Салхит”-ын цахилгаан станц, “Энержи ресурс”-ийн зам, Нарны гүүр зэрэг ажлын туузыг очиж хайчилсан. Бид Хөгжлийн банкны дансанд 600 сая ам.доллар үлдээгээд явсан. Харамсалтай нь, өнгөрсөн хоёр жилийг үр бүтээл муутай өнгөрүүлчихлээ. Хий улстөржлөө. Ардчиллынхаа үнэт зүйлийг бүгдийг нь умартаж эрх мэдлийн төлөө улайрч дайрлаа. Албан тушаал авах гэсэн фракцуудын хоорондын тэмцэл сайн үр дүн авчирсангүй. Оюутолгойг гацаасан явдал нь манайхан гүйж байгаа хөл рүүгээ буу барьж байгаад буудсантай адил зүйл болсон. Өөрөөр хэлбэл, хөгжлөө зогсоосон. Улс хөгжилтэй байхын тулд иргэд нь боловсролтой байх ёстой. Хөгжил эдийн засгийг өрсөлдөх чадвартай болгодог. Нөгөөтэйгүүр өрсөлдөх чадвартай болж байж бид хөгжил рүү тэмүүлнэ. Өрсөлдөх чадвартай байна гэдэг богино хугацаанд чанартайгаар ихийг бүтээж, үнэтэйгээр зарах явдал юм. Ингэхийн тулд бидэнд боловсон хүчин, хөрөнгө мөнгө, дэд бүтэц, худалдан авагч зах зээл, мэргэн санаа хэрэгтэй. Энэ бүхэн нийлж байж баялаг бүтнэ.

Италичууд яагаад арьсан цүнхээ 2000 доллараар зарж байхад Монголд үйлдвэрлэсэн арьсан цүнх 30 мянган төгрөгийн үнэтэй байна вэ. Дизайн, өнгө үзэмж, чанар, брэнд, технологи нөлөөлж байна шүү дээ. Тэд арьс ширний зориулалтаар ашиглах малыг тусгай зориулалтын байранд байлгаж, хооллож, тэжээж, бордож, зориулалтын аргаар нь нядалж байж тэр арьсыг гаргаж авч байна. Нарийн боловсруулалтын технологи, чадварлаг боловсон хүчнийг ажиллуулж байна.

**-Ийм болохын тулд Монгол залуус боловсролтой байх ёстой. Гэтэл манайд боловсролын чанар сайн биш.**

-Боловсролтой болохын тулд бидэнд мөнгө хэрэгтэй. Мөнгөтэй болохын тулд бид төмөр зам тавих ёстой. Хойд хөрш рүү бид нүүрс зөөхгүй. Тэд манайхаас нүүрс авах ч үгүй. Хятадууд манай нүүрсийг авч магадгүй. Тэнэг, явцуу, мэдлэг боловсролгүй, хоосон популист ярианд орж, Нисэхийн замыг барьж буй хятадуудыг очиж зодно гэж зарим залуу ярьж буй нь утгагүй зүйл. Тийм л сүрхий юм бол өөрсдөө хүрз, жоотуугаа бариад тэр замаа барь. Гэхдээ хятадуудыг олноор оруулж ирэхийг би буруутгадаг. Ялангуяа хар ажилчдыг. Харин өндөр технологи нэвтрүүлж буй Хятадын компаниудыг оруулж ирэх ёстой. Солонгос ч адил. Хоолны газар ажиллуулдаг солонгосчууд одоо хангалттай. Бидэнд сайн технологитой, дэлхийд тэргүүлээд байгаа компаниуд хэрэгтэй байна. Бодлогоо ч ийш нь чиглүүлэх ёстой. Тэгэхийн тулд монгол залуус хэлээрээ бус гар, хөлөөрөө ажилладаг болмоор байна. Хятадуудыг үзэн ядах хангалттай. Үзэн ядаад тэвчихгүй бол тэдний хийж буй ажлыг хий. Үүгээрээ эх орондоо хайртай, үнэнч гэдгээ харуул. Битгий хоосон цээжээ дэлд.

**-Эх оронч үзэл гэдгийг та энгийнээр тайлбарлахгүй юу?**

-АПУ компани сүүний үйлдвэр нээлээ. Энэ бол эх оронч хүмүүс. Шинэ технологи оруулж ирэн хүмүүс сурган ажиллуулж, олон зуун хүнийг ажлын байраар хангаж байна. “Салхит”-ын цахилгаан станцыг эх оронч хүмүүс барьсан. “Энержи ресурс”-ийн Өмнөговьд барьсан хотхон эх оронч хүний хийсэн ажил. Тэнд барьсан цахилгаан станц эх орончдын бүтээл. Эрдэнэтийг эх орончид бүтээн байгуулсан. Эх орончид би эх оронч гэж цагаан хоолойгоор зарладаггүй. Ард түмний өмнөөс гэж хоолойгоо зангируулж, цээжээ дэлдэж, талбай дээр хүчирхийлэлд уриалж зогсдоггүй. Эх орончид эх орондоо хайртай учраас бүтээн байгуулахын тулд байшин, үйлдвэр барьж олон мянган хүнийг ажлын байраар хангаад явдаг. Сургууль байгуулж, хүүхдүүдийг сурган хүмүүжүүлж, гадаад багш авчирч ажиллуулдаг. Ар гэр амьдралаа авч явах гэж гэрээгээр ирж энд ажиллаж байгаа ядруухан хятадыг балбачихаад би эх оронч гэж бодож ярих нь утгагүй. Энэ бол гэмт хэрэг. Нөгөөтэйгүүр гадныхныг гудамжинд барьж аваад зодож байгаа залууст хэлэхэд, энэ бол эх орноосоо урваж буй хэрэг. Монголын тусгаар тогтнол аюулгүй байдалд шууд заналхийлсэн үйлдэл гэж би хардаг. Монголчуудыг Сөүлийн “Инчон”-ы нисэх онгоцны буудал дээр буухад солонгосчууд барьж аваад зодоод байвал ямар вэ. Үүнтэй л адил ойлголт. ■

2014 ОНЫ 07 САР.

# Р.Амаржаргал: Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх

*УИХ-ын гишүүн Р.Амаржаргалтай ярилцлаа.*

**-Та уналтад ороод буй эдийн засгийг аврах хамгийн зөв гарц бол өнөөгийн Засгийн газар даруй огцрох хэмээн үзэж байгаа. Өөр гарц шийдэл байхгүй гэж үү?**

-Хагас дутуу шийдлүүд байж болно. Гэхдээ асуудлууд бүрэн шийдэгдэхгүй. Өнгө зассан, эмэгтэйчүүдийн хэллэгээр косметик засварын өнгөлөн далдалсан арга хэмжээнүүд байх болно.

**-Өнөөдрийн Засгийн газрыг өөрчлөөд ч нэмэргүй. Ялгаа байхгүй. Оронд нь адилхан л хүмүүс гарч ирээд суучихна гэж зарим хүмүүс үзэж байна.**

-Credibility гэсэн ойлголт байдаг. Энэ ойлголт эдийн засагт их чухал үүрэг гүйцэтгэдэг. Шинээр гарч ирэх засгийн бүтэц үнэхээрийн нүдээ олбол credibility буюу иргэдийн итгэлийг олж болно. Эдийн засгийн зүг чигийг тодорхойлох, зөв голдиролд оруулахад их зүйл хийж болно. Бусад улс орны туршлага, Засгийн газрууд үе үе бүтэц бүрэлдэхүүн, нүүр царайгаа өөрчилдөг. Итгэл найдвар хүлээлгэж, эрх мэдлийг өгөөд байхад ажил унагааж, асуудлыг хүндрүүлсэн бол тэр хүмүүстэй зууралдаад байх шаардлагагүй гэж үздэг. Эцсийн эцэст энэ нь бид хоёрын хоорондын асуудал биш учраас улс орны хөгжлийг аваад явах, чадвартай хүнийг сонгоод өөрчлөөд явдаг практик олон улсад бий. Харин энэ практик манайд хэрэгжихгүй өнөөг хүрсэн нь хувь хүмүүсийн хоорондын харилцаатай холбоотой. Нөгөө талдаа улс төрийн орчиндоо барьцаалагдчихсан байдаг гэх үү дээ. Өөрөөр хэлбэл, лидер байх чадваргүй, мэдлэггүй, сулхан улстөрч бусдыг аялдан дагах шаардлага гарч ирдэг. Тэр үүднээс асуудалд ханддаг. Гэх мэтчилэн олон зүйл ярьж болно. Гэхдээ зөв хүнээ зөв байранд тавиад явбал асуудлууд шийдэгдэх бүрэн боломжтой. Мөн ард иргэд, бизнесмэнүүдийн зүгээс ч асар их итгэл найдвар төрж, дэмжлэг ирнэ. Алив зүйл итгэл найдвар, дэмжлэг дээр тулгуурлаж явна шүү дээ. Өнөөдөр миний харж буйгаар энэ асуудал хамгийн чухал нь байна.

**-Шинэ засаг гарч ирлээ гэхэд тэд юунаас ажлаа эхэлж, яаж ажиллах нь зөв бол?**

-Шинэ засаг бол үндэсний эдийн засгийн авралын Засгийн газар байх ёстой. Өвөрмөц бүтэцтэй байх хэрэгтэй. Мэдээж лидер, хүчтэй улстөрчид манлайлж, бамбай болж явах нь зөв. Харин салбар салбарын удирдах түвшний хүмүүс нь өндөр мэргэжлийн, мэдлэг боловсролтой, ёс суртахууны хувьд цэвэр ариун, шударга, чигч шулуун зан чанартай байх ёстой. Иймбүрэлдэхүүнтэй шинэ Засгийн газрыг байгуулах боломжийг улс төрийн намууд олгох хэрэгтэй. Намууд, улстөрчид өнөө маргаашаа бодоод улс төр хийгээд явж болох байх, гэхдээ дараа нь юун дээр улс төр хийх вэ гэдгээ бодох нь чухал.Тэр утгаар үндэсний хэмжээний эдийн засгийг аврах засгийг бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Хоёрдугаарт, шинэ Засгийн газрын бүтцийг улс төрийн намуудаас гэж бүү голчлоосой. Улс төрийн намуудын чадвартай төлөөлөл байж болно. Нам бус хүмүүсийг томилох хэрэгтэй. Мэргэжлийн гэдэг рүү гол шалгуурыг авч үзэх ёстой. Гуравдугаарт, хариуцлагын тогтолцоог гол чигээ болгох. Чи энэ албан тушаал дээр ажиллаад цалин авч л байгаа бол ажлаа сайн хийнэ шүү гэдгийг хатуу ойлгуулах. Иймэнгийн зүйлээс ажлаа эхэлбэл бизнесийнхэн, иргэд маш хурдан эерэг дохио авна.Дэмжинэ. Ажлаа саадгүй төлөвлөөд явна.

**-Хоёр дахь Аргентин Монгол гэж олон улсад ярьж байна. Та хүлээн зөвшөөрөх үү?**

-Ер нь манай өрийн менежментийн асуудал түгшүүртэй байгаа. Улстөрөөс гадна эдийн засгийн шийдэл дээр тулгуурлах ёстой. Тэр шалгуур алга болчихсон. Наад захын жишээ нь Чингис бондыг ямар



нөхцөл шалгууруар авч, юунд зарсан нь учир нь олдохгүй баахан маргасан. Энэ өрийн өгөөж, үр ашиг, хэзээ яаж юугаар төлөх нь тодорхойгүй. Дээр нь Самуурай бондыг ямар зорилгоор яах гэж авсан, хаашаа орсныг мэдэхгүй. Дараа нь сонсоход Чингис бондынхоо хүүг төлөхөөр авсан сурагтай. Бид сар, жил бүр мөнгө төлж байна. Энэ бүхэн эцэстээ Монгол Улсын өрийн менежментийг тодорхойгүй, учрыг олохгүй болгоод тавьчихлаа. Эрүүл саруул ухаанаар ярьж, хэлэлцэх шаардлагатай.

Монгол Улс дахин зээл авах нөхцөл нэн тааламжгүй болсон. Үндсэндээ арван хэдэн хувиас доошоо буух санхүүгийн эх үүсвэр манайд олдохгүй. Санхүүгийн институциуд манай улсын рейтингийг нэлээд буулгалаа.Тэгэхээр өнөөдөр арав гаруй хувийн хүүтэй зээл авах

гэж байгаа, ийм шийдвэр гаргах гэж буй хүн бол Монгол Улсын эсрэг гэмт хэрэг хийж байна гэж ойлгох хэрэгтэй. Ийм шийдвэр гаргаж буй улстөрийн намыг зайлуулж, улстөрийн тавцангаас арчиж хаях хэрэгтэй. Засгийн газрыг нь



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

өчиггүй зайлуулах хэрэгтэй. Энэ бол хоноцийн сэтгэлгээ. Миний дараа юу ч болсон яадаг юм, ялангуяа 2016 оны сонгуулийн дараа ямар үр дүн гарах нь хамаагүй гэсэн муухай сэтгэлгээнээс хандаж байна. Одоо Монгол Улсын өр, зээлийг нэмж авахгүйгээр явахад 2016, 2017 оноос хөрөнгө оруулалтын асуудал маш хүнд болохоор байна. Наана нь тодорхой арга хэмжээ авах байх гэж горьдож сууна. Харин ийм нөхцөлд нэмээд зээл авбал үнэхээр хачин юм болно. Босохоос өөр аргагүй. Мөн улсын төсвийн бүрдүүлэлт. Орлого, зарлагын асуудлыг тодорхой ярих цаг болсон. Олон жил хий хоосон ярилаа. Санаа нь оноо нь байгаа. Өмч хувьчлалын асуудал явахгүй байна. Хаяа ярих ч амьдрал дээр хэрэгжүүлсэн зүйлгүй л сууж байна. Санхүү, санхүүгийн зах зээл, даатгалын тогтолцоог сайтар бүрдүүлж хөгжүүлээгүй тохиолдолд эрчимтэй хөгжлийн тухай ярихад учир дутагдалтай. Ер нь бид хүй нэгдлийн үед л амьдарч байгаа юм шиг байна.

**-Эдийн засаг нь өөрөө улстөртэй холбогдох юм. Улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн харалган бодлого, шийдвэрийн сөрөг нөлөө эдийн засагт муугаар тусч байна.Улс төрийн залгамж халаа, бодлого, төрийн хүнийг гаргаж ирдэг систем зэрэг асуудал манайд ор тас хаягдсан. Энэ бүхэн улсын хөгжилтэй холбогдож ирж буйг бид сүүлийн үед тод томруун харж байна. Яаж өөрчлөх вэ?**

-Манайд хуучин тухайн үеийнхээ нийгмийн мөн чанарт нийцсэн боловсон хүчний бодлого гэж айхавтар зүйл байсан. Социализмын, төвлөрсөн төлөвлөгөөт нийгэмд зориулагдсан гээд шүүмжилдэг л дээ. Гэхдээ Монгол төрийн боловсон хүчний бодлого гэж бичигдсэн, бичигдээгүй хууль байсан юм аа. Удам угсаа, нутаг ус, эрхэлж буй ажил төрөл, нэр хүнд, зан чанар, мэргэжил боловсрол, сэтгэлийн хат тэнхээ, хорио цээрийг мэддэг мэддэггүй, уян зөөлөн зан чанар, мөнгөний шунал гэх мэт олон шүүлтүүр механизм байсан. Хуульд яг ийм тийм гэж бичээгүй ч боловсон хүчний бодлого хэрэгжүүлэх явцдаа эдгээр механизмыг голчилдог байсан. Энэ нь Монголын төрт ёсны олон жилийн түүх уламжлалтай уялдаатай. Энэ системийг XXI зуунд улам боловсронгуй болгоод ноён нуруу нь аваад явах байсан. Гэтэл ор тас хаясан. Өнөөдөр төрийн боловсон хүчнийг бэлтгэдэг, дэвшүүлдэг шүүлтүүр алга. Дарга нарыг дагалдан гүйдэг, мөнгөөр асуудлыг шийддэг, эсвэл улс төрийн намуудад элсэж орилж, хашгирч, гүйж дэвшдэг механизм өнөөдөр үйлчилж байна. Тиймээс мэдлэг боловсролтой, шулуун шударга зантай, чадалтай, жинхэнэ төрийн ажил хийх хүмүүс гарч ирэхгүй, гарч ирэх ч нөхцөлгүй байна шүү дээ.

Цаашид Монгол төрт ёсны тогтолцоо, залгамж халаа, боловсон хүчний бодлогыг өнөөгийн нийгмийн онцлогтой уялдуулан холбож авч явах нь зөв байх. Англи, Америк, Японы тогтолцоог шууд хуулл гэдэг. Хүчээр оруулж ирээд шууд хуулж болохгүй. Би энд шүүмжлэлтэй ханддаг. Нэн шинэ үеийн түүхэнд ийм зүйл тохиолдож байсан. Тод жишээ гэвэл дэлхийн хоёрдугаар дайны дараа 1950 оны сүүлээр манайх хоёр хөрштэйгээ эв найрамдалтай сайхан байна гээд армиа татан буулгасан. Гэтэл Зөвлөлт, Хятадын харилцаа муудаад ирэнгүүт армийг шинээр дахин босгох шаардлагатай болж, олон асуудал тулгарсан. Хамгийн гол зүйл нь бүхэл бүтэн үе тасарсан. Хурандаа, Хурандаагийн дэргэд бага дэслэгч байх. Энэ хоёрыг холбох ахмад, хошууч, дэд хурандаа нарын үе тасарсан хэрэг. Армийг шинэчлэн зохион байгуулах, боловсон хүчнийг бэлтгэхэд их хүч хөрөнгө, цаг хугацаа шаардлагатай болсон.

Өнөөдөр бас иймэрхүү зүйл тохиож байна. Нийгэм, үе хоорондын залгамж бодлого тасарсан. Социализмын нэрээр бүх зүйлийг үгүйсгэсэн. Шинээр гарч ирсэн зүйлс нь нийгэмд төлөвшиж амжаагүй байтал одоогийн төрийн тогтолцоо нь өөр үнэлэмжүүд рүү явж байна. Тийм учраас үүх түүхээ сайн мэдэж, ойлгож, авах, гээхийн ухаанаар асуудалд хандах шаардлагатай байна.

**-Дэлхийн улс төрийн чиг хандлага хаашаа явж байна вэ?**

-Өнөөгийн намуудын тогтолцоо зөвхөн Монголд бус дэлхийн хэмжээнд явахааргүй харагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, тодорхой асуудал тойрсон, дэвшүүлсэн нийгмийн хамтлаг, хөдөлгөөн, холбоод цаашид улс төрд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, нэлээд хүчирхэгжиж хөгжихөөр байна. Энэ утгаар ард иргэд өөрсдөө хөдөлгөөнт субьект болж хувирна. Тухайлбал, би байгаль орчныг хамгаалах хөдөлгөөнтэй хамтарч байгаль орчны асуудлаар тэмцэх, маргааш нь унадаг дугуйчдын хөдөлгөөнд элсээд нийслэлд унадаг дугуйны зам гаргах талд хүчтэй дуугардаг болох жишээтэй. Ирээдүй рүү чиглэсэн шинэ цагийн энэ бодлого хүчтэй хэрэгжээд ирвэл улс төрийн намуудын бүтэц бүрэлдэхүүн, зорилгод өөрчлөлт орно. Хатуу гишүүнчлэлтэй байх уу, үгүй юу гэх мэтээр улстөрийн намуудыг төлөвшүүлэхэд ирээдүйн энэ чиг хандлага ихээхэн нөлөөлнө.

**-Өнөөдрийн улс төрийн байдал хүмүүсийг Ерөнхийлөгчийн засаглалтай байх нь ч дээр юм гэсэн яриаг гаргаж байна. Хэрэлдсэн, маргасан, биенээ хэмлэсэн нам, нам доторх олон фракц, улс төрийн хүчин байснаас нэг хүний зангараг удирдлага дор явах нь зөв гэж үзэх хүмүүс байна?**

-Би энэ асуудлыг хөндөг хүнийг нэг. Хөндөхдөө нэг бол Парламент, эсвэл Ерөнхийлөгчийн засаглалтай байх зарчмыг баримталдаг. Өнөөдрийнх шиг өөх ч биш, булчирхай ч биш байх хэрэггүй гэж. 2004 оны сонгуулийн өмнө энэ асуудлыг хөндөж гаргаж ирсэн. Шийдэх боломж байсан ч чадаагүй. Миний хувьд бол Парламентын засаглалыг илүүд үздэг. Монгол Улс сайн, муу ч ийм засаглалтай байх нь зөв. Гэхдээ сонгодог утгаар нь хөгжүүлэх ёстой гэж байнга хэлдэг. Парламентын засаглал өөрөө гал хамгаалллын механизмүүдийг агуулдаг. Өнөөдөр Үндсэн хуулийг шинэчлэх асуудал яригддаг. Нөгөө талаас бид Үндсэн хуулийнхаа потенциалийг бүрэн ашиглаж чадахгүй байгаа. Утга агуулга, үзэл санааг бүрэн мэдэхгүй мөртлөө өөрчлөөд өгье гэх. Үсчсэн байдлаар явж ирсэн нь монгол төрийг ийм хэмжээнд хүргэлээ. Тиймээс одоо асуудалд яарч сандралгүйгээр эрүүл саруул ухаанаар хандах ёстой. Үндсэн хуулийнхаа потенциалийг бүрэн шавхсаны дараа өөр зүйл рүү оръё.

**-Эдийн засагч, судлаачид дэлхийн эдийн засгийг сэргэх хандлагатай байгаа талаар ярьж, бичиж байна. Харин манай төрийн түшээд одоогийн хүндрэлийг дэлхийн хямралтай холбоотой мэтээр ярьж иргэдэд ухуулж байгааг Та хэрхэн дүгнэж байна вэ?**

-Наад тайлбар чинь миний инээдийг хүргээд байгаа. Учир нь дэлхийн эдийн засаг жинхэнэ хямарч байхад манайхан огт дуугараагүй. Хямралаас гараад эдийн засгийн өсөлт өөд аажим аажмаар явж буй үед дэлхийн эдийн засаг хямарсан, хямрал нь манайд нөлөөлсөн мэтээр ярихыг би ерөөсөө ойлгохгүй, гайхаад байгаа. Тэгэхээр тэд ямар ч боловсролгүй хүмүүс үү, эсвэл хэл нь хальтирчихдаг юм уу.

Динамикаар харвал дэлхийн эдийн засаг өөдлөх өнгө аяс руу орсон. Америкийн эдийн засаг сайжрах байдалтай. Японых ер нь их гайгүй өнгөтэй явна. БРИКС-ийн орнуудын эдийн засаг өсөлттэй, заримынх нь саарсан. Түгшүүртэй буй нь Евро зон. Гэхдээ улам бүр дордчихгүй болов уу гэсэн хүлээлттэй. Евро зоны санхүүгийн систем хүндэн байгаа. Гэхдээ улс орнууд бие биенээ татаж чангаагаад хямралаас гарч буй дүр зураг харагдана. Хоёрдугаарт улс төрийн үйл явдлын өрнөл эдийн засгийн нааштай өсөлтөд саад болох вий гэсэн болгоомжлол бий. Гурав дах нь технологийн өөрчлөлт. Сүүлийн үед гарч ирж буй технологийн өөрчлөлт дэлхийн эдийн засгийн дүр төрхийг нэлээд өөрчилж байна. Тухайлбал 3 D принтинг. Өмнө нь бид өргөжилтийн хэмнэлт гэж ярьдаг байлаа. Чи 100 төгрөгөөр үйлдвэр байгуулаад нэг ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол өртөг нь 100 төгрөг. Хоёр бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл нэгнийх нь өртөг 50, 100 төгрөг бол нэгнийх нь өртөг нэг төгрөг гээд өргөжих тусам хэмнэлт гараад явах загвар. Эдийн засгийн энэ загвар өнөөдөр дэлхийд хэрэгжиж байгаа. Хятадын эдийн засгийн гайхамшгийн гол онцлог нь энэ өргөжилтийн хэмнэлтийн хуульд тулгуурласан тогтолцоо юм. 3D принтингийн гайхамшигтай шинж чанар бол нэгж бүтээгдэхүүний зардал ялгаагүй. Нэгийг ч, саяыг ч үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүний зардал адилхан. Өндөр хөгжилтэй орнууд, үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрээ Хятад руу, хөгжиж буй орнууд руу зөөсөн шүү дээ. Тэгвэл 3D принтинг хөгжсөнөөр энэ байдал тэс өөрөөр уншигдахад хүрч байна. Энэ утгаараа үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэлээ эх орон руугаа зөөж эхэллээ.

Америкийн хэд хэдэн компани үйлдвэрээ эх орондоо шилжүүллээ. Германд ийм үзэгдэл ажиглагдах болов. Илүү өндөр технологийн үйлдвэрүүдээ эх орондоо шилжүүлж байна. Ийм процесс дэлхий дахинаа явчихлаа. Ойрын 10 жилийн хугацаанд энэ технологийн хөгжил шийдвэрлэх процесс байх уу үгүй юу гэдэг нь харагдана. Хэрвээ шийдвэрлэх процесс байж чадвал дэлхийн эдийн засгийн бүтэц өөр болно. Тэгэхээр дэлхийн хөгжлийн ирээдүйн хандлага, технологийн хөгжилтэй улс орныхоо эдийн засгийн бодлогоо уялдуулах, алсын хараатай ажиллах шаардлага манайд зүй ёсоор тулгарч байна.

**-Засгийн газрын эсрэг үгүй гэж хэлж чаддаг банкийг жинхэнэ Төвбанк гэж үзэх шалгуур байдаг юм билээ. Харин манай Монголбанк үгүй гэж хэлсэн түүх байдаг уу?**

-Бараг байхгүй. Анх хоёр шатлалтай банкны тогтолцоо гарч ирэхэд Монгол банк Сангийн яамны харьяанд Засгийн газартаа захирагдана гэсэн асуудал гарч ирж, нэлээд маргасан. Түүнээс хойш илт маргаагүй ч Төвбанкны үйл ажиллагаа нь Засгийн газрын хавсарга байдалтай яваад байгаа шүү дээ. Монгол банкны үе үеийн удирдлагууд Төв банкны эдийн засгийн бие даасан байдал, эрх мэдлийг ухамсарлаж байсан эсэхийг мэдэхгүй. Харин сүүлийн үеийн удирдлагууд ойлгоод байх шиг байгаа юм.

**-Зарим хүмүүс Төв банкны явуулж буй мөнгөний бодлогыг дэмжих, нөгөө нь буруу хэмээн шүүмжлэх. Заавал онол дагах бус улс орныхоо өөрийн онцлогт тохирсон мөнгөний бодлого хэрэгжүүлж болох уу?**

-Толгой зовоох асуудал энд

# ХААН БАНК

ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД

Орон даяар байрлах **100%** онлайн
**530 САЛБАР**

Мэдээллийн аюулгүй байдлын
удирдлагын тогтолцооны
**ISO/IEC 27001:2013** сертификат

Таны санхүүгийн
**НАЙДВАРТАЙ ТҮНШ**




МОНГОЛ УЛСЫН
**ШИЛДЭГ БАНК**
**2014**

EUROMONEY 2014 Awards for excellence
2006
2007
2008
2009
2010
2012
2014

МОНГОЛ УЛСЫН
ШИНЭЛЭГ БУТЭЭГДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭГЧ
**ШИЛДЭГ БАНК**
**2014**



МОНГОЛ УЛСЫН ХАМГИЙН
**ИДЭВХТЭЙ АККРЕДИТИВ**
НЭЭГЧ БАНК
**2013**



Харилцагчийн мэдээллийн төв **1800-1917**

www.**khanbank**.com

khanbank.com/**facebook**

khanbank.com/**twitter**

# The BIG DEAL

2014 оны 12 сарын 31 хүртэл онцгой УРАМШУУЛАЛ



## 2014 NEW FORD RANGER

Хөдөлгүүр: 3200 cc
Шатахуун зарцуулалт: 11-14л
Үйлдвэрийн баталгаа: 3жил 60,000км

~~70,000,000~~ **65,000,000**



***Ford Ranger*** загварын бат бөх даац сайтай 985 кг даах тэвш нь ямарч жижиг дунд бизнес эрхлэгчдэд зайлшгүй хэрэгтэй бөгөөд хурд хүч, техник үзүүлэлт, хэлбэр загвараараа ангилалдаа шалгарсан шилдэг автомашин юм.

**ЗЭЭЛИЙН ХҮҮ 0%* БОЛЛОО**

**ДУГУЙ** 4Ш ӨВЛИЙН

**ЗАСВАР** ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ

**2015 ОНЫГ ДУУСТАЛ СЭЛБЭГ**
**10%** ХӨНГӨЛӨЛТТЭЙ АВАХ ЭРХИЙН БИЧИГ

EURO NCAP — First Pickup with a 5-Star Euro NCAP Safety Rating 2011

Overall Car of the Year 2012

International Pick-Up Award 2013

Car Awards Group — Best Pick-Up 4X2 2013

WHAT VAN? — Pick-Up of the Year 2013

VansA2Z.com — Best Pick-Up 2013

4x4 — Pick-Up of the Year 2013

| ЗЭЭЛИЙН ХУГАЦАА* | ЗЭЭЛИЙН ХҮҮ* (ТӨГРӨГ) |
|---|---|
| 1-6 CAP | 0 % |
| 7-12 CAP | 0,9 % |
| 13-18 CAP | 1,2 % |
| 19-24 CAP | 1,4 % |
| 25-36 CAP | 1,55 % |
| 37-48 CAP | 1,65 % |
| 49-60 CAP | 1,7 % |

### FORD EVEREST — 10-14л 2500cc



~~76,000,000~~ **69,500,000**

### FORD EXPLORER — 12-17л 3500cc



~~98,000,000~~ **94,000,000**

### FORD EXPEDITION — 18-24л 5400cc



~~139,000,000~~ **129,000,000**

### FORD RAPTOR — 18-25л 6200cc



~~143,000,000~~ **135,000,000**

- ҮЙЛДВЭРИЙН БАТАЛГААТ ХУГАЦАА
- ЛИЗИНГИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ
- МЭРГЭЖЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ
- БАТАЛГААТ СЭЛБЭГ НИЙЛҮҮЛЭЛТ

Утас: 9910-8368, 9911-8375
9911-8301, 9910-8386

Ford | WAGNER ASIA AUTOMOTIVE LLC

МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

ерөөсөө байхгүй. Ямархуу арга хэмжээ авах талаар нь сурах бичиг дээр хүртэл онол нь байгаа шүү дээ. Тэр онолоор арга хэмжээ авч болно. Гэхдээ Монголын эдийн засгийн онцлог, бүтцийг судлах хэрэгтэй. Нэг хэсэг нь мөнгөний бодлогоор дамжуулаад зайлшгүй барьж байх нөөцийн хэмжээ, Төвбанкны хүүгээр эдийн засгийн асуудлыг тухайлбал, инфляцийг зохицуулна гэдэг. Гэтэл энэ талаас нь харвал тэр нөлөөлөл нь манайд маш бага. Ном дээр хэрвээ бодлогын хүүг нэмэгдүүлбэл эргэлтэд буй мөнгөний хэмжээ багасана, эдийн засгийг хумиж байж эдийн засгийн зарим асуудлыг шийдэж болно гэж бий. Манайд ийм бодлого арга хэмжээ авлаа гээд эцсийн дүндээ инфляци буурахгүй байгаа юм. Тэгэхээр онол гэхээс илүү прагматик бодит амьдралд дээр тулгуурласан зөв шийдвэр хэрэгтэй. Монголбанкнаас хэрэгжүүлэх бодлого,арга хэмжээ бол сурах бичгийн онол дагасан шийдвэрүүд.Төвбанк стандартын бус шийдлүүд гаргах гэж оролдсон. Тухайлбал, үнэ тогтворжуулах хөтөлбөр нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайтар мэдэрч, авсан сайн шийдвэр. Хоёрдугаарт энэ шийдвэр нь цаанаа улс төртэй холбоотой. Цаг хугацааны хувьд Ерөнхийлөгчийн сонгуультай давхцсан, өөрөөр хэлбэл, тэр их мөнгийг эдийн засаг руу цацсан нь Ерөнхийлөгчийн сонгуульд үр дүн гаргах хүсэлтэй холбоотой. Юун дээр алдсан бэ гэвэл цаг хугацааг сунжруулсан. Богино хугацаанд нэг удаа эрчимтэй хийгээд татчих ёстой шийдвэрийг хэтэрхий сунжруулсан. Болж байна, сайн байна, үр дүн гарна гэж явсаар эцэст нь барилгын салбараа унагаад авлаа. Үнэ ханшаа туугаад тавьчихлаа шүү дээ.

**-Эдийн засгийн хүндрэлээс гарах нэг гарц Оюутолгой мөн үү?**

-Мөн. Энэ хорвоо дээр үнэ төлбөргүй юм байхгүй. Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх. Ямар УИХ, ямар Засгийн газартай байна, ямар хууль баталж байгааг харуулж байгаа юм. Мөн манай улстөрчдийн чадавхи, ёс зүй, суртахуун, шунал, хулгай хийх байдал нь ямар билээ. Энэ бүхний нийлбэр явсаар Оюутолгойг ийм байдалд хүргэсэн. Чи өнөөдөр ямар байна, түүний чинь хариу төлбөр гэж ойлгох хэрэгтэй. Зугатах гээд хэрэггүй. Хүлээн зөвшөөрөөд дараа дараагийн алхмуудаа зөв зүйтэй хийгээд явах ёстой. Зөв зүйтэй алхам хийх нөхцөлийг бүрдүүлэх учиртай.

**-Хөршүүдтэй харилцах эдийн засгийн бодлогыг та хэрхэн дүгнэх вэ?**

-Эдийн засгийн асар том потенциал Хятадад бий. Үнийг бид яаж ашиглах вэ гэдэг л асуудал. Зүүн Азийн орнууд Хятадыг бүрэн хэмжээгээр ашигласан. Хятад АСЕАН+1 чөлөөт худалдааны гэрээг АСЕАН-ы орнуудтай байгуулсан. Тухайн үеийн Ерөнхий сайд нь “ Хятад улстай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан АСЕАН-ы орнуудад өрмийг нь өгнө” гэж хэлсэн байдаг. Үнэхээр ч гэрээнийхээ хамгийн амттай хэсгийг тус орнуудад хангалттай өгсөн. Хятад ч өөрөө Зүүн Азийн маш том зах зээлийг эзэлж авсан, санхүүгийн эх үүсвэрийг татлаа. Бүс нутгийн том өөрчлөлт гарангуут зарим орон сандарч эхэлсэн. Хамгийн их сандарсан нь Япон. Япон Сингапуртай очоод эдийн засгийн Иж бүрэн түншлэлийн гэрээг байгуулангуут АСЕАН-д нэгдэж АСЕАН+2 болсон. Дараа нь Өмнөд Солонгос орсноор АСЕАН+3 болов. Үүний цаана бүс нутгийн эдийн засгийн боломж, харилцан ашигтай механизмуудыг бүрэн ашиглах хэрэгтэй гэсэн санаа байгаа юм.

Харин манайх хоёр талын л худалдааны механизмуудыг ашиглаад байгаа болохоос бус олон талт худалдааны механизмаар дамжуулаад Хятадын зах зээлийг ашиглах бололцоог олж хараагүй байна. Одоо дөнгөж эхлээд буй Номхон далайн эдийн засгийн түншлэлийн гэрээнд Монгол Улс нэгдэж орох нь чухал байна.

Хойд хөршийг аваад үзэхээр гунигтай л даа. Хэрвээ би андуураагүй бол Монголын нийт гаргаж буй экспортын 1,4 хувийг ОХУ эзэлж байна. Монголын хувийн салбар, бизнесийнхэн Оросгүйгээр амьдарч болох нь гэсэн үг. Энэ нь ОХУ-аас явуулсан тарифын бодлоготой холбоотой. Энэхүү тарифын бодлого бол монголчуудаа бидэнтэй арилжаа наймаа бүү хийгээрэй гэсэн утгатай агаар нэг. Үндэсний бүтээгдэхүүн, тухайлбал, Оросын зах зээлд хивсээ зарахаар очихоор өндөр тариф урдаас тавина. Тэгэхээр монгол бизнесмэнүүд хивсээ зарах өөр зах зээл хайна шүү дээ. Өнгөрсөн хугацаанд ОХУ-аас авч буй зүйлд бараг л өөрчлөлт ороогүй байна. Нөгөө талаас хойд хөршийн энэхүү харилцааг асар том бололцоо гэж харах хэрэгтэй. Харилцан бие биедээ ашигтай байх зарчмаар худалдааны эргэлтийг эрчимжүүлэх сайжруулах шаардлагатай. Улс төрийн байр сууринаас энэ асуудлыг зөв илэрхийлэх нь чухал байна.

**-Манай иргэд төр засагт асуудал тавих, хэлж ярих, жагсахыг мэдэхгүй, их тайван хүмүүс. Гадаадад бол аль дээр асуудлыг гаргаж, жагсаад тэмцсэн байгаа даа. Энэ нь монголчуудын зан чанартай холбоотой юу?**

-Монгол хүн хүлээцтэй тэвчээртэй байна гэдэг нэг ондоо асуудал. Ер нь монгол хүн дуугаа хураахаараа нэг л өөр болчихдог. Би энэ талаас нь хардаг. Болж байна, бүтэж байна, эсвэл гарч ирж шүүмжилж, орилж хашгираад явбал болж байгаа юм байна гэж дотроо боддог. Ярихаас дөлөөд, зугатаад бүлх залгисан юм шиг л байвал хэцүү байгаа юм байна гэсэн үг. Шинжлэх ухааны үндэстэй шалгуур биш л байх л даа. Гэхдээ би 20-иод жил улстөрд нухлагдаж байна. Хөдөө орон нутгаар явахад ийм зүйл ажиглагддаг.

Ер нь ард иргэдийн ам эргэчихсэн байна лээ. Тэдний итгэл найдварыг сэргээх хэрэгтэй. Энэ нь хувь хүний бус эдийн засгийн, Засгийн газар цаашлаад улс төрийн намын эрх ашиг хөндөгдөнө. Намын үүднээс авч үзвэл иргэдийн итгэл сэтгэлийг сэргээх асуудал чухал байна. Би 2012 оны сонгуулийн өмнө ярьж байсан. Монголд улс төрийн хоёр том хүчин байгаа. Гэрийн хоёр багана гэсэн үг. Нэг багана нь салж бутраад дотроо асуудал үүсч байна. Тэр тохиолдолд хүнд ачаа нөгөө намд ирэх ёстой. Ардчилсан нам илүү их ачаа үүрч, тэр хэмжээгээр хариуцлагатай байх шаардлагатай. Алдаа байхгүй, дутагдалгүй юм шиг царайлж, эх орны эрх ашиг, эв нэгдэл гэх гоё нэр томъёо ашиглаад халхавч хийгээд өөрийн хариуцлагагүй, замбараагүй, мэдлэггүй, чадахгүй буйгаа нуух хаах байдлаар ажиллах хэрэгтүй гэж үздэг учраас би намынхаа төлөө намаа үе үе хатуу шүүмжилдэг. ■

2014 ОНЫ 09 САР.

# БИЗНЕС

*Ядуу буурай орноос ялалтын оргилд хүрсэн, үсрэнгүй хөгжсөн гээд ямар ч орны хөгжлийн тулгуур үндэстний баялаг бүтээгчид болон бизнес эрхлэгчдийн хөдөлмөр бүтээлтэй холбоотой байдаг. Хөгжил дэвшилтэй холбоотойгоор Монголын бизнес эрхлэгчдийн өмнө том сорилт, шинэ боломжууд гарч ирсээр. Шинэ сорилтыг хэрхэн боломж болгох вэ.*






Гэрэл зургийг Б.Бямба-Очир



*1944 онд Австрийн Виллах хотод төрсөн Петер-Брабек Летматете Веннын Олон улсын худалдааны их сургуулийн эдийн засгийн ангийг төгсчээ. 1968 онд "Nestle" компанид борлуулагчаар орж, удалгүй шинэ бүтээгдэхүүн боловсруулагчийн албан тушаалд дэвшжээ. Тэрбээр Чили улсад компанийнхаа борлуулалтын менежерээр 10-аад жил,1981 онд Экуадор дахь компанийнхаа захирлаар, 1983 онд Венесуэл дэх захирлаар тус тус ажилласан байна. Түүний хувьд албан тушаал байнга өсч явсаар 1997 онд компанийнхаа гүйцэтгэх захирлаар сонгогдсон юм. Летматете 2008 оныг хүртэл энэхүү албыг хашаад эдүгээ "Nestle"-гийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.*

*Түүний шаргуу дайчин, хөдөлмөрч чанар, мөн ажилдаа сэтгэлээсээ дуртай байдал нь өнөөдрийн өндөрлөгт хүргэсэн гэж үздэг. Шүлс асгаруулам амттай зайрмагийг өглөөний нарнаас үдшийн бүрий хүртэл борлуулж, өөрийн бизнесийн бяцхан амжилтдаа хөөрөн баярлаж явсан Петер-Брабек Летматете тухайн үедээ дэлхийд алдартай том компанийг удирдан чиглүүлэгч болно гэж төсөөлж явсан болов уу.*

*Летматете "Ньюком" компанийн урилгаар Монголд зочилж манай хувийн хэвшлийнхэнтэй бизнесийн арга туршлагаас хуваалцахаас гадна усны асуудлаар сонирхолтой лекц уншиж хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Бизнесийн нууц, амжилтын талаар түүнтэй хийсэн ярилцлагыг хүргэж байна.*

ЗОЧИН

*"Nestle"-гийн ТУЗ-ийн дарга Петер-Брабек 2012 онд Монголд зочилсон.*

# Зайрмагны борлуулагчаас NESTLE-гийн захирал хүртэл

**-Mongolian Economy сэтгүүлийг сонгон ярилцлага өгч байгаа танд талархсанаа илэрхийлье. Хоёулаа таны бизнесийн гараагаа хэрхэн эхэлж байсан түүхээс ярилцлагаа өрнүүлье?**

-БигэдэгхүнNestle-тэйамьдралаа холбоод 44 жил болчихжээ. Бараг бүхий л амьдралынхаа туршид энэ компанитай хамт байсан гэж хэлж болно. Анх би Австри улсад мөхөөлдөсний худалдаа хийдэг байлаа. Өглөөний нарнаас орой хүртэл мөхөөлдсөө зарж, олсон мөнгөндөө баясаад их л аз жаргалтай байдаг байсан санагддаг. Хурдтай хөгжиж буй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын дунд бизнесээ эхлэх хуучны сайхан аргуудын нэг нь ийм төрлийн жижиг бизнес байсан тул тэр үед тийм ч гайхаад байхаар сонин зүйл байгаагүй юм. Учир нь, бизнесийн гол цөм нь борлуулалт байдаг.

Бүтээгдэхүүн хийж, үйлдвэрлэл явуулаа гээд мөнгөжихгүй. Харин тухайн бүтээгдэхүүнийг борлуулж эхлэхэд мөнгө орж ирдэг. Бид ийм л замаар бизнесээ эхлүүлсэн.

**-Та кофе уух дуртай юу?**

-Миний өглөөний цай гэж хэлж болно. Өглөө босоод хамгийн түрүүнд бага зэргийн шоколад хийсэн аяга кофе уудаг.

**-"Nestle" дэлхийд тэргүүлэгчдийн нэг. Амжилтын нууцаасаа хуваалцана уу?**

-Амжилтад хөтөлсөн тодорхой хүчин зүйлүүд бий. Нэн тэргүүний хүчин зүйл бол урт хугацааны зорилт. Танай компани урт хугацаанд хөгжиж чадах эсэх нь алсын хараатай шийдвэрүүд гаргаж буй эсэхдээ итгэлтэй байхад оршдог. Ахархан хугацааны өндөр ашгийн төлөө бус урт хугацаанд нийгэм болоод хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангасан үнэт зүйлийг бүрдүүлэх асуудал маш чухал.

Хоёрдугаарт, хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхлыг ихэд хүндэтгэдэг байх хэрэгтэй. Дэлхийн хэрэглэгч гэсэн нэг тодорхойлолт байдаггүй. Та дэлхий дээрх хэрэглэгчдийг хоорондоо яг таг адилхан гэж бодож болохгүй. Бүс нутаг, улс гүрнээрээ өөр өөр байдаг. Тухайлбал, Монгол, Хятад, Японы хэрэглэгчдийг хооронд нь харьцуулбал тэдний хооронд асар том ялгаа бий. Тийм учраас шийдвэр гаргах түвшинд хэт ерөнхий авч үзэхгүй байх нь ихээхэн чухал. Хэрэглэгчдэд нөлөөлөхүйц шийдвэр нь үргэлж тухайн бүс нутгийн түвшинд гардаг.

Гуравдугаарт, санхүүгийн хүчирхэг суурь баазтай байх хэрэгтэй.

**-"Nestle"-гийн баримталдаг зарчмуудын талаар сонирхуулахгүй юу?**

-Манай компани хүмүүсийн насан туршын сайн хүнс, сайхан амьдралын төлөө зогсдог. Үүний төлөө л гол зарчмаа тодорхойлж, дагаж мөрдөж, ажиллаж ирсэн. Сайн хүнс, сайхан амьдралыг нь цогцлоох үүрэг хүлээсэн хүмүүс хамгийн чанартай бүтээгдэхүүн хийхийн төлөө явах нь ойлгомжтой. Үнэндээ бид хүмүүсийг хорвоод мэндлэхээс нь өмнө халамжилж эхэлдэг.

Учир нь жирэмсэн эмэгтэйчүүд манай хэрэглэгчид. Үүний дараагаар хүүхдүүдийг амьдралын гараагаа зөв зохистой эхэлж цаашлаад сайхан амьдарч буй эсэхэд анхаарлаа хандуулдаг. Тухайлбал, нярайн тэжээлийн бүтээгдэхүүн Milo байна. Хүүхдийн өсөлт хөгжилтөд дэмжлэг үзүүлж, өсвөр насанд нь хань болдог бүтээгдэхүүн гэж хэлж болно. Мөн ахмад насны иргэдэд зориулсан бүтээгдэхүүн ч бас бий. Энэ мэтчилэн хүний амьдралын бүхий л хугацаанд "Nestle" кофе болон бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүнээрээ дамжуулан хамтдаа байдаг. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын бүхий л үе бидэнд хамаатай юм даа.

**-Танай компанийн түүхэн туршлага болоод амжилт юуг өгүүлдэг гэж Та бодож байна вэ?**

-Аливаа нэг компанийн амжилтад 2-3 голлох хүчин зүйл байдаг. Бидний тухайд, огцом эргэлтэд хөтөлсөн замыг сонгосон юм. Зах зээлд байдаг эсвэл тухайн үеийнхээ хамгийн шилдэг арга замыг сонгож аваагүй. Харин түүнээс илүүтэйгээр зах зээлд тэсрэлт хийсэн тийм л шинэлэг санаанд анхаарлаа чиглүүлсэн. Жишээлбэл, өөрөө уусдаг кофены тэргүүлэгч VR компанийг аваад үзье л дээ. Бид тэр үед яасан бэ гэхээр кофены борлуулалт, үйлчилгээний зах зээлд жинхэнэ шинэчлэл болсон Nespresso кофе-г гаргаж ирсэн юм. Үүнтэй адил манай компани өнөөдөр цайны ертөнцөд тэсрэлт хийхээр дөнгөж саяхнаас төслүүд хэрэгжүүлээд эхэлж байна. Иймэрхүү жишээг, бизнесийн шинэ санааг та өөрийн компанидаа ч туршиж үзэж болно. Шинэ бүтээлээр тэсрэлт хийж, өрсөлдөгчөө хол хаях нь аль ч компанид хамгийн үнэ цэнэтэй асуудал юм. Монголын компаниудын хувьд ч ийм үүд хаалга нээлттэй шүү дээ.

**-Хүндрэл бэрхшээлийг туулах нь бизнесийн амжилтын үндэс болдог гэдэг. Та юу гэж хариулах вэ?**

-Амьдралд хэцүү асуудал бишгүй тохиолддогийн адилаар миний бие энэ компанид 44 жил ажиллахдаа маш олон саад бэрхшээлтэй тулгарч явлаа. Хамгийн гол нь чиглэлээ зөв тогтоож, өөрөөр хэлбэл, өгөөж сайтай чигийг тууштай барьж явах нь эрсдэл саадын алийг нь ч ажралгүй өнгөрөөнө гэсэн үг. Улмаар та өөрөө бэрхшээлийг боломж болгон хувиргах арга замыг төвөггүйхэн олж чаддаг болно. Эрсдэл, боломж хоёр хоорондоо маш ойрхон оршдог. Зарим үед энэ нь тухайн хүний сэтгэлгээний л асуудал байдаг. Сайнаар харвал маш том саад бэрхшээл дундаас сайхан боломж олддог.

**-Бизнесийн сайн удирдагч гэж ямар хүнийг хэлэх вэ?**

-Дэлхий дээр бизнесийн нэр хүндтэй, алдартай эсвэл танил бус удирдагчид надад олон бий. Миний хувьд сайн удирдагч гэж өөрийн компанийн үйл ажиллагааг нэг шатаас нөгөө рүү шилжих үйл явцад бодитой тус хүргэж чаддаг хүнийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, жинхэнэ удирдагч хэзээ нэгэн цагт сэтгэл зүтгэлээ зориулсан компаниа орхиод явах тохиолдолд тухайн компани нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн амжилттай ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадсан байдаг. Ийм хүн бол удирдагч мөн.

**-"Nestle" нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ?**

-Миний бодлоор нийгмийн жинхэнэ хариуцлага гэдэг нь компанийн зүгээс голлох бодлого чиглэлдээ хувьцаа эзэмшигч болон нийгэмд зориулсан үнэт зүйлийг бий болгох асуудлыг сайтар тусгаж өгсөн байхыг хэлэх болов уу. Компанийн нийгмийн хариуцлагыг хүртээмжтэй үнэт зүйлийг бүтээх гэж нэрлэдэг. Бид ингэж ойлгож, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн.

**-Тухайлбал?**

-Энэ бол их энгийн зүйл. Та хотын гадна нэгэн тосгонд шинээр гарч ирж буй зах зээлд чиглэсэн үйлдвэртэй боллоо гэж бодъё. Гэтэл бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй тул нийгэм дэх нөлөөлөл тэр хэмжээнд маш томорч, асуудал үүснэ гэсэн үг. Тиймээс та үйлдвэрээ барихаас өмнө хүмүүсээ бэлтгэж эхлэх хэрэг гарна. За тэгээд ханган нийлүүлэгч олдохгүй, хэрэгтэй механик, цахилгааны мэргэжилтэй хүмүүс ч олдохгүй болно. Тэднийг сургаж авах шаардлагатай тулгарна. Мөн эргэн тойронд байгаа ханган нийлүүлэгчид чанартай нийлүүлэлт хийх үү, үгүй юу гэдэгт итгэлтэй байх ёстой.

Таны бизнесийн зүгээс үзүүлж буй нийгэм дэх нөлөөлөл маш том учир та нийгэмд өөрийн гэсэн үнэ цэнийг бий болгох шаардлага гарна. Жишээлбэл, тухайн тосгон хаягдал

усыг цэвэршүүлэх эх үүсвэргүй бол тийм төрлийн станц барих хэрэгтэй. Үүний дараа та тосгоны иргэдийг бохир усаа ус цэвэршүүлэх станц руу хийхийг зөвшөөрнө. Энэ нь таны нийгэмд тулгамдсан асуудалд оролцож буй нэг хэлбэр болох юм.

Компанийн нийгмийн хариуцлага бол ажил хэргээ зөв зохистой явуулахын хажуугаар үүргээ ухамсарлаж нийгэм дэх үнэт зүйлийг бэхжүүлэхэд оролцоогоо чиглүүлэх гэж ойлгож болно. Энэ нь манай компанийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлдэг арга барил юм.

**-Дэлхийн бизнесийн чиг хандлага хаашаа явж байна вэ?**

-Бид одоо их эгзэгтэй эмзэг үед байна. Бидний урьдчилж хараагүй олон өөрчлөлт болсоор байна. Тухайлбал "Арабын хавар" тэргүүтэй олон хямралыг нэрлэж болно. Нөгөө талаас, эерэгээр харвал асар хүчирхэг ардчилсан хөгжил байна. Дэлхий дээрх хүн бүрт хүртээмжтэй шинэ боломж, шинэ үүрэг хариуцлага гарч ирж байна гэсэн үг. Сайхан амьдралд хөтлөх сайн хүнсийг илүүтэй чухалчилдаг компанийг төлөөлөн Монголд ирсэн бизнесмэнийн хувьд ирэх жилүүдийг, ирээдүйг өөдрөг сэтгэлээр харж байна.

-Дэлхий дээр кофены олон компани бий. Танай компанийн хувьд өрсөлдөгчөө хэрхэн харж, үнэлж дүгнэдэг вэ?

- Nestle бол ямар ч эргэлзээгүйгээр дэлхий дээрх кофены хамгийн том компани гэж хэлнэ. Бид бусдыг их хол орхисон гэж боддог. Өнөөдөр дэлхий дээрх 100 аяганы 25 нь NesCafe-гаар тамгалагдсан байдаг. Бид зах зээлд өөрсдийн бизнесээ тогтвортой хөгжлийн замаар хөтлөн авч явж, манлайллаа тэр хэмжээнд дээшлүүлэхийг зорьдог. Магадгүй бусад компани кофенд илүү ач холбогдол өгч ажиллаж байгаа байх. Гэвч бидний хооронд маш том ангал бий. Тэр бол бидний манлайллыг өдийг хүртэл авч явж байгаа онцлог хөшүүрэг юм. Манай шинэ кофены төрлүүд тухайлбал, NespressoNesCafe, Dolce, Gusto мөн удаан хугацаанд хадгалж болдог Cappuccino гэх мэт бүтээгдэхүүн байна. Бид янз бүрийн хүсэл сонирхолд тохирсон бүхий л төрлийн кофены хэрэглээг бий болгож чадсан.

**-Монголын уул уурхайн баялаг дэлхийн анхааралд орж, үндэстэн дамнасан корпорациуд хэдийнэ манайд үйл ажиллагаа явуулж байна.Таны хувьд Монгол орноос ямар шинэ боломжуудыг харж байна вэ?**

-АНУ-ын Вашингтон хотод байрладаг Дэлхийн банкны дэргэдэх Төр, хувийн хэвшлийн түншлэлд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Германы Усны нөөцийн группын даргынхаа үүднээс би Монголд хоёр ч удаа ирсэн. Өмнө нь ирэхдээ "Монгол дахь боломжууд ба усны менежментийг хэрхэн сайжруулах вэ" гэсэн асуудлаар Монголын Засгийн газартай ярилцаж байлаа. Тэр үед би энэ удаагийнх шиг Nestle-гийн захирлын үүднээс ирээгүй.

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийг миний хувьд бахдан хүлээн авч, ихээхэн дэмжиж байна. Танай оронд улс орноо хөгжүүлэх, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, мөн шинэ бизнесийн олон боломж байгааг харж байна.

**-Та усны асуудлаар дэлхийг төлөөлж ажилладаг хүн. Ер нь усыг хэн хамгаалах вэ?**

-Ус бол хүн төрөлхтөний хамгийн үнэтэй түүхий эд. Иймд хүн бүр усыг хайрлаж хамгаалах ёстой. Энэ бол ямар нэг хувь хүн, албан байгууллагын голчлон хариуцах асуудал бус дэлхий дээр хүн болж мэндэлсэн иргэн бүрийн үүрэг хариуцлага юм. Харамсалтай нь бид урт хугацааны тогтвортой амьдралын үндэс гэдэг үүднээс нь устай хүндэтгэлтэй харьцдаггүй. Тийм л учраас өнөөдөр бид ингэж их усны асуудалд санаашраад санаа тавиад байгаа хэрэг л дээ.

**-Монгол Улс хүрэн эдийн засгаас ногоон руу шилжих тухай мөн л ярьж байна. Та ямар зөвлөгөө өгөх вэ?**

-Ногоон эдийн засаг хэмээх чиг хандлага дэлхий дээрх олон орны эдийн засагт үндэс сууриа баттай олжээ. Копенгаген хотноо долоо хоног үргэлжилсэн дэлхийн нийтийн дээд хэмжээний Ногоон уулзалтад оролцож байхдаа энэ асуудал бүх нийтийн зовнилыг хүртэж эхэлснийг мэдэрсэн. Байгалийн нөөцийг ашиглаж буй өнөөгийн арга барил тогтвортой бус гэдгийг бид ойлгож байгаа. Одоогийнх шиг нөөц баялгаа ашигласаар байвал энэ дэлхий дээрх 11 тэрбум хүнийг байгаль яагаад ч тэжээж, бас аз жаргалтай амьдруулж чадахгүй юм. Бидний хувьд е. Ногоон эдийн засгийн үндсэн уриа хэт материаллаг хэрэглээг халъя л гэсэн үг шүү дээ. Дэлхийн олон орон энэ уриаг хэрэгжүүлээд Засгийн газрынхаа нэн тэргүүний бодлого болгоод явж байна.

**-Та Монголын бодлого тодорхойлогчидтой уулзаж усны асуудлаар ярилцсан байгаа. Манай төрийн түшээдийн хандлагыг та юу гэж дүгнэж байна вэ?**

-Анх Давосын уулзалтын Байгалийн баялгийн хэсгийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой уулзаад ихэд гайхан биширч билээ. Намайг усны талаар ярьж байхад, тэрбээр над руу эргэж хараад "Юу гээч таны саяын хэлсэн зүйлс чинь Монгол Улсад дэндүү их хамааралтай юм байна. Та бидэндтэй хамтарч ажиллах тухай бодож үзээрэй" гэж билээ. Энэ удаагийн миний айлчлал бидний ярилцсан асуудлуудын хүрээнд хийсэн ажил биш. Харин өнгөрсөн оны зургадугаар сард би Монголын Засгийн газраас зохион байгуулсан усны чуулга уулзалт дээр Монголд тулгарч буй сорилтуудын талаар санал бодлоо хэлэх зорилгоор оролцсон юм. Өдийг хүртэлх хугацаанд бид усны асуудлын гүнд бага ч гэсэн орж чаджээ.

Миний хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын хамтаар байгаль орчны тунхагт гарын үсэг зурсандаа маш их баяртай байна. Уулзсан хүмүүсээс харахад Монголын ирээдүйд усны асуудал ямар их ач холбогдолтойг ийм хэмжээнд ойлгож ухаарсан байгаад миний сэтгэл их хөдөлсөн. Тэдэнд усны төлөөх сэтгэлийн болоод улс төрийн чин хүсэл эрмэлзлэл байгаа нь хамгийн сайн зүйл юм. ■

2012 ОНЫ 04 САР.




*“Өгөөж” компанийн захирал С.Түмэнгэрэл, “Их харанга” команийн захирал Я.Энхтайван*

ШИНЭ САНАА БА БИЗНЕС

# Бизнесмэнүүд бол үнэндээ нийгмийн зарц шүү дээ

*Mongolian Economy” сэтгүүл “New Idea & business” гэсэн булан нээлээ. Манай шинэ булангийн анхны зочноор “Өгөөж” компанийн захирал С.Түмэнгэрэл, “Их харанга” компанийн захирал Я.Энхтайван нарыг уригдлаа. Бизнесээ эхлэх гэж байгаа залууст болон бизнесийн тогоонд чамгүй чанагдаж яваа туршлагатай хүмүүст ч манай “Шинэ санаа ба бизнес”-ийн зочдын ярилцлагаас санаа авах, суралцах зүйл багагүй байна гэдэгт итгэлтэй байна. Энэ агуулгын үүднээс бид ч гэсэн зочдодоо “Бизнес хийхэд зөн совиндоо илүү итгэдэг үү, эсвэл мэргэжилтнүүдийн зөвлөгөөг дагадаг уу? Шинэ санаагаа хэрэгжүүлэх цаг нь мөн үү, эсвэл жаахан хойшоо тавих хэрэгтэй юу гэдгээ хэрхэн мэдэрдэг вэ? гэх мэт шинэлэг асуулт тавьж, ярихаасаа хийхээ урьтал болгодог бизнесмэнүүдийнхээ ярилцлагыг улам сонирхолтой болгосон юм.*

**-Бизнес хийхэд ер нь авьяас чухал байдаг юм уу эсвэл шантрашгүй хөдөлмөр амжилт авчирдаг уу?**

**С.Түмэнгэрэл:** -Зүс таньдаг бизнесмэнтэй яриа өрнүүлэх боломж олгож байгаад баяртай байгаагаа хэлье. Шинэ санаа яаж бизнес болдог тухай сэдэв нь өөрөө сайхан санаа байна шүү (инээв).

Миний хувьд бол бизнес эрхлэнэ гэдэг хүн бүрийн чадах ажил биш юм шиг санагддаг. Бурхан хүн бүрт ямар нэгэн авьяас бэлэглэдэг. “Чи дуу дуулж амьдар” гээд зарим хүнд сайхан хоолой заядаг бол зарим хүн зурж, цөөнгүй хүн зохиол бичээд амьдардаг шүү дээ. Хүн бүрт өөрийн гэсэн хувь тавилан бий. Тэр дотор бизнесийн ухаан ч мөн багтах болов уу. Тухайлбал, би Энхтайван захирлыг ажил хэрэгч, бизнесийн хувь заяатай хүн гэж ойлгодог. Тиймээс ч өнөөдөр “Их харанга” компани гудамж, талбайн рекламны акул болтлоо өргөжиж чадсан байх жишээтэй. Их зөв байрлалд рекламны самбаруудаа тавьчихсан харагддаг.

Мэдээж хүн бүр ямар нэгэн шинэ санаа өвөрлөж, бизнес хийхийг хүсдэг байх. Харин тэрийгээ амьдрал дээр хэрэгжүүлдэг нь хэд вэ гэхээс.

**Я.Энхтайван:** -Бизнес хийхэд их, дээд сургуульд хэн нь илүү сурлага сайтай байсан нь хамаагүй. Бодоод үз дээ, эдийн засгийн академи төгссөн хүн бизнес хийвэл мөн мундаг явна аа даа? Гэтэл тийм биш байдаг юм. Хүсээд олдохгүй, хусаад арилахгүй шинж чанартай байж л хүн бизнес хийдэг.

**С.Түмэнгэрэл:** -Гэхдээ бурхнаас заяасан хувь тавиланг хамгийн гол зүйл гэвэл бас буруудчих талтай шүү. “Би бизнесмэн мөн үү, биш үү?” гэдэг нь асуудлын таван хувь байж болох юм. Үлдсэн 95 хувь нь тухайн хүний хөдөлмөр, итгэл үнэмшил, тэсвэр хатуужлаас шалтгаална. Товчхондоо, бизнесмэн байх нэг өөр, цаашид түүнийгээ амьдралд хэрэгжүүлнэ гэдэг бас өөр ойлголт. Хүнтэй харьцаж сурах, хүнийг уншиж сурах, хэнтэй хамтарч ажиллах вэ зэргээс мөн л их зүйл шалтгаална. Үйлдвэрийн гол ажил ганц хүнээс шалтгаалдаггүй. Нэг ширхэг бүтээгдэхүүн ч гэсэн тэр үйлдвэрт ажиллаж байгаа захирал, үйлчлэгч, мэргэжилтэн гээд бүх хүний хамтын бүтээл байдаг.

**-Та хоёр хэн нэгэнд бизнесээ эхэл гэж зөвлөвөл хамгийн түрүүнд юуг анхааруулах вэ?**

**С.Түмэнгэрэл:** -Багаа зөв бүрдүүлнэ гэдэг хамгийн чухал. Манай компанийн хувьд зөв суурь хүмүүжилтэй хүн авч ажиллуулах юмсан гэсэн зарчим баримталдаг. Түүнээс биш, олон дээд сургууль төгссөндөө биш. Зөв суурь хүмүүжилтэй хүн ажилдаа сэтгэлээсээ ханддаг. Тиймээс үнэнч, зөв төлөвшсөн хүмүүсийг л авахыг хичээдэг. Тийм хүмүүсийг ямар ч тохиолдолд сургаад авч болдог.

**Я.Энхтайван:** -Миний бодлоор бизнес нь юуны түрүүнд зах зээлийн судалгаанаас эхэлдэг юм. Таны өвөрлөж яваа шинэ санаа зах зээлд гараад ирэхээрээ амьдарч чадах уу гэдэг хамгийн чухал. Амьдрууллаа гэхэд эдийн засгийн үр өгөөж нь ямар байх вэ гэдгийг сайн харуулсан төсөл хийх нь л нэгдүгээр алхам болно. Бизнесээ эхлэхийн тулд өрсөлдөөн ихтэй салбарт орох уу, өрсөлдөөн багатай бизнес хийх үү гээд л судалгаа эхэлнэ шүү дээ. Өрсөлдөөн ихтэй салбарт орвол эдийн засгийн хувьд ахиц гаргалаа ч зугуухан хөгжинө.

**-Бизнесмэн хүний хувьд шинэ санаа амьдралаас ургаж байдаг уу?**

**С.Түмэнгэрэл:** -Амьдрал дунд орох юм бол шинэ санаа их гардаг, мэдээж бас их унших хэрэгтэй. Энэ бүхэн цогцлоод ирэхээр бизнесмэн-удирдагч гарч ирнэ. Энэ чинь өөр ойлголт шүү дээ. Компанийг зөв авч явахын тулд бизнесмэн-удирдагч байх ёстой.

**Я.Энхтайван:** -Байгууллага удирдаж байгаа хүний инженер сэтгэхүй маш өндөр байх ёстой. Энэ нь юу вэ гэхээр ямар нэгэн ажил явагдаж байхад хянаж чадах гайхамшигтай шинж чанарыг хэлээд байна л даа. Ер нь эдийн засгийн ухаан гэхээр заавал академи төгссөн байх албагүй. Үнэндээ бүх эдийн засгийн онол тэнгэрээс унаагүй, газраас ургаж гарч ирээгүй. Хүний амьдралын баялаг түүх, үйл ажиллагаанаас л гарч ирсэн. Сургалт гэдэг үүнийг л зааж буй хэрэг. Харин авьяаслаг хүний хувьд энэ бүхэн заалгасан юм шиг дотроос нь ургаад байдаг юм. Ургаж буй авьяас удирдагч хүнд байхад урагшаа явдаг болов уу. Түүнээс биш, хүн бүр захирал хийх гээд, бизнесмэн болох гээд амжилтад хүрэхгүй. Төрөлхийн чадвар хэрэгтэй, тэр ч бүү хэл, бизнесмэн хүн хошигнох ч авьяастай байх шаардлага байдаг.

**-Та хоёр баян хүмүүс мөн үү?**

**С.Түмэнгэрэл:** -Манай зарим хүн бизнесмэнүүдийг ашиг хонжоо хайсан сувдаг шунахай хүмүүс гэж боддог. Уг нь тэр талаасаа бодмооргүй байгаа юм. Хүн шинэ санааг амьдралд хэрэгжүүлээд, өөрт болон бусдад тустай юм хийгээд, түүгээрээ өөрөө хөрөнгөө олж байвал жинхэнэ бизнесмэн мөн. Хэн их мөнгө олсондоо гол нь биш, яаж олж байна вэ гэдэгтээ л байдаг. Мөнгийг бол зөвөөр олох ёстой. Хүн хуурч мэхлэх, хулгай хийх зэрэг муу аргаар биш. Зөв замаар явж байгаа, зөв юм бүтээж байгаа хүмүүсээ дэмжиж байж л бид хөгжилд хүрнэ. Бизнесмэн болно гэж итгэж байвал болохгүй юм байхгүй. Сайн явж байгаа хүмүүстэй уулзаад л, хараад л, суралцах хэрэгтэй дээ. Тэр хүн яаж ажлаа амжуулж, зохицуулж амжилтад хүрч байна вэ гэдгийг л харах ёстой.

**Я.Энхтайван:** -Бизнесмэнүүд бол их баян, ханаж цадахаа мэдэхгүй улс гэсэн ойлголт нийгэмд үнэхээр байдаг. Та эмзэглэж явдаг юм шиг байна, би ч мөн ялгаагүй. Манай нийгэм ухамсар болоод эдийн засгийн хувьд төлөвшиж чадаагүй учраас л ийм яриа гарч байгаа болов уу. Тамирчан хүн мөнгөн медаль авчихаад л "Би боллоо" гээд спортоо хаяж байвал хамгийн утгагүй хэрэг биз дээ? Тэгвэл бизнесмэн нэг үйлдвэр ажиллуулаад ирэхээр нэг талаас тэнд ажиллаж байгаа хүмүүсийнхээ хувь заяаг давхар хариуцаж байгаа хэрэг. Нөгөө талаас тэр бизнесмэн ард түмний төлөө үйлчилж байна. Тэгвэл тэр үүрэг, хариуцлагыг асар гүнзгий ухамсарлах ёстой. Ажлаа зогсоох ч эрх байдаггүй. Хоёрыг үйлдвэрлэдэг байсан бол дөрвийг үйлдвэрлэдэг болох, хүмүүстээ 200 мянган төгрөгийн цалин өгдөг байсан бол 400 мянга болгохын төлөө ажилладаг. Хийж буй зүйлээ аль болох л шат ахиулах бодлого баримтлахаас өөр арга байхгүй. Бизнес эхэлнэ гэдэг чинь нэг том хүрд эргэж байна гэсэн үг. Нэгэнт эргэсэн хүрдийг зогсоох эрх захиралд байдаггүй. Түүнээс биш сувдаг, сувдаггүйдээ биш. Мэдээж үйл ажиллагаа явуулж байгаа хүн тодорхой хэмжээний ашиг ололгүй яах вэ. Гэхдээ захирал хүн нийгмийн төлөө асар их хөдөлмөрлөдөг. Үнэндээ нийгмийн зарц л юм шүү дээ.

**С.Түмэнгэрэл:** -Хүн эхлээд өөрийн хэргцээг хангах гээд явдаг. Сайхан амьдрах юмсан, үр хүүхэд, гэр бүлээ сайхан аваад явчих юмсан гэж. Тэгээд өөрийн хэрэгцээг бий болгочихоод нийгмийн хэргцээг бий болгохыг зорьдог. Түүнээс биш, мөнгөний төлөө гээд шунаж байгаа юм биш. Бизнесмэн хүн бүтээн байгуулж байгаа юмнаасаа таашаал авдаг. Хувийн хэрэгцээний мөнгө бол өчүүхэн шүү дээ. Харин хийж бүтээхэд хэрэгтэй болохоор эдийн засгийн суурийг бий болгохоос өөр аргагүй.

**Я.Энхтайван:** -Ер нь баян хүн, бизнесмэн хүнийг ялгаж салгаж ойлгох ёстой. Баян хүн гэхээр асар их хөрөнгө өвлөөд авчихсан, түүнийгээ өсгөж арвижуулахын оронд өөртөө л их мөнгө зарцуулаад явж байгаа хүнийг хэлэх байх (инээв). Тэгвэл бид хоёр хүмүүсээс юугаараа илүү ялгараад байгаа юм бэ? Зөвхөн сэтгэлгээ л баялаг байх. Түүнээсээ баялгийг бүтээж гаргаж байгаа л хүмүүс шүү дээ.

**-Та хоёрын хувьд бизнесийн гал тогоонд 20-иод жил буцалсан. Нэг үгээр хэлбэл, хал үзэж, хашир суужээ. Энэ хугацаанд бизнест хэрхэн туршлагажсан бэ, тэр хэрээр алдаа оноогоо олж харж байгаа болов уу?**

**Я.Энхтайван:** -Миний хувьд илүү сэтгэх хэрэгтэй байдаг юм. Би илүү сэтгэхэд асар их хөтлөгддөг. Илүү сэтгэхүйнээсээ болоод заримдаа хямарчихдаг ч тал бий. Жишээлбэл, байшин барилгын гэрлэн чимэглэлийг Монголд нэвтрүүлэхээр 1999 онд томоохон үзэсгэлэн гаргаад, тэр хэрээрээ эдийн засгийн хохирол амссан.

**-Яагаад?**

-Түрүүлж сэтгээд уг үзэсгэлэнг гаргасан. Монголын байшин барилга, гудамж, талбайг бүгдийг нь ийм гоё болгоё гэж. Тэр үед үүнийг ойлгож хүлээж авах хүн байсангүй. Үзэсгэлэнг сонирхсон хүмүүс ийм гоё юм байдаг аа гээд байсан болохоос хийлгэе гэсэн хүн нэг ч гараагүй. Хий л шогшроод байсан.

**-Монголд өнөөдөр гудамж, талбайн гэрэлтүүлэг чимэглэл ид хөгжиж байна.**

-Бид Сингапур, Хонконг, Япон, Солоносын түвшинд хүргэх гээд үелздэг гэрлийг оруулж ирсэн. Саяхан электрон дэлгэц гэж гарч ирж байсан бол одоо би үүний үеийг нь өнгөрөөж, хална гэж бодож байгаа. Дараагийн шатны зүйлийг тооцоолчихсон. Лазер эффект өгдөг маш гоё зүйл бий. Тэр бол их тасархай юм гараад ирсэн.

**-Үнийн хувьд ямар байх вэ?**

-Үнэтэй үнэтэй. Дунджаар л 100 мянган ам.доллар. Манайд сайн чанартай зүйлийг хөрөнгө хүч гаргаад оруулаад ирэхээр түүнийг түрээслээд хэрэглэх хүн нь бас цөөн шүү дээ. Бараа чанартай, дунд, муу байхад мэдсээр байгаад мууг нь авчих нь бий. Түүнтэй адилхан шүү дээ. "Өгөөж" чихэр боов шиг ийм тогтчихсон компаниуд бол дунд юм уу сайныг авна л даа. Гэх мэтчлэн нийгмийн хэрэглээ гарч ирдэг.

Манай нэг давуу тал байгаа. Оросууд саяхан манайтай гэрээ хийгээд, баталгаажуулалтын төлбөр мөнгөө өгчихөөд буцсан. Электроникийг тэд Хятадаас биш, манайхаас авч байгаа. Сонирхолтой байгаа биз. Монголын нэг бизнесмэн өнөөдөр электроникийн худалдаанд өндөр амжилт гаргалаа. Бид хойд хөршийн зах зээлд нэвтэрч чадлаа. Тэд мэдээж, Солонгос, Тайванийн компанийн үнийн саналыг сонирхсон байж таараа. Энэ дотроос манай үнэ хамгийн боломжийн байж чадсан.

**С.Түмэнгэрэл:** -Би залуучууддаа та нар бизнесмэн бол оо, ажил хий. Тэрнээс биш, нам юм уу, эсвэл хэсэг бүлгийг дагаж битгий хошуур. Сайхан санаа оноотой залуучууд байна. Би бодохдоо залуучууд илүү ихийг сэтгэж, улс орон өмнөхөөсөө илүү хөгжсөн байх ёстой гэж боддог.

Өнөөдөр IPO хийнэ, хувьцаа гаргана, ингэнэ тэгнэ гээд л сэтгэхүй нь шал өөр түвшинд очсон залуус байна. Энэ цаг үе ирснээрээ тийм боломжийг ч гэсэн тэр хүмүүст олгожээ. Хамгийн гол нь манайхан үр хүүхдээ багаас нь зөв хүмүүжил олгох хэрэгтэй юм болов уу. Үүнийг бид орхичихоод байна. Бүр том болоод, төлөвшчихсөн хойно нь түүнийг нь өөрчлөх гээд зовоод зүтгэх. Ясли цэцэрлэг, сургуульд нь төлөвшүүлчих ёстой. Хүн эхлээд зөв бодох ёстой. Зөв бодохоос өмнө тархиндаа зөв программ суулгах ёстой. Зөв үйлдэл хийхэд зөв үр дүн гарах ёстой. Ийм шатлалаар явбал ирээдүйн залуучууд өнөөдрөөс илүү амжилттай өөр сэтгэхүйтэй болж хүмүүжнэ.

**-Бизнес хийхдээ зөн совинд илүү итгэдэг үү, эсвэл мэргэжилтнүүдийн зөвлөгөөг дагадаг уу?**

**Я.Энхтайван:** -Зөн совинд найдаад байж болохгүй. Мэргэжилтнүүдээс зөвлөгөө ч аваад байхдаа гол нь биш. Нэгдүгээр хүн зах зээлийг өөрийн гараар нарийн судалж, өөрийн онолоороо явах ёстой. Тэгсэн тохиолдолд алдах нь ч бага. Алтны хайгуулийн компани геологчийнхоо үгээр ороод дампуурах нь байдаг. Алт олохын хувьд олно. Гэхдээ 300 сая төгрөг зараад 100 саяын алт олсон байх жишээтэй. Ийм байдалд хүрэхгүйн тулд нэгдүгээр хүн Та бизнесээ өөрийн онол, өөрийн оюун ухаанаараа хөтөлсөн цагт амжилттай явдаг.

**С.Түмэнгэрэл:** -Хүмүүстэйгээ ярилцаж, судалгаа шинжилгээнүүдийг үзэх хэрэгтэй. Мэдээллийг авах гэдэг үүднээс. Эцсийн эцэст хариуцлагыг захирал үүрдэг болохоор эцсийн шийдвэрийг захирал гаргах нь зөв өө. Энд мэдээллийг боловсруулах чадвар, мэдрэхүй, мэдрэмж, за тэр зөн совин ч бас орно. Бүгдийн нийлбэрээс л зөв шийдвэр гаргах учиртай. Захирал хүн алхам тутамдаа шийдвэр гаргаж байдаг. Доороосоо зөв хүмүүжилтэй байж, бүгдийг харьцуулж, дотор хүнтэйгээ сайтар ярилцаж байж гаргасан шийдвэр нухацтай бөгөөд зөв байж магадгүй. Шийдвэр гарсны дараа үйл явдал өөрөө харуулна шүү дээ.

**-Энхтайван захирлын хувьд юмыг урьдчилж харж, илүү сэтгэснээрээ хохирдог талтай гэлээ. Шинэ санааг цаг үедээ тохирч байна уу, үгүй юу гэдгийг яаж мэдэрдэг вэ?**

**Я.Энхтайван:** -Энэ бол амьдрал дээр шалгуур болоод гараад ирсэн асуудал. Би сүүлийн үед түрүүлж сэтгэхээ тодорхой хэмжээгээр багасгасан. Нэг үгээр хэлбэл, мэдээллийн технологийг хэчнээн түрүүлж шүүрч авч байгаа ч гэсэн тэр болгоныг түрүүлж хэрэгжүүлэхээ больсон. Хоёрдугаарт, цээж өндөр ч гэх юм уу том бодлоосоо заримыг нь авч хаясан. Мөн хүмүүсийн ахуйн хэрэглээгээр хэрэгжиж байдаг бизнес гэж байдаг. Шүдний оо, саван ч байдаг юм уу. Зарим энэ чиглэлээр ажилласан бизнесмэн мань мэтийн технологийн дэвшил рүү орчихсон бизнесмэнээс давчихсан явах нь ч байна. Тиймээс иймэрхүү зүйлийг хавсрах бодолтой байгаа.

**С.Түмэнгэрэл:** -Аливаа юм өөрийн цаг хугацаандаа байвал илүү үр дүнд хүрч, үнэ цэнэтэй байдаг. Том сэтгэх ёстой юу гэвэл том сэтгэх ёстой. Алсыг харах ёстой юу гэвэл алсыг харах ёстой. Бага зорилго тавих юм бол хол явахгүй ээ. Хэтийн зорилго асар том байх ёстой. Тэрийг чухам хэзээ хэрэгжүүлэх вэ гэдэг өөрийнх нь цаг хугацааны л асуудал байх.

**Я.Энхтайван:** -Энд би ярилцаж байгаа сэдвийнхээ хүрээнд нэг инээдтэй юм ярья гэж бодлоо. Хэн нэгэн ямар нэгэн бизнесийг маш сайн хийсэн байлаа гэж бодъё. Бизнест мөнхөд дээр байна гэсэн онол байхгүй юм аа. Дороос нь бас нэг чадалтай компани гарч ирээд л түлхэж унагачих гээд байдаг. Тэгэхээр бизнесмэн хүний нэг онцлог бол цаг ямагт сэтгэх ёстой. Цаг ямагт өрсөлдөөнийг идэвхжүүлж чангаруулж байх учиртай. Жишээ нь "Өгөөж" дээр бодъё. Түмээ, талх нарийн боовоо байнга л шинэчлэхгүй бол наагуур нь янз янзын амттай боов гарч ирж цохичих гээд л болж өгөхгүй. Тэгэхээр л яаж мөнгө босгох уу, яаж бараагаа чанаржуулах уу, яаж борлуулалтын сүлжээгээ бий болгох вэ гээд түмэн бодолд автаж явдаг. Нэг юманд би хаан гэж хэлэх арга байдаггүй. За одоо инээдтэй зүйлээ ярья.

Нэг боксын аварга хоолонд оржээ. Тэрбээр малгайгаа өлгүүрт өлгөхдөө "Би дэлхийн боксын аварга, малгай авбал нам цохино" гэж бичээд оржээ. Гараад ирсэн малгай нь байдаггүй. Зөрүүлээд бичиг биччихсэн байна гэнэ. "Би дэлхийн гүйлтийн аварга хөөгөөд гүйцвэл нам цохино" гээд бичээд үлдээсэн байна гэнэ. Бизнесийн өрсөлдөөн гэдэг чинь нэгнээ басаж болохгүй, би том гэж томорч болохгүй яг ийм болчихоод байгаа. Өнөөдөр хэнд ч гүйцэгдэж магадгүй. Гагцхүү баялаг сэтгэхүй, зөв технологи дээр л тулгуурлана.

**С.Түмэнгэрэл:**

-Мөнхийн юм гэж байхгүй. Юмны оргил гэж бас байхгүй. Тэгэхээр дандаа л сэтгэж байхаас аргагүй.

**Я.Энхтайван:**

-Бизнесмэнүүдийг судлаад үзсэн байдаг л даа дэлхий дээр. Ингэхэд компанийн 96 хувь нь зөвхөн нэгдүгээр хүн буюу захирлаас болж дампуурсан байдаг. Тэгвэл 96 хувьд оролцож байгаа хоёр хүн энэ ярилцлагаар санаа бодлоо уншигчидтайгаа хуваалцаж байна. (инээв) Тэгэхээр та бүгдэд биднийг сонгож авсанд талархаж байна. Бизнесийг цааш цаашдаа эрүүл, хүртээмжтэй байлгахын тулд танай сэтгүүл чухал хувь нэмэр оруулах байх гэж бодож байна. ■

2011 ОНЫ 04.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

# Т.Лхагвадорж: Эдийн засгийн хямрал илүү ухаарал авчирна

*“Хүннү коал” компанийн гүйцэтгэх захирал Т.Лхагвадоржтой уул уурхайн салбарын уналт, хөрөнгө оруулалтын орчин, ирээдүйн талаар ярилцлаа. Түүний удирдлагад “Wolf petroleum”, “Хүннү ресурс”, “Гариссон капитал” зэрэг компани ажилладаг юм.*

**-Дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын тэр дундаа нүүрсний үнэ навс унасан нь Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Энэ бүхэнд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?**

-Гол хүчин зүйл нь тухайн үедээ үнэд орж буй ашигт малтмалыг тахин шүтэх нь асуудал үүсгээд байна. Нэг үе зэс үнэд ороход зэс шиг л хэрэгтэй зүйл үгүй гээд их шуурсан. Дээр нь бид уул уурхай гэж юу вэ гэдгээ мэддэггүй. Өөрөөр хэлбэл, тус салбарыг хэрхэн хөгжүүлдэг талаар мэдлэг болоод туршлага байхгүй учраас асуудал үүсч байна. Зэс, нүүрс гэх мэт уул уурхайн гаралтай бүх л бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр 5-10 жилд савладаг тогтолцоотой. Хал үзэж хашир суусан уул уурхайн компаниудын хувьд энэ нь тийм ч сандраад хямраад байх асуудал биш. Тэд ийм эрсдэлд зохицуулаад үйл ажиллагаагаа тогтвортой явуулаад сурчихсан байдаг.

Харин монголчуудын хувьд миний дээр хэлсэнчлэн нэг ашигт малтмалын үнэ өсөхөөр дагаж хошуурдаг, тухайлбал, нүүрс үнэд орохоор бүгд л нүүрс олборлогч, нүүрсний эксперт болж, нөгөө нь зээл авч, нүүрсний салбарт хөрөнгө оруулчихдаг. Гэтэл зах зээл нь унаад ирэхээр дампуурахад хүрдэг. Бодлого, төлөвлөгөөгөө ч өсөлттэй байх үетэй холбоод гаргачихдаг. Нүүрсний үнэ өндөр байгаа учраас Хятадаас өөр гуравдагч зах зээлд нийлүүлнэ гэх жишээтэй. Дэд бүтцийнхээ асуудлыг шийдээгүй байж онгоцоор нүүрсээ тээвэрлэх гэж байгаа юм шиг л зүйл ярьж хөөрцөглөдөг. Харин нүүрсний ханш унаад зах зээл нүүрсийг сонирхохоо болих үед нөгөө өөдрөг төлөвлөгөө нь гацаанд орчихно.

Энэ удаагийн Монголын нүүрсний салбарын хямрал бидэнд их туршлага боллоо. Хэрвээ бид хэдэн сая тонн нүүрс гаргаад түүнийгээ борлуулж чадаагүй бол энэ том асуудал. Гэтэл монголчууд нүүрсээ судлаад нөөцөө тогтоогоод дөнгөж л үйл ажиллагаа эхэлж байх үед тус салбар уналтад орсон нь улс орны эдийн засаг, уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хараат байж болохгүй гэсэн том сануулга өглөө гэж ойлгож байна. Тиймээс алдаа оноондоо дүгнэлт хийгээд урт хугацааны туршид улс орныхоо хөгжилд эерэгээр нөлөөлөх тогтвортой бизнесийн бодлого, төлөвлөгөөг төлөвлөж ажиллах хэрэгтэй юм болов уу.

Ерөнхийдөө эдийн засаг уначихсантай холбоотой уул уурхайн салбар хүндэн байдалд орсон. Гол зүйл нь дээр дурдсанчлан уул уурхайд хөрөнгө оруулах уу үгүй юу гэдэг хүлээлт, эргэлзээ хөрөнгө оруулагчдын дунд үүсчихсэн байна. Мөнгө алга болоогүй, хэн нэгний халааснаас гараад өөр хүний халаасанд л ороод явж байгаа болохоос биш дэлхийд хөрөнгө дутагдсан хэрэг огт биш. Тиймээс хөрөнгө оруулагчид байж л байгаа. Харин хөрөнгөө хаана оруулах нь илүү ашигтай вэ гэдэг хүлээлттэй л байна. Тэд жижиг төслөөс илүү том, алсыг харсан өргөн цар хүрээтэй төслүүдэд хөрөнгө оруулах сонирхолтой байгаатай бас холбоотой. Хятад улс гэхэд дотоодын бүх компанидаа аудит хийж байна. Бид тэднээс суралцаж яагаад болохгүй гэж.

**-Хятадын зах зээлд Австрали гээд том өрсөлдөгч гараад ирлээ. Урд хөрштэйгээ ямар бодлого баримтлан ажиллах ёстой вэ?**

-Хятад бол эдийн засгийн хувьд маш том зах зээл. Бүх л улс Хятад руу ахиухан бараа бүтээгдэхүүн нийлүүлээд ихээхэн ашиг хүртэхийг эрмэлзэж байна. Газар зүйн байршлын хувьд алслагдмал орнууд хүртэл тухайн зах зээлд орж ирэхийн тулд тархиа сайтар ажиллуулах боллоо. Гэтэл хөрш зэргэлдээ монголчууд Хятадыг алгасаад гуравдагч зах зээл хайх нь хэр зөв шийдвэр бол. Дээрээс нь манай дэд бүтцийн хөгжил сул. Уул уурхайн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр борлуулж байж сая ашиг хийдэг бизнес учраас дэд бүтцийн сайн хөгжил зайлшгүй шаардлагатай. Энэ утгаараа төмөр замыг хөгжүүлэх, сайжруулах шаардлага бий.

Урд хөрштэйгээ харилцах гол бодлогын нэг нь чанартай бүтээгдэхүүнийг урт хугацаанд тасалдалгүй нийлүүлж чадна гэдгээ батлан харуулах хэмжээнд хүрэх явдал юм. Чанар нь тогтмол сайн, логистик нь тасалдаад байдаггүй болж чадвал бид уул уурхай болон экспортын бүх бүтээгдэхүүнээ өндөр үнээр борлуулж ашгийг нь ард түмнийхээ эрүүл мэнд, боловсролд түлхүү чиглүүлж зарцуулдаг болмоор байна.

**-Монголын нүүрсний компаниудын өнөөгийн байдал ямар байна вэ?**

-Нүүрс олборлодог компаниудын хувьд ажил зогсонги байдалтай байна. Зөвхөн Монголын компаниуд бус дэлхийн нүүрсний компаниудын ихэнх нь зогсонги байдалтай байгаа. Урт хугацааны гэрээтэй, дэд бүтцээ шийдчихсэн улс орны компаниуд хүртэл өртгөө бууруулах замаар бүсээ чангалж байна. Тэгэхээр манайх шиг хөлөө олох гэж яваа компаниудад санхүүжилт босгох, хөрөнгө оруулагч татахад бэрхшээлтэй болчихлоо. Хэрэглэгч нь ч бэлэн биш байна. Хятадаас гадна Япон, Солонгосууд нүүрсний хэрэглэгч орнууд. Тэд хаанаас, хямдхан нүүрс авах боломжтой талаар судалгаа хийнэ. Нийлүүлэгч орнууд ч бас хаана нүүрсээ их хэмжээгээр гайгүй үнээр борлуулж чадах тухай бодно. Ийм нөхцөл байдалд тоглолт хийх чадвартай байх ёстой. Монголын нүүрснийхний хувьд ийм чадвар, туршлага суугаагүй байна. “Энержи ресурс” компанийн таван жилийн ой тохиож байна. Энэ мэт дотоодын томоохон компаниуд туршлага хуримтлуулж амжаагүй байтал зах

зээл нь зогсчихлоо шүү дээ.

**-Гарц байна уу?**

-Нүүрсээ баяжуулаад, боловсруулаад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгож зарах нь хамгийн зөв гарц талаар Уул уурхайн яамнаас ч ярьж байгаа. Мөн тухайлбал, Өмнийн говийн аль нэг компанийн нүүрс зарагдахгүй бол бусад нүүрстэй холиод чанарыг нь жигд болгох замаар хамтарч ажиллах чигийг судлах зөвлөмж өгсөн байна лээ. Ер нь хямралын нөхцөлд хүн бүр тус тусдаа зам бариад, компани байгуулаад нүүрс экспортлох бус хамтраад ажиллах нь чухал байна. Хамтрах гэдэг санаа нь бид яаж монгол нүүрсний брэндийг дэлхийд бий болгох вэ гэдэгт анхаарал хандуулах тухай юм.

Монголын компаниуд нэг зүйл дээр бүгд санал нэгддэг. Тэр нь засаг төр бизнесийн орчныг зөвөөр ойлгож зохицуулж, журамлаж, татварын уян хатан бодлого тогтоогоосой, бага орлогтой, үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж буй компаниудыг хөл дээрээ бостол татварын олон давхар хураамжаар бүү дарамтлаасай гэж хүсдэг. Мөн байгаль орчны асуудалд хэр хандаж байгаагаас нь шалтгаалан татварын торгуулийн шатлалтай байвал тэдэнд өсөж дэвжих боломж олгохоос гадна илүү хариуцлагатай болно шүү дээ.

**-Нүүрсний компаниуд төрийн бодлого, хууль эрх зүйн орчинд ямар бодол санаатай явдаг юм бол?**

-Уул уурхайн салбарт шинэ хууль төрөх нь гэсэн хүлээлт бий болчихсон байна. Төрөөс уул уурхайн бодлогоо яаж тодорхойлох талаар ярьж байна. Хамгийн гол нь аливаа зүйлд сэтгэлийн хөөрлөөр хандаж болохгүй юм л даа. Мэдээж бид язгуур эрх ашиг, үндэсний эрх ашгаа дээдлэх хэрэгтэй. Монгол Улс уул уурхайн салбараа түшиглэж хөгжих гээд байна уу, эсвэл эдийн засгаа хөгжүүлэх нэг хэсэг нь уул уурхайн салбар юм уу. Энэ асуултад хариулах хэрэгтэй. Хариулт тодорхой болчихвол улс төрийн бодлого нь тодорхой болоод ирнэ. Бодлого тодорхой байх ёстой.

Түүнчлэн өмнөх хуулиудынхаа алдаа, онооны асуудлыг олж харж дүгнэлт хийх хэрэгтэй байна. 1997, 2006 оны хуулийн алдаа, оноо, ямар үр дүн авчирсан, ямар алдааг засаг залруулах ёстой юм. Өмнөх хуулиудаа л болсон, болоогүй хэмээн шүүмжлэх нь өрөөсгөл талтай. Тэдгээр хуульд оносон, алдсан ч зүйл бий. Харин яг ямар заалт нь болоогүй вэ гэдгийг ярилцах ойлголцох хэрэгтэй. Үүн дээрээ тулгуурлан хуулиа хөгжүүлэх учиртай. Өөр нэг асуудал нь улс өөрийн хөрөнгөөр хайгуул хийнэ гэх юм. Төр тийм том эрсдэл гаргаж байхаар бүс нутгаар нь хөгжүүлэх бодлогоо тодорхой болгоод түүнийхээ дагуу хувийн хэвшилтэйгээ хамтраад ажиллах нь илүү үр дүнтэй санагдана. Түүнээс биш төрийн эсвэл хувийн гэсэд ялгах нь зөв шийдвэр байж чадах уу гэдэгт бас дүгнэлт хийгээсэй. Хамтран ажиллахдаа аль болох алагчилсан үзэлгүй байх нь чухал байна. Төрийнх учраас татвар бага төлнө, гаднын компани учраас өндөр татвар төлнө гэж болохгүй биз дээ. Төрийн зүгээс савчсан бодлого бариад байвал манайд хөрөнгө оруулалт орж ирэхгүй болно. Хэдий чанга бодлоготой байлаа ч 50-100 жилийн хугацаанд тухайн хууль эрх зүйн орчин нь тогтвортой бол хөрөнгө оруулагчид итгэл үзүүлэн хөрөнгөө оруулахад хүрдэг.

Гэтэл өнөөдөр монголчууд хөрөнгө оруулагчдыг “Манай хөрөнгө оруулалтын орчин тааламжтай, хөнгөлөлт үзүүлнэ ороод ир” хэмээн өөрсдөө дуудаг. Харин орж ирээд том орд нээхээр нь янз бүрийн аргаар хөөж эхэлнэ. Миний юм, улсын өмч гээд л өмчирхөнө. Хөрөнгө оруулагчдыг гараад явчихаар “Өө та нар ямар тоглоом даадаггүй юм бэ, буцаад хүрээд ир, одоо сайхан болгоод өгнө” гэдэг. Хүүхдийн тоглоом биш шүү дээ. Ийм үед томоохон хөрөнгө оруулагчид хэзээ ч орж ирэхгүй. Харин ийм савлагааг ашиглаж ашиг хүртээд гардаг хөрөнгө оруулагчид л манайхыг зорино.

**-Татвар гэсэн бас нэг дарамт байна, компаниудад, тийм үү?**

-Татварын хуулиараа байсгээд л тоглоод байх нь зөв ч юм уу буруу ч юм уу. Хөрөнгө оруулагчид харж байгаа. Сайжрахаар нь нэмээд муудахаар нь багасгаад л гэнэ. Одоо хөрөнгө оруулаад эхэллээ ч ашиг олоод ирэхээр нэмчихвэл яах вэ гэдэг тийм л мессеж өгөөд байна. Тэгэхээр татварын хуулиар тогломооргүй л байх юм.

**-Уул уурхайн салбарт хөрөнгө орж ирэх найдвар байна уу?**

-Хаа сайгүй л хямарчээ. Гэхдээ бидэнд том хөрш байна. Тэдний итгэлийг олж бүтээгдэхүүнээ хүргэхийн тулд бид өөрсдөө дотроо учраа олох хэрэгтэй. Өөрсдөө дотроо учраа олохгүй суух хоорондо бусад орон өрсөөд зах зээлийг эзэлчих вий. Эдийн засаг хямралаас төр болон иргэд ухаарал авсан байх гэж бодож байна.Уул уурхайгаас хамааралтай улсад энэ салбар нь унахаар эдийн засаг яаж хямардгийг хүмүүс харж, мэдэрч байна.

**-Хөрөнгө оруулагчдын итгэлийг яаж олох уу?**

-Тэр л хамгийн хэцүү байна даа.

**-“Хүннү Коал” компанийн байдал ямар байна вэ?**

-Манай компанийн төслүүд төлөвлөгөөний дагуу явж байгаа. Нүүрсний үнэ уначихсан болохоор борлуулалт хийгээгүй. “Хүннү Коал”-ын хувьд хайгуулаас олборлолт явуулах шилжилтийн үе байсан учраас томоохон асуудал үүсээгүй гэж хэлж болно. Одоогоор нүүрсний чанар, нөөцийг илүү нарийн шинжилж, хайгуул хийхэд чиглэсэн судалгааны ажил явагдаж байгаа. Зах зээл дээр үнэ өсч, тохиромжтой нөхцөл бүрдэхэд бэлэн байхын тулд илүү чанартай, өрсөлдөх чадвартай нүүрс зах зээлд нийлүүлэх үүднээс технологийн тал дээр ажиллаж, зардлаа бууруулах эдийн засгийн тооцоог хийж байна. Зах зээл сэргэж, хэзээ нэг өдөр бүтээгдэхүүнээ зарах нь ойлгомжтой болохоор аль болох бараа бүтээгдэхүүнээ сайжруулах тухайд л анхаарч байна.

Одоогоор Өмнөговьд хоёр төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд нэг нь хайгуулын, нөгөө нь уурхай байгуулах төсөл. Говь-Алтайд нэг төслийн хайгуул дуусаагүй байна. Монголын Эрдэс баялгийн зөвлөлөөр саяхан Говь-Алтай аймгийн Төгрөг сум дахь Хүрэн голын төслийн дүнд 250 сая тоннын нөөц батлуулж, Монголын нүүрсний нөөцийг ийм хэмжээгээр нэмэгдүүллээ. Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутагт хэрэгжүүлж буй Үнст худагийн нөөцийг ойролцоогоор 700 сая тонн хэмээн тогтоочихсон явж байна.

**-“Wolf petroleum” компани**

**газрын тосны салбарт бас төсөл хэрэгжүүлж байгаа байх аа?**

-Монгол Улс газрын тосоор хойд хөршөөсөө хараат байж ирсэн. Хэрвээ дотоодын газрын тосны нөөцийг илрүүлж, нэмэгдүүлнэ гэвэл бас л гаднын хөрөнгө оруулагч оруулж ирэх шаардлагатай. Тэр утгаараа бид Австралийн хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгоод "Wolf petroleum" компани байгуулаад ажиллаж байна. Өнгөрсөн жил Газрын тосны газраас манайхыг шилдэг хайгуулын компаниар шалгаруулсан. Учир нь бид гурван жил хийх ёстой ажлыг есөн сарын хугацаанд хийсэн. Байгуулагдаад хоёр жил болж байгаа мөртлөө. Ер нь мөнгийг дараад байхгүйгээр аль болох үр ашигтай төсөлд хөрөнгө оруулаад явдаг. Манай Матью геологич, би уул уурхайн инженер мэргэжилтэй. Бидний хувьд ашигтай төсөлд хөрөнгө оруулагч татаад олон улсын хөрөнгийн биржид үйл ажиллагаагаа ил тод явуулдаг. Хэнээс ч нуугаад байх зүйлгүй. Олон улсын хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгоход үйл ажиллагаа ил тод, шударга явах ёстой гэсэн том шаардлага тавигддаг. Тиймээс бид худлаа хэлэх, хуурмаг зүйл хийх эрхгүй. Тийм ч бодолгүй ажиллаж ирсэн.

"Wolf petroleum" компани маань Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатарын 27 блок дээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад хайгуулын ажил хийж байна. Газрын нэлээд гүнд газрын тосны бассейн байх магадлал өндөр байна гэдгийг тодорхойлуулсан. Үүнийгээ ч нуулгүй зарласан. Одоогоор нарийвчилсан чичир-хиллийн судалгаа хийгээд явж байна. Мөн Засгийн газартай хайгуулын хамтарсан гэрээ байгуулаад Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутгийг дайрсан судалгааны ажил хийж байгаа. Бид нар мөнгөө гаргаад, өөрсдөө эрсдэлээ үүрнэ. Харин Газрын тосны газраас хяналт тавина. Аз болоод газрын тос гарвал борлуулалтын ашгийн дор хаяж 50, түүнээс дээш хувийг төр эзэмших гэрээтэй.

"Wolf petroleum" компанийн 60 орчим хувийг монголчууд эзэмшдэг. Ихэнх ажилтан нь монголчууд, захирал нь монгол. Гаднаас хөрөнгө оруулалт л татсан. Мөн газрын тосны экспертүүд бидний дор ажиллахаар ирж байгаа. Нөгөөтэйгүүр Монголын компани, иргэд манай хувьцааг Австралийн хөрөнгийн биржээс худалдаад авч болно. Одоогоор манай хувьцаа тавхан центийн үнэтэй. Гаднын хөрөнгө оруулагчид Монголын хууль эрх зүйн орчинд итгээгүйн улмаас 20 цент байсан хувьцаа өнөөдөр навс уначихаад байна. Хэрвээ монголчууд бидэнд итгэж байгаа бол, эх нутагтаа хайртай бол Монголд үйл ажиллагаа явуулж буй компаниудынхаа хувьцааг хямд дээр нь худалдаж авах боломжтой юм.

**-Газрын тосны үнэ ч унаад эхэллээ?**

"Wolf petroleum"-ын хувьд хайгуулын шатанд үйл ажиллагаа явуулж байгаа болохоор газрын тосны үнийн уналт хүчтэй нөлөөлсөн зүйлгүй байна. Гол хүндрэл нь томоохон компаниуд ийм үед гаднын хөрөнгө оруулалтаа хумих хандлагатай болдог. Бүсээ чангалж ажиллая гэсэн зорилготой ажилладаг. Тийм учраас хайгуулын эрсдэлийг ойлгодог, бага хэмжээний мөнгө зарцуулаад их ашиг олох бодолтой компаниудад хандаж байгаа. Монголд газрын тосны эрэлт ихсэж байна. Мөн Хятадад газрын тосны хэрэгцээ асар их. Хойд хөрш Хятад улс руу том хоолой барьж нефть нийлүүлэх асуудал тодорхой байхад бид юу ч хийхгүй суугаад байж болохгүй. Тийм учраас ирэх жилүүдэд энэ салбарт амжилттай ажиллах ирээдүй харагдаж байна гэж үзэж байгаа.

**-"Хүннү ресурс", "Гаррисон Капитал" компаниудын хувьд?**

-Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Хүннү Коал" компанийн Монголд үйл ажиллагаа явуулахын тулд байгуулсан компани бол "Хүннү ресурс". Монголтой холбоотой бүх ажил тухайн компаниар дамждаг. Ихэнх ажилчид, албадын дарга нь монгол хүмүүс байдаг.

"Гаррисон Капитал" нь Австралид байдаг хөрөнгө оруулалтын компани. Манай хамтрагч Матью Вүүдийн байгуулсан компани бөгөөд таван хувьцаа эзэмшигчтэй. Миний бие тодорхой хувийг эзэмшдэг. Энэхүү компани нь Австралийн хөрөнгийн бирж дээр гарч байгаа манай компаниудын санхүү, хөрөнгө оруулалт, захиргаатай холбоотой аажлуудыг хийж гүйцэтгэдэг. "Гаррисон Капитал" нь компаниараа энд тэнд хөрөнгө оруулахаасаа илүүтэй хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө байгуулж буй компаниуддаа хөрөнгөө оруулдаг. Бид ч өөрсдөө энэ компанид хөрөнгө оруулсан одоо та манай компанитай хамтарч ажиллаач гэж санал тавихаар өөр шүү дээ. Бусад хөрөнгө оруулагчид итгэл үзүүлж буй хэлбэр л дээ. Мөн "Гаррисон капитал"-ын үзүүлж ирсэн амжилтууд дахин санхүүжилт босгоход том үр дүн болдог. Урт хугацаанд хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээнэ гэдэг маш чухал. Бид ч хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг даадаг. Сүүлийн 10 жилд 20 гаруй компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн бирж дээр гаргасан байна.

**-"Хүннү Коал" ирээдүйгээ хэрхэн төсөөлж байгаа бол?**


-Ирээдүйд нүүрсний салбарт мэргэжлийн өндөр түвшний боловсон хүчинтэй сайн чанарын монгол нүүрсийг олон улсын зах зээлд нийлүүлдэг нийгмийн хариуцлага өндөртэй компани байх зорилготой ажиллаж байна. ■

2013. 09 САР.

*Тайлбар: Т.Лхагвадорж нь өнөөдөр "Хүннү коал" компанийн зөвлөх бөгөөд "Wolf Petroleum" компанийн захирлуудын зөвлөлийн даргаар ажиллаж байна.*

ЗОЧИН

# Увидаст Маестро



Сайн байцгаана уу ?

Эдийн засгийн бус энэхүү арга хэмжээнд ирсэн та бүхэнд баярлалаа хэмээн тэрбээр өөрийн илтгэлээ эхэлсэн юм. Гар, хөлөө сүр сар хийтэл хөдөлгөн, унаж босох шахам сэтгэлийн хөдлөлөө ил гарган найрал хөгжмийг удирддаг нэгэн байхад зөвхөн уруул хөмсөг нүдээ хөдөлгөх төдийд бүхэл бүтэн 100 гаруй уран бүтээлчийг нэгэн аялгуун дор нэгтгэж чаддаг удирдаач ч байдгийг тэрбээр бидэнд харуулсан билээ. Энэ хүн бол Итай Талгам. Анх төгөлдөр хуурчийн замналаар амьдралын гараагаа эхэлсэн удирдаач улмаар хөгжим ба бизнесийн удирдахуйн ухааныг холбогч Маестро болжээ. 2012 оны Монголын эдийн засгийн чуулганы хоёр дахь өдөр мөн ч олон сэтгэл зовоож, толгой өвтгөсөн асуудлуудыг хэлэлцсэн билээ. Түүний дунд зочид төлөөлөгчдийн урмыг тэтгэж, оюуныг тэжээсэн гайхалтай илтгэл тавьсан Итай Талгам манай сэтгүүлд ярилцлага өгсөн юм.

**-Хөгжим ба бизнесийн удирдахуйн ухаан хоорондоо ямар талаар ижил төстэй юм бэ?**

-Шалтгаан нь ерөөсөө л энэ бүгд хүмүүсийн тухай байдагт оршино. Улс төр, нийгэм, бизнес, хөгжим бүгд л хүмүүсийн сайныг нь шилж байдаг. Хэдийгээр хүмүүс өөрийн гэсэн бодол санаа, ашиг сонирхолтой хэдий ч эцсийн бүлэгтээ хөгжимчид сайхан аялгууны төлөө хамтдаа тоглодог шиг нийгмийн сайн сайхны төлөө хүмүүс ч хамтдаа хөдөлмөрлөх хэрэг гардаг. Дэлхийн хаана ч энэ бүхэн адилхан байдгийг би олж харсан.

**-Та яагаад Монголд илтгэл тавихаар шийдэв?**

-Танай Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуягтай уулзсан тэр азтай учралаас үүдэлтэй. Бид Давосын уулзалтын үеэр анх танилцсан юм. Би Монголын зах зээлд маш их өөрчлөлт гарч байгааг, мөн ард иргэдэд нь гайхалтай боломжууд нээгдэж байгаа гэх мэт маш ихийг олж мэдсэн. Үнэхээр сэтгэл хөдөлмөөр санагдсан л даа. Танай оронд ирээд юуны түрүүнд тун энгийн мөртлөө маш их мэдлэг боловсролтойн зэрэгцээ жинхэнэ өөрчлөлтөд бие сэтгэлээ зориулсан тийм л хүмүүстэй уулзсан. Төсөөлж байснаас минь хэд дахин илүү байлаа.

**-Хөгжмийн удирдлагыг бизнес, улс төрийн удирдахуйн ухаантай адилтгах санаа танд хэрхэн төрсөн бол?**


-Үндсэн мэргэжил минь хөгжмийн удирдаач. Хөгжим бол хөгжимчин хүний бүхий л ертөнц байдаг. Гэхдээ хөгжим түүнээс ч илүү нарийн, гүн зүйл юм. Хөгжим зөвхөн хөгжим байхаас хэд дахин илүүг хийж чадах увидастай. Дэлхий дээрх олон зүйлийг өөртөө тусган харуулах толь байж чаддаг. Иймээс л учраас энэ бүхнийг хийснээр хөгжим зөвхөн хүмүүсийг хөглөөд зогсохгүй өөрөө ч хүмүүсийн бодол санаа, мэргэжлээр хөглөгдөн баяжиж байдаг онцлогтой. Миний хувьд, үүнийг хөгжим тоглодог ба эс тоглодог хүмүүсийг найрал хөгжмийн чуулгын танхимд цугласан үзэгчид адил нэгтгэх замаар хийхийг зорьдог. Тэр дундаа тоглолтын танхимаас гадна хөгжим ба үзэгчдийг нэгтгэнэ гэдэг илүү их урам зоригийг өгч байдаг л даа. Учир нь, хүмүүст энэ нь үргэлж гэнэтийн бэлэг болж чаддаг төдийгүй гайхалтай нөлөөг үзүүлдэг.

**-Хөгжмийн удирдаачийн замналаа юуны учир Та энэ зүг залахаар шийдсэн юм бэ?**

-Миний хувьд мэргэжил зөвхөн чиний авьяас билэг, амьдралын зорилгын бодит биеллийг хангаж байдаг хэрэгжилтийн тал юм гэдэгт итгэдэг. Миний оршихуй хэзээ ч удирдаач байгаагүй. Харин миний оршин байх нь удирдахуйн ухаан, хөгжмөөр дамжуулан хүмүүстэй харилцан холбогдох юм. Арга барил маань өөрчлөгдсөн болохоос хүсэл зорилго минь хэвээрээ л байгаа. Магадгүй Та, хэн нэгэн удирдаач болохын тулд олон жил сурч, нөгөө нь олон улсад дуурсагдах нэр хүндийг олсон байхад Та яагаад буугаад өгчихөв гэж гайхаж байж болох юм. Гэхдээ миний хувьд харин ч бууж өгсөн бус амьдралаас хүртсэн шагнал бүхнээ бусадтай хуваалцахыг хичээж яваа гэж боддог. Энэ бол миний илтгэлдээ ч ярьдаг хөрвөн өөрчлөгдөх чадвар юм. Яаж өөрчлөгдөх, хэрхэн өөрийгөө бэлтгэх гэдэг их чухал. Бид Монгол Улс үргэлжилсэн их өөрчлөлтийн салхинд хийсч явааг ярьж байна. Миний өөрөө өөртөө бий болгож чадсан зүйл чинь л тэр юм шүү дээ. Би ердөө л энэ талаар ярихад илүү бэлтгэгдсэн юм даа.

**-Та Монголын дуу хөгжмийг сонсож үзсэн үү ?**

-Ирсэн даруйд нэгэн цэнгүүн дээр хоёр чавхдаст үндэсний



хөгжмийг сонсох боломж гарсан. Тун ч их уянгалаг сайхан төдийгүй мэргэжлийн түвшний суурь сайтай санагдсан.

**-Та одоогийн хийж байгаа ажлаараа яг юуг олон түмэнд хүргэхийг зорьдог вэ?**

-Энэ бол хамтын ажиллагаа буюу хэрхэн хамтран ажиллаж буй тухай юм. Хүмүүсийг удирдана гэдэг нэг төрлийн хамтын ажиллагааны хэлбэр. Хүмүүсийн амьдралыг орвонгоор нь өөрчилж чадахгүй л дээ. Гэвч тэдний тархинд нүдэнд үзэгдэхүйц тийм л бодол санааны үрийг тарьж чадна. Тэр нь юун түрүүнд хөгжим байдгаараа хамгийн сайхан. Илтгэлийн дараа олон хүн тэр удирдаачтай уулзмаар байна. Интернетээс илүү ихийг олж мэдмээр байна гэдэг л дээ. Энэ бол нэг зүйл. Нөгөө талаас хүн болгонд маш олон боломж бололцоо, чадвар гэж байдаг.Тиймдээ ч бид түүнийгээ ашигладаг. Тодорхой арга замаар аливаа зүйлсийг хийдэг. Та тодорхой асуулт асуудаг. Магадгүй таны оюунд дахиад зуун асуулт ч орж ирж мэднэ. Би таныг ажлаа маш сайн хийдэг гэдэгт итгэлтэй байна. Тэгвэл яагаад өөрчлөгдөх ёстой гэж хэмээн бодох байх л даа.

Та олон хүмүүстэй уулзаж, олон үйл явдал танд тохиолдоно. Тэр үед Та өөртөө магадгүй “Өө надад чинь бас ийм нэгэн өөр тал байдаг юм байна” гэж бодох үе гарна. Өөрөөсөө гаргаж зүрхэлдэггүй тийм дэврүүн сэтгэл хөдлөл гэж байдаг. Бусдын оролцоогүйгээр өөрийгөө хөгжөөх гэдэг ч юм уу. Би чинь их хөгжилтэй хүн юм байна гэдгээ ухаарчихвал ярилцлага илүү үр дүнтэй болох гэх мэт юм даа. Олон төрлийн удирдахуйн ухааны арга барилаараа

дамжуулан хүмүүсийн өөрөө ч ухамсарлаж байгаагүй тэр л далд ертөнцийг гаргаж ирэхэд тусалдаг юм. Энэ байдал намайг сэтгэл хангалуун болгодог. Миний зорилго тэр юм. Би олон газраар явж энэ ажлаа үргэжлүүлж яваа. Харин энэ удаад Монголд ирэх завшаан олдсонд байртай байна.

**-Танд удирдахуйн ухааны олон төрлийн илтгэл байдаг уу?**

-Маш их материал бий. Нэг ижил материал ч тухайн илтгэлээсээ шалтгаалан өөр өөр өнгө төрхтэй байж болдог л доо. Цөөхөн үзэгчид дунд илүү ойр дотно яриа өрнүүлэх сонирхолтой. Хүмүүстэй яриа өрнүүлэх тэр үе л маш их зүйлийг зааж өгч байдаг. Энэ бол зөвхөн би лекц уншаад байх бус илүүтэй сонсоход оршдог.

**-Эдийн засаг хөгжим хоёр хоорондоо ямар талаараа холбоотой вэ?**

-Амжилт дагуулсан эдийн засаг, бизнесийн хүмүүсээс тухайн жилийн орлого, төсвийн орлого нь бизнес эрхлэх голлох шалтгаан биш гэдгийг олонтаа сонсож байлаа. Хамгийн чухал нь яагаад би бизнес хийж байгаа вэ гэдэг асуулт юм. Маш олон хүн аливаа зүйлийг хийхэд тодорхой утга учир хэрэгтэй гэдгийг ойлгож ухаарч байна. Юуны төлөө надад мөнгө хэрэгтэй юм. Түүнийг нийгэмд хэрхэн зөв зохистой тараах вэ гэх мэт асуултууд хүмүүсийн хувьд нэн тэргүүнд тавигдах байх гэж би хувьдаа боддог. Энэ их тоонуудын ард хүмүүс л байдаг. Тэдэнд ёс суртахууныг бий болгодог утга учир хэрэгтэй байна. Хүмүүс зөвхөн мөнгийг сонирхож байсан өнгөрөгч хямралын тэр л үед хамгийн ихээр энэ утга учир үгүйлэгдэж байсан болов уу. Зөвхөн мөнгөндөө байдаггүй л дээ. Хөгжмийн хэмнэл, бизнесийн үйл явцын аль алинд нь хүмүүсийн үнэ цэнийн асуудал оршдгоороо хоорондоо дэндүү хамааралтай гэдэгт би итгэдэг. Хувь хүн өөрөөсөө илүү үнэ цэнэтэй зүйлсийг олж харах бололцоог олгохуйц тийм л нийгмийг бий болгох нь миний хүсэл. Энэ бүгд ёс суртахуун ухамсартай дэндүү их холбогдоно.

**-Таны дараагийн ээлжинд гайхшруулах орон аль бол. Эсвэл очихыг хүсэж буй газар ч юм уу?**

-Би Африкийн орнуудад очихыг их хүсдэг. Өмнөд Африкт бол очиж үзсэн л дээ. Гэсэн ч тус тив бүхэлдээ сонирхлыг минь татсаар байдаг. Жуулчлалаар очих сайхан санагдсан. Гэхдээ хөтөлбөрийнхөө хүрээнд тэр оронд ямар нэг санал санаачилгад гар бие оролцож үзээгүй. Тэдгээр улс соёл урлаг, уламжлалынхаа хувьд гайхалтай баян атлаа амьдралын түвшин маш доогуур. Тэнд маш их баялаг байгаа хэдий ч тэрийгээ ойлгож мэдээгүй байна.

**-Монголд ирээд хөл тавиад төрсөн анхны сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?**

-Би зөвхөн Улаанбаатар хотод байсан болохоор Монгол орны тухай тийм ч ихийг хэлж чадахгүй. Гэхдээ хүмүүс нь огтхон ч ширүүн дориун биш, найрсаг, ухаалаг бас их царайлаг юм. Иргэдийн амьдралын хэв маяг их биширмээр санагдлаа. Монгол Улс надад маш их таалагдлаа. Эргэж ирэх боломж хэзээ нэгэн цагт дахин тохионо гэдэгт итгэлтэй байна.

"...Бэлтгэл эхлэхээс өмнө хөгжимчид хувийн бэлтгэлээ базааж, энд тэндгүй төрөл бүрийн хөгжим хангинуулж, тайзнаас нэг л эмх замбараагүй хэзээ ч хоорондоо авцалдахгүй мэт санагдам уур амьсгал мэдрэгдэнэ. Харин Маестрог гараа дээш өргөх тэр л мөчид тайз тэр аяараа аниргүйд автана. Ид шидийн дохилтоор хэдэн зуун хөгжмийн аялгуу голын ус мэт нэгдэн, аугаа хүчит цогц нэгэн эгшиг болон гарах ажээ. Анир чимээ нь үгүй Маестрогоор удирдуулсан хөгжимчин нэг бүр гайхалтай тоглолт хийхийг эрмэлзэх тэр л хүслээр хөглөгдөж нэгэн бие мэт хоорондоо гайхалтай зохицон хөгжмөө тоглосоор. ■



## Итай Талгам

Итай Талгам нь бизнесийн болон аливаа нэгэн байгууллагын удирдлагыг симфони хөгжим удирдахтай харьцуулан, маш сонирхолтой уран илтгэдгээрээ алдаршсан нэгэн юм. 1994 онд, Израил улсын хөгжмийг гадаадад сурталчилахад хувь нэмрээ оруулсныг нь үнэлж тус улсын Хөгжмийн зохиолчдын холбооны хүндэт шагналаар түүнийг шагнасан байна. Талгам нь "Тэл-Авив" найрал хөгжим, "Musica Nova Consort"-ыг удирддаг бөгөөд Израил улсын үндэсний урлагийн зөвлөлөөс "Оны шилдэг тоглолт" хэмээх хүндэт шагнал мөн хүртэж байжээ. Итай дэлхийн нэр хүнд бүхий олон арга хэмжээ тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форум, технологи, энтертайнмент, дизайны дэлхийн чуулган гэх мэт томоохон хурлууд дээр илтгэл тавьж олны итгэл, талархлыг хүлээж байжээ.

Итай Талгамаар Францын алдарт удирдаач Леонард Бернстейн 1987 онд Парисийн найрал хөгжимчдийг удирдуулж байжээ. Мөн тэрбээр дэлхий даяар олон найрал хөгжимчдийг удирдаж байсан байна. Түүн дотроос онцолбол нь Оросын Санкт Петербург филармони болон Германы Лейпциг хотын дуурийн театрын найрал хөгжмийг удирдсан анхны Израил удирдаач аж.

Тель-Авив хотын уугуул Итай Талгам нь Йрусалим Рубин академид Америк Израилийн соёлын сангийн тэтгэлгээр суралцаж, 1987 онд уран сайхны удирдаачаар диплом авчээ. Үүний дараагаар тэрбээр Италийн Чигана хөгжмийн академид Италийн Франко Феррара болон Оросын Геннадий Рождественский нарын хамт Америкийн Тангльвүүд хотод Сеажи Осава, Леон Флейшрболон Ленни Бернстейн гэх мэт алдарт хөгжмийн зохиолч удирдаач нарын удирдлаган дор суралцжээ. Үүнээс гадна Ирусалим хотын Хебрюих сургуульд ерөнхий философи судалж эрдмийн зэрэг хамгаалсан гэнэ.

Итай Талгам нь Рубин хөгжмийн академи, Тель Авивийн их сургууль болон Иерусалим хотын Хөгжим бүжгийн академид багшилж байсан юм байна. Хөгжим удирдахынхаа хажуугаар тэрбээр цөөнгүй боловсролын төсөлд идэвхтэй оролцжээ.

2012. 03 САР.

TRANSWEST
MONGOLIA LLC

*Таны* ***Шийдэл***
*Бидний* ***Зорилт***




# Комацу-ийн
# АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТЕР

- КОМАЦУ БРЭНДИЙН УУЛ УУРХАЙ, ЗАМ БАРИЛГЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- БАТАЛГААТ СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ, НЭМЭЛТ ТОНОГЛОЛУУД
- МЭРГЭЖЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

HENSLEY · BLACK CAT BLADES · PATRIA · JCB HEAVY DUTY LOADING · FSI

KOMATSU
www.komatsu.com

**Трансвест Монголиа ХХК**
СБД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-17, Блю Скай Цогцолбор, 601 тоот
Ш/Х-2016, Улаанбаатар-14210, Монгол улс
Утас: (976) 7010-9905, 9990-9719, 9999-6712, Факс: (976) 7010-9906

www.transwest.mn
https://www.facebook.com/TranswestMongolia
И-мэйл: info@transwest.mn

ЗОЧИН

# Олон улсыг Монголоор “цэнэглэ”

*Хяналтгүй хар тамхи, архи, эрх мэдэл, мөнгөний хэрэглээ мөн төрлөхөөс заяасан аливааг арилжаалах авьяас нь түүнийг луйварчин болгосон. Үнэт цаасны луйвар хийсэн хэргээр 2004-2006 онд 22 сар шоронд ял эдэлсэн “Уолл Стритийн Чоно” Жордан өнөөдөр борлуулалтын авьяасаа өөрийн болон бусдын амьдралыг чиглүүлэхэд ашиглаж байна.*

*Жордан 1990 оны үед өөрийн “Стратон Оакмонт” компаниар дамжуулан маш олон сая долларыг үнэт цаасны зах зээл дээрээс босгосон байдаг. Өдгөө 51 настай тэрбээр 2013 онд түүний амьдралаас сэдэвлэн бүтээсэн алдарт Мартин Скорсесс найруулагчийн “Уолл Стритийн Чоно” хэмээх киног тухайн үед өрнөсөн үйл явдлыг бодитоор дүрсэлсэн гэж хэлдэг. Тус киноны эхэнд Жордан Белфортын дүрийг бүтээсэн Леонардо Ди Каприо хэр их мөнгөтэй харьцаж байсан талаар “Би 26 нас хүрсэн жилээ 49 сая ам.долларын ашиг олсон нь миний уурыг үнэхээр их хүргэсэн. Учир нь тухайн жилийн долоо хоног бүр нэг сая ам.доллар олж байсан гэж нэрлэгдэхэд гуравхан сая ам.доллар надад дутсан юм” гэж хэлдэг. Хар багаасаа мөрөөдсөн баяжих хүслээсээ үүдэн оргилоос ангал руу унасан Жордан өнөөдөр өөрийгөө “Номхорсон Чоно” хэмээн тодорхойлж буй.*

*“Уолл Стритийн Чоно” энэ сард Монголд ирж, улс төр бизнесийнхэнд өөрийн гарамгай эзэмшсэн ятгах, ярих урлагаас хуваалцаж, Монгол хэрхэн өөрийгөө олон улсад зарж борлуулах талаар зөвлөсөн. Энэ үеэр тэрбээр манай сэтгүүлийн асуултад хариулах цаг бидэнд гаргасан юм.*

**-Таныг юу амжилтад хүргэж, бас юу ангал руу унагасан бэ?**

Миний амжилтын зүрх нь олон жил хэрэглэж ирсэн миний арга барил систем байсан. Найман настайгаасаа л олон төрлийн ажил хийж, мөнгөжих санаануудаа хэрэгжүүлж эхэлсэн. Харин 24 нас хүрээд хүмүүсийг сургах санаа төрж, өөрийн гэсэн сургалтын арга барилыг нээсэн гэж хэлж болно. Энэ нь “Шулуун шугам” гэж олонд танигдсан. Үүнийг сурахад гайхам хялбар атлаа өндөр үр нөлөөтэй техник бөгөөд энгийн нэгнийг дэлхийн хэмжээний борлуулагч болгодог. Энэ л үндсэндээ миний болон манай компанийн амжилтын ард байсан хүч. Гэвч бас миний уналт, ёс зүйгээ алдсан шалтгаан. Энэ бүх гамшиг ч гэж хэлж болохоор үйл явдлын үндсэн шалтгаан нь хэт хурдан өндөрт гарсанд оршдог.

Гэвч энэ олон жил өнгөрөхөд, амжилтад бас уналтад хүргэсэн шулуун шугамын системээ би бизнес маркетингаас эхлүүлээд удирдан чиглүүлэх гэх зэрэг олон үйл ажиллагаанд ашиглах болсон. Ямар ч ажил, бизнес эхлүүлсэн дүрэм мэт үйлчилж, амжилтын ард зогсож байдаг тодорхой элементүүд байдаг. Энэ л миний амжилтын суурь байсаар ирсэн.

Тэдгээр өдрүүдэд бий болсон ажил амьдралын эндэгдэл нь агшин зуурын хэт их сэтгэл ханамж хөөрөл дээр суурилж байсан. Би дэндүү огцом хурдалсан, харин өнөөдрийн энэ өндөрлөгөөс бизнес гэж чухамдаа юу болохыг ухаарч, хурдаа хасч явна даа. Үнэ цэнэ гэгчийн мөн чанар, ач холбогдлыг тодорхойлж байна гэсэн үг. Үнэ цэнийг бусдад өгч чадахгүй



*Жордан Белфорт өөрийн амжилтын туршлагаасаа Монголын бизнес эрхлэгчдэд хуваалцсан*

аваас хэчнээн мундаг борлуулагч байсан ч нэгэн цагт эцсийн цэгтэйгээ тулгарна. Хэзээ ч байнгын энэ эрчээрээ зараад борлуулаад байна гэж байхгүй.

**-Эргээд харахад таны хамгийн гүн харуусал юунд оршдог вэ?**

Би хүмүүсийг сургах сургалтын тогтолцоог бодож олохдоо компанийнхаа өсөлтийг сааруулалгүй огцом дээш цойлохыг зөвшөөрсөнд миний харамсал оршдог. Учир нь манай компанийн зах зээлээс түрүүлсэн хөгжил, өсөлтөд тохирсон тухайн үед салбарын зохицуулалт байгаагүй. Тиймээс зохицуулалт байхгүй ч бид үүнийг хуулинд байхгүй аргаар хийж, асар хурдан өссөн. Ингээд л замаас хазайж, өндөрт гарсны дүнд хяналтаас гараад явчихсан. Энэ бол миний хамгийн том алдаа.

**-Хэрвээ цаг хугацааг эргүүлж болдог байсан бол Та юуг өөрчлөх вэ?**

Би амжилтынхаа өсөлтийн хурдыг сааруулж, тогтворжуулах байсан. Мөн тэрхүү ёс суртахууны шугамыг давахгүй байх байлаа. Тэр олон хүнийг мөнгөө алдахад хүргэхгүй байх байсан.

**-Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийн хувьд ёс зүйгүй үйл ажиллагаанд оролцож эхлэх цэг буюу зөв ба буруугийн хилийн дээс гэж байдаг уу?**

-Би ёс журам, ёс зүйн шугам байдаг гэдэгт итгэдэг. Элэг бүтэн өсч, хүмүүжсэн хүмүүсийн дийлэнх нь үүнийг юу болохыг мэднэ. Тэд энэхүү шугамыг давах гэхдээ тийм нэг гэдэс өвдөх мэт таагүй мэдрэмжийг авдаг. Харин зарим хүмүүсийн энэхүү шугамыг давдаг шалтгаан нь өөрийгөө зөвтгөн хамгаалж, шалтагладаг байдал нь. Тэд энэхүү зураасыг давах тоолондоо өөртөө муугүй шалтаг бодон олж, өөрийгөө зөвтгөх бөгөөд зөвхөн энэ удаад л ингээд хийчихье гэдэг. Гэвч энэ бол урт хугацааны амжилтын жор биш. Тэрхүү хил хязгаарыг давсан л бол дагаад ёс суртахууны шугам байрнаасаа хөдөлдөг. Ингээд шугамыг давах тоолонд тухайн хүний ёс суртахууны шугам хэм хэмжээнээс холдсоор байдаг. Хэр хол явснаа мэдэхээс өмнө, та хэзээ ч хийхгүй гэсэн зүйлээ баг багаар хийж эхэлж байдаг. Анхандаа бүх юм зүгээр харагддаг,санагдана. Гэвч нэг л мэдэхэд тийм биш болсон байдаг.

**-Бизнесийнхний хувьд луйврын шинжтэй ямарваа үйл ажиллагаануудад оролцох гэж буй эсэхээ мэдэх сэрэмжлүүлгийн шинж тэмдэгүүд нь юу байдаг вэ?**

-Үнэн байхад дэндүү итгэмээргүй сайхан санал хэн нэгэн танд тавьсан бол энэ бол луйвэр гэдэг нь илэрхий. Хоёрдугаарт, “мэдрэмжийн шалгалт” гэж би өөрөө нэрлэдэг зүйл байна. Хэрэв тухайн нөхцөл байдал таны сэтгэлд нэг л зөв биш санагдвал магадгүй тэр мэдрэмж чинь үнэн байх магадлалтай. Тиймээс ийм тохиолдолд тухайн асуудлыг сайн мэддэг хуульч, мэргэжилтнээс зөвлөгөө ав. Энэ удаад л хийгээд үзчихье гээд азаа туршчихаж болохгүй.

**-Монголчууд таны алдаанаас юуг суралцаж болох вэ?**

-Миний ажил амьдралаасаа олж авсан хамгийн үнэтэй сургамж бол эрх мэдэл, борлуулалтын нөлөөлөл. Монголын хувьд өөрсдийн тухай түүхээ зөв зохистойгоор хүргэж чадахгүй байгаа асуудал дээрээ л сайн ажиллах хэрэгтэй байна. Энэ бол том асуудал.Өөрийн бизнесээ хяналтаасаа гаргаж, зогсохооргүй болгосон нь миний алдаа байсан. Та бүхэнд ч өссөн, урууджсан сургамж бий. Үүнийгээ ашигла. Хяналттай бай.

**-Та Монголын хөрөнгийн биржийн өнөөгийн байдлыг хэрхэн харж байна вэ? Бид хэрхэн хөрөнгийн зах зээлээ хөдөлгөж, сайжруулах вэ?**

-Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд дотоодынхоо зах зээлд суурилдаггүй, итгэл үзүүлдэггүйд оршиж байна. Хууль өөрчлөгдөж гаднын хөрөнгө оруулагчид мөнгөө татсан тухайн үеийн уналтаас та бүхэн дөнгөж өндийж байна. Тэгээд Лондонгийн хөрөнгийн бирж орж ирээд төлбөр тооцооны дүрмүүдийг өөрчилсөн. Гэвч одоо ч засаж сайжруулах дүрэм журам, зохицуулалт байна. Гэхдээ үүнээс илүүтэй, дундаж монгол хүний амжилтын талаарх ойлголтод философийн суурь өөрчлөлт, шилжилт хэрэгтэй байна. Та бүхэн өөрийн хөрөнгийн зах зээлдээ, улмаар эдийн засагтаа итгэл үзүүлдэг байх нь чухал. Тийм биш бол амжилтад хүрнэ гэдэг юу л бол.

**Та хэвлэлийн бага хурлын үеэр Монгол эдийн засгийн хөдөлгүүрээ эргүүлэн асаахад “мөс хагалагчид” хэрэгтэй байна гэж хэлсэн. Тэгвэл үүнийгээ илүү тодорхой тайлбарлаж өгөхгүй юу?**

Хурдасгуур. Тухайлбал, дэлхийд нэрд гарсан томоохон компаниудын нэг Монголд орж ирж үйл ажиллагаа явуулах гэж байгаа талаарх мэдээллийг олон улсад хүргэж болно. Энэ нь эргээд олон улсыг Монголын талаарх сонирхлоор “цэнэглэж” эхэлнэ. Энэ нэг боломж. Нөгөө талаас монголчууд өөрсдөө бусдад нутаг орноо танилцуулж, зөв талаас нь ярьж өгч, хөрөнгийг татах замаар хэрэгжих боломжтой. Тиймээс эдийн засгийн хөдөлгүүрээ дотроос нь мөн гаднаас нь асааж болно. Ямартай ч асах нь гарцаагүй.

**Монголчууд өнөөдөр хөрөнгө оруулагчдыг татахыг ихээхэн чармайж, олон улсын чанартайы уулзалт чуулган зохион байгуулж, бас очиж оролцож байна. Энэ нь хэр үр дүнтэй арга бэ. Таны хэлээд байгаа зөвлөгөөтэй нийцэж байна уу?**

Мэдээж хэрэгзөв. Ер нь олон улсын томоохон компаниудыг авчрах нь их чухал. Гаднын хөрөнгө оруулалтын урсгалыг сайжруулахын зэрэгцээ тэдгээр хөрөнгө оруулагчид танай улсын баялгийг эзэрхийлэн, тоноод явахгүй байх тал дээр хяналттай байх нь зүйн хэрэг. Тиймээс гэрээний зүйл заалт хоёуланд нь ижил тэгш үйлчлэх ёстой. Монголын газрын доорх баялаг, түүний цар хүрээг тооцоод үзсэн ч гаднын хөрөнгө оруулалт сэргэх нь тодорхой. Энэ тал дээр ахиц гаргахаар ихэд хичээж байгааг би харж байна. Эдийн засгийн энэхүү хурдасгуур нь байгаа оноход хугацаа л хэрэгтэй.

**-Хөрөнгө оруулагчид боломж, урт хугацааны өгөөж өндөр байгааг мэдэж байгаа. Гэхдээ Засгийн газрын тааварлаж үл болох үйл ажиллагааг саад гэж харж байгаа энэ нөхцөлд бид хэрхэн тэднийг татах вэ?**

-Хоёр талын хувьд байгуулсан гэрээг тогтвортой хадгалж, аль аль талаас асуудалгүй мөрдөх нь чухал. Компаниуд 68 хувийн гэнэтийн ашгийн татвар төлөхийг хүсэхгүй. Гаднынхан хөрөнгө оруулахад таатай нөгөө талаас Монголын ард түмэн бүрэн хамгаалагдсан тогтолцоог гаргаж ирж, нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх нь Засгийн газарт тийм хэцүү биш. Хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин савласан, тогтворгүй байхад л хамгийн дургүй байдаг. Хэрвээ одоо та бүхэн зөв хөдөлж, ард нь Засгийн газар чинь зогсож чадвал гаднын хөрөнгө оруулалт эргээд л ирнэ. Өнөөдрийн хувьд цаг хугацааны л асуудал. ■

2014 ОНЫ 06 САР.

# Бидний өмнө гурван тэрбумын зах зээл байна

*“НоваТерра” компанийн захирал Б.Бямбасайхантай бизнесийн шинэ стандарт, боломж, хууль эрх зүйн орчны талаар ярилцлаа.*



**-Нэгэн үе “Ньюком”-оор овоглож байсан Бямбасайхан өдгөө “НоваТерра” гээд шинэ компанийн захирал болжээ. Та компанийнхаа талаар товч танилцуулахгүй юу?**

-2013 онд бие биенээ ойлгодог, санхүү, менежментийн туршлагатай хүмүүстэй нийлж “НоваТерра” компанийг үүсгэн байгуулаад ажиллаж байна. Манай компани хөрөнгө оруулалт, төслийн менежмент гэсэн хоёр үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Өнгөрсөн онд манай компанийн хувьд хэд хэдэн төсөл дээр амжилттай ажилласан. Тэр дундаа үйлдвэрлэлийн төсөл дээр хүртэл санхүүжилт босгож чадлаа. Стандартын дагуу ажлаа хийвэл, хөрөнгө мөнгө босгож болж байна.

Эдийн засгийн өндөр өсөлтийг дагаад ойрын 10-15 жил барилга, дэд бүтэц, эрчим хүч, усан хангамжийн чиглэлээр томоохон бүтээн байгуулалт хийгдэхтэй холбоотойгоор бидэнд олон улсын стандартын дагуу ажиллах шаардлага тулгарч байгаа. Энэ шаардлагын дагуу олон улсын томоохон, нэр хүндтэй инженерингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Mott MacDonald” компанитай хамтын ажиллагаагаа Монголд эхлүүлсэн.

**-Эдийн засаг өсөхийн хэрээр яригдаж байгаа нэг зүйл бол олон улсын хэмжээнд ажиллах шаардлага бидний өмнө тулгарч байна. Энэ шаардлагыг Монголын компаниуд биелүүлж чадаж байна уу?**

-Бизнес явуулах таатай орчин зарим талаараа бүрдсэн гэсэн үг. Тиймээс олон улсын стандартын дагуу бизнесээ явуулах нь бизнесийн амжилтын суурь боллоо. Гэхдээ бид санхүүжилтын эсвэл инженерингийн чиглэлийн тодорхой стандартыг шинээр бий болгох гээд байх хэрэггүй. Харин бэлэн байгааг нь шууд аваад ашиглах боломж нээлттэй байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөх нь нэг талдаа хөрөнгө оруулагчдын итгэлийг олох гол арга зам. Нөгөө талдаа тухайн бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь дуусгах чадавхийг нэмэгдүүлдэг. Өнөөдөр бид зөвхөн гурван сая хүн амтай зах зээлд өрсөлдөөгүй. Харин Хятад, Орос, Энэтхэг тэргүүтэй гурван тэрбум давсан хүн амтай асар том зах зээлд ажиллаж байна. Ийм том зах зээлд олон улсын стандартын дагуу ажиллахгүй л бол оршин тогтноход хэцүү.

**-Статистик мэдээллийг харахад муу мэдээ олон байна. Ойрын хугацаанд эдийн засаг бидний төсөөлж байсан шиг сэргэхгүй л болов уу. Энэ талаар бизнес эрхлэгч хүний хувьд ямар хүлээлттэй байгаа вэ?**

-Өнгөрсөн онд бид амжилттай ажилласан. Эдийн засаг уналттай байна гээд зүгээр суугаад байж болохгүй. Эерэг талаас нь харвал хууль эрх зүйн хүрээнд бизнесийн орчныг дэмжих хэд хэдэн хууль батлагдлаа. Засгийн газраас бизнесийн орчныг сайжруулахад анхаарч эхэллээ. Ухаалаг төрийн хувьсгал эхэлсэн. Тиймээс энэ онд

эдгээр ажлын үр дүн гарах байх. Ер нь бол бид өөрсдөө л хичээхгүй бол эдийн засаг өсөхгүй. Харин эдийн засаг өсөхгүй бол монгол хүний амьдрал сайжрахгүй. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг дээ. Түүнээс биш хэн нэгэн шидтэн гарч ирээд бүх зүйл сайхан болчихгүй. Үүнтэй холбоотой хариуцлага гэдэг ойлголт гарч ирнэ. Хувь хүн, бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа компани бүр хариуцлагатай байж чадвал амьдралын түвшин дээшилж, тухайн байгууллага илүү ашигтай ажиллана. Тэр цагт эдийн засаг бидний хүсээд байгаа шиг өсөх нь дамжиггүй.

**-Хариуцлага. Энэ талаар хаа сайгүй ярьдаг ч манайхан хариуцлагаас зугатаж булталх нь их. энэ ойлголтын талаар та юу хэлэх вэ?**

-Хариуцлага гэдэг бол аливаа ажлыг эхлүүлсэн л бол заасан хугацаанд нь чанартай дуусгах явдал юм. Нөгөө талдаа ухаалаг төр гэж яриад байгаа маань хариуцлагатай байх тухай л асуудал юм шүү дээ. 2050 он гэхэд долоон сая иргэнтэй болж дундаж наслалтаа нэмэгдүүлье. ДНБ-ээ 380 тэрбум ам.долларт хүргэе. Нэг хүнд ногдох ДНБ-ийг 55 мянган ам.долларт хүргэх, хөрөнгө оруулалтын хувьд ААА зэрэглэлтэй болох гэвэл олон зорилгыг онцлон Ерөнхийлөгч ухаалаг төрийн талаарх илтгэлдээ дурдсан. Энэ бүхэн боломжгүй зүйл биш. Магадгүй хичээвэл 2050 оноос ч өмнө эдгээр зорилтод хүрч болно. Үүний тулд л хүн бүр миний түрүүний дурдсан хариуцлагатай буюу цагийн юмыг цагт нь олон улсын стандартын дагуу хийдэг болох хэрэгтэй.

Мөн манай улс хуулийн засаглалын тухайд бүс нутагтаа манлайлагч болмоор байна. Хуулиа дээдэлдэг байх нь чухал. Энэ чинь бас л нэг төрлийн хариуцлагын тогтолцоо шүү дээ. Монголтой адилхан далайд гарцгүй жижиг орон болох Швейцарь өнөөдөр яагаад өрсөлдөх чадвараараа дэлхийд тэргүүлж байгаа юм бол. Тэгвэл Монгол Улс далайд гарцгүй хэдий ч гурван тэрбум гаруй хүнтэй том зах зээлийн дунд байдаг асар их баялагтай орон байж яагаад дэлхийн тэргүүлэх улс болж болохгүй гэж. Боломж байгаа юу гэвэл байгаа. Тиймээс тэр зүг рүү л олуулаа хамтдаа алхана. Гурван сая хүн бүгдээрээ нэгдэж нийлээд энэ том зорилгын төлөө хамтдаа хөдөлмөрлөнө. Утааг бууруулна гээд л байдаг. Энд хэн нэг нь нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлаад аль болох утаа гаргахгүйг хичээгээд байлаа гэж бодъё. Гэтэл тэнд байгаа нэг нөхөр тааралдсанаа түлээд утаа гаргаад байж болохгүй биз дээ. Ийм сэтгэхүйтэй байвал бид утаанаас салахгүй. Хамгийн гол нь яндангийн утаанаасаа түрүүлээд сэтгэлгээний угаараа л арилгах хэрэгтэй. Бизнес ч гэсэн ялгаагүй. Дор бүрнээ жижиг ашиг хараад суух биш, Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар буюу өсөлтийн төлөө нэгдэж байж бид мөрөөдөөд байгаа хөгжилд хамтдаа хүрнэ.

**-Та Монголын Бизнесийн зөвлөлийн тэргүүн. Өөрөө ч залуу бизнесмэн. Тэгвэл өнөөдөр бизнесмэнүүд чухам юу хүсч байна вэ?**

-Монголын Бизнесийн зөвлөл 280 гаруй гишүүн компанитай. Эдгээр компанийн удирдлага болон ажилчдын хүсдэг гол зүйл нь хууль эрх зүйн орчин нь тогтвортой, тодорхой байгаасай л гэдэг. Тогтвортой, тодорхой хууль эрх зүйн орчин нь бүрдчихвэл тухайн компани бизнес хийгээд ашгаа олоод, татвараа төлөөд, ажлын байр бий болгоод явах тэмүүлэлтэй байна. Монголын компаниуд олон улсын стандартын дагуу ажиллаж чаддаг болсон. Өмнө нь компанийн эзэд аман гэрээ байгуулаад ойлголцоод ашигтай ажилладаг байсан сайхан цаг байсан. Учир нь аливаа бизнес чинь итгэл дээр тогтдог. Гэхдээ өнөөдөр бизнесийн цар хүрээ нь тэлж, өрсөлдөөн асар хурдтай нэмэгдсээр байна. Ийм нөхцөлд Монголын компаниуд олон улсын стандартад нийцсэн гэрээ хийх, тухайн гэрээний дагуу ажиллах ёстой болж байгаа юм. Хоёр тал гэрээ хийж байгаа тул харилцан ашигтай байх хэрэгтэй. Харилцан ашигтай ажиллах хэд хэдэн зарчим бий. Тухайлбал, зардал багатайгаар үр ашигтай, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхитай менежменттэй байх. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл үйлчилгээ үзүүлэхдээ өндөр үр ашигтай технологи нэвтрүүлэх. Ингэж чадвал тухайн бизнесийн өсөх боломж нэмэгдэнэ. Гэхдээ анхаарах зүйл бий. Нөгөө капитализмыг морьтойгоо харайгаад алгассан гэдэг шиг технологийн хувьд илүү дэвшилтэт шинэ технологийг шууд ашиглаад, менежментээ оновчтой болгож чадвал тухайн бизнес өндөр үр ашигтай ажиллаж чадна.

**-Та хэд хэдэн удаа олон улсын стандартын талаар дурдлаа. Тэгвэл бизнес явуулахад чухам ямар олон улсын стандарт барьж ажиллах ёстой вэ?**

-Стандарт гэдэг өргөн хүрээтэй ойлголт л доо. Хэрвээ барилга барьж байгаа бол тодорхой стандарт, дүрэм журам гаргаад цаасан дээр батлаад бүх барилгын компани тэр дагуу л ажиллаад байж болно. Бизнесийн хувьд арай өөр. Бидний хамгийн их ярьдаг санхүүжилт босгох, хөрөнгө оруулалт татахын тулд хөрөнгө оруулагчдын итгэлийг олох хэрэгтэй. Ашигтай, ирээдүйд “чулуу” болох шинэ санаатай хүн монголоор дүүрэн. Гэхдээ хэчнээн сайхан санаатай байлаа гээд хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй бол ямар ч хэрэггүй. Хэн ч чамд итгэж хөрөнгө оруулахгүй. Хэрэгжүүлэх арга замаа тодорхой болгохын тулд хүн бүрийн итгэдэг, олон улсын хэмжээнд нийтлэг дагаж мөрддөг стандартын дагуу бүх материалаа бүрдүүлэх ёстой. Өнөөдөр олон улсын санхүүгийн компаниуд хүлээн зөвшөөрдөг стандартын дагуу бүх материалаа жин тан болгох нь хэн хэндээ амар. Мөн олон улсын хэмжээнд сэтгэх хэрэгтэй. Тэдэнтэй адилхан сэтгэж байж тэдний юу хүсч байгааг мэдэж авна. Дээр нь нэмээд тухайн гэрээ хийх гэж буй хүнтэйгээ бизнесийн хэлээр ярьдаг байх ёстой. Зөвхөн англи хэлээр ярьдаг байх нь бизнест хангалтгүй. Бизнесийн түншүүд биедээ итгэхийн тулд сайн ойлголцох ёстой шүү дээ. Сайн ойлголцохын тулд бид тухайн хөрөнгө оруулагчийн “төрөлх” буюу санхүүгийн хэлээр нь ярьж чадвал учраа олоход илүү хялбар байдаг. Энэ мэт бизнесийн түншийнхээ итгэлийг олохын тулд бид өөрсдөөсөө шалтгаалах бүх зүйлийг чанарын өндөр түвшинд хийх хэрэгтэй. Тиймээс бизнесийн хувьд чанар, стандарт гэдэг ойлголт нь маш өргөн хүрээг хамардаг. Хэрвээ энэ талаар сайн мэдэхгүй бол мэддэг чаддаг хүнээс нь асуугаад, сураад л явна. ■

2014 ОН. 2 САР.

# Ц.Дашцэрэн: Хөгжлийн хоёр дахь шатанд олон барилга сүндэрлэнэ

*“Бид таны орон сууцыг зарж, борлуулж өгнө” гэсэн зар сонинд гаргаж, ажлаа эхэлсэн бизнесмэн бол “Мастер” группийг үүсгэн байгуулагч, ерөнхий захирал Ц.Дашцэрэн. “Мастер проперти” энэ нэр Монголын үл хөдлөх хөрөнгийн худалдаа борлуулалтын зах зээлд зургаан жилийн өмнөөс орж ирж, өдгөө байр сууриа баттай эзэлжээ. Өндөр үнэтэй орон сууц, оффисын томоохон худалдаа борлуулалтыг тус компани л гүйцэтгэдэг. Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, үйлчилгээ, үнэ ханш, хөгжлийн чиг хандлагын талаар Ц.Дашцэрэн захиралтай ярилцлаа.*

**-Танай группийн охин компани “Мастер пропертис” үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн борлуулалт, худалдааны 41 хувийг эзэлж байгаа статистик мэдээлэл байна. Амжилтад хөтөлсөн нууцаасаа хуваалцана уу?**

-Манай хамт олны хувьд том амжилт. Товчхон хэлбэл, бид маш их хөдөлмөрлөдөг. Амралтын хоёр өдөр ч ажилладаг. Бидний хүсэл мөрөөдөл, зорилго олон улсын стандартыг сурч эзэмшээд эх оронд нэвтрүүлж, эргээд олон улсын зах зээлд гарч ажиллах. Ийм зорилго тавьсан хүмүүс сайн ажиллахаас өөр аргагүй. Мөн бид оюутнууд, суралцагч. Том компаниудаараа бахархдаг. Үндэсний томоохон компаниудын удирдлага, шилдэг менежерүүдээс зөвөлгөө авч, санал бодлоо хуваалцаж, тэднээс үлгэр дууриал авч ажилладаг. Монголын үл хөдлөх хөрөнгийн худалдааны зах зээлд өнөөдөр 20 гаруй компани тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Тэдний ихэнхийг нь манай компаниас ажлын гараагаа эхэлсэн хүмүүс удирдаж байна.

**-Компани анх байгуулагдах үеийн эдийн засгийн байдал өнөөдөр хэр өөрчлөгдсөн бол?**

-2007 онд компани маань хоёр ажилтантайгаар байгуулагдсан. Жилийн дараа хэвлэлд анхны рекламаа үнэгүй өгч байлаа. Тэгвэл өнөөдөр манай компани зар сурталчилгааны зардалд жилдээ багагүй мөнгө зарцуулдаг болжээ. Улс орны нийгэм, эдийн засгийн байдал ч мэдээж өөрчлөгдсөн. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны тухай ойлголт өөр болж, эрчтэй хөгжсөн. Улс нь ч, компани нь ч, хэрэглэгч нь ч хөгжиж байна. Бусад манайхтай ижил төстэй орныхтой харьцуулахад энэ салбарын хөгжил өндөр түвшинд хурдтай явж байна



*“Мастер” группийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал Ц.Дашцэрэн*

гэж үзэж болно. Манай хөрөнгө оруулагч Швейцариас ирээд “Та нар Туркменестан, Дундад Азид ийм төрлийн бизнес хийх боломж байна. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнесийг зааж, сургах түвшинд ажиллахаар байна” гэсэн. Бид урамшаад улам илүү сайн ажиллахыг хичээж байгаа.

**-Үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, худалдааны хууль, эрх зүйн орчин манайд хэр бүрдсэн бэ?**

-Нэг сайн, нэг муу зүйл байна. Үл хөдлөх хөрөнгө өөрөө өндөр үнэтэй. Манай улсын хувьд өмчлөх талаасаа зохицуулагдсан, харин худалдааны харилцаа нь бараг л зохицуулагдаагүй гэж хэлж болно. Тиймээс энэ бизнес эрх чөлөөтэй ч юм шиг, хоорондоо тохиролцоод л, өөрөөр хэлбэл, яаж ч тайлбарлаж болох талтай. Шүүхэд очлоо гэхэд баримтлах хуулийн яг таг нарийн заалтгүй гэсэн үг. Гадаадад Үл хөдлөх хөрөнгийн худалдааны тухай хуулиар зохицуулдаг. Энэ нь худалдаачдад нэмэгдэл төлбөр төлүүлэх гээд байгаа хэрэг биш л дээ. Үл хөдлөх хөрөнгө нь иргэдийн амьдралдаа 4-5 удаа хийдэг том асуудал учир эрсдэлгүй хариуцлагатай байх тогтолцоог бүрдүүлж өгсөн эрх зүйн бодлого юм. Улсдаа ч сайн үр дүнтэй. Тэгэхээр бид эрх чөлөөтэй бизнес эрхэлж байна гээд дураараа явахыг хүсээгүй. Дээрх 20 компанийн төлөөлөл хамтран Үл хөдлөх хөрөнгийн худалдаа борлуулалтын холбоо байгуулж зохих ёсны хуулийн зохицуулалтыг бүрдүүлэхэд анхаарахаар ажиллаж байна. Англи, Америкийн бэлэн туршлагыг эх орны хөрсөнд нутагшуулах л тухай юм. Түүнээс өөр шинэ зүйл сурах гээд явах хэрэггүй. Эрх зүйн орчныг бүрдүүлснээр тоглоомын дүрэм илүү тодорхой болно. Гаднын өндөр хөгжилтэй орнуудад үл хөдлөх хөрөнгийн худалдаа, санхүүжилт, бүтээн босголт, барилгын уялдаа холбоог маш нарийн судалж зохицуулсан байдаг. Энд бид хувь нэмрээ оруулна гэж боддог.

**-Үл хөдлөх хөрөнгийн бизнесийн хөгжил манай улсад ямар шатанд явна вэ?**

-Улс орнуудын хөгжлийн хэд хэдэн шатлал байна. **Нэгдүгээрт,** ямар нэг зүйлээс мөнгө олох. Монгол Улсын мөнгө олох гол салбар нь уул уурхай. **Хоёрдугаарт,** дээрх ямар нэг зүйлээс олсон мөнгө нь тухайн улсын үл хөдлөх хөрөнгийн салбарыг хөгжүүлдэг. Мөнгө хоёр л зүйлд зарцуулагддаг. Нэг нь үл хөдлөх хөрөнгө, нөгөө нь үйлчилгээний салбар. Үл хөдлөх хөрөнгө ба хэрэглээ гэж томьёолж болох. Олсон мөнгөө хэрэглээнд зарцуулсан улс хөгждөггүй юм байна. Үл хөдлөх хөрөнгийн хувьд үнэтэй ч мөнгө хий хоосон үрэгдээд алга болохгүй гэсэн үг. Ингээд хөгжлийн хоёр дахь шатанд улс орнуудад олон байшин баригдаж сүндэрлэнэ. Хөгжлийн гурав дахь шатанд тухайн үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан баталгаажсан үнэт цаас гаргаж эхэлдэг. Англи, Америк, Японы хөгжил энэ жишгээр явж үнэт цаасны арилжааны бизнес хүчтэй хөгжсөн байдаг. Үнэт цаас нь өөрөө санхүүгийн том хөшүүрэг. Тэгэхээр манай улс бусдын замналаар зөв жишгээр гэхдээ нэлээд хурдтай явж байна. Байшин барилга олноор баригдаж байна. Хөгжлийн хоёр дахь шатны эхлэлийг эрчимтэй тавьж байна гэж ойлгож болно.

**-Энд тэндгүй олон барилга баригдаж хөгжиж буй мэт харагдавч чанар талаас харахаар их хэцүү шүү дээ.**

-Хамгийн хүнд сэдэв энэ л дээ. Манай судалгааны ахлах мэргэжилтэн Японоос Улаанбаатар руу нисч ирэхдээ нэг хонгконг хүнтэй танилцсан байна. Тэр манайд баригдсан шинэ орон сууцны насжилтын судалгаа хийж байгаагаа ярьж. Бид их гайхсан. Салбарт нь ажилладаг мөртлөө энэ тухай бодоо ч үгүй байсан. Санаа зовж эхэлсэн. 2001-2008 онуудад баригдсан барилга хяналт сул байсан тул чанар талд хэлэхэд бэрх. Засгийн газрын бодлого үүнд чиглэх ёстой.

Өнгөрсөн хоёрдугаар сарын мэдээгээр 204 төслийн 37000 айлын байр зах зээл дээр борлуулагдаж. Одоо энэ тоо нэлээд нэмэгдсэн. Энэ нь өрсөлдөөнийг харуулна. Өрсөлдөөн чанарыг сайжруулж, үнийг тодорхой хэмжээгээр барина. Социализмын үед барьсан хуучин барилгуудын дулаалгыг цогцоор шийдэх хэрэгтэй байна. Эдгээр хуучин барилга, тэр Дорж, Готов нарын 100 сая төгрөгийн байр чинь нийлээд Монгол Улсын өмч. Дараагийн хөгжлийн суурь бонд үнэт цаасны баталгаа болно. Хэн нэгний байр гэхээсээ илүүтэй үндэсний баялаг хэмээн харж хандаж, анхаарч ажиллаж, амьдрах нь зөв.

**-Монголд орон сууц, оффис өндөр үнэтэй. Зарим хүн 100 сая төгрөгөөр Америкт хоёр давхар хаус барина гэх. Орон сууцны үнэ цаашид өсөх үү, буурах уу?**

-Аль ч улс үндэстэнд баячуудын хороолол байдаг. Америк, Лондон, Японд өндөр зэрэглэлийн тансаг үнэтэй хороолол бий. Америкт үл хөдлөх хөрөнгийн зуучийн бизнес эрхэлдэг монгол хүн надад хэлж байсан. “Америкийн баячуудын хороллыг очиж үзээгүй монгол энд ирээд худлаа яриад байгаад гайхаж байна” гэсэн. Налайхын наана байх хороллын орон сууцны үнийг хотын төв дэх үнэтэй харьцуулж үзэж болохгүй. Тухайн улсын тансаг зэрэглэлийн байрыг тэр орных нь тансаг зэрэглэлийн байрны үнэтэй л харьцуулах ёстой. Оффисын байрыг ч мөн адил.

Манай компани үл хөдлөх хөрөнгийн худалдаа, үнийн талаар таван жилийн турш судалгаа хийж ирсэн. Судалгааны сайн мэргэжилтнүүдтэй, хамгийн сайн судалгаа хийдэг гэж би боддог. Бид 2010-2016 он хүртэлх Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн судалгааг хийсэн. Одоо 2020 он хүртэлх эдийн засгийн хөгжлийн ерөнхий хандлага, үл хөдлөх хөрөнгийн салбарт нөлөөлөх судалгааг хийж байна. 30-40 улсын судалгааг харьцуулан харвал манайтай ойролцоо хөгжил, ДНБ-тэй улсын орон сууцны ам.метр талбайн дундаж үнэ 2000 ам.доллар байна. Манайд бол 1200-1300 ам.доллар. Энэ тоо цаашид өснө. Судалгаагаар 2016 он гэхэд орон сууцны ерөнхий дундаж өсөлт 16 хувьтай нэмэгдэхээр гарсан. Үл хөдлөх хөрөнгийн үнэ өсдөг нэг л шалтгаан бий. Улс орны эдийн засаг хөгжиж, мөнгөний хэмжээ нэмэгдвэл үл хөдлөх хөрөнгийн үнэ дагаад өснө.

Судалгаагаар орлого багатай өрхийнхөө амьжиргааг дэмжих бодлогыг аль ч улс орны засаг төр шийддэг. Тухайлбал, манай Засгийн газраас тодорхой бүлэгт чиглэсэн орон сууцны ам.метр талбайн үнийг 1280 төгрөг гэж тогтоолоо. Энэ бол сайн үнэ. Гэхдээ Монголын бүх байр ийм үнэтэй байна гэж ойлгож болохгүй. Засгийн газар байр худалдан авч дийлэхгүй зорилтот бүлэгт чиглэсэн үнийг тогтоож бага

KIA

*Их хотын амьдралд болон бартаат замын шалгуурт нийцүүлэн орчин цагийн дэвшилтэт технологийг өөртөө шингээн бүрэн шинэчлэгдэн бүтээгджээ.*

SORENTO




SUPER AERO CITY

*Танд тав тух, аюулгүй байдлыг мэдрүүлнэ.*




*Хот хооронд, нийтийн тээвэр болон аялал жуулчлалд.*

HYUNDAI Truck & Bus

MMG
MONGOL MOTORS GROUP

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр - 1/17062, Үйлдвэрийн гудамж 79/ Говь ХК-н зүүн талд, "Монгол Моторс Групп" ХХК
Вэб: www.hmm.mn, www.kia.com, Утас: 90061212, 90061218

орлоготой иргэдээ дэмжиж байна. Түүнээс бусад зэрэглэлийн үнийг хэн ч, ямар ч төр тогтоож чадахгүй. Зах зээлийнхээ жамаар явдаг асуудал юм.

**-2016 он хүртэл орон сууцны үнэ дунджаар 16 хувиар өснө гэж ойлгож болох уу?**

-Бүх орон сууцны үнэ ийм хувиар өснө гэж байхгүй. Жигнэсэн дундаж өсөлт. Зарим байрны үнэ өсөж, зарим нь буурна. Бүр үнэгүйдэх ч байр бий. Байр үнэ цэнэтэй байхын тулд зөвхөн тухайн орон сууц бус, үйлчилгээ, байршил, засвар тордлого гэх мэт зүйлс нөлөөлдөг. Гаднын орнуудад тухайн байшинг 100 жилийн турш үнэ цэнэтэй байлгахын тулд хууль эрх зүйгээр бүгдийг зохицуулсан байдаг. Нэг төгрөгөөр ч авахгүй байр байна. Манай компани герман зөвлөхүүдтэй. Бүтэн хорооллыг маш хямдхан үнээр зарж байсан гэсэн. Тэгвэл нөгөө талдаа хэсэг байрны үнэ 20-30 хувиар өснө. Үл хөдлөх хөрөнгийн хамгийн эхний тоглоомын дүрэм бол хэн ч хэнийг ч хуурч мэхэлж чадахгүй. Тэгэхээр үл хөдлөх хөрөнгөтэй хүн хөрөнгөө сайн үнэлж цэгнэх хэрэгтэй.

**-Үл хөдлөх хөрөнгийн худалдаагаар мэргэшсэн компанийн удирдлагын хувьд орон сууц худалдаж авах талд манай иргэдэд зөвлөгөө өгнө үү?**

**-Нэгдүгээрт,** мэргэшсэн компанийн ажилтнуудаас зөвөлгөө заавал авах хэрэгтэй. Эхлээд байшингаа бус байршлын зөвлөгөө аваарай гэж анхааруулж хэлмээр байна. Ирээдүйд үнэ хүрэх, эсвэл үнэгүйдэх байршил гэж бий. Нэг төгрөгийн ч үнэгүй болох байршлыг анхааран судлах хэрэгтэй. Хүүхэд хаана тоглох, эмээ өвөө нар хаана амарч суух, орой шөнө явахад хир тохиромжтой, агаарын байдал ямар байх, автобусны буудал хэр хол байгаа зэрэг судалгааг маш сайн хийх шаардлагатай. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний 50-иас илүү хувь нь байршил, тухайн байшин бол 50-иас доош хувьд л орно. Манайхан байшингаа л голлоод гял цялд нь хууртагддаг тал бий. **Хоёрдугаарт,** Байшин. Тухайн орон сууц барьсан барилгын компанийн удирдлагыг сайн судлах. Ямар ч захирлын бодлого, хэв шинж, сэтгэл, үзэл барьсан барилгад нь туссан байдаг. Сэтгэлээсээ барьсан, мөнгө олох гэж, таньдаг найз нөхдөөрөө дамжуулан зөвшөөрөл аваад босгосон барилгууд хоорондоо газар тэнгэр шиг ялгаатай. Байшингийн үндсэн тулгуур хийц муу бол хичнээн сайхан гял цял байгаад ч нэмэргүй. Үнэхээрийн сайн чанартай байшин худалдаад авбал та тэр гял цялыг бий болгож болно. Барилгын үндсэн хийцийн чанар маш чухал. **Гуравдугаарт,** орон сууц худалдаж авах өөрийн санхүүгийн бололцоо боломжийн талаар санхүүгийн байгууллагаас зөвлөгөө авах хэрэгтэй. Боломжоо тооцоолоогүйгээс гэрээнүүд олноор цуцлагддаг. Урьдчилгаагаа өгчихье. Тэгээд болно доо гэсэн монголчуудын тооцоолох бус сэтгэлгээг халах хэрэгтэй. Байршил, чанар, санхүүжилтийн эх үүсвэрээ л сайн судлах хэрэгтэй.

**-Танай салбарын онцлог, мөн хүндрэлтэй зүйл юу байна вэ?**

-Энэ нь миний дуртай ажил мөрөөдөл юм. Үнэнээ хэлэхэд бэрхшээл тулгардаггүй гэж хэлж болно. Учир нь би энэ ажилдаа дуртай учраас зарим нэг тулгарах асуудлыг бэрхшээл гэж хардаггүй байх. Бизнест мэдээж асуудал байнга гарна. Асуудал байгаа нь өөрөө бизнес гэж ойлгодог. Хамгийн гол нь түүнийг даван туулах, амжилттай шийдвэрлээд явах хэрэгтэй гэж ойлгодог. Миний хувьд заримдаа төрдөө баярлалаа гэж хэлмээр санагддаг юм. Учир нь эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй тул төрийн зүгээс хорьсон хаасан хүндрэл учруулах асуудалгүйгээр өнгөрсөн хугацаанд ажиллаж ирлээ. Харин бид өөрсдөө ийм чөлөөтэйгээр цааш явж болохгүй гэж үзээд эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй явж байна. Харин иргэдийн зүгээс үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнесийг анхлан ойлгодоггүй, дундаас нь их мөнгө завших нь хэмээн бодож биднийг үздэггүй байлаа. Зургаан жилийн өмнөхийг өнөөдөртэй харьцуулахад өдөр шөнө шиг ялгаатай байна. Үл хөдлөх хөрөнгийн салбар хөгжих тусам манай бизнесийг иргэд сайн ойлгож, ухаарч, хамтарч ажилладаг болно.

Өнгөрсөн хугацаанд нэлээд туршлага хуримтлуулж, хэрэглэгчид ямархуу төрлийн үйлчилгээ хүсдэг, ямар орон сууцтай болохыг боддог, ямар аргаар мөнгөө төлөх хүсэлтэйг нь сайтар ойлгодог болжээ. Бид ер нь хамгийн хэцүү цэг дээр ажилладаг. Хүнээс мөнгө салгах хэцүү шүү дээ. Барилгын компаниудын захирлуудын нэг сул тал нь өөрсдийн мөрөөдлөөр барилга барьдаг. Гадаад үзэмж, орон сууцны өнгөц харагдах байдалд түлхүү анхаардаг. Тэгвэл миний бодлоор барилгын компаниуд иргэдэд орон сууц худалдахаа бодож, өндөр үнэд хүргэх ашгаа тооцоолж, тухайн өрхийн, хүсэл мөрөөдлийг судлаад баривал үр дүнтэй. Ямархуу байр сонирхоод байгаа юм, ямар загвартай, мөнгөний хэмжээ хэр юм, мөнгөө хэрхэн төлөх бодолтой байгааг нь сайн судлах шаардлагатай. Барилгын 51 хувиас багагүй нь судалгаа, хэнд хэдээр, ямар аргаар борлуулах, худалдахыг судлахад чиглэдэг.

**-Дэлхийн үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн чиг хандлага ямар байна вэ?**

-Дэлхийн зах зээл өөр өөр л дөө. Би нэгдүгээр сард Давосын эдийн засгийн чуулганд оролцоод ирсэн. Тэгэхэд өндөр хөгжсөн улсуудад проперти зах зээл дуусан гэж байсан. Манай компани итали, германчуудтай ажиллаж байсан. Тэдгээр улсад 15-20 жил энэ бизнесийн худалдаа идэвхтэй үргэлжилсэн байна. Хөгжлийн гуравдугаар түвшинд гараад ирэхээр санхүүгийн зах зээлд түшиглэсэн бизнес хийдэг тухай дээр ярьсан. Хөгжилтэй орнуудад барилга баригдаж байгаа, гэхдээ бага. Харин 3М буюу Монгол, Мьянмар, Мозамбик улсад үл хөдлөх хөрөнгийн бизнес хамгийн хүчтэй хөгжиж байна. Анголд үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхэлдэг Израйлийн бизнесмэнтэй уулзахад Анголд манайхны хэлдгээр амбаар мэтийн орн сууцны ам.метр тайлбайн үнэ 5000 ам.доллар.Түрээсэлбэл бүр үнэтэй тухай ярьсан. Тэгвэл бид “Blue Sky” тауэрийн 150 ам.метр талбайг нэг тэрбум 800 орчим сая төгрөгөөр борлуулж байсан. Монголын хотын төвийн хамгийн үнэтэй байршил дахь байрны мөнгөөр Анголд нэг муу байшин авах нь гэсэн үг. Үл хөдлөх хөрөнгийн худалдааны бизнес ойрын 100 жилд эрчимтэй хөгжинө. ■

2014 ОНЫ 06 САР.



*Профессор Брэдли К.Гоогинс нь Бостон коллеж дахь Компанийн нийгмийн хариуцлагын төвийн захирал асан. Тэрбээр тус коллежийн Кэррол менежментийн сургуульд багшилдаг. Гоогинс үүний өмнө 20 гаруй жилийн турш Бостоны их сургуульд профессороор ажиллахын сацуу Ажил, гэр бүлийн төвийг үүсгэн байгуулсан билээ. Тэрбээр бизнесийн нийгэмд гүйцэтгэх үүрэг бөгөөд ажил амьдралын тэнцвэртэй байдлаас нийгмийн хариуцлагын чиглэлээр судалгааны ажил хийж, нийтлэл бичдэг. Гоогинс нь ГОУХАН-ээс өнгөрсөн оны есдүгээр сард зохион байгуулсан "Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн хариуцлага" олон улсын хуралд илтгэл тавьсан юм. "Mongolian Econoty" сэтгүүл энэ үеэр түүнтэй хийсэн ярилцлагыг хүргэж байна.*

# Компанийн нийгмийн хариуцлага үнэт чанарын тусгал юм

**-Та манай улсад анх удаа айлчилж байна уу, өөрийн сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?**

-Тиймээ, би Монголд анх удаа айлчилж байна. Гуравхан хоногийн хугацаатай ирсэн ч энд үзэж харж, суралцаж буй зүйлс үнэхээр гайхшруулж байна. Намайг юу тэгж их гайхшруулаад байна вэ гэвэл танай орны өргөн уудам нутаг ба хүн амын тоо. Газрын гүнд орших байгалийн баялаг эдийн засгийн огцом өсөлтийг бий болгожээ. Дэлхийн бусад орон буурч буй өсөлттэйгээ тэмцэж байхад танайд ийнхүү өсөлтийн цаг үе эхэлсэн байна. Маргаашийн нийгмийг хэрхэн бүтээн байгуулах вэ гэдэг асуудлын бэрхшээлүүд надад нэлээд сонирхолтой санагдаж байна.

**-Та Монголын тухай олон ном уншсан байх. Таны нүдээр харсан зүйлс тань мэдээллийн бодит байдалтай хэр нийцэж байна вэ?**

-Шилжилтийн үе дээр гол анхаарлаа хандуулж байсан. Энэ нь танай орон ба хойд хөрш хоорондын харилцаа, социалист дэглэмээс ардчилал руу шилжсэн тухай түлхүү судалсан. Харин миний уншсан материал дээр зөрөөтэй байсан зүйл бол хүн амын тооны мэдээлэл. Та бүгд ирээдүйгээ ямар болох тухай үнэхээр их ойлгохыг оролдож, мөн баялгийг ашиглахыг зорьж байна.

Норвеги улс газрын тосоо яаж ашигласан жишээг надад ихээхэн санагдуулж байна. Танай бизнесийн салбар их сонирхолтой байна. Хурлын үеэр сонссон банкны төлөөллийн / Тэнгэр санхүүгийн нэгдлийн М.Болд захирлын илтгэл/ илтгэл миний олон улс оронд сонсож байсан илтгэлүүдээс хамгийн мундаг нь байлаа. Тухайн орны манлайлал хаанаа байгааг би ямагт олох гэж оролддог. Төрд үү, хувийн хэвшилд үү? Гэхдээ би Монголд удаан хугацаанд байж үзээгүй тул танай төр, хувийн хэвшил хэрхэн хамтарч ажилладаг тухай хэлж чадахгүй.

**-Сүүлийн үед Монгол Улс байгалийн баялгаараа дэлхийн анхаарлын төвд орох боллоо. Та үүнтэй холбоотой тогтвортой хөгжлийн тухай юу хэлэх вэ?**

-Байгалийн баялгийг тойрсон асуудлыг ажих миний хувьд сонирхолтой байдаг. Дэлхий даяар энэхүү баялаг нь хэнийх вэ, хэн үүний эзэмшигч нь вэ гэсэн мэтгэлцээн улам их гарах болсон. Өнгөрсөн үед гаднаас орж ирсэн компаниуд эргүүлж өгөхөөсөө илүү их авдаг байсан. Иймээс тохиолдолд тухайн улс өөрийн нөөц баялгаас бүрэн ашгийг авч чадахгүйд хүрдэг.

Монгол орны хувьд энэхүү үйл явдал 1990 онд биш, харин 2011 онд тохиож буй нь завшаантай хэрэг юм. Учир нь, дэлхийн өнцөг бүрээс компаниуд орж ирэн, улс орны хувьд ашигтайгаар тохиролцож нөөц баялгийг авах нөхцөл 2011 онд илүү сайтар бүрдсэн. Улс орон эхэлж өөрийн ашиг сонирхлыг хамгаалж, компанийн эрх ашгийг харин удаах байранд авч үзэх ёстой.

Компаниуд орж ирээд, баялгийг олборлочихоод гараад явлаа гэхэд Монгол хүн 30 жилийн дараа хаана байх вэ? Ирээдүйг тогтвортой байлгахын тулд юу хамгийн чухал байгааг хэлэлцэх цаг үе иржээ. Байгаа баялгаа хэрхэн ашиглахаас шалтгаалж жинхэнэ тогтвортой хөгжлийн замаар явах уу эсхүл гэдэг тодорхойлогдоно. Бусад улс орны жишээг судлах нь чухал. Тэдний суралцсан зүйлээс Монгол мөн суралцаж болно. Чили, Филиппин, Хятад гэхчлэн орнуудын уул уурхайн салбарт өрнөсөн асуудлыг бид нэлээд харсан. Хамгийн гол нь тогтвортой байдлын асуудлыг чухлаар тавих хэрэгтэй. Өнөөдөр ямар байгаа байдал бус, харин хэрхэн яаж төгсгөх үе шат илүү чухал. Үүнд Засгийн газар болон ард иргэд энэ бүхнээс үр ашгийг авч байгааг баталгаажуулах тул тэдний зүгээс томоохон үүрэгтэй оролцохыг шаардана.

**-Та компанийн нийгмийн хариуцлага сэдэвтэй олон улсын хуралд оролцлоо. Манай улс КНХ-ыг хөгжүүлэхэд цаашид юу хийж болох вэ?**

-Өнөөгийн нийгэмд бизнесийн салбарын гүйцэтгэх үүрэг тэргүүн зэргийн ач холбогдолтой болсон. Энэ нь өрсөлдөх чадвартай уялдаатай. Иймд компаниуд заримдаа миний нэрлэдгээр XXI зууны сүм хийдүүд юм. Тэд хамгийн их нөлөө үзүүлдэг бөгөөд сүм хийд, хаан хатдын залардаг байсан өндөр уулан дээр суудаг. Энэ нь өнөөдөр корпорациуд. Хариуцлага гэдэг нь зөвхөн ёс зүйн төдий асуудал биш. Нийгмийг бүрэлдүүлэхэд тэдний үүрэг юу вэ гэдэг нь илүү чухал асуудал. Байгаль орчны асуудалд тэд ямар үүрэгтэй хандаж байна? Түүхээс авч үзвэл компаниуд байгаль орчныг тойрсон асуудал бол бидэнд хамаагүй, Засгийн газрын үүрэг гэсэн хандлагатай байсан. Шинэ технологи, ил тод байдал гарч ирснээр тэрхүү хандлага

өөрчлөгдсөн. Эдгээр нь “Компаниуд та нар эрх мэдэл, үр нөлөөтэй учир нийгмийн зарим асуудлыг хариуцна. Иймд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг аюулгүй, байгаль орчныг бохирдуулахгүй байх ажлыг эхлүүлэхийн тулд Засгийн газрыг зөвхөн хууль тогтоогч мэтээр үзэх нь зохисгүй юм. Та бүгд бизнесийг хариуцлагатай болгох өөрийн гэсэн арга замыг яагаад хайж олж болохгүй гэж. Хариуцлагатай бизнес гэдэг нь бүх нийтийн сайн сайханд үйлчилнэ. Үүнийг хэр их ашиг олдог вэ гэдэг хэмжүүрээр биш, харин бид бүгдийг хэдий их хөгжил цэцэглэлтэд хүргэх вэ гэдгээр хэмжинэ. Компаниудын үүрэг өргөжин тэлж, тогтвортой нийгмийн төлөө баялгийг бүтээхийн тулд бүх талын оролцогчидтой хамтран ажиллахыг зорилгоо болгодог болсон. Манай оронд жишээ нь цөөн тооны хүн маш өндөр ашиг олж байгаа байдал анзаарагддаг. Тэр бол тогтвортой байдал биш. Компаниуд зөвхөн ашиг орлого олдог явцуу хүрээнээс нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэдэг чиглэл рүү хэрхэн шилжин орох вэ гэдэг асуудалтай нүүр тулж байна.

**-КНХ-ыг манайд хандив өгөх хэлбэр гэж ойлгодог. Америкт ямар байдаг вэ?**

-Хандив тусламж өгдөг тэрхүү хуучин загвар одоо хүртэл Америкт ноёрхсон хэвээр. Яагаад гэвэл компаниуд ямарваа нэг юмыг буцааж өгч байх хэрэгтэй гэсэн ойлголттой. Буяны үйл ажиллагаа хялбар байдаг. Зүгээр л чек биччихнэ, тэгээд боломж тааруу байвал харин юу ч хийхгүй. Гэтэл өнөөдөр Та хэдий хэмжээний мөнгө өгч байна вэ гэдэг биш, Харин энэ мөнгөө яаж олж байна вэ гэдэг асуудал нь чухал болсон. Та бүтээгдэхүүн, үйлчилгээгээ яаж зах зээлд гаргаж байна? Байгаль орчиндоо хэрхэн хандаж байна? Миний хувьд бол, КНХ гэдэг нь тухайн компанийн төлөвлөсөн үнэт чанарын тусгал юм. Энэхүү тогтоож өгсөн үнэт чанарт хариуцлага байхгүй ч гэсэн манай үнэт чанар энэ байна гэж компаниуд хэдэн ч жил хэлж болох юм. Өнөө үед компьютерийн хулганыг ганцхан дарахад л тухайн компани өөрийнхөө тухай юу гэж хэлж байна, бодит жишээн дээр ямар вэ гэдгийн хоорондох ялгааг гаргаж чадна. Үүнд, ажилтнууд нь компаний тухай юу гэж боддог, ямар бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлдэг, байгль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг эсэх гэхчилэн багтана.

-Хэрвээ компаниуд буяны ба хандивын үйл ажиллагааг өөрсдийн хариуцлагын нэгэн хэсэг гэж авч үздэггүй байсан бол тэд бараг яахаа мэдэхгүй байх гэж би хэлдэг байсан. Гэтэл үүнд бизнесийн зүгээс нийгмийн ээдрээтэй асуудалд хэрхэн оролцож, яаж нийгэмд хувь нэмрээ оруулах вэ гэсэн өргөн хүрээ багтдаг. Миний бодлоор, бизнесийн найдлага ба амлалт нь нийгмийг бүтээн байгуулалцахад хэний ч оролцооноос илүүтэй том боломжийг агуулдаг. Компаниуд шинэчлэлийн тухай маш сайн ойлголттой байдаг. Нийгмийн бүх хэсэгт шинэчлэл хэрэгцээтэй. Компаниуд тэрхүү шинэчлэлийг хэрхэн нийгэмд шилжүүлэх вэ?

Монгол Улсыг хамгийн сайн жишээ болно гэж үзэж байна. Хэн нэгэн орж ирээд, ихэнх байгалийн баялгийг ухаж олборлочихоод, улс оронд багахан хэсгийг үлдээгээд гараад явчих магадлалтай. Гэтэл Та бүгд үүнээс ч илүү зүйлийг бүтээж чадна. Өнөөдөр компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг ихээхэн бодож тунгаах шаардлагатай. Компаниуд төрийн бодлогод хэрхэн эерэгээр нөлөөлж болох вэ гэдэг асуултад өгөх хариуг эргэцүүлэн бодох цаг иржээ.

**-Та бидэнтэй КНХ-ын тал дээрх туршлагаасаа хуваалцана уу. Засаг захиргааны зүгээс хариуцлагатай компанийг яаж урамшуулдаг вэ?**

-Хэдэн жилийн өмнө би Америкт компанийн нийгмийн хариуцлагын төвийг хариуцдаг байлаа. Зарим компаниуд нь Форчюн 500-ын жагсаалтад орсон байсан. Би тэдэнтэй танилцаж, өдөр бүр хамтарч ажиллах болсон. Хэдэн жил өнгөрсний дараа харин тэдгээрийн КНХ-ын түвшин адилгүй байсныг анзаарч эхэлсэн. Иймд би КНХ-д зориулж манлайлал, стратегийг багтаасан таван үе шатыг боловсруулсан. Компаниудын дунд Та өөрийгөө одоогийн байдлаар эдгээр үечлэлийн алин дээр нь байна гэж бодож яваа вэ гэсэн асуулга өгсөн. Эхнийх нь уламжлалт үе шат бөгөөд “Мөнгө өгдөг” гэсэн байхад дараагийнх нь “Бизнесийг ашиглан нийгмийг өөрчилмөөр байна” гэсэн заалттай байсан. Тэгэхэд оролцогчдын 90 хувь нь хоёрдугаар үе шатанд байгаа байхаа гэж хариулсан байв. Энэ нь шинэ утга, арга замыг илэрхийлсэн КНХ-ын хөдөлгөөн дөнгөж эхэлж байна гэдгийг надад сануулж өгсөн.

Компаниуд үүнийг үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж болохыг суралцах гэж оролдож байгаа. Энэ чанарын хөдөлгөөн одоогоос 20, 30 жилийн өмнө гарч ирч байсан үеийн түвшинд байгааг би ажигласан. Компаниуд анх чанарын тухай сонсоод “Энэ чинь нээрээ хэрэгтэй санаачилга байна. Үүнийг дэмжие” гэсэн. Дараа нь чанарын ажилтантай болсон. Гэхдээ тэр нь хязгаарлагдмал байсан. Тэгээд оффистой болсон. Тэр нь нэг алхмаар урагшилсан ч бас л хол явж чадаагүй байв. Харин хүн бүр чанар гэдгийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэйг ухамсарласан үед л жинхэнэ утгаа олсон. Үүний тулд маш их цаг хугацаа орсон. КНХ яг үүнтэй адил. Арван жилийн өмнөх байдлыг харахад, ихэнх гүйцэтгэх захирлууд КНХ-ын ач холбогдлыг олж харахгүй байна гэж байв. Зарим нь харин стратегийн хувьд л маш чухал зүйл байна гэж хэлж байсан. Ихэнх ажилтнууд миний бодлоор үүнийг ойлгодоггүй бөгөөд хэрэгжилт ч маруухан. Цөөн хэдэн компани л КНХ-ыг бизнесийн асар том боломж гэж ойлгож, хэрэгжүүлж байна. Гэвч тэдгээрийн тоо одоо ч гэсэн цөөхөн. Ихэнх компани нийгмийн хариуцлагыг үл ойшоож болохгүйг ойлгож байна. Тэд үзэгч байхаа больж, энэхүү үйлст оролцох шаардлагатай тулгарч байгаа. Гэсэн хэдий ч ямар байдалтай оролцох вэ, компанид ашигтайгаар хэрхэн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх вэ гэдэгт одоо хүртэл суралцсаар. Хэрвээ компани үүнийг өрсөлдөх чадвараа болгож ашиглаж чадахүй бол компанид үүнээс өөр том ашиг гарахгүй. Хандив тэтгэлэг, буяны ажилд хүмүүс баярлалаа л гэж хэлэхээс компани, бизнесийг сайжруулахгүй. Нийгэмд ч гэсэн нөлөөлөл үзүүлж тус дэм болж чадахгүй.

Өнөөдөр КНХ нь үнэ цэнийг бий болгох, түүнийгээ бизнесийн загварт оруулж хэрэгжүүлэх, оролцогч талуудтай харилцаж бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан шинэчлэл хийх зэргийг багтаасан цогц үйл ажиллагаа юм. ■

2012 ОНЫ 03 САР.

## ЗОЧИН

*Ардчилсан нийгмийг төлөвшүүлж, ашигт малтмалын арвин нөөцөөрөө дэлхийн анхаарлын төвд орсон Монгол Улсад хол, ойрын зочин гийчид дөрөө мултлах дуртай. Бид ч байгалийн баялгийг хөгжил болгон хувиргаж чадсан орнуудын туршлагаас суралцах учиртай. Залуусын орон гэгдэх Монголд эрдэм боловсрол, өндөр технологи, инновацийг түлхүү хөгжүүлэх шаардлага ч бий. Тиймээс бид холын хүнээс үг сонсоход цаг, зай харамлах учиргүй.*



*2014.07.07. Монгол Улс ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн хүрээнд Гадаад харилцааны сайд Л.Болдын урилгаар ХБНГУ-ын Гадаад хэргийн сайд Франк Вальтер Штайнмайер албан ёсны айлчлал хийв.*



Гэрэл зургийг Б.Бямба-Очир

# “Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг”

*Киргизстан улсын анхны эмэгтэй ерөнхийлөгч Роза Отунбаева өнгөрсөн долдугаар сард зохион байгуулагдсан “Эмэгтэйчүүдийн манлайллын үндэсний чуулганд” оролцохоор Монгол улсад айлчилсан билээ. Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд сэтгэл зүтгэлээ зориулсан тэрбээр Киргизстан улсын гадаад хэргийн сайд, Парламент дахь Социал Демократ намын бүлгийн дарга байжээ. Одоогоос хоёр жилийн өмнө буюу 2010 оны дөрөвдүгээр сард авлигад идэгдсэн Засгийн газар,өвдөг сөхрөм амьдралын өртөгийг Киргизстан улсын ард түмэн эсэргүүцэн, бослого гаргаж байсан. 2000 гаруй хүн амиа алдсан цуст мөргөлдөөнийг таслан зогсооож, улсаа эмх цэгцэнд оруулах үүднээс байгуулагдсан түр Засгийн газрыг Роза Отунбаева намынхаа бүрэн дэмжлэгтэйгээр тэргүүлж, улмаар ерөнхийлөгчийн албыг 2011 оны эцэс хүртэл хашиж байсан билээ. Улсынхаа хувь заяаг тэгшитгэсэн эмэгтэй ерөнхийлөгч гэдгээрээ нэрд гарсан Роза Отунбаеватай манай сэтгүүлч ярилцсаныг хүргэе.*



**-Таныг өмнө нь Монгол улсад ирж байсан гэж сонссон. Тэгвэл таны энэ удаагийн айлчлал өмнөхөөсөө ямар ялгаатай байх вэ?**

Монголд би хоёр дахь удаагаа ирж байна. Өмнө нь Социализмын үед, 1990-ээд онд ирж байлаа. Тэр үед ЗСБНХУ-ын ЮНЕСКО-гийн Үндэсний хорооны даргаар ажиллаж байсан. Тухайн үед би Гадаад хэргийн яаманд ажиллаж байлаа. Өөрчлөн байгуулалт уриан дор явж байсан тэр үеэс хойш Монголд хөгжил дэвшил их гарчээ. Монгол улсын нам болон залуу иргэдийн тоо их юм. Хүмүүс комминуст намын үзэл суртлын нөлөөллөөс ангид сэтгэж эхэлнэ гэдэг бол яах аргагүй сэргэн мандалт.

**-Өнгөрсөн хугацаан дахь**

**хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг дүгнэн хэлэхгүй юу?**

-22 жилийн дараа ирэхэд танай улсад олон зүйл өөрчлөгдөж, сайхан болсон байна. Харамсалтай нь манай хоёр улсын хамтын замнал идэвхгүй явж иржээ. Олон улсын хурал цуглаан дээр монгол хүмүүстэй уулзаж, танилцах боломж их. Харин бүх зүйл дээр бид өөр өөр хэсэгт байх нь олонтой. Жишээ нь, танай улс НҮБ-д одоо Азийн бүлэгт харьяалагддаг болсон. Мөн Европын банк, Дэлхийн банк болон Азийн банкны ангилалд ч тэр өөр хэсэгт багтдаг. Тиймээс өнгөрсөн хугацаанд бидэнд бие биетэйгээ дотно нөхөрлөх боломж дардан байгаагүй. Өөрөөр хэлбэл, бид бие биенээсээ хөндийрч, харилцаа холбоо тасарсан гэж хэлж болно. Хамгийн наад зах нь гэхэд би сая Истанбулаас Бишкек хүрч, тэндээсээ Улаанбаатар руу шууд нисч ирсэн. Энэ нь цаашдаа “Туркиш Эйрлайн” компанийн тогтмол нислэгүүдийн нэг болж байгаа юм билээ. Би үүнийг манай хоёр улсын харилцаанд гүүр тавигдаж эхэллээ гэж дүгнэж байгаа.

**-Манайд ардчилал хөгжөөд 20 гаруй жил болж байна. Тэгвэл ардчилал томоохон ямар өөрчлөлтүүдийг Монгол болон Киргизстан улсад авчирсан гэж Та бодож байна вэ ?**

-Манай улс ардчилсан засаглалтай дөнгөж танилцаж байгаа орон. Хэмжээгүй эрхт засаглалтай байсан оронд мэдээж танил бус байх нь тодорхой ч, ардчилал гэж юу болохыг бид сайн мэднэ. Намууд сонгуульд тэгш эрхтэйгээр оролцон, суудал авч эвсэн засагладаг. Аливаа зүйлийн хөгжлийн эхлэл бол улс төрийн энэ байр суурь гэдгийг бид мэднэ. Гэвч хөлөө олтлоо чамгүй олон жилийг үзэх байх.

Ардчилсан Парламент манай улсын нийгэмд засаглалын ил тод нээлттэй байдал, хамтын зөвшилцөлийг авчирч байна.

Нэг засаглалаас нөгөөд шилжих шилжилтийн үед танай улсын эдийн засаг маш хүндэрч, ард түмний амьдрал нэлээд туйлдсан тухай би сонссон. Гэсэн ч 2012 онд буюу өнөөдрөөр энэ улсыг харахад эдийн засаг, улс төрийн хөгжлийн хүрээнд маш өндөр амжилт гаргаж яваа гэж ойлгож байна. Нэн тэргүүнд, ардчилсан засаглал үр дүнтэй хэрэгжиж, амжилттай урагшилж байгаа нь илт байна. Өнгөрсөн хугацаан дахь зургаан сонгууль тайван болж өнгөрлөө. Найман жил үргэлжилсэн нэг намын засаглал нөгөө намд шилжлээ зэрэг ардчилал жинхэнэ утгаараа хөгжиж буйг илтгэх зүйл танайд олон байна.

**-Эдийн засгийн хүрээнд Монгол, Киргизстан улс хамтарч ажиллах ямар боломжууд байгаа вэ?**

-Маш их бололцоо байгаа гэж бодож байна. Би айлчлалынхаа хүрээнд хамгийн сүүлд Монгол улсын ХХААХҮЯ-ны үйл ажиллагаатай / одоогийн ҮХААЯ/ танилцсан. Мөн танай Ерөнхийлөгч болон сайд нар манайд айлчилсан. Ингэхдээ Монгол манай улсад ноос, ноолууран бүтээгдэхүүнээ борлуулах нь зүйтэй гэдэг дээр ихээхэн шийдвэртэй хандсан юм. Киргизстан улсын хувьд энэхүү бүтээгдэхүүний хөгжилд ахиц дэвшил гаргах хэрэгцээ үлэмж байна. Манай улс танайхтай адил малчин өрх олон бий. Танай улс ойролцоогоор хэчнээн сая толгой малтай вэ? 10-12 мянган малчин, долоон сая гаруй хонь, ямаатай. Харин танайд үүнээс тав дахин их мал бий.

Социализмын үед бид ав адилхан байсныг санадаг. Харин өнөөдөр манай улс ноосны хомсдолд орчихсон. Ноосыг Хятад болон Туркууд худалдаж авдаг. Гэвч гар урлаачдын хувьд ноосны үйлдвэрлэл эрхлэхэд багагүй бэрхшээл тулгардаг. Ноос, ноолуурын худалдааг маш чухал алхам гэж бодож байгаа.

**-Тэгвэл манай улсад танайхаас юу нийлүүлбэл боломжтой вэ?**

-Манайх их хэмжээний жимс, хүнсний ногоог танай улсад экспортлох боломжтой. Би танай улс хүнсний ногооны хэрэгцээгээ дотоод боломжоороо бие даан хангах сонирхолтой байгааг ойлгож байгаа. Гэвч танай улсын ХХААХҮЯ-ны сайд манай орноос хатаасан жимс болон бусад хүнсний ногоог худалдан авах санал тавьсан. Манайх гүйлс, алим зэрэг олон жимсийг хатаан боловсруулдаг. Танайх Оюутолгойд хөрөнгө оруулалт татаж байгаа шиг бид жимсний чанамал болон шүүс гэх мэт үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт татах хүсэлтэй байгаа. Товчхондоо үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нэн шаардлагатай байна.

**-Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх үндэсний чуулганы үйл явцад Та ямар үнэлгээ өгөх вэ? Өмнөх хурлуудаас юугаараа онцлог байсан бол?**

-Дэлхий ертөнц санхүүгийн хямралтай нүүр тулаад байна. Өнгөрсөн арван жилийн эхэнд Европ, АНУ мөн барууны орнууд хэрхэн үсрэнгүй хөгжлөөр амьсгалж байгааг бид харж суусан. Өнөөдөр дэлхий ертөнц бүхэлдээ хямралаас гарах арга замыг эрэлхийлж байна. Харин эмэгтэйчүүд бол түүнтэй тэмцэх нууц зэвсэг юм. Миний хувьд энэ жил 2-3 эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаарх хуралд оролцсон. Түүнээс гадна эмэгтэйчүүдийн мэдлэгт суурилсан эдийн засгийн талаар ярилцдаг тусгай хэсэг бүхий Европын сэргээн босголт хөгжлийн банк /ЕСБХБ/-наас жил бүр зохион байгуулдаг уулзалтад оролцсон. Тус хурал их сургууль төгссөн эмэгтэйчүүдийн тэр дундаа эмэгтэй инженерүүдийн мэдлэг чадамжыг үр бүтээлтэй ашиглаж чадаж буй эсэх асуудлаар хэлэлцдэг юм.

Энэ оны сүүлчээр би Арканзасын Литтл Рок хэмээх газар руу явна. Би мөн хуучин ерөнхийлөгч, ерөнхий сайд нарын нэгдсэн клубын гишүүн. Энэ бол нэг төрлийн эмэгтэйчүүдэд зориулсан уулзалт юм. Улс орон болгонд хөгжлийг бий болгохын тулд үйлдвэрлэлд өөрсдийн хүчин чармайлтаа зориулдаг маш олон эмэгтэй байдаг. Дэлхий даяар өнөөгийн эдийн засгийн хөгжлөөс ангид хэчнээн эмэгтэй гэртээ суугаа бол? Тэд бол дэлхийн тал. Хятадын зүйр үг байдаг шүү дээ. “Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг гэж”.

**-Тэгвэл Таны цаашдын улс төрийн бодлого чиглэл чухам ямар асуудлууд дээр илүү төвлөрөх бол.**

-Эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн оролцоо их багаас үл хамааран чухал асуудал юм. Би хоёр асуудлыг чухалчилдаг. Нэгдүгээрт, бидний нийгэмд шууд хамаардаг авлигатай тэмцэх асуудал юм. Одоогийн түвшинд авлигатай тэмцэхгүй аваас бид өвдөг сөхөрнө. Одоогоос хорин жилийн өмнө миний, чиний улс өөрчлөлтийн догшин шуурганд

өртсөн билээ. Өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөн. Улсад харьяалагддаг байсан бүхэн нийгмийн хэсэг бүлэгт очсон. Нэг шөнийн дотор зарим хүн яагаад хахаж цацатлаа баяжиж нөгөө хэсэг нь ядуу хэвээр үлдэх болов? Бидний адилаар танай улсын нийт хүн амын 30 хувь нь нэн ядууд багтаж байна. Яагаад ийм болчихсон юм бэ? гэж асууя. Бид бүх зүйлийг хүн бүрт эн тэнцүү хуваадаг эрх тэгш нийгэмд амьдардаг байсан шүү дээ. Иймээс ч би хүн болгон авлигыг нугачин дарах маш чухал зэвсэг гэдэгт итгэдэг.

Улс төр өөрийн эрх мэдлийн хүрээнд авлигатай тэмцэхэд бүх аргыг хэрэглэх нь зүйтэй. Түүнчлэн бүх гэр бүл тэмцэх хэрэгтэй. Гэр бүл бүр төрийн төлөө ажиллаж байгаад нэг шөнийн дотор маш их эд хөрөнгөтэй болно гэдэг хэр боломжтой вэ гэдгийг өөрсдөөсөө асууж үзэх хэрэгтэй юм. Энэ нийгэмд хүн бүр төрийн албан хаагчийн цалин хэд вэ гэдгийг мэднэ. Парламентад байгаа хүмүүс эд баялгаа хамгаалах гэж ажилладаг. Үүнийг харин ард түмэн ажаад сууж байдаг.

Бидний хувьд Засгийн газрын өмчит болон хувь нийлүүлсэн компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн гишүүнчлэлийг бий болгох нь чухал юм. Яагаад захирлуудын зөвлөлд эмэгтэйчүүд байдаггүй юм бэ? Яагаад тэд энэ бүгдээс хоцрох ёстой гэж? Бид энэ бүхний төлөө тэмцэх ёстой. ТУЗ-ийн уулзалт мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дээр суурилсан нээлттэй ил тод байх ёстой. Одоог хүртэл төлөөлөн удирдах зөвлөлийн мэдэлд нь маш их мөнгө эргэлдэж байдаг харилцаа холбоо, төмөр зам гэх мэт салбар олон байна. Ард иргэдийнхээ төлөө тэд зохих ёсны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна уу, үгүй юу гэдгийг бид мэдэж байх ёстой.

**-2010 онд Киргизстанд бослого гарч засгийн эрхийг гартаа авахад тань дэлхий нийт таныг эмэгтэй хүн гэдэг утгаар өөр өөрөөр хүлээж авсан. Та өөрийгөө Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэр их зүйл хийсэн гэж боддог вэ?**

-Бүх өөрчлөлт, шинэчлэлийн тэргүүн шугаманд эмэгтэйчүүд байсаар ирсэн. Манай улсын хувьд лав өмнө нь Засгийн газрын эмэгтэй үүрэг гүйцэтгэгчтэй байгаагүй. Харин одоо бидэнд байна. Олон эмэгтэй хотын дарга, сайд болоосой гэж хүсэж байгаа. Манай улсад эмэгтэй нэг дэд сайд, хоёр дэд парламентийн дарга мөн цөөн тооны хорооны дарга бий. Харин Парламентийн 23 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг.

**-Манай улсын Парламентад суудаг эмэгтэй гишүүдийн тоо энэ удаагийн сонгуулиар гурваас ес болсон. Үүнийг Та хэрхэн үнэлэх вэ?**

-Энэ тоо гурав дахин өссөнд би хувиасаа халуун баяр хүргэмээр байна. Гэсэн ч үүний хажуугаар дүрэм, журам, зохицуулалтын хувьд тийм ч дэвшилттэй харагдахгүй байна. Бид пропорциональ системээр сонгуулиа явуулдаг. Намын жагсаалтаар нэр дэвшигч дөрвөн хүн тутмын нэг нь эмэгтэй нэр дэвшигч байдаг. Жагсаалтад орсон л бол түүнийг өөрчлөх, солих эрх хэнд ч байхгүй. Танай улс ч ийм төрлийн зохицуулалттай байх нь зүйтэй болов уу гэж бодож байна. ■

2012 ОНЫ 10 САР.

# Оюутолгой бол шалгалт



*Жан-Себастьен Жак "Рио Тинто" компанийн Зэсийн группийн гүйцэтгэх ерөнхий захирлаар 2013 оны хоёрдугаар сараас эхлэн ажиллаж байгаа. 2011 онд "Рио Тинто"-гийн олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчөөр ажиллаж тус компанийн Өмнөд Африк, Австрали, Америк, Индониз дэх уурхайнуудын удирдлагын багийг чиглүүлэн ажиллаж байсан. Тэрбээр уул уурхайн, тэр дундаа хөнгөн цагаан, боксит, төмөрлөгийн салбарт стратеги төлөвлөлт, үйл ажиллагаа удирдлагын чиглэлээр 15 жилийн туршлага хуримтлуулсан. "Рио Тинто"-д орохын өмнө Тата Стил группын Удирдлагын багийн гишүүн, Стратеги төлөвлөлтийн багийг удирдан ажиллаж байв.*

*"Mongolian Econoty" сэтгүүлийн сурвалжлах баг өнгөрсөн долдугаар сард Англи улсад хийсэн сурвалжлагынхаа үеэр "Рио Тинто" компаниар зочилж, түүнтэй ярилцсан юм. Лондонд байрлах "Рио Тинто"-гийн төв оффист ороход үүдний ханан дээрх видеогоор манай Өмнийн говийн зураг, Оюутолгойн барилга байгууламж, ажилтнуудын тухай мэдээлэл гарч байгаа нь нүдэнд тусав. Өөр нэг зүйл нь Монголын алт, зэсийн дээжийн билгэдэл болсон Лондонгийн Олимпийн медалийг шилэн хоргонд хийж үүдэндээ залжээ. Монголын үнэр шингэсэн эдгээр зүйлсийн дэргэд зураг авахуулах зуур нүдэндээ инээмсэглэл тодруулсан монгол эмэгтэй ирж, бидэнтэй мэндчиллээ. Тэрбээр тус компанид корпарацийн харилцаа холбоо, брэнд хариуцсан мэргэжилтнээр ажилладаг ажээ. Ингээд Рио Тинто дахь монгол мэргэжилтэн Б.Энх-Ундрамын хамт Жан-Себастьен Жактай "Рио Тинто"-гийн хурлын танхимд ярилцсан юм.*

**-Юуны түрүүнд Монголын сэтгүүлчдийг хүлээн авч уулзаж байгаад талархлаа илэрхийлье. Та манай оронд хэдэнтээ очсон гэсэн. Хамгийн сүүлд хэзээ Монголыг зорьсон бэ?**

-Хамгийн сүүлд зэсийн баяжмалыг экспортлох ёслолын арга хэмжээний үеэр Монголд очсон. Бүх талын хувьд сэтгэл ихэд хөдөлсөн сайхан мөч байлаа. Нөгөө талаас Монголын Засгийн газрын төлөөлөл болсон зочид үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн. Тэдний хувьд ч маш чухал ач холбогдол бүхий үйл явдал байсан болов уу. Төслийн багийнханд зургаан тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт, 12 жилийн уйгагүй хөдөлмөрийнхөө үр шимийг үзэж эхлэх нь ямар сэтгэл хөдлөм байсан нь илт. Төсөл дардан замаар өдий хүрээгүй. Багагүй саад бартаатай тулсан учраас хүмүүс хийж бүтээсэн зүйлсээрээ бахархаж байлаа.

**-Одоогийн нөхцөл байдлыг дүгнээд харвал Монголын эдийн засаг урт хугацаанд ямар дүр төрхтэй харагдаж байна вэ?**

-Ашигт малтмалын арвин их нөөцтэй Монгол орны эдийн засгийн ирээдүйг сайнаар төсөөлж байна. Уурхайг асар их бүтээн байгуулалтын үндсэн дээр барьж байгуулдаг. Бид уурхайд ажиллаж буй нийт ажиллах хүчний 90 хувь нь монголчуудаас бүрдэнэ гэсэн хүлээсэн амлалтдаа хүрэхээр ажиллаж байна. Ер нь цаашдаа бид Монгол хэмээх агуулгыг нэмэгдүүлэх болно. Компани хүчтэй, чадварлаг ханган нийлүүлэгчидтэй байхыг хүсч байгаа. Мөн Монголын Засгийн газартай цахилгаан станц, сайн дэд бүтэц хэрэгтэй гэсэн асуудлууд дээр санал нэгдсэн. Манай зүгээс Оюутолгой Монголын эдийн засагт урт удаан хугацаанд шууд болоод шууд бус байдлаар үр өгөөжийг үзүүлнэ гэдэгт илгэлтэй байдаг.

**-Энэ жил "Рио Тинто" үүсэн байгуулагдсаны 140 жилийн ой тохиож буй. Танай компанийг чухам ямар хүчин зүйлс дэлхийн хэмжээнд авчирдаг вэ?**

-Манай компани 140 гаруй жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэ хугацаанд асар их туршлага хуримтлуулжээ. Бид ашигт малтмалын нөөцийг илрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг осол аюулгүйгээр, үр ашгийг нь нэмэгдүүлэн ажилладаг. Энэ нь тийм ч хялбар зүйл биш. Мөн манай группын баримталдаг зарчим тодорхой. Энэхүү зарчмыг мөрдөж ажилласнаар урт удаан хугацаанд тууштай үйл ажиллагаа явуулж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг.

**-Компанийг чиглүүлэгч гол бодлого, зорилго юу вэ?**

-Бүх л компанийн адилаар хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг.Бусдаас ялгарах манай онцлог гэвэл бид салбартаа хамгийн үнэ цэнэтэйд тооцогдох томоохон хэмжээний, зардлын хувьд өрсөлдөхүйц, урт хугацаанд ашиглагдах, өсөн нэмэгдэх нөөц бололцоо бүхий төслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нь манай компанийн стратегийн салшгүй нэг хэсэг. Тиймээс аливаа хөрөнгө оруулалтын чанарт тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг.

**-Аюулгүй ажиллагаа уул уурхайн компаниудын хувьд хамгийн чухал. "Рио Тинто"-гийн аюулгүйн зарчмууд гэж чухам ямар байдаг вэ?**

-"Рио Тинто" АНУ, Австрали, Монгол гээд дэлхийн аль ч оронд үйл ажиллагаа явуулсан аюулгүй ажиллагааны нэг л стандартыг дагаж мөрддөг. Бид аюулгүй ажиллагааг хангахын тулд дэлхийн өнцөг булан бүрээс мэргэжилтнүүдийг нэгтгэдэг. Оюутолгойн хувьд монгол мэргэжилтнүүдэд бодит туршлага хуримтлуулах үүднээс тэднийг Англи, Америк болон Австрали дахь Рио Тинтогийн уурхайнуудад ажиллуулж байна. Ингэснээр тэд эргээд эх оронддоо очихдоо Рио Тинтогийн аюулгүй ажиллагааны арга барилыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой болдог.

**-Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагаа тодорхой хэмжээний туршлага шаардана. Рио Тинто энэ тал дээр хэрхэн анхаарч байна вэ?**

-Бид шинээр сургууль төгсөгчдийн хөтөлбөрт цөөнгүй монгол залуучуудыг хамруулан туршлага хуримтлуулах зорилгоор Рио Тинтогийн томоохон уурхайнуудад ажиллуулж байгаа талаар ярьсан. Далд уурхайн үйл ажиллагааг таван жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд одоогоор хоёр босоо амыг барьж байгуулаад байна. Оюутолгойд мөн техник, мэргэжлийн сургалтын төвийг нээсэн. Энэхүү сургалтын төвийн симулятор машиныг ашиглан суралцагчид далд уурхайн орчинд ажиллаж байгаа юм шиг туршлага хуримтлуулах боломжтой. Ингэснээр ажилтнууддаа далд уурхайд ажиллахаас өмнө зохих технологиуд дээр аюулгүй орчинд дадлагажих боломжийг нь бэлтгэж өгч байна.

**-Цөөн хүн амтай Монголд төдийгүй дэлхийд хүний нөөцийн асуудал том сорилт болж буй. Энэ бартааг даван туулах танай арга барил юу вэ?**

-Хүний нөөц, түүний хөгжих чадавхи бол хамгийн том сорилт. Тиймээс бид үүнд анхаарлаа хандуулж багагүй хөрөнгө оруулалт хийдэг. Оюутолгойд ажилладаг гаднынхан нэг л зорилгын төлөө тэнд байгаа. Тэд монгол боловсон хүчинд чадвар, туршлагыг зааж сургаж, өвлүүлж үлдээхээр ажиллаж байна. Гадны мэргэжилтэн бүр монгол ажилтныг дэргэдээ дагалдуулан сургаж, ажиллуулах зарчмаар туршлагыг шилжүүлж байна. Ингэснээр хэсэг хугацааны дараа монгол ажиллах хүч төслийг бие даан үргэлжлүүлэх боломжтой болно. Энэхүү зарчмыг Оюутолгой уурхайн бүх хэлтэст баримтлан ажиллаж байна.

**-Дэлхийн зах зээл дээр металлын үнэ хэлбэлзэлтэй байгаа энэ үед танай компанийн эрсдэлийн удирдлага хэрхэн хариу үзүүлэх бол?**

-Уул уурхайн салбарт өөрчлөлт мэдрэгдэж тус салбар нь сорилтот цаг үетэй тулгарч байна. Бүгд үндсэн хөрөнгөө эргэн тооцоолох, зардлыг дахин нарийн авч үзэх шаардлагатай тулгарч байна. Энэ бол том сорилт мөн бас шинэ боломж. Гэвч үүнийг зөвхөн зардал хөрөнгийн тухай асуудал гэж ойлгож болохгүй. Хэдэн тэрбум ам.доллар зарцуулан төсөл хэрэгжүүлж байхад хамгийн сайн баг ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал. Тиймээс энэ нь зөвхөн хөрөнгө зардлын бус боловсон хүчний тухай асуудал мөн. Төсөл хэрэгжүүлэх үед зардлаас гадна тухайн төслийн үргэлжлэх хугацааг харгалзан үздэг. Үнэ ханш гэдэг байнга өөрчлөгдөж байдаг, түүнийг тогтоох боломжгүй. Энэ тохиолдолд бид хоёр хүчин зүйлсийг харгалзаж үздэг. Үүнд урт хугацаанд алс хэтээ харсан

шийдвэрүүдийг гаргах, мөн аль ч тохиолдолд хувьцаа эзэмшигчиддээ хөрөнгө оруулалтаас хүртэх үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийг чухалчилдаг.

**-Иймэрхүү нөхцөлд компани зардлаа танах нь хямралын эсрэг авах эцсийн арга хэмжээ мөн үү?**

-Эцсийнх гэж хэлэх нь зохистой эсэхт итгэлтэй бус байна. Юм бүхнийг бид олон талаас нь авч үздэг. Энэ бол асуудлыг ямар дараалалтай авч хэлэлцэх вэ гэдэгт оршдог болов уу. Зардлын хязаарлалт нь өргөн цар хүрээтэй багц арга хэмжээнүүдийн зөвхөн нэг хэсэг нь.

**-Рио Тинтогийн хувьд хариуцлагатай уул уурхай гэж юу вэ?**

-Хамгийн чухал нь үйл ажиллагаа явуулсан газартаа эерэг нөлөөг үлдээх ёстой. Хариуцлагатай уул уурхай нь усны хэрэглээ, байгаль орчны удирдлага, орон нутгийн хөгжил гээд өргөн цар хүрээний асуудлуудыг хамардаг. Газар, газрын онцлогоос шалтгаалан хэрэгжүүлэх арга барил нь өөр хоорондоо ялгаатай байж болно. Гэхдээ гол нь тухайн орон нутагт эерэг нөлөө үзүүлэх ёстой гэдэгтээ итгэлтэй байх хэрэгтэй.

**-Дэлхийд тэргүүлсэн компани өнөөдрийн түвшинд улс орнуудад газар авч эхлээд байгаа "Resource Nationalism" буюу иргэдийн баялгаа өмчлөх гэсэн үндсэрхэг үзэлд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байна вэ?**

-Энэ бол зөвхөн Рио Тинтод бус бусад уул уурхайн компанид ч хамааралтай асуудал. Ерөнхийд нь авч үзвэл, хөрөнгө мөнгө, боловсон хүчин бол хязгаарлагдмал. Тиймээс хамгийн боломжтой гэсэн төсөл, газар нутагт хөрөнгө мөнгийг зарцуулж боловсон хүчнийг ажиллуулдаг. Үүнийг мөн хүмүүс сайн ойлгох хэрэгтэй. Компани маань дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тогтвортой орчин, тууштай байдал маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү орчин хязгаарлагдмал тохиолдолд хөрөнгө оруулалт илүү тогтвортой орчин руу чиглэдэг. Хөрөнгө оруулагчдыг татах таатай орчин бол тогтвортой байдал. Зөвхөн уул уурхайн салбарын асуудал бус бусад бүхий л салбарт хамааралтай.

**-Рио Тинто компани хариуцлагаа биелүүлэх тал дээр хэрхэн ажилладаг вэ?**

-Рио Тинтогийн ажилтнуудын мөрдөж ажиллах бүхий л стандарт Монголд хэрэгжиж байна. Үндсэн нэг л төрлийн стандарт бий. Америкт, Монголд дэлхийн аль ч оронд үйл ажиллагаа явуулсан энэхүү стандарт жигд мөрдөгддөг. Бид ажиллагсдаа энэхүү стандартыг дагаж мөрдөхийг уриалдаг. Мөн бид улс төрийн үйл ажиллагаанаас ямагт ангид байх байр суурийг баримталдаг. Бүхий л үйл ажиллагаа тогтсон дүрэм журамтай, тэдгээрийг байнга хянан шалгаж байдаг. Хянах шалгалтыг дотоод журмын дагуу, заримыг нь гуравдагч байгууллагын оролцоотой явуулж дэлхий даяарх үйл ажиллагаа дүрэм журмын дагуу тогтвортой явж байгааг ажиглаж ажилладаг юм.

**-Монголын хөгжил дэвшилд Рио Тинто ямар хувь нэмэр оруулна гэж та боддог вэ?**

-Олон улсын санхүүгийн корпорациас гаргасан статистик мэдээллүүдийг харвал Оюутолгой Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэлээд хэсгийг бүрдүүлнэ гэсэн мэдээллийг харж болно. Миний хувьд Оюутолгой Монголын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Оюутолгой амжилтад хүрэх нь чухал ач холбогдолтой. Оюутолгойн үйл ажиллагааг олон хүн анхааралтай харж байна. Нэг



ёсондоо Оюутолгой шалгалт мэт харагдаж байна. Хэрэв Оюутолгой шалгалтыг давж амжилт болж чадвал Монгол Улс цаашид илүү их хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдүүлнэ шүү дээ.

**-Монголын хууль эрхзүй, бизнесийн орчинд ямар давуу болон сул тал байна вэ?**

-Бид монгол ажиллах хүчнийг маш чадварлаг, сурах хүсэл эрмэлзэл өндөртэй гэж үздэг. Оюутолгойн амжилтын төлөө тэд шаргуу хөдөлмөрлөж байгаа нь илт харагддаг.

**-Монгол хүн анх удаа дэлхийн хэмжээний том компанийн удирдлагын багт ажиллаж байна. Б.Болдын Рио Тинтогийн Зэсийн группт ажиллаж буйг монголчууд олон талаас харж буй. Монгол хүнийг тус албан тушаалд ажиллуулсны давуу тал нь юу байх вэ?**

-Сэтгэл маш өндөр байгаа. Б.Болд миний өмнөх ажлыг хүлээж авсан. Нэгдүгээрт, Б.Болд өөрийн авьяас чадвараараа энэ түвшинд хүрсэн. Хоёрдугаарт, дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахад шийдвэр гаргах түвшинд олон үндэстний бүрэлдэхүүн байх нь чухал. Тухайлбал, Өмнөд Африкт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол тухайн бүс нутгаас боловсон хүчинтэй байх нь чухал. Хамгийн гол учир нь тухайн газар нутагт зуу зуун жилээр үйл ажиллагаа явуулахад тухайн үндэстний соёл заншлыг ойлгодог байх нь нэн ач холбогдолтой. Соёлын зөрүүг арилгаж, сорилтыг давах шалгарсан арга бол тухайн үндэстний улсуудтай хамтарч ажиллах. Бид Монголын соёлыг ойлгохыг эрмэлзэж байгаагийн адил монголчууд ч Рио Тинтогийн соёлоос суралцаасай гэж хүсч байна. ■

2013. 10 САР.



Гэрэл зургийг Б.Бямба-Очир




# Салхи хагалагчдаас итгэл эхэлнэ

*Бид Лондонд ажиллах үеэрээ Лондонгийн хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн газрын орлогч дарга Жон Эдвардстай ярилцаж амжсан юм. Тэрбээр ОХУ болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн орнуудад тус биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлыг хариуцдаг. Жон Эдвардс ОХУ, Казакстан, Украйн болон Монгол Улс руу ажлын журмаар тогтмол аялдаг байна. Тэрбээр Колумбийн их сургуульд суралцаж, Орос судлалын бакалаврын зэрэг, мөн бизнес, хууль хосолсон чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан бөгөөд 2003 оны наймдугаар сараас хойш ЛХБ-д ажиллаж байгаа.*

**-Та Монголд олон удаа ирж байсан. Монголын санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлийн талаар Таны бодлыг сонирхъё?**

-Монголын зах зээлийг их эрчтэй гэж боддог. Залуу зах зээл ч, ялангуяа Монголоос төрөн гарч буй шинэ уул уурхайн компаниудад боломж их байна. Гаднынхны сонирхол их байгаа нь дотоодын хүчтэй хүсэл эрмэлзлэлтэй нийцэж, хөгжлийн шинэ түүхүүдийг бичих үндэс болж байна. Энэ нь зөвхөн уул уурхайгаар хязгаарлагдахгүй бөгөөд аялал жуулчлал зэрэг туслах үйлчилгээ мөн багтана. Тиймээс Монгол Улс олон түвшинд анхаарал татаж буй. Хөрөнгийн зах зээлийн хувьд энэ бүгд онцгой боломж. Зах зээлээ бий болгохын тулд нэн тэргүүнд хийж бүтээсэн зүйлтэй, тодорхой туршлагатай байх шаардлагатай. Хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан ямар нэг зүйлтэй байх хэрэгтэй юм.

**-Түншлэлийн хүрээнд Монголын хөрөнгийн зах зээлтэй хуваалцах хамгийн чухал туршлагыг Та юу гэж бодож байна вэ?**

-Бидний хуваалцаж чадах хамгийн чухал хүч бол өдийг хүртэл бүрдүүлж чадсан хүрээлэл, сүлжээ гэж боддог. Бид хөрөнгө оруулагчдын өргөн сүлжээ, мэргэжлийн зөвлөхүүдээ Монголын зах зээлд татан оролцуулах бүрэн чадамжтай. Мөн Монголын

компаниудыг энд авчирч хөрөнгө оруулагч, мэргэжилтнүүдтэйгээ уулзуулж байсан удаатай. Энэ бол манай хоёр биржийн хамтын ажиллагаа. Монголын зах зээлд илүү олон хөрөнгө оруулагч татах нь түншлэлийн нэг хэсэг. Бид давхар бүртгэлийн боломжийг ихээхэн сонирхож байгаа. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан Монголын компаниуд Лондонд Дэлхийн үнэт цаасны хадгалалтын бичиг (GDR-global depository receipt)-тэй болох боломжтой. Мөн Монголын хөрөнгийн бирж өөрийн бүртгэлийн жагсаалтаа хадгалж авч үлдэхэд тусална.

**-Лондонгийн хөрөнгийн биржийг дэлхийн шилдгүүдийн нэг гэлцдэг. Цөөн үгээр амжилтын хүчин зүйлсээ тодорхойлохгүй юу?**

-ЛХБ үйлчилгээгээ сайжруулах шинэ арга замыг байнга эрэлхийлж, улмаар арилжаанд оролцогчдод хамгийн сайн үйлчилгээ хүргэхэд бэлэн байдагтай холбоотой. Тэд бол компаниуд, хөрөнгө оруулагчид, зуучлагчид юм. Олон оролцогч тал байдаг учир биржийн ажил маш хэцүү. Энэ бол бидний МХБ-тэй хамтран ажиллаж, ойлгохыг хичээж буй нэг зүйл. Өргөн хүрээний оролцогч талуудтай байх нь хүндрэлтэй. Хоорондоо харилцан адилгүй бүлгүүдийн санаанд тааруулна гэдэг амар биш. Зарим тохиолдолд компаниудын дунд хэвийн үйлчилдэг зүйлс хөрөнгө оруулагчдад таарахгүй байх нь элбэг тохиох тул алтан дунджийг барих нь оновчтой. Энэ бол ЛХБ-ийн үнэхээр сайн хийж чадсан зүйл.

**-Лондонгийн хөрөнгийн зах зээл дэлхий дахинд хаашаа замнаж байгаа вэ?**

-Өргөн хүрээг хамрах асуулт байна. Тэр дундаа ЛХБ-ийн байр сууриас харвал манай бирж дэлхийн эдийн засгийн хөгжилд амин чухал үүргийг гүйцэтгэсэн хэвээр байна гэдэгт бид итгэдэг. Тиймээс ч Монгол Улсын Засгийн газраас олон улсын түнш татах зорилгоор МХБ-ийг орчин үеийн бирж болгон өөрчлөхийг дэмжсэн шийдвэр гаргасан нь үнэхээр алсыг харсан алхам болсон. Үүний тулд улсынхаа нөөц, баялгийг хөшүүрэгдэж, өсөлтөө хурдасгах нь чухал юм. Аль ч оронд шинэ бизнесийн өсөлтөд дэмжлэг болох хөрөнгө оруулалтыг татахад зах зээл болон хөрөнгийн бирж чухал үүрэг гүйцэтгэж, тэдгээрийг хурдасгуур болгон ашигладгийг харж болно. Энэ нь аливаа улс орны эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой. Олон зүйл өөрчлөгдөж болох ч хөрөнгийн бирж үлдэнэ.

**-Төрийн өмчит компаниудыг хувьчлах үүднээс МХБ-ийг байгуулсан. Монгол Улс өдгөө арай өөрөөр өсч, хөгжихийг чармайж буй. Харин энэ зах зээлд монголчуудыг хэрхэн оролцуулах вэ. Энэ тохиолдолд түншлэл юу хийж чадах вэ?**

-Түншлэлийн нэг хэсэг бол боловсрол, тэр дундаа хувьцааны зах зээл дээрх олон нийтэд зориулсан боловсрол. Энэ бол хоёр биржийн хамтран ажиллаж буй талбар юм. Энэ мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэх талаар бид уулзалт, хэлэлцээр хийж байгаа. Үүнд брокеруудын гүйцэтгэх үүрэг маш чухал. Учир нь тэд зуучлагчид. Ихэнх тохиолдолд олон хөрөнгө оруулагчтай харилцдаг нь тэд. Бид брокеруудын боловсролд зориулан олон зүйл хийдэг бөгөөд Монголын брокеруудад зориулан боловсрол, маркетинг, олон нийтэд таниулан сурталчлах зэргийг багтаасан арга хэмжээг Лондонд зохион байгуулсан. Үүний зэрэгцээ бидний зүгээс брокеруудад тусгайлан анхаарч өөрсдийн байнгын үйлчлүүлэгчидтэй, үр дүнтэй ажиллахад нь шаардлагатай бүхэн байгаа эсэхт анхаардаг.

**-Монголын санхүүгийн зах зээлийг харвал хөрөнгийн зах зээл болон банкны салбарын тэнцвэрт байдал сайн биш. Таны бодлоор хөрөнгийн зах зээлийг хэрхэн хүчтэй хөшүүргэдэж болох вэ?**

-Тохиромжтой компаниудтай байх асуудал дахин сөхөгдөнө. Ийм компаниудтай болохын тулд үйл ажиллагаа явуулах тохиромжтой газар болон олон нийтийн зах зээл гэдэг итгэл үнэмшлийг төрүүлэх хэрэгтэй. Томоохон болон олон улсын тоглогчдыг урдаа барьж эхэлбэл бусад компани араас нь дагах нөхцөл бүрдэнэ. Энэ бол аажмаар үйл хэрэг болох явц. Амжилттай явж ирсэн компаниудын түүхийг сөхөн харж, тэднийг татан оролцуулахад чиглэж ажиллах нь зүйтэй. Тэд орж ирснээр, бусад нь ч дагана. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн шатыг түргэсгэх арга байж болно.

**-Ашигт малтмалын тухай хуулийн төслийн талаар олон хэлэлцүүлэг өрнөсөн. Монголын стратегийн ордууд Монголын хөрөнгийн биржээр заавал дамжих ёстой гэсэн заалтыг аваад хаячихсан. Тус заалт байсан эсвэл байгаагүйн нөлөө юу байх вэ?**

-Давхар бүртгэл хийж болох хосолмол зах зээлтэй байх нь, тэр дундаа уул уурхайн салбарт ихээхэн түлхэц болдогийг миний ажиллаж байсан ОХУ-ын зах зээлийн амжилт гэрчилнэ. Бид дотоодын хөрөнгө оруулагчдыг “Дэлхийн хадгалалтын бичиг” (GDR)-тэй болгосноор үнийн өөрчлөлтийг брокеруудаар хөнгөвчлүүлэх боломжтой болох юм. Ингэснээр хөрвөх чадвар бий болно. Ялангуяа зарим томоохон компанийн хувьд энэ нь маш хэрэгтэй. Харин жижиг компаниудад зориулан хөрөнгө оруулагчдыг татах түншлэлийн ажлаа улам эрчимжүүлэх нь бидний хувьд чухал. Ингэснээр тухайн компани орон нутгийн зах зээл дээр хэрэгцээт хөрөнгө, мөнгөө өсгөх боломжтой болно. Энэ үйл явцыг хөнгөвчлөхийн тулд дотоодын хөрөнгө бий болгох шаардлагатай. Харин дотоодын хөрөнгийн биржийн асуудлаар дан ганц гаднын хөрөнгө оруулагчдад найдаж болохгүй. Дотоодын хөрөнгө оруулагчдад тулгуурлан тухайн зах зээл улам хүчирхэгжиж байх учиртай. Үр нөлөө нь ямар байх талаас баруун руу чиглэсэн томоохон урсгал бий болно гэж би бодохгүй байна. Компаниуд хөрөнгөө өсгөхөөр хаашаа явж байгаагаа маш нухацтай бодож, болгоомжтой хандах ёстой. Дотоодын хөрөнгийн бирж бий болгохдоо зайлшгүй эрэлт, хэрэгцээнд тулгуурлах ёстой болохоос биш хиймлээр хийж болохгүй. Компаниуд дараагийн шатанд гарахын тулд хөрөнгөө өсгөх шаардлагад тулдаг. Тэд хөрөнгөө хаана өсгөж болохыг чадварлаг зах зээл зааж, чиглүүлж өгдөг. Бидний ажил бол Монголд болон МХБ-д дээрх хөрөнгийг хангалттай босгож болох тогтолцоог бүрдүүлэх юм.

**-Монголын хөрөнгийн зах зээлд томоохон хөрөнгө оруулагчид л хэрэгтэй байгаа. Тэднийг татахын тулд бид юу хийх вэ?**

-Энэ тал дээр олон асуудал байгаа. Зарим нь макро түвшний асуудал бол зарим нь тохиромжтой зах зээлийн гарц нээгдэхийг хүлээж буй. Үүний зэрэгцээ хөрөнгө болон төөврийн үйлчилгээ зэрэг салбар Монголд хурдацтай хөгжиж

байна. Уул уурхайн салбар хүчээ авч, тасралтгүй өсч эхлэх үед Монголын компаниуд өөрсдөө зах зээлээ туршин гарч ирэх хэрэгтэй. Томоохон хөрөнгө оруулагчидтай болохын тулд томоохон компаниуд зах зээлд орж ирэхийг хүлээх шаардлагатай байна. Эцсийн эцэст, хөрөнгө оруулагчид арилжих үнэт цаасуудыг л хүсдэг. Дутагдаад байгаа нь энэ. Компаниуд шинээр гарч ирж, улмаар зах зээлд нэвтрэх үед л бид томоохон хөрөнгө оруулагчид орж ирэхийг харна.

**-Төрийн өмчит зарим компанийг одоо хувьчилж эхлэх нь зүйтэй гэж Та бодож байна уу ?**

-Хувьчлал бол тухайн нөхцөл байдал бүрээр нь авч үздэг зүйл. Тодорхой салбар, компанид ойлгомжтой асуудал. Энэ нь мөн хувьчлалыг хэрхэн хийж, хэрхэн компанийн шилжилтийг хийх гэж байгаа тухай юм. Хэрэв хувьчлалыг олон нийтийн зах зээл дээр хийвэл компанийн шинэ хэлбэр юу байхав. Хувьчлал хийх тохиромжтой хувилбарыг гаргахын тулд холбогдох мэргэжилтэн, зөвлөхүүдийг оролцуулах шаардлагатай болдог тул хүндхэн ажил байдаг. Энэ нь тодорхой нөхцөл байдалд үйлчилдэг. Азаар Монголын хувьд бусад зах зээл, тэр дундаа хөрш орнуудынхаа зах зээлээс жишээ авч хувьчлалыг хэрхэн хийснийг үлгэрлэх боломж байна. Хувьчлалыг тохиолдол тус бүрээр нь тусгайлан авч үзэх шаардлагатай. Ерөнхийдөө энэ нь бизнесийн үйл ажиллагааг түлхэх, шинэ оролцогч талууд, үр ашгийг авчрах талаасаа үр дүнтэй үйл явц.

-Монголын компаниуд хөрөнгийн биржээр IPO гаргах төдийлэн сонирхолгүй болоод байгаа. Тэгвэл тэдний анхаарлыг хэрхэн татах вэ?

-Тэдгээр хөрөнгө оруулалтын компанийг татах нь шургуу ажиллахтай л холбоотой. Тодорхой бөгөөд ойлгомжтой дүрэм, журамтай байх хэрэгтэй гэсэн үг. Үүний тулд бидэнд "салхи хагалагчид" хэрэгтэй байна. Гэвч тэднийг оруулж ирэхийн тулд итгэл хэрэгтэй. Бусдаас түрүүлж итгэл хүлээлгэх компани байж л таарна. Тэдний араас л явах хэрэгтэй. МХБ боломжийг сайн эрэлхийлэх ёстой. Учир нь Монголын компаниудыг татах, тэдгээрийн хөрөнгийг өсгөх энэ ажлыг эхлүүлж чадах брокерууд тэнд ажиллаж байгаа бөгөөд тэдэнд жагсаалт үүсгэх ихээхэн боломж байдаг. Үүнийг эхлүүлж чадвал бизнесийн шинэ эгнээтэй болно. Та нарын хувьд гадаад валютад толгойгоо бүрэн мэдүүлчихсэн улс биш. Бизнесийн тусдаа хэсгүүдтэй шүү дээ. Энэ нь тайлан тэнцэлд ч сайнаар нөлөөлдөг. Эхлээд хийх ёстой хамгийн чухал зүйл бол итгэл төрүүлэх.

**-Засгийн газрын зүгээс хөрөнгийн зах зээлд үзүүлэх ямар дэмжлэг байж болох вэ?**

-Үүнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээлийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг асуулт гарч ирнэ. Тэтгэврийн сангийн шинэчлэл, дотоодын хөрөнгийг бий болгох зэрэг арга хэмжээ бий. Дотоодын урсгалыг дэмжихэд дээрхүүд чухал ач холбогдолтой. Хэдийгээр бүх хариулт надад байхгүй ч дээрх сонголтууд анхаарч авч үзэх ёстой аажлууд. Дүрэм журмаа нэн тэргүүнд харах хэрэгтэй. Бидний зүгээс гаднын хөрөнгө оруулагчдыг "мөшгиж" чадах бол Монголын тал дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжсэн ажил хийх нь чухал. УИХ-аар хэлэлцүүлбэл зохих дараагийн асуудал энэ ч байж болох юм.

**-Хөгжиж буй орнууд хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхэд харилцан адилгүй хугацаа зарцуулдаг. Харин Монголын хувьд хэр хугацааг зарцуулах бол?**

-Бусад зах зээлийг харахад тухайлбал, ОХУ-ын эдийн засаг ерээд онд богино хугацаанд амжилттай хөгжсөн түүхтэй. Тухайн үед "Renaissance Capital" тэргүүтэй брокеруудын үйл ажиллагаа дөнгөж эхэлж байв. Тэд байгууллага болон дотоодын эрэлт, хэрэгцээнд хариулах, шийдвэрлэх чадвартаа тулгуурлан хурдацтай хөгжиж чадсан юм. Тус улсын хувьд томоохон компаниуд зах зээлд орж ирсэн нь ихээхэн дэмжсэн байдаг. Монголын хувьд төстэй боломж бий. Тэгэхээр энэ нь ердөө зах зээлийн хувьд цаг хугацааны асуудал бөгөөд эдгээр томоохон хөрөнгийн боломж ороод ирвэл цаашид гаднын хөрөнгө оруулагч байгууллагууд дагах нь тодорхой. Мөн дотоодын хөрөнгө оруулагчид зах зээлд оролцож эхлэх бөгөөд брокерууд үүнийг ойлгон мэдэрч, тухайн эрэлтийг хариулах чадвар сууна. Энэхүү үйл явц эхлэх үед одоогийн дотоодын брокеруудыг улам бэхжүүлнэ. Олон улсын брокерууд ч судалгаа явуулах болно. ■

2013 ОНЫ 10 САР.



# ХӨГЖИЛ

*Бид  сүүлийн жилүүдэд хөгжил ярих дуртай болсон. Эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийг алмайруулж ч үзсэн Монгол Улс өнөөдөр хөгжиж байна уу, хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн хаана нь явна вэ гэдэг хэн бүхний анхаарал татсан асуудал. Юуг хөгжил гэх вэ?  гэдэг талаар нэгдсэн ойлголт  ч одоохондоо бидэнд  алга.  Уул уурхайг хөгжил гэх үү, бондын мөнгөөр дэд бүтцээ хөгжүүлсэнийг үү, эсвэл эдийн засгийн өсөлтийг  үү,  монгол ахуй соёл, сэтгэлгээг үү. Энд олж мэдэхийн хэрэгцээ их.*





Гэрэл зургийг Б.Бямба-Очир



*Ерөнхий сайд С.Батболдтой эдийн засгийн асуудлуудаар ярилцлаа. Манай "Mongolian Economy" сэтгүүлийн хувьд ч үүсэн байгуулагдсаны нэг жилийн ойгоороо Засгийн газрын тэргүүнтэй ярилцаж байгаадаа таатай байна.*

# С.Батболд: Нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой засаглалтай оронд хөгжил ирдэг

**-"Ашигт малтмал зөвхөн хөрсөн дээр мөрөө үлдээдэг биш, хүний хөгжилд мөрөө үлдээх ёстой" гэж түрүү жилийн Эдийн засгийн форумын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч хэлж байсан. Чуулганы үеэр монгол хүний ур чадвар, авьяас билгийг дэлхийн тавцанд гаргах цаг нэгэнт ирсэн тухай цөөнгүй яригдаж байсан. Тэгвэл энэ чиглэлээр юу хийсэн бэ?**

-Хүний хөгжлийг олон хэлбэрээр авч үзэх хэрэгтэй. Нэгд, боловсрол, хоёр дахь нь эрүүл мэнд, гуравдугаарт, эдийн засгийн орлого гэж авч үзнэ. Уул уурхай ашигт малтмалын нөөц дээрээ тулгуурлаад Хүний хөгжил сан болон төсвөөр дамжуулаад дээрх гурван үзүүлэлтэд том ахиц гарлаа гэж бодож байна. Нэгдүгээрт, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр манай улс дундаж орлогын тоонд анх удаа багтлаа. Хоёрдугаарт, орлогыг дахин оновчтой хуваарилах талаар бодлогын нэгдсэн ойлголтод хүрлээ. Энэ хүрээнд дээр ярьсан бодлогуудыг хэрэгжүүллээ. Боловсролын салбарт Кембрижийн тогтолцоонд шинээр шилжих, оюутны хотхон барих, Ерөнхий боловсролын олон сургуулийг барьж, засахад томоохон ахиц гарсан.

Монгол хүний дундаж наслалт нэмэгдсэн байгаа. Хуучин 64 байсан бол 68 хүрлээ. Энэ бол хүний хөгжилд тодорхой ахиц гарч байгаа гэсэн үзүүлэлт юм. Тэгэхээр цаашдаа эрүүл мэндийн тогтолцоог сайжруулж, Монгол Улс эрүүл мэндийн салбараараа бүс нутагтаа тэргүүлдэг болох. Монголчууд гадаад явж эмчлүүлэх бус гаднынхан манайд ирж үзүүлдэг байх ийм хэмжээний эрүүл мэндийн системийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн хөдөө орон нутагт олон төрөлжсөн шинэ эмнэлэг барих, хуучин эмнэлгийг засах ажлын өртгийг улсын төсөвт урьд өмнө байгаагүйгээр суулгасан байгаа.

**-Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлсэн ч Монголд ажилгүйдэл их хэвээр байна. Иргэдээ ажлын байртай болгоход Засгийн газар яаж анхаарч байгаа вэ?**

-Хөдөлмөрийн бирж болон бүртгэл дээр үндэслэсэн хөдөлмөрийн зах зээлийг холбож өгөх асуудлыг төр хийх ёстой. Тиймээс ч мэргэжлийн сургалтын төвүүдийг өнгөрсөн хугацаанд олноор байгууллаа. Өнгөрсөн онд 70 мянган хүн ажлын байртай болсон. МСҮТ-үүдийн сургалт үйл ажиллагаанд эрс шинэчлэл хийж хөрөнгө оруулалт зоригтой хийсний үр дүнд зах зээлд эрэлт ихтэй нарийн мэргэжлээр суралцах хүмүүсийн тоо нэмэгдлээ. Тэр хэмжээгээр уул уурхайн томоохон төслүүдэд хамрагдаж ажлын байраар хангагдаж байна. Хоёрдугаарт, ажилгүйдлийн түвшинг тооцох статистик аргачлалд зөрүү байна. Дэлхийн банкны олон улсын аргачлалаар манай ажилгүйчүүдийн төвшин нэлээд буурч, бараг 10 хувьд хүрсэн байдаг. Гэтэл ҮСХ-ны гаргасан тооцоогоор энэ тоо 39 хувь дээр явж байна. Юуны өмнө энэ аргачлалаа маш тодорхой болгох хэрэгтэй юм.

Хөдөлмөрийн бирж болон шинэ бүртгэлийг үндэслэн ажилгүйчүүдийн дунд мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг төр хийнэ. Харин иргэдээсээ болон залуучуудаасаа хүсэх зүйл гэвэл ажил хийвэл ам тосдоно гэдэгчлэн хөдөлмөрлөх хэрэгтэй гэдгийг хэлмээр байна. Жишээ нь, өнгөрсөн оны эхээр би хөнгөн үйлдвэрийнхэнтэй уулзах үеэр "Говь" компани 400 гаруй хүний ажлын байр байгаа ч долоохон хүнийг ажилд авсан тухайгаа ярьж



байсан. Яасан гэхээр нэхмэлчин, сүлжигч гэх мэргэжлийн ажилтан олдохгүй байгааг учирласан. Иргэдэд ажил хийх, бас нарийн мэргэжлээр суралцах санаачилга ермэлзлэл тийм ч сайн биш байна. Тиймээс Засгийн газраас тэднийг хүссэн мэргэжилдээ эзэн болгох хэмжээнд мэргэшүүлэх, ингэсний хүчинд хөдөлмөрийн үнэлэмжээ зөв үнэлүүлж боломжит амьдралыг бий болгох тал дээр дэмжих ёстой гэсэн бодлогыг барьж байна. Мөн эдийн засгийн боломжийг ч тийш нь чиглүүлэх ёстой гэж үздэг.

**-Монгол орныг тэжээн тэтгэж ирсэн хөдөө аж ахуйн салбарыг шинэ тутам хөгжиж буй уул уурхайн хөгжилтэй хэрхэн зохицуулж зөв авч явах ёстой вэ?**

-Монгол Улсын эдийн засаг олон тулгууртай байх ёстой. Жишээ нь зөвхөн зэсийн үнэ унахад л манай төсвийн бүрдэлт үндсэндээ хүндэрдэг. Тэгэхээр бид уул уурхайд түшиглэсэн эдийн засгийг голлох биш, боломжийг зөв ашиглах ёстой. Уул уурхайг хөгжлийн түлхүүрийн түлхэц болгох учиртай. Нөгөө талаас монголчуудыг үеийн үед тэжээж ирсэн, тэтгэж байгаа, маргааш бүр ч илүү тэтгэх хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг онцгойлж авч үзэх ёстой гэж би үздэг. Энэ бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын асуудал юм. Эдийн засгийн хөгжлийн асуудал болсон хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахын зэрэгцээ экспортын боломж ч бидэнд бүрэн дүүрэн бий. Тэгэхээр эхлээд дотоодын хэрэгцээгээ чанартай бүтээгдэхүүнээр хангах асуудлаа төр бодлогоор дэмжих ёстой. Бодлогын дэмжлэгийг энэ удаагийн Засгийн газар, УИХ-аас маш тодорхой гаргасан. “Монгол мал” гэсэн үндэсний том хөтөлбөр гаргалаа. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогоо тодорхойлсон.

**-Дэд бүтэц, боловсрол, шинжлэх ухааны салбарт дорвитой хөрөнгө оруулалт байхгүй байгаа тухай салбарын мэргэжилтнүүд гомдоллодог. Гэрлийн хурдаар өссөн Монгол Улсын хөрөнгө оруулалтын чанарт Та ямар үнэлгээ өгөх вэ?**

-Монгол Улсын хувьд дэд бүтцийн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа. Сүүлийн жилүүдэд зөвхөн 2011 онд хийсэн хөрөнгө оруулалт 600 тэрбум төгрөг байсан бол 2012 онд үүнээс хоёр дахин их хөрөнгө оруулалт хийж байгаа. Үүний дийлэх нь засмал зам, цахилгаан станц зэрэг дэд бүтцийн хөгжилд зарцуулагдана.

Түүнчлэн боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа. Шинжлэх ухааны салбар хөрөнгө оруулалтыг хэр үр өгөөжтэй ашиглаж байгааг авч үзэх ёстой. Өнөөгийн байдлаар ШУА-д 20 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхэд энэ нь ерөнхийдөө цалин болоод хувирч байна. Монгол Улсын хөгжилд хамгийн тулгамдсан дэд бүтэц, утаатай тэмцэх, эрчим хүчний асуудлаар практикт хэрэгжиж байгаа зүйл тун бага байна. Зөвхөн суурь судалгаа, онолын судалгаа хийгээд байгаа нь хүмүүсийн бодит амьдралтай нийцэж, уялдаж өгөхгүй байгаа юм. Тиймээс цаашид ШУА-ийн тогтолцоог цогцоор нь шинэчилж, практик амьдралтай холбох хэрэгтэй байна. Шинжлэх ухааны салбарыг шинэчилснээр Монгол Улсын хөгжилд ихээхэн үр өгөөжтэй өөрчлөлт болно гэж бодож байгаа. Тус салбарт олон мянган залуу эрдэмтэн судлаач, академич ажиллаж байна. Тэдний мэдлэг чадварыг ашиглах, улс орны хөгжил рүү дорвитой чиглүүлэх хэрэгтэй байна.

**-Лондоны хөрөнгийн биржтэй манай бирж хамтран ажиллаж байгаа нь хөрөнгийн зах зээлийг бодитоор хөгжүүлэх шинэ алхам болсон. Цаашид хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчинд ямар өөрчлөлт хийх вэ?**

-Үнэт цаасны тухай хуулийг шинэчилж олон улсын системд ойртуулах шаардлага байгаа. Манай хөрөнгийн зах зээл анхлан хувьчлалын зориулалтаар байгуулагдсан учраас орчин үеийн бодитой, хэрэгцээтэй шаардлагаас хоцроод байгаа юм. Техник, менежмент, зохион байгуулалтын хувьд хоцорсон гэсэн үг. Сүүлийн хоёр жилд хөрөнгийн биржийг дорвитой өөрчлөх чиглэлээр ажилласан. Үүний дүнд олон улсын менежментийн багийг авчраад техникийн шинэчлэлтийг бүрэн хийлээ. Одоо хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох болно. Бусад хөгжиж байгаа орны санхүүгийн эрүүл тогтолцоо нь банк 50, хөрөнгийн зах зээл нь мөн хэмжээний хувийн харьцаатай байдаг. Гэтэл манайд банк 95 хувь, хөрөнгийн зах зээл таван хувийг эзэлж байна. Ийм буруу тогтоолцоог засаж сайжруулахад бас л хугацаа орно. Гэлээ ч манай Засгийн газар сүүлийн хоёр жилд энэ чиглэлд багагүй ажил эхлүүлээд байна. ■

2012. 01 САР.

# Бид өсөлтийг хөгжил гэж андуураад байна



*УИХ-ын гишүүн Д.Энхбаттай ярилцлаа. УИХ-д нэр дэвшихийн төлөө улайран тэмцэлдэж буй үед тэрбээр нэр дэвшихээс татгалзсан юм. Намынхаа жагсаалтын хувьд С.Оюун гишүүний дараа хоёрт бичигдэж, мөн УИХ-д дахин сонгогдох магадлал өндөр байсан Энхбат гишүүн нэрээ татсаны учир юу юм бол.*

*Нөгөөтэйгүүр миний бие түүнийг улстөрд орохоос өмнө олонтаа ярилцлага хийж байлаа. Улс орны хөгжил дэвшил, шинэ санаа оноо, мэдээллийн технологийн талаар бидний ярилцлагын сэдэв өрнөдөг байсан бол түүний сүүлийн дөрвөн жилд сонин хэвлэлд өгсөн ярилцлага нь түлхүү улс төр, намын тухай ярьжээ. Энэ удаа түүний улс орны хөгжлийн төлөө юу бодож явдаг талаар голлон сонирхохыг хичээлээ. Төрийн ордонд дөрвөн жил суусан УИХ-ын гишүүн Д.Энхбат "Монголчууд хуурамч багаа хуулж хаясан цагт хөгжил ирнэ" хэмээн ярилаа.*

**-Өнөөдөр манай улс хөгжлийн гарааны дээр ирчихээд байна. Хурдацтай хөгжих үү, эсвэл ангал руу унах уу. Сонголт бидний өмнө байна. Таны бодлыг сонсъё?**

-Өнөөдөр манайд оршин буй төр, ардчилал гээд бүх зүйл нь хүнийх байна. Гаднын улс төр, тэр ч бүү хэл хүмүүс хоорондын маргааныг ажиглахад соёлын ялгаа ихэд харагддаг. Товчхон хэлэхэд, хөгжил мөнгөний, эдийн засгийн ч асуудал биш. Гаднын орнууд өөрсдийн уг үндэс, ёс заншил дээр тулгуурлаж хөгжиж буй болохоос биш, уул уурхайгаас гэнэт мөнгөтэй болоод хөгжчихсөн юм байхгүй. Өнөөдөр Африкын улсуудад 100 тэрбум ам.доллар өгөөд ч хөгжихгүй. Учир нь, тэр улс орнуудын төр, шүүх засаглал, хууль гээд бүх зүйл нь хүнийх. Тэгэхээр хөгжлийн талаарх миний дүгнэлт бол хэлбэр, агуулга хоёр давхардаж, өөрийн соёл дээр тулгуурласан тэр үед л хөгжил ирнэ. Гэхдээ би хөгжилд уул уурхай, эдийн засаг, мөнгө чухал бус гэж хэлэх гэсэнгүй. Харин уул уурхай, эдийн засгийн өсөлтийг даваад харвал нийгмийн асуудал байгаа. Тэр нийгмийн

асуудлын цаана нөгөө соёл иргэншил бий. Тэгэхээр соёл иргэншил хэмээх уг гарвалаа мэдэхгүй бол бид хэзээ ч хөгжихгүй.

Өнөөдөр улс төр, эдийн засгаараа хямрахаас илүүтэй монгол хүн гэж хэн бэ гэдгээ мэдэхгүй байх том хямралтай нүүр тулах вий. Бид яг юу хүсэж буйгаа хэлж чадах хүн өнөөдөр ховор. Алисиа гайхамшгийн оронд гэдэг кино байдаг даа. Тэр кинонд Алисиа найзуудтайгаа явж байгаад зам дээр нэг хүнтэй таарч энэ зам хаашаа хүрэх вэ гэж асуудаг. Нөгөө үл таних хүн чи хаашаа явж байгаа юм бэ гэхэд Алисиа мэдэхгүй гэнэ. Нөгөө хүн тэгвэл энэ зам хаашаа явах нь танд ямар хамаатай юм бэ гэж хариулдаг. Яг л үүнтэй адилхан монголчууд бид хаашаа явж байгаагаа мэдэхгүй бол энэ зам хаашаа явах нь ямар хамаатай юм бэ. Ийм нөхцөл замбараагүй байдлыг үүсгэдэг.

**-Уул уурхай, эдийн засгаас илүү Монгол Улс, монгол хүн гэдэг мөн чанараа ярих нь чухал гэсэн үг үү?**

-Бид өнөөдөр уул уурхай, эдийн засаг их ярьж байна. Харин өөрсдийн мөн чанараа яагаад ярихгүй байна вэ. Хөгжихийн тулд үүнийг л ярих хэрэгтэй. Чи гараад захын монгол хүнээс амьдрал ямар байна вэ гэхэд өө сайхан болж байна гэдэг. Харин дотны найзтайгаа цай уугаад суухаараа өө ёстой хэрэг алга, бараг л үхмээр байна гэнэ. Ийм л худлаа царайлж байна ш дээ.

Улс төрийг аваад үзье. Монгол ардын нам гэж юу гэсэн үг вэ. Толь бичиг бариад харсан ч болно, ард гэдэг үгийг. Тэнд эд хөрөнгөгүй, угсаа гаралгүй хүнийг ард гэнэ гэсэн байгаа. Тэгвэл МАН харц ардын нам байх ёстой болж байна аа даа. Тэгвэл өнөөдөр ямар нам билээ. Бас нэг жишээ дурдахад монголчууд их савладаг ард түмэн. Намайг Статистикийн үндэсний хороонд ажиллаж байхад манай нэг найз саалийн хэдэн үнээтэй болж, сүүгээ зарж мөнгөө цуглуулаад машин авч уналаа. Тэгсэн хувийн өмчтэй боллоо гээд найзыг маань намаас хөөсөн.

Харин өнөөдөр бүгдээрээ зах зээлд орчихсон явна. Урьд нь нийтийн юмыг л дээдэлдэг байсан бол өнөөдөр нийгмийн, нийтийн эд хөрөнгийг юман чинээ бодохгүй байна. Бүгдийг л хувьчлах бодлого явуулж ирлээ. Хууль нь хүртэл тийм байна. Тухайлбал, танай нутгийн гол хордчихлоо. Шүүх танаас “Та өөрөө хордсон уу” гэж асууна. Хэрвээ хордоогүй бол шүүх таныг хохирогч биш гэж үзээд хэргийг авч хэлэлцэхгүй. Та хохироогүй л бол шүүхээр явах эрх байхгүй гэсэн үг. Тэгвэл бидэнд Туул гол ширгэх, Богд уул түймэрт автах хамаагүй юм байна л даа. Эндээс харахад хамтын, нийтийн эрх ашиг гэх зүйл алга. Энэ нийгэмд амиа л бодвол тэргүүний мундаг хүн юм байх. Бид ийм байдлаар савлаж байна. Хамгийн аймаар нь өөрийн үзэл бодолгүй хүмүүс ингэж савладаг юм.

**-Тэгвэл Монгол Улс өөрчлөгдөхийн тулд энэ бүх хуурамч байдлаасаа л гарах хэрэгтэй юм байна. Хэрхэн яаж энэ хуурамч зангаа хаях вэ. Юунаас болоод алхам тутамдаа ийм хуурамч зан гаргаад байгаа гэж Та бодож байна вэ?**

-Хоёр шалтгаан байх шиг байна. Эхнийх нь бид өөрсдөө хуурамч байгаагаа мэдэхгүй явна. Социализмын үеэс л хуурамч амьдарсаар сурчихаж. Тухайлбал, чи нэг машинтай болох гэтэл коммунист үзэл суртлаар болж чаддаггүй. Тэгэхлээр хуурамч дүр эсгэж эхэлнэ. Ингэж явсаар өөрийн мэдэлгүй хуурамч амьдралд сурчихсан хэрэг. Угтаа монгол хүний төрөлх мөн чанар юу билээ. Билэг танхай, дуу шуутай хүмүүс.

Нэг жишээ дурдахад, япончууд хүүхдээ билэг танхай болгох гэж яаж ч хичээгээд чадахгүй. Тэдний цаад ясанд нь биднээс өөр бүрэг, даруу зан байдаг. Харин монгол хүн эсрэгээрээ. Гэтэл монголчууд хүүхдүүдээ япон хүүхдүүд шиг болгох гээд зүтгэдэг. Монголчуудыг яаж ч даруухан болгох гээд чадахгүй. Тэгэхээр монголчуудад зориулсан арга барил хэрэгтэй байна. Монголчууд шиг дураараа хэрэлддэг хүмүүст зориулсан хурлын арга хэрэгтэй гэсэн үг. Энэ бол муу зүйл ерөөсөө биш. Хүн дураараа билэг танхай байх нь орчин үеийн хэллэгээр лидер, манлайлагч хүний хамгийн том араншин шүү дээ.

Гэхдээ үүн дээр нэмээд боловсрол, хувь хүний соёл байх хэрэгтэй. Яг л үүн шиг жирийн иргэнээсээ аваад төр хүртлээ өөрийнхөө төрөлх мөн чанар дээр суурилж аливаа нийгмийн үе шатуудыг өөрийн оронд зохицуулан бүтээж чадвал бид өөрийнхөөрөө хөгжиж, хөгжлийн шинэ шатанд гарч ирж чадна. Харин одоо бид хурал дээр герман маягаар үг хэлж, гэртээ монгол хэлбэрээр амьдарч байна. Хэлбэр, агуулга нь энэ мэт зөрөөд буй үед хэзээ ч мөнгө тус болохгүй. Дэмий үрээд л дуусна. Тиймээс өөрсдийнхөөрөө байж чадах тэр орчин л бидний хуурамч байдлыг алга болгох учиртай.

**-Тэгвэл хэлбэр, агуулга хоёр хэзээ зөв голдиролд орох вэ?**

-Өнөөдөр бүгд уул уурхай ярих эсвэл бүгд алт ухах хэрэггүй. Монгол Улсын Ерөнхийлөгч, дээд давхаргын тэр сэхээтнүүд л өөрийн төрөлх мөн чанартаа ойртох хэрэгтэй. Алт ухах нь ухаг хамаагүй. Харин Ерөнхийлөгч нь уурхайчин байх хэрэггүй. Хэрвээ Ерөнхийлөгч уурхай яриад уурхайчин болчихвол Монгол Улс хөгжиж эс чадна.

**-Өсөлт хөгжил мөн үү?**

-Бид өсөлтийг хөгжил гэж андуураад байна. Хөгжил нь бидний өөрсдийн уг үндэс дээр цэцэглэхийг хэлдэг юм. Хоёр сар гарны өмнө Швед улсын хэдэн судлаач манайд судалгаа хийгээд буцлаа. Тэд манай залуучуудтай уулзаад их сонин зүйл надад хэлсэн. Танай орны ихэнх залууст шударга зан, үндэсний соёл, ажилсаг байх талаар нэгдсэн ойлголт алга. Танай залуучууд том дарга таньдаг эсэх, ганган хувцас, унасан машинаараа хуваагдчихсан байна. Түүнээс биш, үзэл бодлоороо хуваагдсан нь цөөхөн. Энэ юуг харуулаад байна гэхээр бид өөр хоорондоо хэрэглээгээрээ ялгараад байгаа болохоос биш хүн чанараараа ялгарч чадахгүй байгаагийн илрэл юм.

Мөн судалгааны явцад манай залуучуудын хувьд секс бол хайр дурлал, харилцаа огт биш гэж гарсан байна. Зүгээр л хэрэглээ болчихож гэсэн үг. Яг үүнийгээ дагаад улс төрийн намууд мөн адил үзэл бодлоороо бус хэрэглээгээрээ л сэтгэдэг болчихсон. Хаана очвол дарга болох вэ л гэж бодно. Эцэст нь Шведийн судлаачид энэ бол танай улсын сүйрэл гэсэн. Өнөөдөр биднийг үзэл бодол, хүн чанар биш, ердөө л уул уурхай нэгтгэж байна. Хэрвээ уул уурхайн баялаг дуусвал яах вэ. Тэр судлаачид яг манайх шиг

байдлыг Нигери улсад ажигласан байна. Тэнд нефть л тухайн улсын оршин тогтнох эх үүсвэр болж, нефть дагаж улс төр, эдийн засаг тэр ч бүү хэл, сонгууль нь явагддаг байна. Тэгвэл манай орон өнөөдөр Нигериэс юугаараа ялгаатай юм бэ. Уул уурхайг л дээр, доргүй ярьж байна шүү дээ.

**-Тэгвэл бид сүйрэл рүү гээ яваад байгаа хэрэг үү?**

-Өнөөдөр өнгөцхөн харахад бид бүгдээрээ гар утастай, машинтай байна. Энэ бол XXI зууны гайхамшиг. Энэ зууны XI зуунаас ялгагдах онцлог нь хүмүүс турж биш таргалж сүйрдэгт байгаа юм. Швед эрдэмтдийн хэлснээр энэ зуунд улс гүрэн мөнгө дутаж биш, мөнгө нь илүүдэж сүйрдэг болжээ. Энэ үнэн. Харин манайхан үүнийгээ хөгжил гэж нэрлээд байгаа юм. Бид хөгжлийг хүртэл хэрэглээгээр дүгнэж байна. Хөгжлийг буруу гаргалгаагаар авч үзээд байвал нөгөө тал нь юу байх вэ. Тэр бол сүйрэл. Хөгжлийн гаргалгаагаа мэдэхгүй бол бид мөнгөө хэрэглээндээ зарцуулсаар яваад таргалж сүйрнэ. Хөгжлийг хөдөлгөгч нь мөнгө биш.

Хүмүүс намайг уул уурхай, эдийн засгийн өсөлтийн эсрэг нөхөр байна гэж бодож магадгүй. Миний хувьд эсрэг зүйл огт яриагүй. Харин ч эсрэгээрээ уул уурхайд баярлаж, мөнгө эдийн засагт их байгаасай гэж хүсдэг. Уул уурхайн хөгжилд баярлалаа гэсний шалтгаан нь бид эндээс мөнгөтэй болж, хөгжлийн талаар ярьж эхлээд байгаа явдал юм. Хэрвээ мөнгөтэй болоогүй бол хөгжлийн талаар яриа ч уу, үгүй ч үү.

**-Жинхэнэ хөгжил өөрсдийн мөн чанар, соёл дээр тулгуурласан тэр зүйлийг л хэлэх ажээ. Харин хөгжлийн талаар нэгдсэн зөв ойлголттой байж чадаж байна уу гэдэг бас нэг асуудал юм биш үү?**

-Энэ талаарх нэгдсэн нэг ойлголт чухал. Германчууд Монгол Улсад боловсролын чиглэлээр хэдэн жил дараалан хурал зөвлөлгөөн зохион байгуулжээ. Тэгээд бүр сүүлдээ хийсэн ажил нь нурахад хүрч. Гэтэл дөрвөн жилийн дараа нэг герман эрдэмтэн монголчууд яагаад хэл амаа ололцохгүй, хэрэлддэгийг ойлгосон гэнэ. Манайхан боловсролыг өөр өөрийнхөөрөө ойлгоод байдаг. Зарим нь боловсрол гэдгийг математик гэж ойлгодог бол нөгөө нь шударга, хүмүүжилтэй байх гэж бодох жишээтэй. Товчхондоо бид боловсрол гэж юу хэлдгийг мэдэхгүй, хар ухаанаар л ойлгодог шүү дээ.

Харин Германд аль эрт XVII зуунаас энэ талын нэгдсэн ойлголттой болчихсон ард түмэн. Бүх зүйл дээр герман хүн бүр яг л нэг тодорхойлолт хэлдэг, түүнийхээ дагуу маргадаг, хэлэлцдэг арга зам хайдаг. Монголд нэг хурал боллоо. Зааланд хорин монгол хүн байлаа гэхэд бүгдээрээ өөр өөр зүйл ярьж эхэлнэ. Үүний учир нь 200 гаруй жил манай улс Манжийн нэг хэсэг байсан, 80 гаруй жил Оросын хэсэг болсон. Тэр үед манжууд, эсвэл оросууд боловсролыг гэдгээ нэгдсэн нэг ойлголтоор мэддэг байсан байх. Харин манайд зүгээр л даалгавар өгчихдөг. Бид юу хийгээд байгаагаа мэдэхгүй дагаад л хийчихдэг байсан шүү дээ. Тэгэхээр бид өөрийн гэсэн нэгдсэн нэг ойлголт тодорхойлолтгүй бол юу ч хийгээд хөгжихгүй.

**-Монголчуудын дунд ойлголтын зөрүү их байна. Ойлголтоо нэгтгэж байж хөгжих нь бас тодорхой юм. Яагаад ийм байдалд хүрчихэв ээ?**

-Хэрэглээний нийгмийн аюул энэ юм. Өнөөдөр уул уурхай гэж юу хэлдгийг ч мэдэхгүй байна шүү дээ.

**-Таны хэлдгээр мөн чанар руугаа ойртоод гэдэг ч юм уу сүүлийн үед улс орнууд байгаль дэлхийд ээлтэй органик, ногоон хөгжлийн тийш яваад хэдийнэ эхэлжээ.**

-НҮБ-аас гаргасан хүний хөгжлийн 10 индексийн тав нь байгаль орчных байдаг. Яг үүнтэй адилхан соёл иргэншлийн тэн хагас нь байгалийн хуулиар явна. Хүн өөрөө байгалийн нэг хэсэг учраас тэр. Тиймээс ногоон хөгжил нь шинэ зүйл огт биш. Ирээдүйд манай уул уурхай тойрсон олон хот, бүтээн байгуулалт бий болно. Харин тэр үед бид тогтвортой хөгжлийг бий болгож чадаагүй бол миний тооцоолсноор 50 гаруй жилийн дараа Монгол Улс 200 орчим Налайх шиг хоттой л хоцорно.

Нэг бодит жишээ дурдахад Чойр хот руу явах замд орос цэргүүдийн амьдардаг үнэхээр тансаг хотхон байсныг мэдэх юм. Тэр хотхоны орос оршин суугчид хэрвээ нутаг буцвал монголчуудад амьдрах сайхан хот үлдэх нь дээ гэж боддог байлаа. Тэгсэн оросууд нутаг буцсан, тэр хотхон өдгөө балгас болсон. Учир нь, тэр хотхон тогтвортой хөгжлийг бий болгож чадаагүй хэрэг. Үүнтэй адилхан одоо ашиглаж буй уул уурхайн баялаг дуусахад дэргэд нь байсан зүйлс яах вэ. Үүнийг бид бодох хэрэгтэй. Тухайлбал, уул уурхай руу тавьж байгаа зам, өндөр хүчдэлийн шугам одоо зайлшгүй хэрэгтэй ч тэр уурхайн ашиглалт зогсвол эдгээр бүтээн байгуулалт юу ч биш болно. Үүнийг эртнээс тооцож, ирээдүйд хэнд ч хэрэггүй “хог” болохооргүй бүтээн байгуулалт хийх хэрэгтэй. Улс орны хөгжил эндээс л эхэлнэ.

Бид дэлхийн ердөө л нэг хэсэг. Тиймээс анхнаасаа аливаа зүйлийг хийхдээ зөв системтэй хийх хэрэгтэй. Тэр дундаа байгалийнхаа системтэй уялдаж чадвал алдаа бага гарна. Энэ бол Ерөнхий сайд асан Бямбасүрэн гуайн хэлдэгчлэн даацтай хөгжил юм. Манайхны томъёолж буйгаар тогтвортой, ногоон хөгжил. Байгалийн системтэй уялдсан бодлого явуулдаг, алдахаасаа өмнө арга хэмжээ авахыг зорьж буй улс төрийн хүчнийг Ногоон нам гэдэг. Харин тухайн үед нь л учрыг нь олох талаар боддог бол тэр өөр нам юм. Ялгаа нь ердөө л энэ.

**-Та өнгөрсөн дөрвөн жил УИХ-д ажиллалаа. Чухам юу ойлгосон бэ?**

-Би нэг л зүйлийг үнэхээр сайн ойлголоо. Сүүлийн 20-иод жил монголчууд зах зээл, эдийн засаг, ардчилал, эрх чөлөө гээд олон зүйлийг ойлгохын төлөө явсан. Үүнийгээ дагаад өөрчлөгдөж, тодорхой хэмжээнд хөгжсөн. Харин ганцхан зүйл л өөрчлөгдөөгүй үлджээ.Тэр нь улс төрийн намууд. Социалист дэглэмийг үндэслэсэн Ленин гэдэг нөхрийн бий болгосон тэр улс төрийн систем өнөөдрийн манай улс төрд явсаар л байна. Өнөөдөр хэлж мэдэхгүй ч дотроо хамгийн хэрэггүй зүйл бол улс төр гэж боддог болчихсон байгаа. XXI зуун гарчихаад байхад өнгөрсөн зууныхаараа оршин буй улс төр Монгол Улсад өнөөдөр яваад байна.

**-Тэгвэл манай нам, улс төрийн хүчнүүд яагаад өөрчлөгдөж, хөгжихгүй байна вэ?**

-Сул мөнгө тэдэнд морфин

PC mall | EPSON
EXCEED YOUR VISION

# Утасгүй холболт, хямд зардалыг агуулсан Epson L455 шинэ загварын зөөврийн принтер

Утасгүй холболтын технологийн тусламжтайгаар Epson L455 олон үйлдэлт принтер таныг гэрийнхээ, оффисынхоо хаанаас ч комманд өгсөн хэвлэж чадна. Хувилах, сканердах үйлдлийг нэг дор багтааснаараа зай бага эзлэж, ажлын байрны эмх цэгцтэй байдлыг бий болгоно.

**Хэвлэлтийн зардлын гайхалтай хэмнэлт**

Epson-ийн оригиналь бэхэн хор гайхалтай өнгийг дүрсэлж чадахаас гадна зардлыг хэмнэж өгдөг. Хар хорооroo 4000, өнгөт хорооroo 6500 хуудас хэвлэх хүчин чадалтай.

**Хэрэглэхэд хялбар байдал**

1,44 инчийн өнгөт удирдлагын дэлгэцтэй учир принтер дээрээ үйлдэл, тохиргоо хийх болон хорныхоо хэмжээг харах, SD картаас зургаа сонгон хэвлэхэд маш хялбар. Компьютер ашиглалгүйгээр картнаас зургаа хэвлэх слоттой.

**Гайхалтай чанартай хэвлэлт болон хурд**

L455 загвар нь 5760dpi нягтаршилтай хэвлэдэг. Хар цагаан нооргийг хамгийн ихдээ 33ppm хурдтай, стандарт хар цагаан материалыг 9,2ipm хурдтай хэвлэнэ.

**Epson Connect технологи**

Epson iPrint – Хэвлэх болон сканердахдаа шууд ухаалаг утаснаас эсвэл онлайн клауд хадгалах үйлчилгээг ашиглах боломжтой.
Epson Creative print – Мобайл төхөөрөмжөөсөө зургаа засварлаж, хүссэнээрээ хэвлэх боломж
Epson Email print – Имэйл хандалттай бүх л компьютерээс шууд хэвлэх боломж
Remote Print Driver – Интернэт холболтой дурын газраас Remote print driver ашиглан Epson iPrint апп ашиглан хэвлэх боломжтой
Мөн Apple AirPrint, Google Cloud Print технологиор хэвлэх боломжтой.

# L455
## ШИНЭ ЗАГВАР

Хараар 4000 хуудас

Өнгөтөөр 6500 хуудас

Wi Fi

1 жилийн баталгаа




Технологийн дэвшил
Таны дэргэд

Хялбар Wifi тохиргоо




7575-3535

Онлайн худалдаа:
www.pc-mall.mn

Join us on Facebook
http://www.facebook.com/PCmallOfficial

тасралтгүй тариад байна л даа. Тэд морфиноор амьдраад байна гэсэн үг. Тэгээд түүнээсээ гарч чадахгүй байгаа юм. Угаасаа мансууруулах зүйлд донтсон хүн гарах хэцүү байдаг гэдэг шүү дээ. Яг л үүнтэй адил юм.

**-Тэгвэл энэ мансуурлаас яаж гарах вэ?**

-Маш том улс төрийн шинэчлэл хийх ёстой. Үүний тулд хамгийн түрүүнд намыг улс төрийн хэдэн дарга нарын биш гишүүдийн, олон нийтийн байгууллага болгох хэрэгтэй. Намууд олон гишүүнтэй л гэж байна. Гэвч тэдний үүрэг юу вэ. Өнөөдөр гишүүд зүгээр л тоо төдий болчихсон. Ийм зүйл ярихаар хүмүүс улс төр гээд байж магадгүй юм. Яг үнэндээ энэ чинь улс орныг авч явах уураг тархины зохион байгуулалт. Харин өнөөдөр биднийг авч явах уураг тархи сонгуульд ялахын тулд л эдийн засгийн бодлого явуулж байна. Ийм нөхцөлд хэзээ ч бодит үр дүн гарахгүй. Эндээс эргээд л миний ярилцлагын эхэнд хэлсэн хуурамч байна гэдэг дээр очно. Чехийн Ерөнхийлөгч асан Бацелавь Хавель хэлэхдээ “Улс орноо шинэчлэх тухай ярихын тулд эхлээд бүгд хуурамч байхаа л болих хэрэгтэй. Бусад нь бүгд бидэнд бий” гэсэн байдаг. Бидэнд үнэхээр л бүх зүйл байна. Хуурамч байгаагаасаа болоод л бүх зүйл худлаа болоод байгаа юм.

**-Бусад улс орны Ногоон намууд хариуцлагатай, өөрийн гэсэн өндөр үүрэг хүлээсэн байдаг нь ажиглагддаг. Тухайлбал, Германы Ногоон нам ногоон хөгжлийн төлөө тун хариуцлагатай ажилладаг юм билээ. Харин танай намын тухайд хэр байна вэ?**

-Германы ганцхан жишээг хэлье. Германы Ногоон намын зохион байгуулалт хариуцсан баг манайд хоёр удаа ирж, нам ямар байх талаар манай гишүүдэд хичээл заасан. Гэтэл намын гишүүд маань сэтгэлээр бүр уначихсан. Бидний мэдэхээс шал өөр зүйлийг нам гэж хэлдгийг ойлгосон болохоор тэр. Зарчим нь их энгийн. Германы Ногоон нам жилд хоёр удаа хурлаа хийдэг бол манайх дөрвөн жилд ганц удаа хийдэг. Германы Ногоон намын их хуралд намын бүх гишүүн тэр ч бүү хэл нам бус хүн ч орж болно. Би нэг удаа тэр хурал дээр нь очсон л доо. Гишүүд нь бүр эхнэр, хүүхэдтэйгээ ирчихсэн, гадаах талбайдаа мах шараад л. Энэ бол хэлбэр тал нь. Харин агуулга нь тэр хурлаар намын бүх гишүүний саналыг нэгтгэж, дүгнээд Парламентад буй гишүүддээ төрийн бодлого гаргахад нь нөлөөлөх үүднээс хүргүүлдэг.

Хамгийн сонирхолтой нь Та Ногоон намын гишүүн биш байж болно. Магадгүй Ардын намын гишүүн байлаа гэхэд Та манай намын гишүүдээс өөрийгөө дэмжсэн 40 гаруй хүний гарын үсэг зуруулж чадвал манай намын хурал дээр илтгэл тавих эрхтэй. Тухайн илтгэлд дурдагдсан санаа үнэхээр зөв бол намын бодлого болгоод ч явж болно. Эндээс нам бол төрийн эрхийг барих цөөнхийн бүлэглэл биш гэдэг тодорхой болж байна. Нам бол иргэдийн төрд оролцох гүүрийн үүрэг гүйцэтгэгч. Ленины тодорхойлсноор нам төрийн эрхийг барих цөөнхийн бүлэглэл гэх хоцрогдсон ойлголт өдгөө үеэ өнгөрөөжээ.

Дээрээс нь Германд сонгууль их энгийн зарчмаар явдаг. Та намын бодлогыг дэмждэг бол тодорхой хэмжээний татвар төлнө. Харин нам таны сонгуулийн бүх зардлыг даах учиртай. Яагаад гэвэл сонгууль мөнгө биш. Иймээс нам хамгийн итгэлтэй, нэр хүндтэй гишүүнээ сонгуульд нэр дэвшүүлдэг. Харин манайд эсрэгээрээ шүү дээ. Мөнгөтэй нь л сонгуульд нэр дэвшдэг. Ингээд ирэхээр төрд цөөнхийн бүлэглэл үүсдэг юм байна.

**-Таныг Монголд интернэтийн эцэг гэдэг. Мөн өнөөдөр Twitter-ээр ч Монголдоо “байлдан дагуулагч” гэж ярьж байна. Таныг хэчнээн жиргээчид дагаж байна вэ?**

-Одоогоор 15 мянга гаруй хүн байх шиг байна. Гэхдээ сүүлийн 10 гаруй хоног нэг ч удаа Twitter-т орсонгүй. Энэ нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, хүмүүс улс төр ярихаар дургүйцээд байна. Хоёрдугаарт, намын даргын хувьд өөрийн байр сууриа Twitter-ээр хэлж болохгүй байна. Тэгэхээр би гадаа бороо орж байна гээд бичээд байлтай биш. Дээрээс нь өнөөдөр манайд Twitter арай буруу хөгжөөд байна. Уг нь Twitter бол чат биш ямар мэдээлэл хаана болж байгаа талаарх дохио юм. Гэтэл хоёр хүний хоорондын чат болчихож. Гэхдээ энэ энгийн үзэгдэл л дээ.

**-Та тэгвэл facebook-ээр хэр зэрэг зочилдог вэ?**

-Facebook-ийг сонирхож үзсэн. Гэхдээ тэнд юмны учрыг олох гэсэн бус маш олон янз бүрийн юм сонирхсон хүмүүсийн нэгдэл байсан. Тиймээс Facebook-ийг ажлын талбар биш гэж үзэх болсон. Магадгүй ирээдүйд энэ хандлага өөрчлөгдөх байх аа.

**-Монгол Улсын мэдээллийн технологи, интернэтийн хөгжлийг та өдгөө хэрхэн дүгнэж байна вэ?**

-Мэдээллийн технологийн талаар миний бодол тийм ч сайн биш байгаа. Адаглаад цахим хуудас руу ороход тэнд ердөө л сонины хуулбар байх. Уг нь интернэт нь задгай далай юм. Чи юу ч хийж болно. Өөрийн дураар. Сонинг аваад үзэхэд хэдийгээр мэдээллийг чөлөөтэй нийтэлдэг ч Эрхлэгчийнхээ зөвшөөрөлгүй ямар нэг мэдээ нийтлэх эрх сэтгүүлчид байхгүй. Энэ нь нэг талаараа хувьчлагдчихсан орон зай гэсэн үг. Харин интернэт бол өөр. Манайхан энэ талаар сайн мэдэхгүй байх шиг. Интернэтийг зүгээр л сонинг цахим хэлбэрээр унших хэрэгсэл гэж ойлгоод байна. Яваандаа энэ байдал өөрчлөгдөх болов уу.

Дээрээс нь бид уншихыг хүсдэг ч бичдэггүй. Энэ нь нэг талаар бидний соёлтой холбоотой. Манай ард түмэн аман соёл ихтэй харин бичгийн соёл бага. Би хувьдаа блог хөтөлдөг. Учир нь би интернэтийг хэлбэр бус мөн чанар гэж боддог учраас тэр. Би тэнд өөрийнхөөрөө байж, өөрийнхөө үргэлжлэлийг тэнд үлдээж чаддаг. Хэрвээ интернэтийг далайтай зүйрлэх аваас бидний дунд далайчин хүн алга. Далайн эрэг дээр нар өөд саравчлан харж зогсоо хэдэн хүн л байна. Далайчин болохын тулд ядаж нэг модон завинд суугаад далайн ус руу орох хэрэгтэй шүү дээ. ■

2012. 06 САР.



*Н.Энхбаяр. Тэрбээр 1992 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн цагаас Сангийн яаманд 16 жил тасралтгүй ажиллажээ.Тус яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газрын орлогч дарга, Макро эдийн засгийн газрын даргаар ажиллахын зэрэгцээ Олон улсын валютын сангийн тэтгэлгээр Японд Засгийн газрын нийтийн санхүүгийн бодлогын чиглэлээр суралцсан байна. 2008 оноос Ерөнхий сайд асан Сү.Батболдын зөвлөхөөр гурван жил ажиллаад 2011 онд Дэлхийн банкны төв оффист иржээ. Сэтгүүлч миний бие өнгөрсөн долдугаар сард АНУ-ын Вашингтон хотноо ажлаар очих үедээ Н.Энхбаяр зөвлөхтэй уулзаж ярилцсан юм. Дэлхийн банкны төв оффист өрнөсөн ярилцлагаа уншигч танаа хүргэж байна.*

# Н.Энхбаяр: Уналтыг сааруулж буй салбарыг бодлогоор дэмжих ёстой

**-Та Дэлхийн банкны төв оффист ямар алба хашиж байна вэ?**

-Дэлхийн банкны Гүйцэтгэх захирлын зөвлөхөөр ажилладаг. Дэлхийн банкны бүрэлдэхүүнд Олон улсын хөгжлийн агентлаг, Олон улсын хөрөнгө оруулалт, хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Олон талын батлан даалтын байгууллагууд (IDA, IBRD, IFC, MIGA) байдаг. Тус банкны гишүүн 180 гаруй орныг төлөөлсөн 25 захирлаас Гүйцэтгэх захирлуудын зөвлөл бүрддэг. Дэлхийн банкны, нөгөө нь Олон улсын санхүүгийн корпорацийн гэсэн хоёр төрлийн Зөвлөлийн хурал болдог. Эдгээр захирлын зөвлөл долоо хоног бүрийн гурван өдөр байнга хуралдаж, улс орнуудад хэрэгжүүлж буй хөгжлийн бодлого хөтөлбөр, Дэлхийн банкны баримталдаг стратегийг хэлэлцэж баталдаг. Монгол улсын хувьд 23 дахь жилдээ гишүүний үүргээ гүйцэтгэж явж байна. Энэ жил Дэлхийн банк анхлан үүсэн байгуулагдсаны 70 жилийн ой тохиож байгаа юм. Энэ хугацаанд ядуу буурай олон улс орнуудыг хөгжлийн шинэ шатанд гаргахад туслалцаа үзүүлсэн байна. Хөрөнгө мөнгөнөөс гадна бодлогын туслалцаа өөрөөр хэлбэл, хөгжлийн зөв арга зам, бусад орны туршлага, мэдлэг солилцуулахад түлхүү анхаарч ирсэн гэж ойлгож болно.

Австрали, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Камбож болон Номхон далайн арлуудын 14 улсын төлөөлөл нийлж, нэг бүлэг газар болж ажилладаг. Энэ бүлэгт Монгол Улс багтаж байгаа. Газар зүйн байршлын хувьд алс хол байгаа ч хөгжлийн олон талын төстэй байдлаараа хуваагдсан байдаг. Энэ бүлэгт хөгжлийн өнөөгийн түвшний хувьд манай улстай ойролцоо болон өндөр хөгжилтэй улсууд ч бий. Манай бүлэг газарт Гүйцэтгэх захиралд зөвлөгөө өгөх 7-8 зөвлөх ажилладаг. Миний бие 2011 оноос хойш Захирлын зөвлөхөөр ажиллаж байгаа бөгөөд удахгүй гэрээт хугацаа дуусна.

**-Гүйцэтгэх захирлын зөвлөх албанд нэлээд өндөр шалгууруар очсон уу?**

-Дэлхийн банкны үйл ажиллагааны цар хүрээ маш өргөн. Вашингтоны төв оффис нь \ОУХОХБ, ОУХА, ОУСК зэрэг байгууллагын дүнгээр\ таван мянга гаруй ажилтантай. Үндсэн ажилтнаа олон нийтэд ил тод зарлаад өрсөлдүүлэх замаар сонгон шалгаруулж авдаг. Гүйцэтгэх захирлын зөвлөхийг тухайн улс орноос нь санал болгосноор, гэхдээ голдуу Сангийн яам, Төв банкны ажилтнуудаас сонгодог юм билээ. Тухайн улсын Засгийн газар өөрийн хүнээ санал болгодог гэсэн үг. Түүнийг нь Дэлхийн банкны холбогдох захиргааны газар нь нягталж, туршлага, мэдлэг бусад ур чадварыг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. Хамгийн гол нь ажилласан туршлагыг ихэд хардаг. Учир нь дэлхийн улс орнуудын бүхий л асуудлыг Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцдэг тул санал дүгнэлт өгөх хэмжээний, олон талын туршлагатай хүн байвал давуу талтай.

**-Энэ хугацаанд Дэлхийн банкнаас манай улсад хандах хандлага ямар байсан бэ. Та хэр туршлага, мэдлэг хуримтлуулж авав?**

-Сүүлийн жилүүдэд Олон улсын санхүүгийн корпорацийн үйл ажиллагаа Монголд нэлээд өргөжиж байна. Тус корпорациас 100-гаад сая ам.долларын санхүүжилтийг

шийдвэрлэсэн байгаа. Голдуу хувийн хэвшилд, тухайлбал, банк, санхүү, барилга угсралт, дэд бүтэц, зочид буудал, худалдааны салбарт хөрөнгө оруулалт хийжээ. Дэлхийн банк түлхүү нийгмийн хөгжлийн чиглэлд ядуурал, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин гэх мэт чиглэлээр техникийн туслалцаа, хөнгөлөлттэй зээл олгож хамтран ажилладаг.

Өнгөрсөн хугацаанд гарсан томоохон өөрчлөлт бол Монгол Улс 2012 оноос өмнө Дэлхийн банкны өөрийн ангиллаар бага орлоготой орны тоонд багтаж, зөвхөн хөгжлийн туслалцаа авч байсан. Олон улсын хөгжлийн ассоциациас урт хугацааны буюу 25-38 жилийн хугацаатай, эхний 10 жилдээ үндсэн зээлийг төлөхгүй байх, маш бага хүүтэй хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж ирсэн. Харин 2012 оны долоодугаар сард Дэлхийн банкны шинэ ангиллаар манай улс дунд орлоготой орны түвшинд \ дунд орлоготой орны доод шатлалд\ багтсан. Иймд ангилалд багтангуут арилжааны зээл авах боломж шууд нээгдэхгүй.

Монгол Улс зах зээлийн хүү, нөхцөл бүхий арилжааны зээл авах, түүнийгээ эргэн төлөх чадамж бүхий орон болж байна. Энэ шилжилт нэг жилд бус 3-4 жилд аажмаар өөрчлөгдөж, улмаар хөгжлийн албан ёсны тусламжийг цаашид авах шаардлагагүй болно гэсэн үг.

Одоогоор Монгол улс зээл авах боломжийн хувьд холимог гэсэн ангилалд багтаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улс нэг талаар хөгжлийн албан ёсны туслалцаа авах боломж нээлттэй хэвээр байгаагийн зэрэгцээ анх удаа арилжааны нөхцөл бүрдлээ. Тухайлбал, зөвхөн техникийн туслалцаа биш, тодорхой томоохон төсөл дээр арилжааны зээлийг арай богино хугацаатай 15-20 жилээр ч юм уу авах нөхцөл бүрдэж байна. Энэ нь арилжааны зээл бөгөөд хүүний хувьд олон төрлийн нөхцөлтэй, тухайн үеийн зах зээлийн өгөгдлөөс хамаарч дунджаар “ЛИБОР + 0.6-1.35%” (LIBOR+0.6-1.3%) аргачлалаар тооцогдох хүүтэй зээл юм.

Зээлийг эргэн төлөх хугацааны хувьд урт, баталгаа, барьцаа шаардагдахгүй учраас улс орнуудын хувьд хөгжлийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд тун чухал санхүүгийн эх үүсвэр гэж үздэг. Энэ нь манайх шиг хөгжлийн тулгамдсан асуудал ихтэй улс оронд маш том боломж, санхүүгийн нэг чухал эх үүсвэр юм.

**-Манай төр, засгийн удирдлагууд гаднаас их л зээл авч байна. Тэдэнд таатай л боломж байх?**

-Дээрх ангилалд саяхан багтаж байгаа учраас зээлжих эрх одоо л нээгдэж байгаа. Зээлжих эрх нээгдэхийн тулд Дэлхийн банк 3-5 жилд явуулах хамтын ажиллагааны стратегийг эхлээд баталдаг. Манайх энэ бичиг баримтыг 2013 онд Захирлуудын зөвлөлийн хурлаар оруулж, шинэчлэн батлуулсан. Энэ үеэр Дэлхийн банкнаас Монгол Улстай 2017 он хүртэлх хугацаанд хамтран ажиллах үндсэн чиглэлүүдийг баталсан байгаа. Энэ чиглэлүүдээ хэрэгжүүлэх ажил нь эхэлж байна. Дэлхийн банкны санхүүгийн жил нь хуанлийн жилтэйгээ давхарддагүй. Зургаан сарын 30-нд дуусаад долдугаар сард дараагийн санхүүгийн жил нь эхэлдэг. Дэлхийн банкны 2015 оны санхүүгийн жил нь 2014 оны долдугаар сарын 1-нд эхэлсэн. Тэгэхээр Монгол Улс Дэлхийн банкнаас арилжааны чанартай зээл авах чадамжтай болж байна гэсэн үг. Гэхдээ төслөө сонгох хэлэлцэх, үндсэн бичиг баримт бэлтгэх, батлуулах зэрэг ажилд багагүй цаг хугацаа шаардагдана.

Мөн энд хэд хэдэн асуудал бий. Тухайлбал, зээлдэгч улс орнууд зээлийн хязгаартай. Жишээ нь, 100 тэрбум ам.долларын ДНБ-тэй улсад нэг өөр, 10 тэрбумаар хязгаарлагддаг ДНБ-тэй улсад нэг өөр. Дэлхийн банк дотоод дүрмээрээ гишүүн орнуудынхаа оруулсан хөрөнгийн эзлэх хэмжээгээр нь хувийг тогтоосон байдаг. Манай улс бусад улс оронтой харьцуулахад ДНБ-ий хэмжээгээр харьцангуй бага, 10 гаруй тэрбум ам.долларт хүрч байгаа. Энэ хэмжээнээс хамаараад Монгол улсад ногдох зээлийн эрх, хуваарилалт нь 0.03 хувь байдаг. Хөгжлийн ижил түвшинтэй бусад улстай нэгэн адил түвшинд гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тухайн нэг жилд авах зээлийн хэмжээ нь дээрх зээлийн шугамаас хэтрэх ёсгүй.

**-Хэдий хэмжээний зээл авах боломжтой бол, манай улс?**

-Энэ хэмжээг тоогоор шууд хэлэхэд амаргүй, энэ бол жил бүр өөрчлөгдөн тогтоогддог үзүүлэлт. Дэлхийн банк санхүүгийн жилдээ төсвийн хөрөнгийг гурван жилээр тооцоод ирэх жил хандивлагчдаас ийм хэмжээний хөрөнгө босгох боломжтой гэсэн тодорхой мөнгөн дүнг тооцож гаргадаг. Тэр босгосон эх үүсвэрээс дээр дурьдсан квотоор бүс нутаг, улс орнуудад мөнгө хуваарилдаг. Олон улсын хөгжлийн ассоциациас манай улсын авах боломжтой зээлийн хязгаар одоогоор 30 орчим сая ам.доллар байгаа.

**-Дэлхийн банк бусад оронд зээл тусламж өгч буйн үндсэн зорилго нь юу вэ?**

-Ядуурлыг бууруулах нь энэ банкны үндсэн зорилго. “World free of poverty” буюу ядууралгүй дэлхий гэсэн үндсэн зорилгын төлөө ажилладаг. Ажилгүйдэл, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, хот байгуулалт, ногоон хөгжил зэрэг хөгжлийн бүхий л асуудал энд багтдаг. Аливаа хөтөлбөр хэрэгжсэнээр тухайн улсын ажилгүйдэл, ядуурал хэчнээн хувиар буурах боломжтой вэ, дэд бүтцийн хөгжилд нь хэр өөрчлөлт гарах уу зэрэг 10 гаруй шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг. Шалгуур үзүүлэлтээ жил бүр өөрчилдөг. Дэлхийн банкны мөнгө бол хөрөнгө оруулагчдаас бүрдүүлсэн эх үүсвэр учраас хөрөнгө оруулагчдын дуу хоолой шийдвэрлэх үүрэгтэй.

**-Дэлхийн банкийг нэлээд шүүмжилдэг л дээ. Америкийн бодлогыг хэрэгжүүлэгч гэх мэтээр. Азийн хөгжлийн банкийг Японых гээд л.**

-Оруулсан хөрөнгө оруулалтаасаа шалтгаалдаг. Дэлхийн банкинд Америк, Европын орнууд илүү хөрөнгө оруулсан. Азийн хөгжлийн банк бол бүс нутгийнх. Хөгжлийн банктай улс орон олон бий. Бүс нутгийн банк дотор ч давамгай хөрөнгө оруулсан улс орны банк байгаа. Азийн хөгжлийн банкны хувьд Япон улс гол хөрөнгө оруулагч нь юм. Нэгдүгээрт, оруулсан хөрөнгө мөнгө, хоёрдугаарт, тухайн банкны удирдлагыг томилоход давуу хөрөнгө оруулсан улс нь түлхүү дуу хоолойгоо оруулдагтай холбоотой. Жишээлбэл, Олон улсын валютын сангийн захирлыг томилоход гол

төлөв Европын орнуудаас сонгодог.

**-Дэлхийн банкинд Америк 17 хувь эзэмшдэг гэдэг?**

-Энэ хувь байнга өөрчлөгддөг. Хамгийн суулд 2010 онд жилийн уулзалт болсон. Хөгжингүй орнуудын дуу хоолой давуу байна гэсэн шүүмжлэлийг тус уулзалтаар ярилцаад хөгжиж буй орнуудын хувь оролцоог нэмэгдүүлж өөрчилсөн. Уг шийдвэрийн дагуу 30 гаруй орон дүрмийн сангаа шинэчлэн нэмэгдүүлсэн. Тэгэхээр аажимдаа хөгжиж буй орнуудын эзлэх хувийн жин, дуу хоолой сайн сонсогдож эхлэх байх аа.

**-Одоо хоёулаа улс орны макро эдийн засгийн талаар ярилцъя. Учир нь таныг макро эдийн засгаар мэргэшсэн мэргэжилтэн гэж хэлж болно. Сангийн яаманд Макро эдийн засгийн газрыг хариуцан ажиллаж байсан. Одоо танай газрыг буулгасан байгаа. Бусад улсад Макро эдийн засгийн стратегийн төлөвлөгөө боловсруулдаг тусгай газар, хэлтэс байдаг юм байна. Та юу гэж үзэж байна вэ?**

-Аль ч улс оронд хөгжлийн асуудлуудаа зөв бодлогоор судалж шийдвэрлэхийн тулд Макро эдийн засгийн стратегийн газар байх ёстой. Тухайн үед бид шилжилтийн эдийн засагтай байсан учраас жижиг эдийн засгийн хэт деталчилсан төлөвлөгөөтэй явж ирсэн. Төвлөрсөн төлөвлөлтөөс зах зээлийн эдийн засагт шилжсэн болохоор макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн ач холбогдол, үүргийг одоо ч манайхан сайн ойлгоогүй л байна. Хөгжлийн томоохон зорилтоо хэрэгжүүлэх арга зам нь макро эдийн засагтай зайлшгүй холбогддог. Улс орны эдийн засаг нь аливаа аж ахуйн нэгжийн түвшний асуудал биш. Олдсон хэдэн төгрөгөө аль өөрт таалагдсан дуртай зүйл рүүгээ хийгээд л хөгжинө гэж ойлгох ёсгүй. Хамгийн наад зах нь хөрөнгө оруулалтаа хэрхэн сонгох, ач холбогдолыг нь тогтоох, нийгэм, эдийн засгийн харилцан хамаарал, үр ашигтайгаар нь дараалуулах гэх мэт макро эдийн засгийн бодлого зайлшгүй хэрэгтэй. Тухайлбал, хөрөнгө оруулагч Монголд хөрөнгө оруулах, мөн эсвэл буцааж гаргах нь эерэг болон сөрөг үр дагавартай. Бид үүний эерэг, сөрөг талыг сүүлийн жилүүдэд нэлээд сайн мэдэрч байна.

**-Эндээс ямар сургамж авч ажиллах ёстой гэж та бодож байна вэ?**

-Гадаадын хөрөнгө оруулалт орж гарч байгаа урсгал өөрөө цаашид эдийн засгийн олон салбарт нөлөөлдөг. Валютын ханш, валютын зах зээл, цаашлаад уул уурхай дагасан олон ажлын байр бий болгож байна, нөгөө талаар хөрөнгө оруулалт гарахад нь олон ажлын байр байхгүй болж байна. Тэгэхээр аль нэг талын эдийн засаг биш цаад гинжин холбоосуудыг харж, цаашид авч хэрэгжүүлэх бодлоготойгоо зөв уялдуулахад макро эдийн засгийн бодлого үндсэн арга хэрэгсэл нь болдог.

2012 оноос өмнө Сангийн яамны Макро эдийн засгийн бодлогыг газар 5-8 мэргэжилтэнтэй, макро эдийн засгийн бодлого дээр 4-5 хүн ажиллаж байсан. Энэ нь бүхэл бүтэн улсын хувьд дунд хугацааны бодлого боловсруулахад хангалттай тоо биш. Бид урт хугацааны эдийн засгийн бодлого боловсруулах гэж оролдож байсан. Тухайн үеийн Засгийн газрын санаачлагаар Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан үндэсний хөгжлийн цогц бодлогыг боловсруулсан. Мэдээж энэ бодлого дээр нэмж хасах, сайжруулах зүйл зөндөө бий. Гэхдээ энэ бол урт хугацааны бодлого зайлшгүй хэрэгтэй гэдэг тодорхой ойлголтод хүрсэн маш сайхан жишээ. Энэ бодлогыг цааш нь үргэлжлүүлээд, сайжруулаад аваад явах хэрэгтэй байсан гэдгийг одоо олон хүн хэлдэг. Хөгжлийн бодлого төлөвлөлт хэрэгтэй, энэ тухай хуультай болъё гэж ярьж байна. Бид хөгжлийн бодлогынхоо ач холбогдлыг ойр ойрхон алдсанаас болж их алдагдалд хүрч байна. Урт хугацааны бодлогоо тууштай авч явах нь маш чухал юм.

**-Дэлхийн банкны төвөөс эх орондоо нүүрлээд буй эдийн засгийн хүндрэлийг та хэрхэн харж байна вэ?**

-Түүхий эдийн экспортоос хэт хамааралтай манай улсын хувьд гадаад зах зээлийн нөхцөл байдал шууд хамааралтай. Эдийн засаг, үйлдвэрлэл хөгжөөгүй, уул уурхайн салбар нэг хэсэгтээ давамгайлсан улс гадаад зах зээлээс олон талаар хамааралтай. Яг одоогийн байдлаар гадаад зах зээл дээр түүхий эдийн үнэ бууралттай хэвээр. Олон улсын судлаачдын хэлж буйгаар ойрын хоёр гурван жилд гол нэр төрлийн металуудын үнэ өсөх хандлагагүй гэж таамаглаж байгаа нь манай эдийн засагт төдийлөн таатай үр дүн авчрахгүй. Бид зарим нэг түүхий эдийн гэнэтийн өсөлтөд их баярлах, хөөрөх хэрэггүй. Харин хөрш орнуудтай хийж байгаа гадаад худалдааны зөв бодлогодоо түлхүү анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл гадаад худалдаанаас л бид валют, гадаад урсгалаа олж байгаа. Хамгийн зөв бодлого бол урт хугацаандаа эдийн засгаа төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай. Төрөлжилт нь байшингийн хэлбэрийг өөрчлөх төдий асуудал биш учраас нэг, хоёр жилд бус, урт хугацаанд хийх асуудал. Нөгөө талаар хүмүүсийн ойлголтыг өөрчилнө. Урт хугацааны хөгжлийн болон макро эдийн засгийн бодлоготой байх нь хамгийн эхний зорилт гэдгийг дахин хэлмээр байна. Мөн гадаад зах зээлээс гадна дотоодын байдлаас эдийн засаг хүндэрсэн гэж үзэж буй хүмүүстэй санал нэг байна.

Өмнөх засгийн алдааг засаж, бодлогоо зөв болгоод цэгцлээд явах. Ялангуяа эдийн засгийн бодлого барьж байгаа хүмүүс юуны түрүүнд бодит байдалд зөв дүгнэлт өгөх ёстой. Бидний боломж юу вэ, баримталж буй бодлогыхоо юуг нь засах ёстой вэ гэдгээ ойлгох хэрэгтэй. Энэ тал дээр олон улсын байгууллагууд манайд удаа дараа зөвлөмж өгч байгаа. Ялангуяа төсөв дээр тууштай бодлого баримтал, төсвөөс гадуур бүртгэж, үрэлгэн зарцуулалгүй аль болох тэргүүлэх ач холбогдолтой салбартаа хөрөнгө оруулалт хий гэдгийг олон улсын байгууллагууд байнга хэлж, зөвлөж ирсэн. Бодлогын хувьд өөрсдөөс хамаарах асуудал их бий. Мөн боловсон хүчний чадавх. Төрөөс цөөн тооны боловсон хүчиндээ маш болгоомжтой хандаж тогтвортой, тууштай ажиллуулж, улам цааш нь дадлагажуулж мэргэшүүлж ажиллаасай. Гэтэл улс төрийн өнцгөөр хараад боловсон хүчнээ солих нь өөрөө улс орны хөгжилд маш их сөргөөр нөлөөлж байгаа нь харагдаж байна.

*Эрхэмсэг бүсгүй таны шинэ жилийн гоёл*




*Swarovski boutique # 1 Наран Плаза, 4-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29, Утас: 70116918*
*Swarovski boutique # 2 Сентрал Тауэр, 2-р давхар, Сүхбаатарын талбай*
*Swarovski Crystal Forest boutique Наран Молл, 1-р давхар, Сөүлийн гудамж-42/1, Утас: 70136918*

**-Эдийн засгаа сайжруулах өөр ямар боломж байна вэ?**

-Эдийн засаг сайжрах гэдгийг тоо болон чанарын хувьд ярих ёстой. Тоон үзүүлэлтийг нэг, хоёр жилийн дараа гаргаж болох байх л даа. Чанарын хувьд бид алдаатай бодлогоо өөрчилж чадсан уу үгүй юу гэдэг хамгийн чухал. Жишээлбэл, алдагдалтай төсөв нэг, хоёр жилийн дараа алдагдалгүй болж болно. Энэ бол тоон үзүүлэлт. Гэхдээ цаана нь буй үрэлгэн зардал үнэхээр багасаж чадсан уу,төсвийн орон тоог тэлээд байгаа хууль тогтоомжууд хэвээрээ байна уу, үгүй юу. Энэ хамгийн чухал. Гадаад худалдааны алдагдал ч нөлөөлнө. Түр зуурын тоон үзүүлэлтэд хууртах хэрэггүй. Нэгэнт л бид дунд болон урт хугацааны тогтвортой тоон үзүүлэлтийн тухай ярьж байгаа бол илүү тогтвортой, чанартай өөрчлөлт болгох талд анхаарах ёстой.

Сүүлийн үеийн судалгааны бичиг баримтуудад хоёрдмол алдагдлын тухай ярьж байна. Төсөв, гадаад худалдаа нь алдагдалтай байгаа тохиолдолд мөнгөний бодлого тун хүнд байгаа. Валютын ханш чангарахаас өөр арга байхгүй. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. Уул уурхайн салбар өсөх үед мөнгө олж, хуримтлуулж болж байна. Харин унахад хуримталсан мөнгө байхгүй байна. Тэгэхээр манай эдийн засгийн ямар салбар өсөлтийг, ямар салбар тэнцвэрийг бий болгож буйг харах хэрэгтэй. Бид зарим салбараа мартчихаад яваад байна. Улс орны бодлого л юм бол бүгдээрээ нэг тийшээ харчихаад уул уурхай, дэд бүтэц гээд ташуураад байж боломгүй.

Ялангуяа эдийн засаг ийм саармаг байгаа үед дараагийн ажлын байрыг хадгалах салбараа дэмжиж байх ёстой. Жишээлбэл хөдөө аж ахуй. Эдийн засгийн ямар ч хямралын үед эдийн засгийг барьж тогтоож чаддаг, хүн амыг хүнд байдалд, хоол хүнсний дутагдалд орохоос хамгаалах хамгийн гол, тулгуур салбар бол хөдөө аж ахуй. Иргэдийн энэ тэргүүний хэрэгцээ болсон хүнсний хангамжийг нийлүүлж буй энэ салбар уналтад орвол юу болох вэ. Зөвхөн уул уурхай гэж хошуурахаасаа илүү уналтыг барьж байгаа суурь салбараа маш сайн дэмжиж, алсыг харсан бодлогоор хөгжүүлэх, тогтвортой хөрөнгө оруулалт хийдэг байх ёстой.

**-Олон улсын валютын сангийн хүмүүс Монголд очиж, манай төр засгийн удирдлагуудтай уулзаж, эдийн засгийн бодлогоо эргэж харах зөвлөмж өгсөн?**

-Саяхан Олон улсын валютын сан Дэлхийн банкинд Монгол Улсын гадаад өрийн талаар судалгаа өгсөн байсан. Жил бүр хийдэг өрийн тогтвортой байдлын судалгаагаар манай улсын макро эдийн засгийн бодлогын гол гол үзүүлэлтүүдийг гаргасан байгаа. Мөнгөний бодлогоос гадна Монголын өр санаа зовоосон асуудал боллоо. Эдийн засгийн бодлогуудын үр дүн таагүй гараад нэлээд хугацаа өнгөрчихлөө. Олон улсын судалгааны байгууллагууд манайд зөвлөгөө зөвлөмж өгснөөс хойш мөн л багагүй хугацаа авлаа. Гэтэл өнөөдөр асуудал намжаагүй байна гэдэг нь цаашид байдал улам л хүнд болно гэсэн үг. Тэгэхээр өнгөрсөн хоёр жилд явуулсан макро эдийн засгийн бодлогоо зайлшгүй эргэж харахгүй бол илүү уналтад хүрч магадгүй гэдгийг л Олон улсын валютын сангаас удаа дараа анхааруулсаар байна.

**-Та эдийн засгаар мэргэшиж яваа залууст хандаж зөвөлгөө өгнө үү?**

-Хувийн хэвшил, төрийн байгууллагуудад ажиллаж буй манай залуучууд ажлын байран дээрээ боловсрол, мэдлэгээ алхам тутамдаа дээшлүүлэх хэрэгтэй. Боловсролоо дээшлүүлнэ гэдэг нь зөвхөн онолын сурах бичиг унших, танхимд сууж сурах гэсэн үг биш л дээ. Нэгдүгээрт, гадаад хэлийг маш сайн сур, тэр дундаа мэргэжлийн гадаад хэлийг гүнзгийрүүлэн үзэж, бусад улс орны туршлагыг байнга уншиж судалж байх ёстой. Мөн улс орны тухайн цаг үеийн мэдээллийг уншиж судлаад өөрөө дүгнэлт хийдэг байх. Хэн нэгэн судлаачийн боловсруулсныг, дүгнэлт хийчихсэн бэлэн зүйлийг унших нь мэргэжлийн хүнд төдийлөн мэдлэг нэмэхгүй. Оюутнуудад бол бусдын гаргасан дүгнэлт, судалгаа маш их хэрэгтэй. Хятадын эдийн засгийн өсөлт яагаад саарч байна, Европын өрийн асуудал яагаад хүндэрсэн, Оросын эдийн засаг яагаад удаашралтай байна гэдэг дээр өөрийн хариултыг олох ёстой. Чиний хайж олсон хариулт чинь нэр хүнд бүхий олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас гаргаж буй судалгаа, дүгнэлттэй ойролцоо буюу нийлж байвал мэдлэг, туршлага чинь сайжирч байна гэсэн үг. Ингэж л өөрийгөө боловсруулах хэрэгтэй. Ялангуяа төрийн байгууллагынхан ийм чадварт суралцаж, шинийг байнга эрэлхийлэх нь залуучуудыг хөгжүүлнэ.

Өнгөрсөн хоёр жилд явуулсан макро эдийн засгийн бодлогоо зайлшгүй эргэж харахгүй бол илүү уналтад хүрч магадгүй гэдгийг л Олон улсын валютын сангаас удаа дараа анхааруулсаар байна.

Манай эдийн засгийн ямар салбар өсөлтийг, ямар салбар тэнцвэрийг бий болгож буйг харах хэрэгтэй. Бид зарим салбараа мартчихаад яваад байна. Улс орны бодлого л юм бол бид бүгдээрээ нэг тийшээ харчихаад уул уурхай, дэд бүтэц гээд ташуураад байж боломгүй.

Шинэ Зеланд, Камбож болон Номхон далайн арлуудын 14 улсын төлөөлөл нийлж, нэг бүлэг газар болж ажилладаг. Энэ бүлэгт Монгол Улс багтсан. ■

2014 ОНЫ 9 САР.



*Сингапур дахь Монголын Элчин сайд Б.Дэлгэрмаатай ярилцлаа. Тус улсад жилдээ 14 сая жуулчин ирдэг статистик бий. Мөн Азийн бар болсон тус орны хөгжлийн нууц юунд байна вэ. Монголын Элчин Сингапурт ажиллаж амьдарч буйн хувьд хөгжлийн нууцыг хэрхэн харж байна вэ. Сингапурын төв дэх тэнгэр баганадсан барилгын 24 дүгээр давхарт байрлах Монголын ЭСЯ-ны байранд бидний ярилцлага өрнөсөн юм.*

# Б.Дэлгэрмаа: Сингапурын сайн туршлагуудыг нэвтрүүлмээр байна

**-Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сингапур улсад томоохон хэмжээний айлчлал хийсэн. Айлчлалын үр дүнг Элчин сайдын хувьд Та хэрхэн харж байна вэ?**

-2001 онд хийсэн Ерөнхийлөгч Н.Багабандийн айлчиллаас хойш 12 жилийн дараа болсон өндөр ач холбогдолтой айлчлал юм. Хоёр орны төрийн дээд хэмжээний айлчлалын давтамж ойр байх тусам харилцаа сайжирч, үр дүн гардаг. Сингапур улстай 1970 онд дипломат харилцаа тогтоосон ч Сингапурын талаас манай улсад төрийн өндөр түвшний айлчлал хийгээгүй байгаа. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сингапурт айлчлахаасаа өмнө ухаалаг төрийн асуудлыг хөндөж, бодлогоо тодорхойлж ирсэн нь чухал ач холбогдолтой байлаа. Сингапур нь ухаалаг төрийн системээр тэргүүлэгч бодлоготой, үлгэр жишээ төдийгүй бүс нутагтаа, АСЕАН-ы орон дундаа зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг, мэдээлэл технологи, эдийн засаг, батлан хамгаалах, банк санхүүгийн төв болсон орон. Монголтой адил төстэй зүйлүүд бий. Том улсуудын дунд оршсон жижиг газар нутагтай учраас үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хөгжилд гарц олсон улс. Бидний хувьд сурах, үлгэр жишээ авах их зүйлтэй орон юм.

Монголын хөрөнгө оруулалтын орчин 2012 оноос буурч, нэр хүнд унасан энэ үед Ерөнхийлөгч айлчилснаар олон асуултыг хариуг сингапурчуудад өгч чадсан.

Бизнесийн форумд хэлсэн үгээрээ Ерөнхийлөгч маань хөрөнгө оруулагчдын эргэлзээг тайлсан гэж үзэж байна. Тус айлчлалын зорилго Сингапурт Монголын хөрөнгө оруулалтын орчны талаар сурталчлан таниулахад чиглэж байсан. Дүгнээд хэлбэл, Монголд хөрөнгө оруулахаас бүү ай. Таны оруулсан хөрөнгө оруулалт хэд дахин өснө. Монгол асар их баялагтай. Төр нь тогтвортой, хүчтэй, амласнаа биелүүлдэг. Хөрөнгө оруулалтын баталгаа нь Монгол Улсын төр өөрөө гэсэн утгатай эерэг мэссэжийг өгсөнд нь Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн айлчлалын гол үр дүн юм. Ийм том мэдэгдэл хийх болсон шалтгаан нь Сингапур хоёр том гүрний дунд оршдог улс. Тэгвэл Монгол их гүрнүүдийн дундах далайд гарцгүй орон. Манай улс бүс нутгийн интеграчлалын бодлогод орж чадахгүй байна. Бүс нутгийн худалдааны бодлогод орж байж л уул уурхайн бүтээгдэхүүнийг сайн үнээр борлуулж чадна. Орос, Хятадын хамаарлыг багасгах болно. Үүний тулд төр нь ухаалаг байх ёстой.

**-Айлчлалын хүрээнд зарим нэг бодитой асуудлыг шийдвэрлэсэн. Тухайлбал, Сингапур хороолол, шууд нислэг гэх мэт?**

-Сингапур нь тав таван жилийн төлөвлөгөөтэйгээр улсаа хөгжүүлж ирсэн онцлогтой. 60-аад оноос бүх иргэнээ орон сууцжуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Орон сууцны хөгжлийн зөвлөл гэж байдаг. Орон сууцжуулах хөтөлбөр нь хэдэн байшин барилга босгох тухай ярьдаггүй. Бүхэл бүтэн хот төлөвлөлтийн асуудлыг цогцоор нь тусгаж, хэрэгжүүлснээр иргэдийн тайван, тохьтой ажиллаж амьдрах орчныг бий болгосон хорооллууд босч ирдэг. Энэ чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан улс. Тухайлбал, Сингапураас Дубай хотын ерөнхий төлөвлөгөөг гаргасаар өнөөдөр тус хотын

метро, машины түгжрэлийн асуудлыг цэгцэлсэн. Тэгэхээр Сингапур хорооллыг Улаанбаатарт барихаар тохирсон нь онцлогтой. Хэдийгээр халуун бүсийн улс ч гэлээ байшин барилгыг дан барилга гэж харахгүйгээр цогц дэд бүтэцтэйгээр шийдэж байгаа нь манай төрийн түшээдэд нэгийг бодогдуулсан болов уу.

Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл болон албаны бусад төлөөлөл орон сууцны хөтөлбөртэй уялдсан хот төлөвлөлт, хог хаягдал, метро болон ус цэвэршүүлэх станцын үйл ажиллагаатай танилцсан. Сингапур нь дэлхий дээрх усны нөөцгүй ганц орон. Малайзаас усаар 100 хувь хамааралтай бөгөөд энэхүү хамаарлаа өнөөдөр 80 хувьтай арилгаж чадсан. Борооны усны нөөц бий болгох, саарал усыг ашиглах зэрэг бодлогыг хэрэгжүүлэхээс гадна далайн усыг цэвэршүүлэх станцыг ашиглалтад оруулаа. Далайн шорвог усыг цэвэршүүлж, ундны усны хэрэглээнд хүртэл ашиглана гэдэг бол технологийн, шийдлийн гайхамшиг юм. Хөгжлийн ийм гарц, шийдлүүд манай албаны хүмүүс сонирхлоо. Уул уурхай ашиглалтад орж байгаатай холбоотой усны хэрэгцээ манайд ихэсч байна. Усыг ариг гамтай хэрэглэх, хэрэглэсэн усаа эргүүлж ашиглах, усны нөөцийг бий болгох, саарал усны туршлагыг нэвтрүүлэхэд анхаарал хандуулж, бодлогоо чиглүүлэхэд энэ орны арвин туршлага хэрэгтэй.

**-Шууд нислэгийн талаар юу хэлэх вэ?**

-Миний бие 2012 оны хоёрдугаар сард итгэмжлэх жуух бичгээ барьснаас хойш хоёр орны хоорондох шууд нислэгийн асуудлыг холбогдох хүмүүсийн түвшинд багагүй ярьж ирсэн. Энэ асуудал удахгүй шийдэгдэх байх аа. Сингапурт манай иргэд аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их ирж байна. Мөн шууд нислэг нь Бээжин, Хонгконгоор дамжин Монголд очиж буй хүмүүсийн цаг завыг хэмнэнэ. Дэлхийн хоёр дахь том онгоцны буудал шүү дээ. Монголын хувьд аялал жуулчлалын том чиглэл. Сингапурчуудыг дэлхийн хоёр дахь том генерацигэж хэлье. Хэтэвч зузаан иргэдтэй баян орон. Сингапурт жилдээ 14 сая жуулчид ирж байна. Яг үнэндээ Сингапурт үзэх үзвэр ховор шүү дээ. Гэтэл яагаад энэ улс руу хүмүүсийн урсгал хошуураад байна вэ гэдэг нь сонирхол татна. Долоо хоног тутам олон улсын томоохон үзэсгэлэн яармаг болж байна. Австралийн компаниудын төлөөлөгчид Сингапурт ирж хурал зохион байгуулж байна. Энд томоохон хурал хийх хүчин чадал бүхий зочид буудал, хурлын танхимуудтай. Үйлчилгээний чанар, соёл өндөр. Тэгвэл манайд том хэмжээний олон улсын хурал семинар зохион байгуулах хүчин чадалтай зочид буудал, танхимууд байна уу. Үйлчилгээ, хоолны чанар ямар билээ. Ялангуяа үйлчилгээний чанарт шинэчлэл хийх хэрэгтэй гэж бодож байна. Нэг үеэ бодвол уул уурхайтай холбоотой хурлууд манайд хийх болсон шүү дээ. Үйлчилгээ дагаж орлого орж ирнэ гэдэг талаас анхаарч ажиллах шаардлагатай байна.

**-Хэчнээн монгол ажиллаж амьдарч байна вэ, энд?**

-170-180 монгол амьдарч байна. Ихэнхдээ хүүхдүүд нь бага сургуулиудад сурдаг учраас тэднийгээ дагаад эцэг эх нь амьдарч байна. Сингапурын боловсролын чанар маш сайн. Дээр нь зөвхөн англи бус хятад хэл сурах боломжтой. Сургалтын систем нь Британийн системтэй холбогддог учраас Лондон, Австралийн их, дээд сургуульд сурах түвшний дипломтой төгсдөг. Дээр нь сургалтын төлбөр нь харьцангуй хямд. Мөн эмнэлгийн үйлчилгээ авах зорилготой манай иргэдийн хөл тасардаггүй. Сингапураас элэг шилжүүлэх нарийн мэргэжлийн баг Монголд очиж ажиллаж байгаа. Түүнчлэн шүд,гоо сайхан, бөөр гэх мэт өвчний чиглэлээр хамтарсан хөрөнгө оруулалтаар эмнэлэг байгуулах асуудлууд яригдаж байна.

**-Сингапурын хөгжлийн нууцын тухай олонтаа ярьдаг. Таны хувьд юу гэж харж байна вэ?**

-Энэ орон 1965 онд тусгаар тогтнолоо олсноос хойш гурван том зорилт тавьсан. Нэгдүгээрт, бүх нийтээрээ англи хэлтэй байх ёстой. Хүн төрөлхтний хөгжлөөс хоцрохгүй, суралцаж, тэргүүлэх эгнээнд явахын тулд англи хэлээр дамжуулан боловсролд маш их анхаарвал хөгжилд хүрч чадна гэж тодорхойлсон. Энэ нь мэдээж өнөөдрийн хөгжилд хүргэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Хоёрдугаарт, орон сууцжуулах хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлсэн. Иргэн сайхан байранд, сэтгэл хангалуун амьдарвал тухайн хүний хөдөлмөрийн бүтээмж сайжирна гэж үзсэн. Гуравдугаарт, авлигаас ангид байх ёстой. Үүний тулд эрх зүйн орчноо сайжруулж, хуулиа ягштал мөрдсөн. Гудамжинд бохь зажилвал 1000 доллар, түмпэнтэй усаа гадаа хонуулж болохгүй, шумуул үржинэ гэсэн байхад зөрчвөл 1000 доллар, нохойгоо шөнө хуцуулж болохгүй, Аниргүйн тухай хуулиар шөнө дөлөөр нохойгоо хуцуулсан айлд торгууль ногдуулна. Ингэхийн тулд айл нохойгоо шөнө хуцуулдаггүй сургалтад хамруулна, бүр хуцаад байвал нохойных нь улаан хоолойд хагалгаа хийж, хуцдаггүй болгоно. Ийм хатуу чанга эрх зүйн орчноор төгс төгөлдөр төрийг бий болгож чаджээ.

Авлигаас ангид байхын тулд эхлээд шүүгч, төрийн албан хаагчдадаа хангалттай цалин өгсөн. Бизнесийн орчныг хүнд сурталгүй байлгах талд ихэд анхаарч, үүд хаалгаа хөрөнгө оруулагчдад цэлийтэл нээсэн. Манайд хөрөнгө оруулаач, хөрөнгө оруулахад ямар ч асуудалгүй эрх зүйн орчныг бүрдүүлсэн зэргээр хөрөнгө оруулагчдыг тойлж, гүйсний дүнд хэдэн мянган компани, аж ахуйн нэгж, олон улсын 110 банк санхүүгийн байгууллага ажиллаж байна, Сингапурт. Компанийг 30 минутад л бүртгэж, нэг цонхны үйлчилгээг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлсэн улс. Энэ нь Сингапурын төр, засаг ухаалаг, тунгалаг, хариуцлагатай ажилласны үр дүн юм. Мөн тус орны баялаг нь хүн. Хүндээ бүх зүйлээ зориулж, хөрөнгө оруулж боловсрол, эрүүл мэндэд нь анхаарсан бодлого түлхүү явуулж байна. Өнөөдрийн өрсөлдөөнт нийгэмд сингапур иргэн яаж баян цатгалан, тайван, стрессгүй амьдрах вэ гэдэгт л төрийн бодлого нь чиглэдэг учраас улс орон нь хурдацтай хөгжиж, иргэд нь илүү их хөдөлмөрлөх сэтгэлгээтэй болж,

OASiS

# Оффисын цогц шийдэл!




## 8+ ШАГ
Алжаахгүй ажиллана

БСБ Мишээл, Мишээл төв, D-14 павильон
70110441
facebook.com/bsbmebel

*Better Lifestyle*

BSB

тайван сайхан амьдарч байна.

**-Та Сингапурын төрийг ухаалаг, үлгэр жишээ төрийн системтэй гэсэн. Монголын төрийн удирдлага ухаалаг төр рүү шилжих тухай ярьж тодорхой ажлыг эхлүүлээд байна. Сингапурын ухаалаг төрийн бодлогын туршлагаас хуваалцана уу?**

-Мөнгө гаргахгүйгээр ухаалаг төртэй болох хэдхэн жишээг хэлье. Юуны түрүүнд манай төрийн байгууллагуудын ажлын арга барил, менежментийг өөрчлөх хэрэгтэй. Энд олон байгууллагаар орж, ажил хөөцөлдөх, мөн ажил хэргийн холбоо харилцаатай ажиллаад ирэхээр хөнгөн шуурхай, ямар ч хүнд сурталгүй, ажил хэрэгч систем үйлчилж буйг улам бүр мэдэрдэг. Гэтэл Монголын төрийн байгууллага, агентлагууд руу мэйл бичихээр ямар ч хариу өгөхгүй, усанд хаясан чулуу шиг алга болчихдог. Миний хувьд Ерөнхийлөгчийн санаачилгыг бүрэн дэмжиж, Сингапурын хэд хэдэн туршлагыг Монголд нэвтрүүлмээр байна. Үүнд татвар төлөгчдийн мөнгийг зарцуулах шаардлагагүй.

Хамгийн эхний асуудал бол цагийн юмыг цагт нь хийж сурах. Манайд төрийн яамд нь хүнд сурталтай, тухайн асуудлыг шийдэх гэж хэдэн сар болдог, сайдын зөвлөлийн хурлаар оруулна гээд л цаг аваад байх. Сайдынх нь цаг зав гардаггүй ийм л дүр зураг байдаг шүү дээ. Энд бүх зүйл, цаг минутаар хэмжигдэж, бүх зүйлийн зорилго тодорхой байдаг. Сингапурт нэг яамны сайдтай уулзах цаг авахын тулд ямар асуудлаар хэдий хэр хугацаанд зарцуулах, ямар үр дүнд хүрэхээ тов тодорхой бичих ёстой. Монголоос ирж буй хүмүүс ажлын зорилгоо зөв тодорхойлоход суралцмаар байна.

Өөр нэг асуудал нь төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг бий болгох. Ялангуяа гадаад улс орнуудад суугаа ЭСЯ-тайгаа уялдаа холбоотой ажилламаар байна. Яагаад Чингис хаан биднийг Элч гэж нэрлэсэн юм. Элч бол тагнуулч. Орчин үеийн тагнуулч Элч нар тухайн орныхоо хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулж төв рүүгээ явуулах үүрэгтэй. Гадаад хэргийн яам тэрхүү явуулсан мэдээлэл дээр анализ хийгээд дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ мэдээллийг Эдийн засгийн яам, тэрийг нь Эрчим хүчний яам руу явуул. Монголдоо хэрэгжүүлэх боломжтой мэдээлэл нь энэ байна. Улс орнууд хөрөнгө оруулалтыг ямар салбарт хийж үр дүнд хүрсэн байна, бидний явуулж буй бодлого зөв эсэх дээр Элчингүүдээс авсан мэдээлэл дээрээ тулгуурлан ажиллаж, шийдвэр гаргахдаа ашиглах. Тэгээд ГХЯ дипломат бодлогоороо эргээд салбарын яамдаас саналаа цуглуулж аваад ЭСЯ руугаа явуулж, энэ асуудлуудыг ажил хэрэг болгоход анхаарч ажилла хэмээн чиглүүлж ажиллах ёстой. Гэтэл өнөөдөр ГХЯ мэдээлэл хүлээн авлаа гээд л таг чиг болдог.

Төр нь ухаалаг байвал иргэд нь сайхан амьдарна. Монгол хүн боловсрол руу үеийн үед тэмүүлж ирсэн. Өндөр боловсрол, соёл эзэмшсэн залуусаа алсыг харсан төрийн бодлогоор зөв байршуулж, зөв ашиглаж, ажилуулж чадахгүй, олон улсын байгууллага, хувийн хэвшил, гаднын компаниудад алдаад байна. Энэ нь төрийн ухаалаг бус бодлоготой холбоотой.

**-Та төрийн албанд олон жил ажилласан хүн. Өнөөдөөр хилийн чанадаас харвал манай засгийн бодлого, үйл ажиллагаа хэр байна вэ?**

-Маш товчхон хэлэхэд, би төрийн үйл ажиллагааг өөрийн туршлага, алдаа оноооосоо дүгнэн хараад алив зүйлд шинжлэх ухааны байр сууринаас хандах хандлага дутагдаад байна л гэж үздэг. Тухайн нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр судалчихсан судалгаа дээр үндэслэн шийдвэр гаргадаг л болмоор байна. Түүнээс сэтгэлийн хөдөлгөөн, нам, фракцын байр сууринаас, хувь улстөрчийн үүднээс хандаж асуудлыг шийдэх бол манай төрд ужгирсан өвчин. Сингапурт өнөөдөр судалгааны томоохон think tank байгууллага олон бий. Улс төрийн өндөрлөгт ажиллаж байсан улстөрчид нь тэдгээр хүрээлэнгийнхээ захирлаар нь очдог. Тухайлбал, Зүүн өмнөд Азийн судалгааны хүрээлэнгээс долоо хоног бүр семинар явуулдаг. Тухайн орны төлөөлөгч, тухайн сэдвээр судалгаа хийсэн шинжээчийн илтгэл тавигдана. Эдгээр илтгэл, бодлогын суурь болсон судалгааг төрийн байгууллагууддаа явуулдаг. Яам нь судалгааг үндэслэж бодлого шийдвэрээ тодорхойлох замаар төрийн ажил явж байна. Түүнээс манай яамд шиг өдөр тутмын ажилд дарагдсан, байнгын хуралдсан байдалтайгаар ажил явахгүй ээ. Монголын яамд руу утасдахаар хуралдаж байна л гэх юм. Ерөнхийлөгчийн санаачилгыг илүү судалгаан дээр тулгуурласан ухаалаг төр байгуулах гэж ойлгож байгаа. Судалгаа бол амьдрал. Хоёрдугаарт, асуудлыг цогцоор нь авч үзэж, зөв шийдэх. Бид өнөөдөр алив зүйлийг өм цөм, энд тэндээс нь авч шийдээд байна. Сингапурчууд жижигхэн зүйлд ч их нямбай хандаж, ул суурьтай шийддэг улс.

**-Энэ жижиг газар нутаг дээр таван сая хүн амьдарч, тэнгэр баганадсан барилга байшин, хорооллууд, олон арван машин тэрэг сүлжилдэн байгаа мөртлөө замын түгжрэл үүсэхгүй юм. Ямар бодлого, дүрэм хэрэгжүүлсэн юм бол?**

-Замаа нэг урсгалтай л болгосон.

**-Сингапурын хөрөнгө оруулагчид манай аль салбарыг түлхүү сонирхож байна вэ?**

-Ерөнхийлөгчийн айлчлалын дараа манай орныг сонирхсон хөрөнгө оруулагчид нэмэгдсэн. Одоогоор "Темасек холдинг" Оюутолгойд хөрөнгө оруулалт хийсэн байгаа. Дэлхийд нэр хүндтэй том компани. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүн хэр байхаас дараагийн хөрөнгө оруулалтуудын урсгал шийдэгдэнэ. Сингапурчууд "Танайд газар байна. Манайд хөрөнгө мөнгө байна, мөн бэлтгэгдсэн боловсон хүчин байна, хамтраад ажиллая гэдэг. Сингапур хороолол барих, хот төлөвлөлт, эмнэлгийн салбар зэрэг сонирхож буй салбар бий. Гэхдээ Сингапурын хөрөнгө оруулалтыг манай төрөөс хамгаалж чадах эсэхээс хамааран хамтарч ажиллах саналууд гарч ирж байгаа. ■

2014 ОНЫ 02 САР.



*Жэймс Ло нь анх 2001 онд байгуулагдсан "Жэймс Ло Сайбертекчюр Интернэшнл" компанийн үүсгэн байгуулагч. Тэрбээр Лондоны их сургуулийн Коллежийн уран барилгын ангийг 1992 онд төгсжээ. Дэлхийн эдийн засгийн форумаас 2010 онд Дэлхийн залуу удирдагчаар шалгарсан бөгөөд одоо сайбер технологийг орчин үеийн барилгатай хослуулах зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Жэймс Ло нь алдартай архитектор. Англиийн уран барилгачдын Ройал Институтын гишүүн.*

ДЭЛХИЙН ЗАЛУУ МАНЛАЙЛАГЧ

# Нялх хотын төрх

**-Таныг Улаанбаатар хотын төлөвлөлт дээр хамтран ажиллах сонирхолтой гэж сонслоо. Та төлөвлөгөөгөө гаргасан уу?**

-Юуны өмнө хот нь аливаа улсын маш чухал хэсэг мөн гэдгийг хэлмээр байна. Ялангуяа өөрчлөлт шинэчлэлтийг дагуулах Монгол Улсын хувьд амин чухал үүрэгтэй. Бид хотын төлөвлөлтийг өнгөрсөнд бус, ирээдүйдээ зориулж гаргах хэрэгтэй. Тэгэхлээр Улаанбаатар хотын төлөвлөлтийг 10, 20, 50 жилээр бус, харин ирэх хэдэн зуун жилийг урьдчилан харж хийх шаардлагатай. Танай нийслэлд ирж үзсэний хувьд хэлэхэд, өнгөрсөн үеийн бүх бэрхшээлтэй асуудал ил харагдаж байна. Дотоод бүтэц тааруухан, мөн хот асар хурдацтай өсөн томрох хандлагатай байна.

Ирэх жилүүдэд гарах өсөлтөд зориулж "ухаалаг" хотын сүлжээний суурийг тавих хэрэгтэй. Үүний дизайн болон тогтолцоог үйл ажиллагаа тус бүрт зориулсан бүсээр эхлүүлж болно. Ингэснээр бизнесийн, оршин суугчдын, соёлын, эрдэм шинжилгээ технологийн, мэдээллийн, эрчим хүчний гэсэн дүүргүүдтэй болно. Дүүрэг бүр органик хэлбэрээр өсөж, цаг хугацаа өнгөрөх тусам сайжирна. Үүнийг компьютерийн программыг шинэчлэхтэй адил гэж зүйрлэж болно. Ийм шинэ ухаалаг хотуудыг бид сайбертекчюр хот гэж нэрлэдэг. Эдгээрийг улс үндэстэн, нийгэм хөгжих тутам компьютерийн программ шиг сайжруулан шинэчилж болдог.

Мөн хотыг илүү тогтвортой хөгжлийн замаар хөгжүүлэх хэрэгтэй. Эрчим хүч болон бусад нөөцийг шинэ маягаар дахин боловсруулж, хэрэглэснээр үндсээр нь шинэчилнэ. Тэгэхлээр өнөөдөр хотыг ирээдүйн цахилгаан машинд

зориулж төлөвлөнө. Хотод амьдарч ажиллах хэдэн мянган хүмүүст зориулсан, агаар бохирдуулахгүй, түгжрэл үүсгэхгүй тийм олон нийтийн тээврийн хэрэгсэл болох дамжин суух галт тэргийг бодолцох хэрэгтэй. Гэр бүлээ өсөн нэмэгдүүлж, таатай бөгөөд ногоон орчинд амьдрах байшин барилга, олон улсын дээд зэрэглэлийн стандартат нийцсэн бизнесийн дүүргийг бодолцоно. Энэ бүх ажлыг өнөөдөр төлөвлөж эхэлнэ. Учир нь, эдгээр санааг хэрэгжүүлэхэд 10, 20, 30 жилийн хугацаа орно. Хуучин биш, шинэ "сайбертекчюр" концепц бидэнд хэрэгтэй. Бид хотыг зөвхөн бетон, төмөр, шилнээс бус харин эдгээрийг маргаашийн технологи, шинэчлэлтэй хослуулан барих хэрэгтэй. Тэгж чадваас энэ нь Монголд урт удаан наслах үндэслэлтэй болно.

**-Та манай хотыг анх удаа хараад архитектор мэргэжилтэй хүний хувьд юу гэж бодсон бэ?**

-Анх нийслэл Улаанбаатар хотыг хараад нялх хүүхэд шиг байна даа гэсэн сэтгэгдэл төрсөн. Онгоцноос харахад уулсын дунд олон жижиг чулуунуудыг талаар нэг тараасан мэт харагдсан. Ямар ч зохион байгуулалт, хил хязгаар, бүлэглэл, удирдлагагүй замбараагүй. Харин хот руу ороод ирэхээр хөгжил нэлээд хурдацтай явагдаж буйг мэдэрсэн. Шинэ барилга байшин баригдаж байгаа ч нэгдсэн бодлогын хүрээнд орж чадаагүй байна. Мөн орон сууцны байранд зориулсан загвар алга. Хүмүүс гэрт, хувийн байшинд, зарим нь нийтийн орон сууцанд амьдарч байна. Аливааг бүтээхдээ, мөн чанарыг хэрхэн бий болгох вэ гэдэг дээр тодорхой систем алга. Замын түгжрэлийн бэрхшээл нь зам биш, харин зохицуулалтдаа байна. Гэрлэн дохиог би анзаарч харсан. Зарим үед гэрэл асахгүй, дохио солигдох хугацаа буруу, эсхүл хүмүүс гэрлэн дохиог үл тоомсорлон гарч байсан.

Хотын замын хөдөлгөөнийг зохицуулна гэдэг нь ганц биш, хэдэн мянган уулзварыг удирдана гэсэн үг. Компьютер ийнхүү хөдөлгөөнийг хамгийн үр ашигтайгаар зохицуулж чадна. Орчин үеийн хотын цагийн тогтолцоо нягт нямбай байх ёстой. Нийслэл хотыг балчир хүүхдээр авч үзэхэд, энэ хүүхдийг өсгөж томруулахын тулд шинэ тоглоом, хэрэгсэл өгөх зайлшгүй хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ур чадвар олгож, том хүн болгож авна гэсэн үг. Энэ бүхнийг яг одоо л хэрэгжүүлж эхлэхгүй юм бол, Улаанбаатар хотын ачаалал, бэрхшээл нь улам нэмэгдэнэ. Бид урьдчилан харагчдын хувьд Засгийн газарт хот төлөвлөлт дээр зөвлөж байж урт настай, тогтвортой, орчин үеийн, ухаалаг хот бий болно.

**-Ухаалаг хот гэж Та ямар хотыг хэлэх вэ. Жишээ хэлж болох уу?**

-Ухаалаг хот гэдгийг тайлбарлахаас өмнө, хот гэж чухам юу болохыг ойлгох хэрэгтэй. Нийгэм, эдийн засгийн шалтгааны улмаас нэг газар аж төрж, ажилладаг хүмүүсийн бүлэг хотыг бүрдүүлдэг. Тэнд том компани аж ахуйн нэгжүүд, Засгийн газар, сургууль, онгоцны буудал, аж үйлдвэр бүгд төвлөрдөг тул хүмүүс ч мөн адил тэнд төвлөрдөг. Гэхдээ эдгээр хүмүүсийг нэг дор бөөгнөрүүлэхэд тэд сайн зохицуулагч байж чадахгүй. Хүн хэдийгээр сайн сэтгэн боддог ч амиа хичээсэн байдаг. Эртний хотууд ухаалаг байгаагүй.

Ухаалаг хот гэдэг нь хотыг төлөвлөж, үр ашгийг өндөр түвшинд байлгахад чиглэгдсэн хүрээ юм. Эрсдэлтэй тулгарах чадамжтай байх ёстой. Жишээ нь хотод үр ашиггүй алдагдаж байгаа ус, эрчим хүчний хэмжээ асар их байна. Ухаалаг хотод нэг дүүрэг албан байгууллагын зориулалттай байх бөгөөд өдрийн цагт эрчим хүчийг түлхүү хэрэглэнэ. Өөр нэг дүүргээс тэр эрчим хүчийг хуваалцах боломжтой. Тэгээд бизнесийн хороололд амралтын өдрүүдэд эрчим хүчний зарцуулалт бага болохоор нь илүү их хэмнэлт гаргаж болно. Эрчим хүч, хүний нөөц, харилцаа холбоон дээр ч гэсэн ийм л аспектаар хандах шаардлагатай билээ. Бүсүүдийг бизнесийн болон оршин суугчдийнх гэж хуваана. Хүмүүс ажилдаа очих гэж хотын нэг захаас нөгөө рүү явж байна. Тэгвэл шинэ хотын оршин суугчид яагаад нэг л газраа ажиллаж амьдарч болохгүй гэж. Бид эрчим хүч, цагаа хэмнэн тэрхүү нөөцөө хүмүүсийн амьдралыг нь сайжруулахад зарцуулъя. Иргэдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын стандартыг нь сайжруулж байж ухаалаг хот болно. Иймэ хотыг бүтээн байгуулахын тулд шинэ дотоод бүтэц, шинэлэг санаа бидэнд шаардагдана.

**-Улаанбаатар маань хэзээ таны ярьж байгаа шиг иймэ ухаалаг хот болох бол?**

-Нэг шөнийн дотор бүтээн байгуулагдах зүйл биш. Гэхдээ Монгол Улсын хувьд том давуу талтай. Лондон, Хонконг гэхчлэн томоохон хотуудын дотоод бүтэц аль хэдийнэ хийгдсэн учир шинэчлэхэд хэцүү. Өсөлтийнхөө дунд шатанд байгаа Шанхай, Бээжин хотууд ч мөн адил.

Харин Улаанбаатар залуу хот учраас хүмүүс ирээгүй, утасгүй холболт, шугам сүлжээ тавигдаж дуусаагүй байна. Иймд одооноос ухаалгаар ажлыг эхлүүлбэл хотын өсөлт хөгжил ч үүнтэй хамт эхэлнэ. Эхний үе шатанд таван жилийн хугацаа шаардлагатай байх гэж бодож байна. Гэхдээ маш ухаалгаар бодож хийх нь чухал. Тэрнээс биш, шил толь болсон гял цал өндөр барилгуудыг чухалчлах нь гол биш. Хойч үеэ бодож, урт хугацааны төлөвлөлтөд чиглүүлэх хэрэгтэй.

**-Та залуучуудад хандаж юу хэлэх вэ?**

-Монгол хүүхэд, оюутан залуустай уулзсан. Тэд өөдрөг үзлээр дүүрэн байгаа нь мэдэгдсэн. Мөн хүмүүс өнөөдрөөр биш, маргаашаа бодож амьдарч байгаа нь улс орны хувьд маш сайн юм. Монгол 15 жилийн дараа дэлхийд тэргүүлсэн манлайлагч орон болохыг үгүйсгэхгүй. Залуу удирдагчид бид өөрчлөлт шинэчлэлт, өөдрөг байдал, мөрөөдлийн эрч хүчийг олж хардаг. Монголд ирээд сая сая хүний амьдралыг өөрчлөх боломж байгааг мэдэрсэн. Тэр бол жинхэнэ боломж. Бид цаг алдалгүй боломжийг тэвэрч аван, ирээдүйд тохирсон бодит санаа, арга барил, алсын хараг гаргах хэрэгтэй байна. ■

2012. 02 САР



# Б.Төмөрчулуун: Манай төр ёолкны мод шиг байна

*Үйлдвэрлэл дагнасан "Сэргэн Мандалт" группийн Ерөнхийлөгч Б.Төмөрчулуунтай ярилцлаа.*

**-Төр улсын талаарх таны бодлыг эхлээд сонсоё. Учир нь Та Монголоо бас төрөө цэвэр цэмцгэрийн дээд яаман ухааны уурхай байх ёстой гэж хэлсэн шүү дээ.**

-Төр бүр ялангуяа Монголын төр ард түмнийхээ эргэж хувирдаггүй сайн анд нь байх ёстой. Хувиршгүй анд гэдэг бол нэг зантай, цөөхөн үгтэй, амалснаа биелүүлдэг, уул ус шиг түшигтэй, эцэг шиг нь зангарагтай, ээж шиг нь энэрэлтэй байх ёстой. Гэтэл бидний анд маань хувираад байна. Төр хувирахаар дагаад хүн ард нь хувирдаг боллоо. Дээрээ гүйдлээ олохгүй байхад доороо яаж олдог юм бэ гэсэн ардын маань үнэн үг бий. Төрийн эрх барих дээд шатны буюу нийгмийн харилцааг зохицуулах дээд шатны алтан жолоо цулбуурыг барьдаг хүмүүс нь эргэж хувираад байгааг би хэлж байна. Ард олон манай залуучууд соёолон морьд л гэсэн үг. Уяа сойлгыг нь тааруул.

УИХ-ын гишүүд гурван зүйлийг сайн анхааралсай. Нэгдүгээрт, Санамсар гэж юу юм бэ? Үүнийг ойлгож зүрх сэтгэлээ сайн дадуулах хэрэгтэй. Би хэнээс төрсөн хэн билээ, хэн байгаад хэн болсон гэдгээ сайтар тунгаан бодох. Хоёрдугаарт, анхааран авлага гэж юм бий. Тэгэхээр эх орноосоо, аав ээжээсээ, ард түмнээсээ, сонгогчдоосоо авахаа авчихсан. Харин одоо өглөгийн эх булгийг ундруулах, өгч чадах бүхнээ өгөх хэрэгтэй, өгөх юм байхгүй бол ядахдаа сайхан ааштай, хүнд сурталгүй бай.

Гуравдугаарт, Үлдэх амьдрал гэж юу болох тухай бодох ёстой. Монгол орон мөнх үлдэнэ. УИХ-ын гишүүн мөнхөд байхгүй шүү дээ. Энэ бүхнийг сайн ойлгож манай УИХ-ын гишүүд бүгд нямбанд суу. Яагаад валютын ханш өсөөд байна, энгийн ардууд, найз нөхөд минь утсаар ярихад яагаад би утсаа авахгүй байна, яагаад би их мөнгө олоод байна, яагаад би албан тушаал хашмаар санагдаад байна, би ямар хоол идэж байна, би ямар өвөө, ямар өрхийн тэргүүн, ямар найз байна гэдгээ эргээд сайн бодож тунгаах хэрэгтэй. Нямбанд сууж Яаман ухаантай болохын тухайд амьдрал мэддэг хүнээс асуугаарай даа эрхэм гишүүд ээ.

Орчин үеийн шинжлэх ухаан, эдийн засаг, филисофын ухааны хэллэгээр ярьвал эргэж хараад зогтусхийгээд дахин төлөвлө. Өнгөрснөө нэг эргээд хар л даа. Тэгээд дахин шинээр төлөвлөөсэй. Бизнесийн тогоонд 20 гаруй жил борц болтлоо чанагдсан, сүүлийн дөрөв гаруй жил нийслэлийн иргэдийг төлөөлж байгаа хүний хувьд ийм бодол төрөх юм. Өөрт тустайгаас илүү түмэнд тустай ажил хийх хэрэгтэй. Бүр ядахдаа хаягдал цаасан дээр нэрийн хуудсаа хэвлэ.Талцахаа болиосой. Нам бус Монгол чухал байна.

**-Та монгол төрийг ёолкны модтой зүйрлэн ярьсан. Их сонин зүйрлэл шүү.**

-Бид шинэ жилээр ёолк засах дуртай биз дээ. Ye үеийн төр ийм л гялтганасан байна л даа. Гаднаа гяланцаг дотроо паланцаг байгааг үе үеийн төрийн түшээд мэдсээр байвч засахгүй юм. 23 жил чамлахаар бага хугацаа биш ээ. Төр нуруун дээрх их ачаанаасаа салах шаардлагатай. Яргуй, Сарнай цэцэг шиг болох хэрэгтэй. Ард түмнийхээ төлөө үрээ өгөхийн тулд дэлгэрмээр байна. Ийм ийм зүйл рүү оролцохгүй гэдгээ зарлачих. Ялангуяа төр татвар төлөгчдийн мөнгөөр худалдан авах үйл ажиллагаа хийхгүй байх нь зөв. Яагаад гэвэл ичээд байх юм гэж хариул. Татвар төлөгчдийн мөнгөөр А4-ийн цаас л авъя, бусдыг бизнесмэнүүд мэдэг гэж хатуу бод. Ингэж бодож чадвал монгол төрийн жинхэнэ бодлого, уужуу ухаан болно. Монгол орныхоо алсын хараа, хөгжлийн бодлогыг яг л бяслаг шиг шахаад өгчих. Зүсэхийг нь аж ахуйн нэгжүүд, өөр бусад нь зүснэ биз. Ийм хөгжлийн бяслаг үйлдвэрлэдэг, тархи толгой нь цэцэн мэргэн төртэй, оюун ухааны уул уурхайн түшиц болсон улс баймаар байна. Монгол орон илт сэргэнэ. Харин одоо энэ буй байдлаар бол ерөөсөө болохгүй гэдгийг л би зөвлөж хэлэх гэсэн юм. Бүх түвшинд шүү. Улаанбаатарчуудын их унтаж, уурлаж ундууцахад хэзээ ч бэлэн байгаагаас эхлээд солонгос кино үзээд унтах хүртэл.

**-Төр хувирч болохгүй гэж байна. Өнгөрсөн хугацаанд төр хувирахгүй байсан тохиолдол байгаа юу?**

-1990 онд худал хэлсэн баймааргүй. Хүнлэг ардчилсан иргэний нийгэм байгуулна гэчихсэн. Тэрийгээ мартаад одоо нам төвтэй Монгол улс болсон. Төрийг хувиргаж, эргүүтүүлээд буй зүйл бол нам. Намын нэрээр хэсэг нөхөд лобби, танил тал, хуйвалдаан хийж байна. Ард түмэн хувираагүй. Тэд монгол төрийн үнэнч хэвээр байгаа. Төрийн гаргасан алдаа, мөнгөний ханшны сулрал, агаарын бохирдолт, ажилгүйдэл, ядуурал, архидалт, авилгал бол төрийн муугынх. Энэ бүгдийг тэсвэрлэн суугаа уужуу ард түмэнтэй гэдгээ л сана. Йим ард түмнийхээ ачийг нь үтэр түргэн хариулах хэрэгтэй.

**-Төр юуг амлах ёстой вэ?**

-Би энд зөвхөн эдийн засаг материаллаг талаас нь харж хэлье л дээ Миний бодлоор засаг хоёр зүйл амлаад, нэг зүйлийг нэхсэн шиг нэхэх хэрэгтэй. Нэгдүгээрт, зах зээлийн эдийн засгийн хэрэглээ талаасаа байнга эргэлддэг зүйл бол мөнгө. Ер нь мөнгө тооцоон дээр амлалт өгөх хэрэгтэй. Тухайлбал, төгрөгийн, долларын ханш гучин жил тогтвортой 500 төгрөг байна гээд амлаж, энэхүү амлалтынхаа төлөө ажиллаж, тэмцэж, амлалтаа биелүүлж данагар байх хэрэгтэй. Хоёрдугаарт, та ийм хэмжээний татвар төлнө гэдгийг зарлах. Ялгавартай биш. Мөнгө эргэлдүүлж байгаа л бол тэр нэмүү өртгийн албан татвар төлнө. Түц ч төлнө. Чи их олдог 30 хувь, чи чааваас түц юм төлөөд хэрэггүй гэсэн яриа байх ёсгүй. Ард түмэн нэгэнт тогтоосон дүрэм журмыг ягштал биелүүлэх ёстой. Төр амлалтаа өгнө, иргэд татвараа төлнө. Амлалт, татвар хоёрын хоорондох зайнд улс хөгжиж, бизнес цэцэглэж сайхан амьдарна.

**-Өнөөдөр бид бүх л бурууг, болохгүй байгааг төртэй холбодог. Төр муу менежер гээд л байнга ярих. Энэ зөв үү?**

-Төрөөс их итгэл хүлээсэндээ л тэгж хэлээд байгаа юм. Засаг байгаа, засаглаж байгаа бол бидэнтэй адилхан л сайхан ааштай байгаач, татварыг тодорхой болгоод өгөөч, саад битгий болоочээ гэж л байгаа. Төр хэрэгтэй гэвэл хэрэгтэй. Төр юунд хэрэгтэй вэ. Ард түмэн алгатай цоогтой амьдрал эрээнтэй бараантай шүү дээ. Тиймээс асрах энэрэх ёстой. Аав шиг нөмөр нөөлөгтэй, ээж шиг энэрэлтэй байхыг хүсээд байна. Өөр зүйл хүсээгүй. Ер нь монголчууд дэндүү ухаалаг ард түмэн болохоороо төрөөс хүсч буй зүйл нь даруухан.

Ард түмний мэдэлд газар доорх баялаг л байх ёстой. Тэрнийг төр мэдсэн шиг мэдэх. Сүүлийн үед баялгаа ерөөсөө хувийн хэвшилд өгөөд байя гэсэн хандлага ажиглагдаж байна. Хувийн хэвшлийнхэн сурсан чадал чансаагаараа баялаг бүтээж эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулна. Түүнээс газар доорх баялгийг ухаж гаргаж ирснээр баялаг бүтээгч болчихдог юм биш. Баялаг ухагч болж байгаа юм. Тодорхой зорилго дэс дараатай төлөвлөгөөтэйгээр хийх нь төрийн ажил. Яг Франкфуртын олон улсын нисэх онгоцны буудалд диспетчерийн удирдлагаар онгоц бууж нисгэдэг шиг. Улс орны хөгжлийг хэмжихэд ядах юм байхгүй. Таксины жолооч, оюутан, бараан захын худалдагчтай ярилцаад л мэднэ. Тэд би аз жаргалтай сайхан амьдарч байна гэвэл төрийн сайн бодлогын хэмжүүр, эсрэг зүйл яривал тэр нь өнөөгийн төрд өгсөн дүгнэлт, ташуур. Улс орны хөгжлийг Ерөнхийлөгчөөс, УИХ-ын даргаас асуух шаардлагагүй. Энгийн иргэдийн аманд монгол төрийн үнэлгээ хүлхэгдэж байдаг. Ийм учраас НИТХ-ын төлөөлөгчийн хувьд надад нэг даруухан мөртлөө Монголын төрийг иргэнлэг байхад ачтай санал байдаг. Иргэдийн хурлын төлөөлөгчдийг намаас нэр дэвшүүлэхээ болъё. Өөрөөр хэлбэл 35 мянган хүнээс нэг нь л сонгогд. Намаас бол Улсын их хурал нь сонгогддог юм байгаа биз гэж бодох юм.

**-Та 1990-ээд оноос бизнесийн зовлон жаргалыг биеэрээ туулж ирсэн бизнесмэнүүдийн нэг. Өнгөрсөн бизнесийн түүхээ эргээд харахад танд юу бодогдох юм?**

-Залуусаа л хайрлах хэрэгтэй байна.Хэд нь хатуу системийн золиос болсон, хэд нь хэнэггүйхэн алхаж байна, хэд нь ухаажиж байна. Зах зээл өнөөдөр нэг төгрөгийн юмыг гурван төгрөгөөр зарах тухай яриа биш. Их мэдлэг шаардсан ажил. Гэтэл өнөөдөр мөнгө гэхээр л уул уурхай яриад байна. Уул уурхайгаас илүүтэй хамгийн чухал зүйл мэдлэгт суурилсан эдийн засаг. Үүнийг л эрчимтэй хөгжүүлбэл улс орон хурдацтай хөгжинө. Монголчууд дэлхийн шинжлэх ухааны ололт амжилтаас булаалцалдан байж хүртэн нутагшуулмаар юм. Уул уурхайг төр зөв мэддэг байх юм бол тэр хэмжээгээр улсын хүчин чадал нэмэгддэг байх нь. Нэгэнтээ улсын нэмэгдэх хүчин чадлыг өөртөө авч байгаа бизнесмэнүүдийг хүндлээд даалгавар өгөх ёстой. Уул уурхайн бизнес эрхэлж буй хүмүүс ийм ийм даалгаврыг гүйцэтгэх талаар тодорхой зааж өгөх хэрэгтэй. Харин тийм гэрийн даалгавартай нь үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүл. Уул уурхай ухсан хүмүүсээс

Хөдөлмөрийн баатар төрөхгүй, уурхайчнаас харин төрж болно. Мэдлэгт суурилсан эдийн засаг шүтвэл эрдэмтэд олноор төрөх ёстой. Генийн суутнууд, оюун санааг дээдэлсэн хүмүүс олон болно гэсэн үг. Гэхдээ манай улсын өнөөгийн нөхцөлд буюу холилдсон байдалд баялгийн балансаа төр мэргэн гаргаж тайлангаа тавьмаар байна. Уул уурхайд амжилт олж буй нэгнээ дэмжих л ёстой. Төрөөс өгсөн үүрэг даалгаврыг хийж чадахгүй бол дараачийн хүндээ өгдөг байх. Улс даалгасан шиг даалгадаг нөгөө тал биелүүлсэн шиг л биелүүлэх нөхцөл бүрдүүлэх нь чухал байна.

**-Таны өрөөний цонхоор амьдрал ямар харагдаж байна вэ?**

-Албан тасалгааны цонхоор амьдрал яг нүцгэн үнэнээрээ харагддаггүй. Энэ нүцгэн үнэнийг ойлгож буй хүн л очсон албан тушаалдаа заавал сайн ажиллана. Манай эдийн засаг өнөөдөр жишээлбэл, чардайсан резин шиг байна. Арай л тасраагүй. Энэ резиныг тосолж чадвал суларна. Гэхдээ хүчээр сулруулж болохгүй. Хайр энэрэлээр, зөв тэмцлээр сулруулах хэрэгтэй. Бүр тасалж болохгүй. Наад зах нь ханшийг тогтоох шаардлагатай. Амласан бол амласан ш дээ. Энэ жилийн валютын ханш 1341 байна гээд амалсан бол хэлсэндээ хүрэхээс өөр ямар ч арга байхгүй. Ханш 1800-д хүрвэл зөрүү мөнгийг нь өгөх ёстой. Бидний муулаад байгаа Оюутолгой валютын ханшийн зөрүүг зарим компанид уучлаарай гээд өгсөн байна лээ. Монгол Улс валютын ханшны зөрүүг өгөх ёстой. Гэхдээ бид шаардаагүй. Ханшийг тогтворжуулах асуудалд засаг сайтар анхаарах цаг ирсэн. Дугаарлаж буй асуудлуудаа эрх ашгаар нь байр эзлүүлж эхний таван байрын асуудлаа амь тавьж шийд. Валютын ханшаа зогсоож, ер нь асуудлуудаа нэг цэгцэлж авах цаг болжээ.

**-Монгол бизнесмэнүүдийг дүгнээд хэлбэл?**

-Монголын арилжааны банкууд бол мөнгө хүүлэгчид. Ийм өндөр хүүтэй бизнесийн циклд сөгдөлгүй тэмцсээр яваа хүмүүс бол монгол бизнесмэнүүд. Маш их самбаатай, хүчтэй, хурдтай, өвөрмөц улсууд. Маш үнэнч, тэдэнд итгэж болно.

**-Ер нь монгол хүн гэж хэн юм бэ?**

-Би “Тусгаар тогтнол” номондоо бичсэн. Генийн донж гэдэг содон бүтээгдэхүүн байдаг. Генийн донжоор хүнийг ямар ухаантай, ямар гаралтайг мэддэг. Генийн давамгайлсан шинжээрээ дэлхийд гайхуулахаар, дэлхийн гал голомтыг тойроод суух хүмүүс Монголд байгаа юм шиг санагддаг. Монгол хүний генийн шинж маш сайхан, өгөгдөл сайтай, цэвэр. Монгол хүн давтагдашгүй дээ, гайхалтай. Тийм ч учраас нандин хүмүүс.

**-Сүүлийн үед эдийн засаг бус монгол хүмүүсийн сэтгэхүй нь хямарчихаад байна. Төрөө шүүмжилж, муулж, болох, болохгүй зүйл төрийн л буруу болдог болсон гээд.**

-Хүн бүр тийм бодолтой биш л дээ. 20 гаруй жил нам төвтэй явлаа, манай улс. Дархлаа суусан байж болно. Монголын төр дээр хэлсэнчлэн эцэг эх шиг энэрэх ёстой. Хүүхдүүддээ туслах үүрэгтэй. Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, ёс зүй, бодлогоо бяслаг шиг болгохын тулд иргэдээ дархлаажуулах асуудал чухал. Солонгос кино үзсэнээр сэтгэхүй нь тэр бүр өөрчлөгдөхгүй байх.

Харин манай залуу үе гадаадад сурвал л болох нь тэр гэж үздэг болсон байна. Энэ бол тийм ч зөв шийдвэр биш гэж би боддог. Тийм учраас би МАХА гэж хөдөлгөөн үүсгээд яриад яваад байгаа юм.

МАХА гэдэг нь-Монголоороо л, Амьтайгаа л, Хүчирхэг л, Аугаа л байж Монголыг Аугаа Хүч Аварна (МАХА).

Тэрхүү аугаа хүч нь мэдлэг, уламжлал, зан заншил.

Наад зах нь монгол хүүхдийг 13-ны жил орох хүртэл нь монгол ахуйдаа л сургах хэрэгтэй. Ямар ч гадны хэл заахгүй. Монгол наадгайгаар наадуулж, нагац, авга нарын талаар тодорхой ойлголт өгөх нь чухал. Монгол хүн, монгол ген, монгол ахуйг мэдэж, монгол сэтгэхүйтэй, монгол дархлаа суусных нь дараа өөрөө гадаад хэл сурахаа сонго.

Цаашлаад Монголдоо их, дээд сургуулийн диплом аваад ямар нэг газар ажиллана. Үүний дараа харин гадаадад мэргэжил дээшлүүлж, ажиллаж буй байгууллага, мэргэжлийнхээ хүрээнд гадаадад магистр хамгаалаад ирсэн бол хэрэгтэй. Энэ нь тухайн байгууллагын үнэт зүйл, Монголын баялаг болно. Түүнээс гадаадад магистр, бакалавр хамгаалсан хүмүүс одоо сонин биш болсон.

**-Таны бизнесийн зарчим юу вэ?**

-Бидний зөв зарчим болөөрийнхөө чадлаар нэг ажлыг л хийх. Өөрөөр хэлбэл, манай группийн зарчим бол нэг чадлаар олон ажил хийх бус, нэг чадлаар нэг ажлыг чинээнд нь тултал хийх. Нэг чиглэсэн зүйлдээ амиа тавьтал ажиллах ёстой. Миний хувьд энэ нь үндэсний үйлдвэрлэл. Сая төгрөгнөөс санаа төрөхгүй, санаанаас сая сая төгрөг төрнө гэсэн өөр нэг зарчимтай яваад 20 жил болж байна. Заримдаа баярлах зүйл байна, нөгөө талдаа хэцүү зүйл ч тохионо. Үйлдвэрлэлээр дагнаж, амтыг нь мэдэрч, үйлдвэрлэл эрхлэхийн үр дүнг үзэж яваадаа бахархдаг. Манай групп бүх төрлийн хоолой, шуудайн үйлдвэрлэл эрхэлдэг. Бүх төрлийн хаягдлаас сүрэл гаргаж авахдаа мэргэшсэн туршлагатай компани. Хамгийн гол нь тусгаар тогтносон Монгол улсын иргэн болж төрсөндөө л баярлаж, бахархаж, жигүүрлэж явна даа.

**-Таны хообий?**

-Шүлэг бичих. Миний үгийг нь зохиосон арваад дуу бий. Саяхан би твиттэрт нэг шүлгээр жиргэсэн.

**-Ямар шүлэг вэ? Сонирхъё.**

*Хөхрөн цэлийж л байвал*
*Монгол нутаг*
*Тэмээн жин хөвөрч л байвал*
*Миний өвөө*
*Сүүн цацал цайрч л байвал*
*Миний эмээ*
*Хүүхэд гадаа эрхээрээ тогложх*
*Хөгшид нарлаж байвал*
*Монгол нутаг*

гэсэн дөрвөн мөрт. ■

2014 ОНЫ 5 САР.




Бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээллийг хэвлэмэл болон онлайн хувилбараар уншаарай.

# ХЭВЛЭЛ + ОНЛАЙН ЗАХИАЛГЫН БАГЦ

Эрхэм уншигч та энэ багцыг захиалснаар бүтэн нэг жил эдийн засаг, бизнесийн чухал мэдлэгийг авч ажил, амьдралдаа илүү сайн шийдвэр гаргана. Сэтгүүлийг редакциас 14 хоног тутамд **ҮНЭГҮЙ** хүргэнэ. Мөн энэ багцад онлайн эрх үнэгүй дагалдаж та бүтэн жилийн турш ажил, гэр, хүссэн газраасаа манай сэтгүүлийг уншина.

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЭС 181,440₮ ХЭМНЭЛТ

☑ **За тэгье, би Mongolian Economy сэтгүүлийн бүтэн 1 жилийн (24 дугаар) хэвлэмэл + онлайн захиалгын багцыг хамгийн доод (250,560₮) үнээр авмаар байна.**

Овог, нэр / Full Name

Захиалга хүргэх хаяг/ Address for delivery

Харилцах утасны дугаар / Telephone

И-мэйл (онлайн захиалгад шаардлагатай) / E-mail (Required for online subscription)

☐ Төлбөрийг данс руу тушаасан.

☐ Нэхэмжлэх илгээгээрэй.

**Төлбөрийг ХААН Банк: 5041139370 дансаар шилжүүлнэ.**
***(Төлбөрийн утга "багцийн захиалга" гэж оруулна.)***

ЗАХИАЛГАТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ 7011-5476 УТСААР ЛАВЛАНА УУ.





Бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээллийг хэвлэмэл болон онлайн хувилбараар уншаарай.

ХЭВЛЭЛ + ОНЛАЙН ЗАХИАЛГЫН БАГЦ

Эрхэм уншигч та энэ багцыг захиалснаар бүтэн нэг жил эдийн засаг, бизнесийн чухал мэдлэгийг авч ажил, амьдралдаа илүү сайн шийдвэр гаргана. Сэтгүүлийг редакциас 14 хоног тутамд ҮНЭГҮЙ хүргэнэ. Мөн энэ багцад онлайн эрх үнэгүй дагалдаж та бүтэн жилийн турш ажил, гэр, хүссэн газраасаа манай сэтгүүлийг уншина.

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЭС 181,440₮ ХЭМНЭЛТ

☑ За тэгье, би Mongolian Economy сэтгүүлийн бүтэн 1 жилийн (24 дугаар) хэвлэмэл + онлайн захиалгын багцыг хамгийн доод (250,560₮) үнээр авмаар байна.

Овог, нэр / Full Name

Захиалга хүргэх хаяг/ Address for delivery

Харилцах утасны дугаар / Telephone

И-мэйл (онлайн захиалгад шаардлагатай) / E-mail (Required for online subscription)

☐ Төлбөрийг данс руу тушаасан.

☐ Нэхэмжлэх илгээгээрэй.

Төлбөрийг ХААН Банк: 5041139370 дансаар шилжүүлнэ.
*(Төлбөрийн утга "багцийн захиалга" гэж оруулна.)*

ЗАХИАЛГАТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ 7011-5476 УТСААР ЛАВЛАНА УУ.


**Ажлын хамтрагч анд найздаа бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээлэл, амжилтыг бэлэглээрэй.**

# ХЭВЛЭЛ + ОНЛАЙН ЗАХИАЛГЫН БАГЦ БЭЛЭГЛЭХ

Эрхэм уншигч танд дотны найз, ажлын хамтрагчаас энэ багцийг захиалснаар бүтэн нэг жил эдийн засаг, бизнесийн чухал мэдлэгийг авч ажил, амьдралдаа илүү сайн шийдвэр гаргана

БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЭС 181,440₮ ХЭМНЭЛТ

☑ **За тэгье, би Mongolian Economy сэтгүүлийн бүтэн 1 жилийн (24 дугаар) хэвлэмэл + онлайн захиалгын багцыг хамгийн доод (250,560₮) үнээр авмаар байна.**

Хэнд бэлэглэх / Gift to

Захиалга хүргэх хаяг/ Address for delivery

Харилцах утасны дугаар / Telephone

И-мэйл (онлайн захиалгад шаардлагатай) / E-mail (Required for online subscription)

Хэнээс бэлэглэх/ Gift from

Хаяг/ Address

Харилцах утасны дугаар / Telephone

И-мэйл / E-mail

☐ Төлбөрийг данс руу тушаасан.

☐ Нэхэмжлэх илгээгээрэй.

**Төлбөрийг ХААН Банк: 5041139370 дансаар шилжүүлнэ.**
***(Төлбөрийн утга "багцийн захиалга" гэж оруулна.)***

ЗАХИАЛГАТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ 7011-5476 УТСААР ЛАВЛАНА УУ.

марк энд наах

**Mongolian Economy сэтгүүл**

ш/х-2762, Төв шуудан
15160 Улаанбаатар
Монгол Улс




Бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээллийг хэвлэмэл болон онлайн хувилбараар уншаарай.

марк энд наах

**Mongolian Economy сэтгүүл**

ш/х-2762, Төв шуудан
15160 Улаанбаатар
Монгол Улс




Бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээллийг хэвлэмэл болон онлайн хувилбараар уншаарай.

марк энд наах

**Mongolian Economy сэтгүүл**

ш/х-2762, Төв шуудан
15160 Улаанбаатар
Монгол Улс

**Ажлын хамтрагч анд найздаа бүтэн жил эдийн засаг, бизнесийн чухал мэдээлэл, амжилтыг бэлэглээрэй.**



ИЛТГЭЛ

# Ан Сан Су Чи: Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр

*Өмнөд Африкийн домогт удирдагч Нелсон Манделатай зүйрлэдэг Мьянмар улсын Үндэсний Ардчилсан лигийн тэргүүн Ан Сан Су Чи үндэстнийхээ энх тайвны төлөө тэмцэж, ардчиллын аясын салхийг эх орондоо авчрахад үнэтэй хувь нэмэр оруулсан эмэгтэй баатар билээ. Тун удахгүй 68 нас зооглох Ан Сан Су Чиг олон улсад танихгүй хүн үгүй болсныг түүний 1991 онд хүртсэн Нобелийн Энхтайваны шагнал гэрчилнэ. Үндэсний тусгаар тогнолын баатар генерал Ан Саны гэр бүлд төрсөн тэрбээр хоёрхон настайдаа аавыгаа алдсан. Ан Сан генералын амийг хөнөөснөөс ердөө зургаан сарын дараа тус улсын тусгаар тогтнол цуурайгаа хадаасан билээ. Оксфордын их сургуульд улс төр, эдийн засаг, философийн чиглэлээр боловсрол эзэмшсэн түүнд Мьянмарыг аврах баатрын зүрх зориг заяажээ. Ардчилсан шинэчлэлийн төлөө тэмцэгч ажилчид болон лам хуваргуудтай нийлэн анх бослого хөдөлгөөнд оролцож эхэлсэн тэрбээр амьралдаа хоёр удаа гэрийн хорионд урт хугацаагаар орж, шоронгийн хаалга татсан байдаг. Ан Сан Су Чи нийт 15 жил гэрийн хорионд суусан аж. Түүний гэрийн хорио 2010 онд дууссан бөгөөд хүү Ким Арис нь өнгөрсөн хугацаанд эх орондоо очихоор виз олонтаа хөөцөлдсөн ч ээжийгээ суллагдсаны дараа буюу 10 жилийн дараа л эргэж ирэх боломж олдсон байдаг. Тэмцэл, хагацал, зовлон дүүрэн амьдралыг туулсан Ан Сан Су Чи Монгол дахь айлчлалынхаа үеэр "Би өнгөрсөн амьдралдаа сэтгэл хангалуун байдаг" хэмээн инээмсэглэн хэлсэн билээ. Тэрбээр манай улсад 2013 онд АОХН-ийн Сайд нарын VII бага хуралд оролцсон. Манай сэтгүүл түүний Монголын залуучууд, шийдвэр гаргах түвшний хүмүүст зориулах тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь орчуулан хүргэж байна.*

Олон орны хүмүүстэй тэр дундаа залуустай хамтрах боломж олдоно гэдэг миний хувьд маш олзуурхууштай санагддаг. Би үргэлж хэлдэг шигээ Монголын залууст ч мөн та бүхэн хүн төрөлхтний найдвар шүү гэж хэлмээр байна. Учир нь, тэдний хүсэл эрмэлзлэл, итгэл найдвар, мэдрэмж юу болохыг бид мэдэж байх нь чухал юм. Манай оронд залуус жинхэнэ ардчилалд хүрэх гэсэн бидний зорилго, хичээл зүтгэлд оролцохдоо эрч хүч дүүрэн байгааг харахдаа урам зоригтой байдаг. Залуус эрх чөлөөг хүсдэг. Эрх чөлөө болон ардчиллыг салгаж үл болно. Гэвч ардчилалыг үргэлж үүрэг хариуцлага дагадаг. Үүнийг би цаг үргэлж онцлон тэмдэглэхийг чармайдаг. Зарим хүн ардчиллыг зөвхөн эрх эдлэх гэж ойлгодог. Энэ бол үүрэх ёстой хариуцлагаа үл огоорч, зөвхөн эрх чөлөөгөө эдэлнэ гэсэн үг. Энэ бол миний хөхиүлэн дэмждэггүй зүйл. Хүн төрөлхтний хийж чадах үнэтэй зүйлсийн нэг бол хариуцлагаа ухамсарлах гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Залуусыг хариуцлагатай хүн гэдгээрээ бахархдаг байхыг би хүсдэг. Тэднийг ажил үүргээ ямар нэг нэр хүнд, шагналын төлөө, аль эсвэл хөгшин, уйтгартай хүмүүсийн таалалд нийцэхийн тулд хийгээсэй гэж би хүсдэггүй. Одоогийнхоос илүү хариуцлагатай залуу хүмүүс бол аливаа үндэстний аугаа итгэл найдвар юм. Гэхдээ хариуцлага нь ятгалгаас үүдэн бий болдог. Тиймээс бид залуусаас хариуцлагатай байхыг хүсч байгаа бол тэднийг хариуцлагатай байхаас өөр аргагүй болгох ямар нэг үр дүнтэй зүйлээр ятгах, итгэлийг нь төрүүлэх ёстой. Олон жилийн туршид манай орны иргэд ардчиллын наад захын үндсэн эрх чөлөөгөө хасуулсан. Тэдгээр он жилүүдэд Мьянмар улс Зүүн өмнөд Азийн хамгийн дэвшилтэт орнуудын нэг хэмээх хүндтэй байр сууринаас хасагдаж, хойно хоцорсон. Манай ард түмэн ардчилсан эрх, эрх чөлөөгөө хасуулаад зогсоогүй, дотоод үнэлэмж, хүндлэлээ алдсан юм. Ард түмэн дотоод үнэлэмжээ алдана гэдэг үндэстний хувьд ирээдүйн мөхөл гэсэн үг. Бирм улсдаа ардчиллыг буцаан авчрахын тулд бид ард иргэдээ өөрсдийгөө хүндэлж сургах хэрэгтэй байв. Ард иргэд маань ардчиллыг сайн сайхныг өөрсөддөө бий болгож, олж авахын төлөөх төгсгөлгүй аялал гэдгийг ойлгох хэрэгтэй болсон. Учир нь ардчилсан байгууллыг бэхжүүлэх хичээл зүтгэлд төгсгөл гэж үгүй юм. Ардчиллын төлөөх үндэсний лиг буюу манай намыг яагаад ардчиллын төлөө тэмцэж байгааг хүмүүс асуудаг. Тэдэнд би үргэлж "Бид ард иргэд маань эх орондоо эрх чөлөөтэй, аюулгүй ажиллах амьдрах эрхээр хангагдаасай л гэж хүсдэг" гэж хэлдэг.

Хэрэв ардчиллыг хөгжүүлэх гэж байгаа бол эрх чөлөө, аюулгүй байдлыг эрүүл, тэнцвэртэй хадгалах ёстой. Аюулгүй байдлын үүднээс манай ард түмний эрх чөлөө, аюулгүй байдал аль аль нь хангалтгүй байна. Тэд олон арван жилийн туршид үндсэн эрх чөлөөгөө хасуулсан. Эрх чөлөө талаасаа ч гэсэн өөрийгөө хүндэлдэг үндэстнүүдийн иргэн бүрийн хүртэх ёстой аюулгүй байдлыг ард иргэд маань эдлэхгүй байхыг бид хүснэ гэж үү. Тэгэхээр ардчилал гэдэг эрх чөлөө болон аюулгүй байдлыг эрүүл, тэнцвэртэй хадгалахыг хэлж байна. Энэ нь хариуцлага гэсэн үг. Бид зөвхөн өөрсдийн эрх чөлөөний төлөө бус, бусдын эрх чөлөөний төлөө хариуцлага хүлээж байгаагаа ойлгох хэрэгтэй. Үүний адил бид зөвхөн өөрсдийн аюулгүй байдлын төлөө бус, мөн бусдын аюулгүй байдлын төлөө хариуцлага хүлээж байна. Энэ нь бид яагаад хүчирхийллийн бус замыг сонгосны шалтгаан мөн. Хүчирхийлэл нь эрх чөлөө, аюулгүй байдлын аль алиныг нь заналхийлдэг. Биднийхийг ч, мөн бусдынхыг ч. Иймээс бид хүчирхийллийг хөсөр хаяж, ардчилалд хүрэхийг зорьж



байна. Энэ талаар хүмүүс мөн асуудаг. Хүчирхийллийн эсрэг хүч хэрэглэн цэргийн дэглэмийг унагаах гээд бүтэлгүйтсэн олон хүн байдаг. Учир нь, цэрэг гэдэг зэвсэгт хүчнээр л тодорхойлогдоно. Цэргийн дэглэмийг зөвхөн цэрэг, армийн хүчээр унагах боломжтой гэсэн итгэл, үнэмшлийг олон хүн тээж явсан. Харин би хэзээ ч үүнд итгэж байгаагүй. Хүн төрөлхтөн учир, шалтгаанд нээлттэй байдаг гэж би боддог. Энхтайван замаар өөрчлөлтийг авчирч болдог гэдэгт би итгэдэг нь шалтгаанд нээлттэй байдгийнх. Энхтайван замаар замнах нь хүчирхийллийн замаас урт удаан байдаг. Гэхдээ урт удаан замд бидний зорьж буй зорилгод хүрэх зам бол богинохон. Учир нь хүчирхийллийн хор уршгаар эдгэхэд маш олон жил шаардагдах олон гүн шарх үлддэг. Заримдаа тэдгээр шарх улам идээлж, удаан үргэлжлэх нь ч бий. Мөн эргэн тойрны хүмүүст хуваагдал, гуниг зовлон, гансрал, үл итгэлцлийг авчирдаг. Эдгээр шарх нь эдгэхдээ маш удаан бөгөөд хүрэхээр зорьж буй эцсийн зорилгыг улам холдуулдаг. Харин хүчирхийллийн бус зам урт санагдах ч эцэст нь үлдэх шарх, зовлон бага байдаг. Энхтайвны төлөөх замналаас үүдсэн шарх амархан бороолдог. Тайван замаар замнаснаар бид тавьсан зорилгодоо урт хугацаанд хүрэх ч олон бэрхшээлтэй тулгардаг. Мэдээж зэвсэгтэй хүний өөдөөс гар нүцгэн өөрийгөө хамгаалах хэцүү нь ойлгомжтой. Тэгэхээр хүчирхийллийн бус замаар ардчиллын төлөө тэмцэхэд шийдлийг олж, бат зогсох ёс суртахууны эрэмгий зориг илүүтэй хэрэгтэй. Бидний хүсч буй зүйл цаашид тогтвортой үргэлжлэх шийдэл болохоос амархан сарних зуурдын шийдвэр биш. Ардчиллын талаар хэтэрхий их ярьж байна гэж зарим хүн хэлэх байх. Энэ бүхэн тэгээд юуны төлөө юм, юу нь тийм гайхамшигтай юм бэ гэж тэд асуудаг. Ингэж хэлдэг хүмүүс ардчилсан эрх чөлөөг удаан эдэлсэн хүмүүс байдаг гэж бид боддог. Намайг Лондонд байх он жилүүдэд олон найз маань сонгууль өгөх сонирхолгүй байгааг би анзаарсан. Энэ нь улстөрчдийг шинжлэх ухааны хүмүүс, эрдэмтдээс дорд гэж үздэг сэхээтний хүрээн дэх өвөрмөц сэтгэлгээ бөгөөд өөрсдийгөө гадагш гарч, тэдний төлөө сонгууль өгөх нь зохисгүй гэж тэд бодож байсан. Үүнд би үнэхээр сэтгэл дундуур байсан бөгөөд учир нь би Англид байх үедээ огт сонгууль өгч үзээгүй. Намайг мэдээ орох үеэс л манай оронд шударга, чөлөөт сонгууль гэж байгаагүй. Нэр дэвшигчид болон намд өөрийн сонголтоор санал өгөх нь ямар болохыг би мэддэггүй байлаа. Тиймээс ч би Англид байгаа найзуудаа хандан сонгууль өгөх эрхээ эдлэх хэрэгтэйг хэлдэг байв. Учир нь энэ та бүгдийн үүрэг учраас эрхээ эдлэх ёстой гэж. Хэрэв та бүгд өөрийн саналаа өгч, үүргээ биелүүлэхгүй бол нэг л өдөр эрхээ алдах аюул бий. Найзуудаа саналаа өгдөг болтол нь хангалттай үглэсэн гэж боддог. Сүүлд би Японд айлчлахдаа ахмад хүмүүс залуусын талаар надтай адилхан гомдоллож байгааг харсан. Тэнд залуус санал өгөх сонирхолгүй аж. Миний бие Японы их сургуульд залууст зориулан тавьсан лекцэндээ саналаа өгөх эрхээ эдлээч гэж хэлсэн. Учир нь энэ бол мөн тэдний хариуцлага юм. Саналаа өгөхгүй байх нь эрх чөлөөгөө дороомжилж буй хэрэг. Түүнчлэн би одоо 68 настай ч чөлөөт, шударга сонгуульд нэг ч удаа саналаа өгч чадаагүйгээ тайлбарласан юм.

Манай оронд чөлөөт сонгууль 1990 онд болсон ч тэр үед би гэрийн хорионд байлаа. Би саналаа өгөхийг хүссэн. Хуулийн дагуу гэртээ хоригдсон ч саналаа өгч болох байв. Тиймээс санал хураалтыг миний өмнөөс зохион байгуулж, би харгалзагчийн хараанд санал өгсөн л дөө. Гэхдээ энэ бол өөрийн дэмжихийг хүссэн намд болон хүнд санал өгөх эрхээ эдэлсэн гэж үзэж болохгүй үйл явц байсан. Тухайн үед өөрийн амьдарч байсан хэсэгтээ намаасаа нэр дэвшихээр сонгогдсон ч нэр дэвшигчээс намайг түдгэлзүүлсэн. Харамсалтай нь дэндүү оройтсон учир манай намд тухайн тойрогт нэр дэвшүүлэх өөр хүн байгаагүй. Тиймээс л бид өөр намд саналаа өгөхөөс аргагүйдэж байлаа. Саналаа өгч чадсан гэж хэлж болох ч чөлөөт гэдэг ухагдахууны дор би саналаа өгч үзээгүй. Би өөрийн намын дэмжихийг хүссэн нэр дэвшигчийн төлөө саналаа өгч чадаагүй юм. Би үүнийг япон залууст тайлбарлаж, саналаа өгөх гэдэг хэчнээн үнэтэй эрх болохыг ойлгуулахыг зорьсон. Одоо ч би шударга, чөлөөт сонгуульд санал өгч үзээгүй л явна.

Өнгөрсөн жилийн дахин сонгуулиар төрсөн газрын минь суудал сул байгаагүй. Тиймээс би өөр газраас төрд гарсан. Тэр хэсэгт харьяаллаа шилжүүлэлгүйгээр саналаа өгч болохгүй байсан л даа. Тиймээс би одоо ч шударга ардчилсан сонгуульд саналаа өгөөгүй байгаа.

Монголын санал өгөх эрхтэй бүх залууст та бүгд эрхээ эдлэх ёстой шүү гэж хэлье.

2010 оны сонгулиас өмнө хүмүүст үүнийг их энгийнээр тайлбарлахыг хичээсэн. Гэвч тэдгээр сонгуулийн

үеэр НҮБ-ын тодотголоор бид гүн шархалсан байв. Сонгуульд итгэх хүмүүсийн итгэл 2010 оны сонгуулиар төдийлэн сайжраагүй. Тиймээс түрүү жилийн бидний гол зорилгуудын нэг 45 тойрог бүхий сонгуулийн хэсэгт очиж саналаа өгөхийг уриалах явдал байлаа. Бидний уриалга их энгийн. Ямар нийгэмд амьдармаар байна, түүнийгээ тэд өөрсдөө шийдэх ёстой байв. Өөрөөр хэлбэл тэд улс, үндэстнийхээ ирээдүйд хариуцлагатай байх хэрэгтэй болсон. Хариуцлагатай байх нэг зам нь ганц л өдөр сонгуульд саналаа өгөх юм. Мөн хүн бүрийн санал өгөх эрх Ерөнхийлөгчийнхтэй адил эрх тэгш. Түүнд санал өгөх ганцхан эрх байдагтай ижил бусад жирийн иргэн бүрт нэг эрх бий. Тиймээс та бүхэн саналаа өгөх хэрэгтэй гэж бид ард түмнээ уриалсан. Учир нь энэ бол иргэний дээд эрх. Ерөнхийлөгч хүртэл чамаас давуу эрхгүй. Эцэст нь бидний кампанит ажил чамгүй амжилт дагуулж, сонгуульд оролцох эрхтэй хүмүүсийн 70 гаруй хувь нь санал хураалтад оролцсон. Чөлөөт, ардчилсан сонгуульд дасал болоогүй манай ард түмны хувьд дээрх тоо нь гайхалтай үр дүн байлаа. Түүгээр зогсохгүй, манай ард түмэн сонгох эрх нь давуу байдал гэдгийг ойлгож эхэлсэн. Тиймээс ардчилал, эрх чөлөөний төлөөх замнал бол хүний оюун ухаан, зүрх сэтгэлээр дамждаг жим юм. Хүмүүст ардчиллын үйл явцад оролцох нь эрх төдийгүй үүрэг хариуцлага юм гэдгийг ятган ойлгуулах ёстой. Энэ эрх чөлөө бол хууль ёсонд захирагдахыг хүлээн зөвшөөрч, үүрэг хариуцлагаа ухамсарласан эрх чөлөө юм. Хууль ёс бол ардчилсан тогтолцоог бий болгоход асар чухал. Бид хууль ёс гэдэг шударга үнэнд нийцсэн тохиромжтой хууль гэсэн үг гэдгийг ойлгох ёстой. Хууль ёс гэдгээр бид Засгийн газар соёрхон баталсан тэдний эрх ашгийг хамгаалж, ташуурыг нь зузаатгасан хууль гэсэн утгаар нь хэлээгүй.

Өнгөрсөн жил манай нам сонгуульд өрсөлдөхөд бидний мөрийн хөтөлбөрт багтсан голлох ажлуудын нэг нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдал байлаа. Тус Үндсэн хууль нь 2008 онд бүх нийтийн санал асуулгаар батлагдсан хууль. Түүн дээр Үндсэн хуулийг батлахад нийт иргэдийн 92 хувь нь саналаа өгсөн гэдэг. Гэвч энэ тоо тун эргэлзээтэй. Үүнийг хойш нь тавиад харвал тус хууль маш сайн суурь бүхий хэсгүүдтэйд эргэлзэх зүйл үгүй. Үндсэн хууль бол улсын амин сүнс. Хэрвээ ардчилсан Засгийн газар тогтвортой, уян хатан урагшлая гэвэл амар тайван, өрнөл бүхий нийгмийг бүрдүүлж чадах хүмүүст хүлээн зөвшөөрөгдсөн шударга Үндсэн хуультай байх нь зайлшгүй юм. Хүмүүсийн итгэл төрөөгүй Үндсэн хууль бол жинхэнэ ардчилалд хүргэх хууль биш. Үндсэн хууль бол дээд хууль учир нэмэлт өөрчлөлт хийхээс өөр арга үгүй. Бид Үндсэн хуулиа хамгийн сайн нь байгаасай гэж хүсч байна. Ард түмний олонх нь хүлээн зөвшөөрсөн хууль байх ёстой.

Бирм бол олон хүний гэр. Манай улс олон үндэстэн ястнаас бүрддэг. Манай улсын дотоодын ялгаатай байдал бидний үндэстнээрээ бахархах хүчин зүйл. Харамсалтай нь бид үүнийгээ хараахан сайн ойлгоогүй байна. Өөр байдлыг хүч гэж харахаар тэрхүү ондоошил нь биднийг заналхийлж байгаа мэт боддог хүн олон бий. Гэвч тийм биш. Хамаагүй өөр байна гэдэг харьцангуй олон боломж гэсэн үг. Амар тайван, харилцан зохицол дунд амьдарч сурах боломж юм. Бие биенээсээ өөр ондоо байдлыг үл харгалзан бид 1988 оноос хойш үндэсний нэгдлийн төлөө зүтгэж ирлээ. Ардчиллын төлөөх зам ч үндэсний эв нэгдлийн төлөөх зорилгод суурилж эхэлсэн. Бидэнд улс төрийн хүчин, ард түмний зүгээс хүлээн зөвшөөрсөн Ардчилал хэрэгтэй. Зөвхөн нэг нь хүлээн зөвшөөрснөөр хол явахгүй.

Цэргийн дэглэм олон жил ноёрхсоны дараа манай ард түмний дийлэнх нь цэргийнхэнд дайсагнах хандлагатай болчихсон. Гэвч үүнийг өөрчлөх хэрэгтэй. Бирмийн армийг энэ үндэстэнд тусгаар тогтнол авчрах гэж байгуулсан түүхтэй. Миний аав Бирмийн армийг 1940 онд байгуулж байхад, тэд илүү олон хүмүүсээр хүрээлүүлж, хайрлуулдаг байлаа. Манай ард түмэн цэргүүдийг хамгаалагч гэж хүлээн авдаг байв. Бид тийм л хандлагыг иргэдийнхээ дунд хадгалж үлдэх ёстой юм. Иргэний нийгэм, цэрэг арми хоорондын ойлголцлыг олон жилийн өмнөх бахархлаар хэмжигддэг байсан шигээ болж, эргэн сэргэнэ гэдэгт итгэж байна. Үндэсний эв нэгдэл сэтгэл зүрхнээс бий болох ёстой. Ийм л учраас бидний ардчилал, эрх чөлөөний төлөөх зам хүмүүсийн зүрх сэтгэл, оюун ухаанаар дамжин бий болох учиртай. Бид хүмүүсийг итгэ гэж хүчилж чадахгүй. Итгэсэн мэт дүр үзүүлж чадах ч үнэн итгэлцэл албан хүчээр бий болдоггүй. Харин ухамсарт нь хүргэх замаар л үүсдэг. Хүчээр шийдсэнээс илүүтэй хүн амын дийлэнх хэсгийг ятгах замаар тодорхой үнэт зүйлүүдийг хүлээн зөвшөөрүүлэх нь хугацаа их шаарддаг. Авторитар/Захиргаадалтын дэглэмийн дор амьдарч байсан Монголын иргэд магадгүй үүнийг илүүтэй сайн ойлгох биз ээ. Өөрийн өмнөх дотоод үнэлэмж, итгэлээ өөрчилж, одоогийнхтой нийцүүлнэ гэдэг ямагт хэцүү болохыг та нар мэднэ. Бид ард түмнээ дотоод ертөнцдөө зөрчилдөж, гаднаа нийцсэн мэт жүжиглэж, улмаар тарж бутраасай гэж хүсэхгүй байна. Хүмүүс итгэл үнэмшил, бодол саналаа чөлөөтэй илэрхийлж болох ч бусдад хохирол учруулах замаар эрхээ эдэлж үл болохыг ямагт санах нь зүйтэй. Бусдын эрх гэдэг өөрийн чинь эрхтэй адил юу юунаас илүү чухал. Зөвхөн өөрийн эрх, ямбаа бодож бусдынхыг огоордог хэсэг бүлэг ардчиллыг ойлгодоггүй.

Ардчилал өөр ондоо байдлыг нэг үнэт зүйл дор нэгтгэдэг. Энэ бол бусдын санаа бодлыг өөрийнхийгөө зөв гэж боддогтой адил хүлээн авч, үнэлж дүгнэх тухай юм. Өөрийгөө бусдаар хүндлүүлэхийг хүсдэг шиг бусдынхыг мөн хүндэлж сурна гэсэн үг. Эцэст нь, Ардчилал бол хэцүү байдаг шигээ амархан зүйл. Хүний нэр төр, үнэлэмжийг өөрийнх шигээ хүндлэхэд л ардчилал суурилдаг. Ийм учраас хүний эрхийг ардчиллаас салгах боломжгүй. Тиймээс л бид ардчилал, хүний эрхийн төлөөх тэмцлийн тухай ярьдаг.

Ардчилал бол тогтоон барихад хамгийн хэцүү тогтолцоонуудын нэг. Бид зөвхөн тэмцлээ зориулаад зогсохгүй түүний төлөө амьдрах хэрэгтэй. Зарим үед тогтолцооны төлөө амьдрахаас илүү тэмцэх нь амархан байдаг. Ардчилал руу алхах хамгийн хэцүү үе нь хувьсгалын тактикуудаа больж, илүү боловсронгуй улстөрч аргаар зорилгодоо хүрэх цаг нь болсныг




*Ан Сан Су Чи: Олон орны хүмүүстэй тэр дундаа залуустай хамтрах боломж олдоно гэдэг миний хувьд маш олзуурхуушатай санагддаг. Би үргэлж хэлдэг шигээ Монголын залууст ч мөн та бүхэн хүн төрөлхтний найдвар шүү гэж хэлмээр байна.*

ойлгох юм. Ардчиллын чухал чанар нь сөрөг хүчнээ хүлээн зөвшөөрөх байдаг. Эрүүл сөрөг хүчин эрүүл ардчлалыг хадгалах нөхцөл болдог. Би өөрийн улсдаа сөрөг хүчнээ төлөөлдөг. Манай намын хувьд олон түмний дэмжлэгийг нэлээд хүлээсэн нам гэж боддог. Бусад намаас илүү дэмжлэг хүлээдэг гэж хэлмээр байна. Хууль тогтоох байгууллагын хувьд бид 600 гаруй гишүүн дундаа ердөө 45-уулаа. Гэвч тэдгээр 600 хүн эрх баригч намд харьяалагддаггүй. Тэд олон үндэстний олон намаас бүрддэг. Эрх баригч Үндэсний нэгдэл, Хөгжлийн төлөөх эвлэлийн намаас гаднах Парламентад хамгийн олон суудалтай нам нь манайх юм. Хэдийгээр тоогоор цөөн ч хууль тогтоох байгуулал хамтран ажилладаг учир манай нам хүчтэй сөрөг хүчин байж чаддаг. Дээд, доод танхимийн дарга гар, гараасаа барилцан, хамтарч намуудад шударга ханддаг. Иймээс Парлементад хэлэлцэж буй асуудлуудад бидний оролцоо өндөр. Энэ нь эв нэгдэл боломжтой бөгөөд, хамтарч ажиллах нь өнгөрсөнд өширхөж, бие биенийхээ эсрэг ажиллаж ирсэн үеэс илүү удаан, тогтвортой зам гэдгийг харуулж буй хэрэг юм. Бид өнгөрснийг ирээдүйн хичээл болгон ашиглах ёстой болохоос дөнгө болгож болохгүй. Хэрвээ бид өнгөрснөөр хөлөө тушиж, юу үзэж өдийг хүрсэндээ шаналсаар байвал өнгөрсөн рүүгээ буцсаар л байх болно. Үүнийг бид хүсэхгүй. Өнгөрсөн үе гэдэг нам, үндэстэн, ард түмний хувьд ирээдүйд алдаагаа давтахгүй байх хичээл юм. Хэрвээ бид өнгөрснөө дээш гарах шат болгон ашиглаж, илүү сайхан ирээдүй өөд зүтгэвэл, ичих зүйл үгүйгээр ардчилал, эрх чөлөөний аль алинд нь хүрэх нь дамжиггүй. Ирээдүйд үр хойчид маань ч ичих зүйл үгүй юм. Ялалтад хүрэх замнал нь ялалт шигээ үнэтэй.

Залууст “Буруу замаар амжилт олсноос зөв замаар алдсан нь дээр” гэж үргэлж хэлдэг. Учир нь ичгүүр сонжууртай, буруу замаар ирсэн амжилт бол жинхэнэ амжилт биш. Энэ бол хүн төрөлхтний ёс суртахууны хамгийн том алдаа юм. Харин бүтэлгүйтлээ даван гарч, илүү чадварлаг хүн, байгууллага, үндэстэн болж чадвал энэ бол алдаа бус ирээдүйд хүрэх гүүр юм. Ардчилал бол сурах үйл явц.

Сайн, муу, тэнэг, цэцэн гэж би ялгадаггүй. Харин сурч чадах, чадахгүй гэж хүмүүсийг ялгадаг. Сурна гэдгийг би ном сурах, бичиг, анги танхим, амьдралаас сурах тухай гэж ойлгодог. Хэрвээ бид ардчилалд хүрэхийг хүсвэл мөн тэрхүү амжилтаа удаан оршин тогтноосой гэж хүсч байвал бид үргэлж суралцагсад байх ёстой. Бид насан туршдаа сурахад өөрсдийгөө бэлдэх нь зүйтэй. Ардчилалд хүрчихлээ гэж хэлэх нь зөвхөн хангалттай биш. Ардчиллын



үнэ цэнэ нийгмийн амьдралд гүн үндсээрээ сууж, бат оршиход бид анхаарах ёстой. Ардчилсан байгууллалууд нь хүчтэй, үе уламжилсан байх нь зөв юм. Энэ бол бидний үр хойчдоо үеэс үед өвлүүлж үлдээх ёстой үүрэг, хариуцлага. Залуу үеэ суралцагч, үндэстнээ суралцагсад болгож чадахгүй аваас бид хүрсэн ардчиллынхаа алтан үнэ цэнээ тогтоон үлдээж чадахгүй. Бирм улс өнөөдөр ардчилалд нэвтрэх хаалганы өмнө зогсож байна. Бид хаалгаар хараахан орчихоогүй байна. Зүгээр л үүдэн дээр тулаад зогсож байгаа. Бидэнд олон боломж нээгдэж байгаатай адил олон аюул хаалга тогшин зогсож байна. Мөн аугаа их итгэл найдвар бидэнд бий. Хэрвээ бид боломжоо буруу ашиглавал, ийм боломжийг дахин олж авахад дахиад хэдэн жил зарцуулахыг төсөөлөхөд бэрх. Тиймээс манай улсын хувьд ямар сорилтуудтай нүүр тулах гэж байгаагаа сайн мэдэх нь чухал. Сорилтуудтай нүүр тулж байгаа энэ үед бид дэлхийн өнцөг, булан бүрт буй нөхөддөө, мөн эхлэл нэгтэй монгол найзуудаа хандаж байгаа. Би энд ирээд танай Ерөнхийлөгчтэй их сонирхолтой яриа өрнүүлж, түүнд манай улсын иргэд ч мөн хөх толботой төрдөг гэдгийг хэлсэн. Тиймээс бид холбоотой хүмүүс гэхэд эргэлзэх зүйл үгүй. Бид дэлхийн олон найзаасаа тэр дундаа төрөл садан монголчуудаасаа олон сорилттой тулгарч, гүн үндэст ардчилал, эрх чөлөөг ойрын ирээдүйд эх орондоо авчрахад туслаач хэмээн хүсч байна. ■

2013.05 САР. №043

# БАНК, САНХҮҮ

*Ардчилал хөгжсөн 25 жилд Монголд хамгийн сайн хөгжсөн салбар бол банк, санхүү. Өдгөө Монголын санхүүгийн салбарын 95 хэртэл хувийг дангаараа банкны салбар эзэлдэг. Тэгвэл хөгжлийн гарц шийдэл үгүйлэгдэж буй эдийн засгийн энэ хүндрэлтэй цаг үед санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх шаардлага бий. Тус зах зээлийг хөгжүүлэх боломж ямар байна вэ?*







М.Болд /Монголын банкны холбооны ерөнхийлөгч/



Г.Ганболд /"Голомт" банкны гүйцэтгэх захирал/



Д.Хүрэлбаатар "Худалдаа хөгжлийн банк"-ны гүйцэтгэх захирлын орлогч



Норихико Като / ХААН банкны гүйцэтгэх захирал/



Д.Батсайхан /"Төрийн банк"-ны гүйцэтгэх захирал/

*Монгол Улсад банкны салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой энэ онд тохиож буй. Тиймээс "Mongolian Economy" сэтгүүл томоохон банкуудын захирлуудыг "Редакцийн уулзалт"-даа урилаа. Банкны салбарын хөгжил, цаашдын ирээдүйн талаар бид хөндөн ярилцсан юм.*

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

# "Валютын ханшийн эрсдэлээс гарах гарц бол монголчууд хийж бүтээж сурах"

**-Юуны өмнө Та бүхэнд Монголд банкны салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын мэнд дэвшүүлье. Ойн хүрээнд "Банкны ногоон төгөл"-ийг бий болголоо. Ногоон хөгжлийг банкны салбарынхан хэрхэн харж байгаа талаар яриагаа эхлэх үү?**

М.Болд: -Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд өнгөрсөн долоо хоногт /2014.05.16/ банкны ажилтнууд "Банкны төгөл" нэртэй ногоон байгууламжийг байгууллаа. Энэ нь банкны салбар зөвхөн санхүү, ашгийн төлөө явдаггүй гэдгийг харуулж буй хэрэг. Байгаль орчинд ээлтэй ногоон орчинг бий болгох, түүнийг хамгаалахаас гадна олон нийтэд илүү хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх хүсэл эрмэлзлэлийн бэлгэ тэмдэг болсон гэж бид үзэж байна. Өнгөрсөн онд банкууд тогтвортой санхүүжилт нэртэй үүсгэл санаачилгыг эхлүүллээ. Энэ хүрээнд ирэх жилээс банкнаас зээл авч буй харилцагчдад байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй эсэхийг харгалзан үзсэн нөхцөл шаардлага тавина.

**Г.Ганболд:** -Банкууд зээлийн шаардлага болон бусад эрсдэлийн бодлогын баримт бичигтээ байгаль орчныг хамгаалах, ээлтэй бизнесийг түлхүү дэмжих чиглэл баримтлах юм. Банкуудад өмнө нь ийм бодлого байсан. Харин одоо үүнийг гүнзгийрүүлж, уул уурхай эрчимтэй хөгжиж буй энэ үед нөхөн сэргээх үйл ажиллагаанд түлхүү дэмжлэг үзүүлэх ёстой юм. Энэ утгаараа ногоон орчинг шинээр бий болгоход анхаарна. Тухайлбал, "Голомт" банк хүлэмжийн аж ахуйг дэмжихээр нэлээд төсөл хөтөлбөрт санхүүжилт өгөхөөр ярилцаж байна. Ялангуяа дэвшилтэт технологитой өвлийн хүлэмжүүдийг шинээр байгуулах, байгальд ээлтэй шинэ төрлийн хүлэмжийг дэмжиж, санхүүжүүлэх бодлого барьж байгаа. Ногоон хөгжил гэхээр бид нэг тал руу хэт туйлширч болохгүй. Манайд уул уурхай, тэргүүлэх салбар болон хөгжиж байна. Үүн дээр банкуудын хандлага нь зохистой санхүүжилтийг хийх юм. Тэгэхээр Засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтарч шаардлага тавих, уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд анхаах нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг санхүүжилтийн төлөвлөгөөнд нь тусгах нь чухал байна.

**Д.Батсайхан:** -Банк гэхээр хүмүүс мөнгө боддог. Банк мөнгөн урсгалыг зохицуулдаг бизнесийн байгууллага байхаасаа гадна нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж чаддаг байх ёстой. "Сайн яваагаа мэдэрч байгаа бол сайн сайхны төлөө ажил хийж бай" гэсэн үг байдаг. Тэгэхээр хувь хүний болон компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах нь зүйн хэрэг. Энэ утгаараа банкууд хамтран нийгмийн сайн сайхны төлөө олон ажил хийж буйн нэг нь "Банкны ногоон төгөл" юм. Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглахад банкууд хамтарч ажиллаж байна. Үүнээс гадна банк бүрт нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа ажлууд бий. Тухайлбал, "Төрийн банк"-ны хувьд байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих "Хүрээлэн" төслийг эхлүүлээд байна. Бид байгаль орчныг хамгаална гэхээр мод тарих мэтээр сэтгээд байдаг. Эцсийн дүнд байгаль орчныг хамгаална гэдэг нь түүнийг танин мэдэх асуудал юм билээ. Энэ талаарх мэдлэгийг боловсролоор дамжуулан олгох үүднээс уг төслийг манай банк эхлүүллээ.

**Норихико Като:** -Энэ жил бид Монголын банкны салбар үүсч, хөгжсөний 90 жилийн ойг тэмдэглэж байна. Өнгөрсөн 90 жилийн хугацаанд тэр дундаа

сүүлийн 20 гаруй жилд Монголын банкны салбар хурдацтай өсч, эрс өөрчлөлтийг харуулж чадсан. Би Монголд ирээд гурван жил болж байна. Энэ богинохон хугацаанд банкны салбар шинэ технологиудыг нэвтрүүлж, дэлхийн жишиг болсон арга техникийг хэрэгжүүлэн, ил тод байдал болон бусад дэвшлүүдийг хөрсөндөө суулгаж эрчимтэй өөрчлөгдөж байгааг биеэрээ мэдэрч байна. Өмнө нь бид дор бүрнээ өөр өөрсдийн ажилдаа анхаардаг байсан бол манай захирлуудын дурьдсанчлан, банкууд ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийн талаар ярилцаж, зарим талаар хамтарч ажиллаж байна. Монголын эдийн засагт хүчтэй санхүүгийн салбар хэрэгтэй. Тиймээс хамтдаа урагшилцгаая.

**-Та бүхэн Монголын банкны салбарын туулсан түүхэн замналыг сайн мэдэх хүмүүс учраас өнгөрсөн хугацааны ололт амжилтаас товчхон хуваалцахгүй юу. Банкны салбар санхүүгийн зах зээлийн 95 хувийг дангаар хангадаг болтлоо хөгжиж чадсаны гол учиг нь юу гэж боддог вэ?**

**М.Болд:** -Монголын банкны салбарт өнөөдрийн байдлаар 10 гаруй мянган хүн ажиллаж байна. Нийт 1.2 сая орчим хадгаламж эзэмшигч, 690 орчим мянган иргэн зээлийн үйлчилгээ авсан. Үүнээс Монголын өрх бүр зээлтэй гэсэн статистик харагдаж буй юм. Бараг хүн бүр банкинд данстай. Улсын хэмжээнд банкны 1500-гаад салбар, нэгж байна. Үүнээс 1000 гаруй нь хөдөө орон нутагт байдаг. Нийт 20 гаруй их наяд төгрөг банкуудад эргэлдэж байна. Энэ нь ДНБ-ий 119 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө юм. Эдгээр үзүүлэлтээр бид манайхтай ижил хөгжилтэй орны түвшинд очсон гэсэн үг. Хөрш зэргэлдээ орнууд болон олон зуун сая хүн амтай, том эдийн засагтай зарим улс ч банкны үйлчилгээг хүн амдаа бүрэн төгс хүргэж чадаагүй байгаа. Бидний дээр дурьдсан тоонд хүрэх гэж мөрөөдөж байна. Тоо талаас нь харвал Монголын банкны салбар маш сайн урагшилсан гэж үзэж болно.

**Д.Батсайхан:** -Түүхэн хөгжил, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг нь манай захирлууд ярьсан учраас би бүтээгдэхүүн үйлчилгээний талаар ярья. Сүүлийн 20 гаруй жилд дэлхийн технологид нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг Монголд нэвтрүүлэхээр банкууд түлхүү ажилласан. Технологийн дэвшилд суурилсан банкны тогтолцоо үүссэн энэ үе банкны системд нэлээд жинтэй байр суурь эзлэх байх. 2013 онд Азийн банкны холбооны чуулган манай улсад болсон. Тэнд ирсэн хүмүүс Монголын банкны тогтолцоо дэлхийн жишигт хүрсэн байна гэж дүгнэсэн. Энэ бол бид зөвхөн дотооддоо биш олон улсад үнэлэгдсэн гэсэн үг. Банкны бүртгэл санхүүгийн асуудал ч банкныхан нэлээд төгөлдөржсөн. Гар аргаас техник технологи рүү шилжлээ. Одоо бүртгэлийн систем олон улсын стандарт руу шилжиж байна. Олон улсад санхүүгийн тайланг уншиж болох хэл рүү шилжиж орсон нь томоохон амжилт юм.

**Г.Ганболд:** -90 жилийн түүх гэдэг ололт амжилт, бэрхшээлтэй нүүр тулсан цаг хугацаа. Монголын банкны салбар зөвхөн дотоодын арилжааны банкуудаар хэмжигдэхгүй түвшинд хүрчээ. Сүүлийн 20 гаруй



HAPPY CITY GROUP
монгол дахь албан ёсны гэрээт борлуулагч




Missha 's slogan has its meaning starting from
" The real **beauty** is **loving yourself** "
**LOVE YOUR SKIN LOVE YOUR SOUL**
Missha will always be together with the
process of finding your beauty and value.

# MISSHA

LOVE YOUR SKIN LOVE YOUR SOUL

Хаяг: MISSHA1 - УИД-ийн зүүн талд
MISSHA2 - 3,4 хороолол APEX худалдааны төв 1 давхар
MISSHA3 - Зайсан дахь Оргил Шилтгээн худалдааны төв 1 давхар

Утас: 7011-3234
9906-0318

жил банкууд өөрөө өөрсдийгөө бүтээсэн. 1998, 2008 оны хямралыг амжилттай даван туулсан. Уул уурхайгүй байхад Монголын банкууд ихэнхдээ өөртөөгөө зэрэгцэн явж буй хувийн хэвшлийг хамтдаа авч явсан. Сүүлийн жилүүдэд гаднаас шууд болон шууд бус санхүүжилт орж ирж буй учраас олон улсын оролцоо нэмэгдэж байна.

**Норихико Като:** -Миний бодлоор энэхүү хөгжлийн гол хүчин зүйл нь банкуудын хоорондын өрсөлдөөн болов уу. ХААН банк хувьчлагдах үед Монголын хөдөө аж ахуйн банк нийт 260 салбар нэгжтэй, Улаанбаатар хотод ердөө хоёрхон салбартай байв. Тиймээс ХААН банкны өмнөх удирдлагууд хичээнгүйлэн ажиллаж, орон нутагт болон нийслэлд хүрээгээ тэлж чадсан. Одоо бид орон даяар 530 салбартай болоод байна. Үүнтэй зэрэгцэн бусад банк ч хүчин чармайлт гаргасан учраас нийслэлийн харилцагч нар хүссэн банкиндаа хандах боломж бүрджээ. Орон нутагт ч мөн адил, нэг суманд гэхэд л 2-3 банкны салбар үйл ажиллагаа явуулж байх жишээтэй. Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагууд банкуудыг өрсөлдүүлсэн нь ухаалаг алхам болсон гэж боддог. Үүний үр дүнд банкны зах зээл маш өрсөлдөөнтэй болж, хурдацтай өссөн.

**-Банкны салбарын түүхэн хөгжлийн явцад бий болсон олон ололт амжилтын нэг нь моргейж буюу найман хувийн хүүтэй орон сууцны зээл. Олон жил ярьсан зүйлийг жилийн өмнөөс ажил хэрэг болгож чадлаа. Цаашид банкны салбар моргейжийн зээлийг урт хугацаанд авч явах боломж хэр байгаа вэ?**

**Д.Хүрэлбаатар:** -Засгийн газраас хэрэгжүүлж буй энэ хөтөлбөрт Арилжааны банкууд ч идэвхитэй хамтран ажиллаж байна. Нийслэлээс ч орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр ярилцаж байна. Улаанбаатарт хүн амын төвлөрөл өндөр. Нийслэлд газар нь байгаа учраас банкуудтай хамтарч болно шүү дээ.

**М.Болд**: -2014 оны нэгдүгээр улирлын статистик мэдээллээс харахад банкнаас хамгийн их зээл олгосон нь худалдаа, үйлчилгээний салбар байсан бол дараа нь орон сууцны санхүүжилтын зээл байсан. Өмнө нь байрны зээл нэлээд хойгуур байр эзэлдэг байв. Сүүлийн хоёр жил орон сууцны ипотекийн зээлийг Засгийн газар, Монголбанк, арилжааны банкуудтай хамтарч эрчимтэй олгосны үр дүнд амжилттай хэрэгжиж байна. Энэ хугацаанд 20 гаруй мянган хүн жилийн найман хувийн хүүтэй орон сууцны зээлд хамрагдсан байна. Үүнийг өмнөх жилүүдтэй харьцуулахад өдөр шөнө шиг ялгаа харагдана. Цаашид энэ эрчээ алдахгүйгээр явуулахад хамтын хүчин чармайлт чухал байгаа юм.

**Д.Батсайхан:** -Сайн ойлголцоод, хамтраад эхлүүлбэл аливаа асуудалд болохгүй зүйл гэж байдаггүй гэдгийг найман хувийн хүүтэй орон сууцны зээл харууллаа. Өмнөх Засгийн газрын үед жилийн зургаан хувийн хүүтэй "100 мянган айлын орон сууц" хөтөлбөр эхлүүлсэн. Үүний гол ачааг үүрч явсан банк нь манайх. Бид тухайн үед жил гаруйн хугацаанд 1600 гаруй хүнд зээл өгсөн. Тогтолцоо нь буруу байсан учраас тодорхой хайрцагласан хэдэн хүний хүрээнд хомсдолтой эх үүсвэрээр явуулсан нь сөрөг үр дүн авчирсан. Банкууд ч орох сонирхол багатай байв. Энэ мэт туршлага дээр суурилагдаж найман хувийн хүүтэй зээлийг гаргаж ирсэн. Ингэхдээ гурван зүйлийг нь өөрчилсөн юм. Хамгийн түрүүнд, хүүг нь нээлттэй, банкуудад орох бололцоотой нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Хоёрт, харилцагчдын хувьд тодорхой хязгаар тавиагүй. Гуравт, барилгын компаниудын оролцоог нээлттэй болгосон. Ингэснээр өмнө нь арилжааны банкуудад байсан маш олон орон сууцны зээл найман хувь руу шилжсэн. Энэ нь нэг харилцагч дээр сард 150-300 мянган төгрөгийн хүүгийн хөнгөлөлт гарч ирж буй юм. Өөрөөр хэлбэл, шууд бус аргаар цалин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний хөтөлбөр болж чадсан. Энэ зөвхөн ганцхан жишээ. Бид цаашид төр засагтайгаа ойлголцоод аль аль талынхаа эрх ашгийг төвлөрүүлсэн хөтөлбөр боловсруулж чадвал амьдрал дээр хэрэгжих юм. Одооны тогтолцоог би их зөв гэж бодож байгаа. Нөгөөтэйгүүр иргэд тодорхой зорилготой амьдрах хэрэгтэй. Ингэхийн тулд эхлээд хуримтлал бий болгож, дараа нь зээл рүү шилжвэл үр дүнтэй. Энэ хүрээнд "Төрийн банк" өнгөрсөн жил орон сууцны зээл-хадгаламж гэсэн хосолсон бүтээгдэхүүнийг бий болгосон. Өөрөөр хэлбэл, тухайн иргэн орон сууцны хадгаламж нээлгээд би сар бүр зээлтэй бол хэдэн төгрөг төлөх вэ гэж бодуулаад хийгээд байж болно. Таны төлсөн мөнгө хүүтэйгээ хамт орон сууцны урьдчилгаа төлбөрийн 30 хувийг хангасан өдөр найман хувийн хүүтэй зээл рүү хөрвөх юм.

**Г.Ганболд:** -Орон сууцны зээл санхүүгээс гадна хөрөнгө оруулалтын томоохон хэрэгсэл юм. Хүний амьдралын урт хугацааны хөрөнгө оруулалтыг шийдэж өгч буйгаараа иргэдийг тогтвортой ажлын байртай байлгах, илүү бүтээмжтэй ажиллах хөшүүргийг бий болгож өгч байна. Монголын банкууд 15-16 жил моргейжийн зээл дээр ажилласан туршлагатай. Олон улсын зах зээлд гарах бүрэн бололцоо бий. Орон сууцны зээлд хамрагдах гэхээр 20-30 хувийн урьдчилгаагаа өгч чадахгүй байх тохиолдол түгээмэл. Үүнийг шийдэх олон гарц байгаа байх. Манай банкны хувьд "Мандал" даатгалтай хамтран орон сууцны тодорхой хувийн эрсдэлийг тэд хариуцахаар туршилт хийж эхэллээ. Өөрөөр хэлбэл, залуу гэр бүл 10 хувиа гаргаад үлдсэн 20 хувийнх нь эрсдэлийг даатгалын компани хариуцаад явах тухай юм. Манайхан бага хуримтлуулж, их зарцуулаад байх шиг. Хуримтлалыг бий болгох сайн хэрэгслүүд бий болж байна.

**-Банкны салбар өнгөрсөн хугацаанд өөрөө өөрсдийгөө бүтээсэн гэж хэллээ. Монголын санхүүгийн үйлчилгээний 95 хувь банкны систем дээр тогтож байна. Бид эдийн засгаа тэлэхийн тулд үүнээс өөр хувилбар сонгох ёстойг мэргэжилтнүүд хэлдэг. Энэ асуудалд та бүхэн ямар байр суурьтай явдаг вэ?**

**М.Болд:** Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг банкныхан эзэлж байна гэдэг банкуудын сайных гэж хэлж болно. Доголдоод байгаа нөгөө хэсэг нь хөрөнгийн зах зээл. Үүнийг идэвхжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчноо сайжруулахын зэрэгцээ шүүхийн тогтолцоо шударга байх хэрэгтэй. Мөн санхүүгийн эх үүсвэр байх ёстой. Энэ гурав нийлж байж

хөрөнгийн зах зээл хөгжинө. Банкны салбарын хувьд хийх зүйл маш их байна. Тухайлбал, банкны том зээл олгох чадварыг суулгах шаардлага бий. Улсын хэмжээнд өрнөж буй томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх чадвар нэг талаараа дутмаг байгаа. Тиймээс банкуудын өөрсдийнх нь хөрөнгө татах чадварыг нэмэгдүүлэх ёстой.

**-Та бүхэн цаашдын салбарын хөгжлөө хэрхэн харж байна вэ. Уул уурхайгаас гадна газар тариалан, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл авахад банкны шаардлага өндөр хэвээр байгааг бизнесмэнүүд хэлдэг. Тухайлбал, "Чингис" бондын хөрөнгөөр санхүүжих төсөл банкны босгын наана үлдэх нь их болсныг ч хэлж байсан.**

**Д.Хүрэлбаатар:** -Банк бүр өөрийн онцлогтой. Нийтлэг шинжтэй үйл ажиллагаа ч явуулж байгаа. Худалдаа хөгжлийн банкны хувьд томоохон харилцагч нарт зориулсан үйлчилгээг түлхүү хэрэгжүүлдэг. Хөрөнгө мөнгө босгоход Монголын улс төр, эдийн засгийн орчноос ихээхэн шалтгаалдаг. Бид өөрийн хэмжээнд хөрөнгө татахаас эхлүүлээд бонд босгож, эдийн засагт болон үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

**Д.Батсайхан:** -Банкны системийн цаашдын хөгжил гэдэг дээр би хэдэн зүйл хэлье. Санхүүгийн секторын 95 хувийг банкны салбар бүрдүүлж байгаагаас харвал манай улсад банкны системийн хөгжил нэлээд өндөр түвшинд очсон байна гэж болох. Гэтэл нөгөө талдаа олон улсын түвшинд авч үзэхэд, Монголын банкууд жижиг хэвээрээ байгаа. Эдийн засаг өсөхийн хэрээр банкнаас шаардах зүйлүүд өсч буй учраас өргөжих, хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага бий. Мөн банкны систем цаашид тогтвортой хөгжихөд эрх зүйн зохицуулалт сайн байх нь чухал. Банкны системийн хөгжил эрх зүйн орчноосоо түрүүлээд байгаа. Цахим төлбөр тооцооны хэрэгслийг банкууд аль хэдийнэ хэрэгжүүлж эхэлсэн ч үүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт алга. Тиймээс эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх шаардлага байгаа. Зээл авахад гарч буй хүндрэлийг манайхан өөрсдөө бий болгоод буй юм. Далд эдийн засаг болон инфляцийн түвшинг бууруулах, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх шаардлага буй. Гаднын улс орнуудад олон улсын банкууд зээл өгөхдөө хөрөнгө барьцаалахгүйгээр данс барьцаалж өгдөг. Харин манайд үл хөдлөх хөрөнгө гэдэг. Гэтэл гаднынханд данснаас гадуур нэг ч төгрөг эргэлддэггүй байх нь. Бүртгэл нь тодорхой, яг таг учраас үл хөдлөх хөрөнгөнөөс илүү данс барьцаалах нь үр дүнтэй байдаг. Манайд далд эдийн засаг өндөртэй учраас дансаар дамжихгүй байх нь түгээмэл. Албан бус мэдээгээр 40 хувь нь далд эдийн засаг байна гэх тоо бий.

**Г.Ганболд:** -Банкны салбарын ирээдүй цаашид гэрэлтэй байна байх гэж боддог. Улс орны эдийн засаг тэлэхийн хэрээр бизнес дагаад өсөх байх. Бизнес эрхлэгчид банкнаас зээл авахад хэцүү байдаг гэх яриа байдаг. Энэ хоёр талтай ойлголт. Банкны өөрийнх нь борлуулж буй гол бүтээгдэхүүн буюу ашиг олж байгаа гол хэрэгсэл нь зээл. Тиймээс банкууд зээл өгөх сонирхолтой. Гэхдээ нөгөө талдаа иргэдийн, компаниудын эх үүсвэрийг зээл болгож өгч буй учраас бид хариуцлагатай хандах ёстой. Засгийн газрын бондын хувьд ч гэсэн 100 хувь эрсдэлийг нь үүрээд компаниудад өгөөд буцаагаад 2-3 жилийн дараа эргүүлж төлнө. Ийм байхад бид хариуцлагагүй иргэн, компанид зээл өгөх эрхгүй. Тиймээс банкуудын тавьж буй нийтлэг шаардлагыг манай үйлдвэрлэгчид аль аль талдаа биелүүлэх хэрэгтэй. Тэгэхээр зээл авахад хэцүү байгаа нь дан ганц банкнаас хамаараагүй гэдгийг хэлье. Сүүлийн 2-3 жил эдийн засгаа тэлэхийн тулд Төвбанкнаас явуулж буй бодлогыг бид зөв гэж үзэж байгаа.

**-Банкуудын захирлуудтай уулзсаных валютын ханшийн талаар асуулгүй өнгөрч болохгүй нь. Валютаар зээл авсан аж ахуйн нэгж олон байгаа. Банк төгрөгөөр зээл олгож болдоггүй юм уу. Мөн зээлийн хүүг бууруулах боломж бий юү?**

**М.Болд:** -Монгол Улсад ам.доллар байхгүй учраас төгрөгийн ханш суларч байна. Үүнээс гарах ганц л арга зам бий. Монголчууд өөрсдөө хийж бүтээж сурах ёстой. Ярих бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ядаж л хүнс, гутал хувцсаа өөрсдөө хийгээд өмсчихдөг болох хэрэгтэй. Тэгж байж үнэ ханшийн огцом хэлбэлзлээс гарна. Банкны зээлийн хүүг бууруулахын хувьд хэлэхэд, хувийн хэвшил, төр засгийн хамтын ажиллагаатай холбоотой зүйл. Инфляцийн түвшинг бид хамтын хүчин чармайлтаар буулгах ёстой. Ингэж байж бид хадгаламжийн хүүг бууруулна. Үүний дараа бага хүүтэй зээл олгох боломжтой. Энэ бол ярьсны зоргоор бүтэхгүй. Хамгийн гол нь ярьснаа хийснээр бүтэх юм.

**Д.Батсайхан:** -Аливаа бизнес эрсдэлийн менежменттэй байдаг. Аж ахуйн нэгжүүд валютаар эсвэл төгрөгөөр зээл авах нь тэдний өөрийнх нь сонголт. Түүнээс хүн төгрөгөөр зээл авъя гээд байхад нь банкны зүгээс ам.доллараар ав гэж хэзээ ч шаарддаггүй. Авсан зээлээ юунд зарцуулж байна гэдгээс хамаарч тухайн харилцагчид төгрөгөөр үү, валютаар уу гэдгээ шийддэг. Валютын ханш байнга өсдөг зүйл биш. Өсдөг бас буурдаг. Ам.долларын зээлтэй харилцагчдад ханш буурч байвал ашигтай. Ханш унаж байсан үед бизнес эрхлэгчид ашгаа олж байсан түүх бий. Нөгөөтэйгүүр ханш өсөхөөр банк мөнгө олчихдог юм шиг буруу ойлголт нийгэмд байдаг. Ханш өссөнөөс банк ч мөн адил алдагдал хүлээдэг. Учир нь, банкин дээр байршиж буй эх үүсвэр хэн нэгэн хүнийх. Тэгэхээр ханшийн өсөлт нь тухайн хадгаламж эзэмшигчдээ очдог юм. Зээлийн хүү өндөр буй нь банкуудын дотоод эх үүсвэрийн зардал өндөр байгаатай шууд холбоотой. АНУ-д зээлийн хүү есөн хувьтай байхад Монголд 18 байна гэж зарим хүн хэлдэг. Үүнд хоёр зүйл шууд хамаардаг. Банк хоёр далавчтай. Нэг нь зээл нөгөө нь хадгаламж. Хадгаламж зээлийнхээ үнэ цэнийг тогтоодог. АНУ-д зээлийн дээд хүү есөн хувь байхад хадгаламжийнх гурван хувь байх жишээтэй. Зээл хадгаламжийн хүүний зөрүү манайд олон улсын жишигт хүрсэн. Гагцхүү хадгаламжийн хүү олон улсын жишгээс 5-6 дахин өндөр, дотоод эх үүсвэрийн өртөг өндөр учир зээлийн хүү буурахгүй байгаа. Цаашид бид хадгаламжийн хүүгээ бууруулах ёстой юм. Ингэж байж хөрөнгийн зах зээл нэмэгдэнэ. Энэ бүх зүйлүүд харилцан бие биедээ хамааралтай учраас нэг субьектын өнцгөөс асуудлыг тайлбарлах нь сайн үр дүн авчрахгүй. ■

2014 ОНЫ 6 САР.

# Д.Баярсайхан: Олон улсад манай эрх зүйн орныг хүлээн зөвшөөрсөн

*Монгол Улсад санхүүгийн зохицуулах байгууллага үүсч байгуулагдсаны 20 жилийн ой энэ онд тохиож байна. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхантай зохицуулах салбарын өнгөрсөн, одоо, ирээдүйн талаар ярилцлаа.*



**-Үнэт цаасны хороо байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байна. Нийгэм, эдийн засгийн амьдралд ч багагүй өөрчлөлт гарсан. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд танай аль нэг салбарт гарсан бодит өөрчлөлтийг онцлохгүй юу?**

-Нэг бодит жишээ нь даатгалын салбар байна. Дөнгөж хороо байгуулагдах үед 21 даатгалын компани үйл ажиллагаа явуулж байсан. Тэдний санхүүгийн чадвар сул, зах зээл нь зогсонги, эрсдэлд өртөмтгий, эмзэг байсан. Тэгвэл өнөөдөр эрсдэлээ даах чадвартай 17 компани өрсөлдөөнт зах зээлд ажиллаж байна. Энэ бол 20 жилийн хугацаанд бий болсон томоохон өөрчлөлтийн зөвхөн нэг нь. Мэдээж даатгалын салбар төдийгүй санхүүгийн зах зээл хөгжих, илүү сайжрах шаардлага бий. Гэхдээ ард үлдсэн цаг хугацааны ололтыг үнэлж, түүнээс суралцах ёстой. Хорооны хувьд арилжааны банкны үйл ажиллагаанд зохицуулалт хийх эрхгүй. Тэгвэл сүүлийн үед банкуудад хороо өөрийн зөвшөөрөл олгож эхэлсэн. Энэ нь хөгжлийн бас нэг үзүүлэлт байх гэж бодож байна. Банкууд даатгалын зуучлалын үйл ажиллагаа болон кастодианы үйлчилгээний эрх авахаар хандах болсон. Өөрөөр хэлбэл, хорооны зохицуулалтад банкны салбар орж ирж байна. Өнгөрсөн хугацаанд санхүүгийн салбарт хадгаламж зээлийн хоршоог дагасан хямрал гарч байсан. Үүнийг тодорхой ажлын хүрээнд цэгцэлсэн. Төрөөс хохирлыг нь барагдуулсан. Одоо хадгаламж зээлийн хоршоо бие даасан хуультай, зохицуулалттай боллоо.

**-Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд танайх ямар ажил хийсэн бэ?**

-Компанийн засаглал ч манайд хамаарч байгаа. Энэ чиглэлд хэд хэдэн томоохон ажил хийгдээд явж байна. Хорооны зүгээс засаглалын үндэсний кодексыг баталж гаргасан. Мөн Компанийн тухай хуульд

засаглалтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг оруулаа. Монгол Улс албан журмын даатгалын тогтолцоогүй орны нэг байсан. Тэгвэл өнгөрсөн гурав хүрэхгүй жилийн хугацаанд Жолоочийн хариуцлагын даатгалыг хуульчлан батлууллаа. Үндсэндээ албан журмын даатгалын тогтолцоог бүрдүүлсэн гэж хэлж болно. Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд бүх салбарын хуулиудаа шинэчилсэн. Хамгийн сүүлд Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж холбогдох байгууллагад нь өргөн барьсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль хэрэгжиж байна. Товчхондоо, эрхзүйн зохицуулалт, хяналтын түвшинд нэлээд амжилт гаргасан он жилүүд байлаа.

**-Манай үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчин дэлхийн түвшинд ойртсон гэж үзэж болох уу?**

-Үнэт цаас болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль энэ оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Энэ хугацаанд тухайн хуулийг дагасан холбогдох дүрэм, журмыг боловсруулж эцэслэн баталж гаргалаа. Дээрх хуулиуд гарснаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх, эрх зүйн таатай орчин бүрдэх чухал алхам болсон. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд манайх Олон улсын үнэт цаасны байгууллагуудын холбооны бүрэн эрхт гишүүн орны нэг боллоо. Ингэснээр үнэт цаасны холбоодын гишүүн улсуудтай ижил тэгш хэмжээнд харилцах, хамтран ажиллах, мэдээлэл солилцоход нээлттэй болсон. Өөрөөр хэлбэл, Олон улсад манай эрх зүйн орчныг хүлээн зөвшөөрсөн.

**-Монголын хөрөнгийн биржийн шинэчлэлд тулгамдаж буй ямар асуудал байна вэ?**

-Лондоны хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн биржийн хооронд байгуулсан гэрээг сунгаад явж байгаа. Гэрээний хүрээнд өндөр хөгжсөн зах зээлийн технологи, мэдээллийн сан, программ хангамжийг өөрийн орны зах зээлд нутагшуулах ажил сүүлийн гурван жилд хийгдсэн. Одоо зах зээлийг хөгжүүлэхэд бүтээгдэхүүн нийлүүлэх нь чухал болоод байна. Дэлгүүрээр зүйрлэвэл бид орчин цагийн шаардлага хангахуйц "супермаркет"-тай болчихлоо. Одоо түүнд арилжаалах бараа бүтээгдэхүүн хэрэгтэй. Харамсалтай нь өнөөдрийн байдлаар нийт бүртгэлтэй байгаа хувьцааны гуравны хоёрыг төрийн мэдлийн хувьцаа эзэлж байна. Тиймээс төр өөрийн өмчөө биржээр хувьчлах хэрэгтэй. Томоохон уул уурхайн эрдэс баялагтай стратегийн орд газруудаа хөрөнгийн биржид гаргах улмаар хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх шаардлагатай.

**-Тухайлбал, энэ чиглэлээр ямар ажил хийгдэж байгаа вэ?**

-Биржийн шаардлагын дагуу хувьцаа нь их хэмжээгээр төвлөрсөн компаниуд нэмэлт хувьцаа гаргах эсвэл хувьцаагаа задлах ажлыг хийх ёстой. Мөн шинээр хувьцаагаа хөрөнгийн биржид гаргах, IPO хийх компаниудыг дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах гээд хийх ажил цөөнгүй байна. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 475 хувьцаат компани байсан. Тэдгээрийг цэгцлэх арга хэмжээг аваад эхэлсэн. Биржийн листийг цэвэрлэх ажил тасралтгүй цааш үргэлжилнэ. Энэ сарын байдлаар манайд үнэт цаас нь бүртгэлтэй 304 компани байгаа. Үүнээс 200 нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байна.

**-Санхүүгийн зах зээлийн дунд болон урт хугацааны төлөв байдлыг та хэрхэн харж байна вэ. Одоогийн эрчээрээ явбал бидний хүсэд буй зах зээл хэр ойрхон байна уу?**

-Санхүүгийн зах зээлийн 95 орчим хувийг банкны систем бүрдүүлж байна. Үүнийг банк давамгайлсан тогтолцоо гэж нэрлээд байгаа. Сүүлд нэг судалгааны байгууллагын хийсэн тооцооллоор банкны салбар 90 орчим хувийг эзэлж байсан гэсэн үр дүн гарсан байна лээ. Бидний хувьд ямар системийг банк давамгайлсан тогтолцоо гэж хэлээд байгаагаа эргэж харах л хэрэгтэй. Гол нь тэнцвэртэй, олон тулгуурт санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна. Хөрөнгийн зах зээл болон даатгалын систем нь хөгжсөн олон тулгуурт санхүүгийн бүтэцтэй болох ёстой.

Сүүлийн үеийн статистик судалгаа үзэхэд манай зохицуулалтад байгаа салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд дандаа өссөн дүнтэй гарсан. Энэхүү өсөлт сүүлийн 10 жил үргэлжилж буй. Даатгалын салбарын бүх үзүүлэлт ч өссөн. Дандаа ашигтай гарсан. Банк бус санхүүгийн байгууллагынх ч мөн адил. Амжилттай яваа салбараа дэмжихийн сацуу сул хөгжсөн хөрөнгийн зах зээлээ ч хөгжүүлэх ёстой. Ингэснээр зах зээл тэнцвэржинэ. Санхүүгийн зах зээлийн хөгжил олон зүйлээс хамаардаг. Тухайлбал, иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах шаардлага ч энд байна. Хорооны зүгээс иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах хүрээнд Азийн хөгжлийн банк болон бусад байгууллагуудтай хамтраад зорилтот төсөл хэрэгжүүлж байгаа. Үүнээс эерэг үр дүн гарна гэж хүлээж байна.

**-Хөрөнгийн зах зээл дэх ихэнх компаниудын хувьцаанд хэт төвлөрөл явагдаж, тэдгээр хувьцаа цөөн хэдэн хүний мэдэлд шилжсэн. Энэ нь үнэт цаасны зах зээлд зогсонги байдал үүсгэх болсныг тус зах зээлийн оролцогчид хэлдэг.**

-Аливаа улсын хөрөнгийн бирж өөрийн гэсэн бүртгэлийн шалгууртай. Манай хөрөнгийн биржийн шалгууруар бол тухайн биржид бүртгэлтэй нээлттэй компанийн нийт хувьцааных нь 25 хувь олон нийтэд арилжаалагдаж байх ёстой. Гэтэл тийм биш. Манай компаниудын дийлэнх нь гэр бүлийн шинж чанартай болсон. Хөрөнгийн захад оролцох идэвх сонирхол нь ч сул. Хувьцааны төвлөрөл нь 80-90 хувьтай компаниудад биржийн дээрх шаардлагыг хангаж ажиллах учиртай. Компаниуд нэмэлт хувьцаа гаргах эсвэл арилжаагаа идэвхжүүлэхийн тулд хувьцаагаа задлах, хуваах асуудал гарч ирнэ. Дараа нь бүтээгдэхүүн нийлүүлэлтэд анхаарах хэрэгтэй. Төрийн өмчит компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах нь засаглалаа бодсон ч илүү өгөөжтэй. Үүнд төрийн зүгээс ач холбогдох өгөх нь чухал. Ил тод, нээлттэй компанийн давуу тал нь хөрөнгө оруулалт татах боломж бүрддэг. Тухайн компани биржид бүртгэлтэй, олон нийтэд хувьцаагаа арилжаалах сонирхолтой байгаа бол биржийн шаардлагыг хангах ёстойг дахин хэлье.

**-СЗХ-ны дэргэд Маргаан таслах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл ямар асуудлыг шийдэх вэ?**

-Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу хорооны дэргэд Маргаан таслах зөвлөл байгуулагдсан. Бидний хувьд санхүүгийн зах зээлд мэргэжлийн арбитар бий болгох зорилготой ажиллаж байна. Оролцогч талуудын хооронд үүссэн маргаан эцэс төгсгөлгүй шүүхээр явдаг. Үүнийг нэг мөр шийдэх үүднээс дээрх арга хэмжээг авсан. Маргаан таслах зөвлөлийн дүрэм журам гарч, гишүүдээ сонгосон. Зөвлөл нь манай зохицуулалтын байгууллага болон зах зээлийн оролцогч нарын хоорондын маргаантай асуудлыг шийдэх юм. Түүнээс хороотой маргасан асуудлыг үүгээр шийдэхгүй. Тухайлбал, Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв, Хөрөнгийн бирж, Брокер диллерийн компаниуд хооронд маргаан үүсвэл тус зөвлөлөөр асуудлыг шийдүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд манай хорооны төлөөлөл орж байгаа. Зах зээлийн оролцогч болон хөндлөнгийн судлаач, шинжээчид ч мөн багтсан. Долоон хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг манай ажлын албаны дарга ахалж байгаа.

-Сүүлийн үед “Монел”, “Улаанбаатар” зэрэг цөөнгүй хувьцаат компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хассан. Үүнийг цэвэрлэгээ хийгдэж байна гэж ойлгож болох уу?

-Одоогийн зах зээл нь биржид бүртгэлтэй байгаа компанийг хүчээр барьдаг тогтолцоо биш юм. Харин сайн засаглалтай, ногдол ашгаа тогтмол тараадаг, ил тод үйл ажиллагаа явуулдаг, зах зээлд идэвхтэй оролцдог, арилжаа нь идэвхтэй зах зээл байх ёстой. Зах зээл ном ёсоор буюу сонгодог байдлаар ажиллах цаг нь ирсэн. Хасагдаж буй компаниудын тухайд хувьцааны төвлөрөл нь 90 хувиас давсан, арилжаа нь зогссон, ямар ч арилжаа байхгүй, өмчийн эзэд буюу хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө энэ зах зээлээс гаръя гэсэн санал оруулж ирээд гарч байна. Бид үүнийг хуулийн хүрээнд нь хянаад асуудлыг шийдвэрлэсэн. Дээр нь олон брокер диллерийн компаниудын зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“Эрдэнэс Тавантолгой”-н 1072 ширхэг хувьцааг эзэмшүүлэхтэй холбоотойгоор борооны дараах мөөг шиг брокерын компаниуд өөрсдийн зах зээлийн эрсдэлийг тооцохгүйгээр байгуулагдсан. Одоо арилжаа идэвхгүй байгаа үед өөрсдөө үйл ажиллагааны зардлаа дийлэхгүй хүнд байдалд орцгоож байна. Зарим нь арилжаа хийхгүй бүтэн жилээр явсан учраас хуулийн шаардлагын дагуу нэг хэсгийнх нь зөвшөөрлийг хүчингүй болгосон. Нэг үе брокерын компанийн тоо 90 хүрч байсан бол одоо 60 болж буурсан. Хаалттай болж буй компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, өмчийн эзэд өөрсдөө хаалттай болъё гэсэн хүсэлт манайд гаргасан учраас асуудлыг нь шийдсэн. Түүнээс хороо хүчээр хаалттай болгох, арилжааг зогсоох, татан буулгахгүй.

**-Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТТХТ/ хэрхэн шинэчлэгдэх вэ?**

-ҮЦТТТХТ-ийн хувьцаа эзэмшигч нь Төрийн өмчийн хороо байсан. Засгийн газрын шийдвэрээр бүтцийн өөрчлөлт хийгдэж, хувьцаа эзэмшигчээр нь Сангийн яамыг томилсон. Хоёрдугаарт, ҮЦТТТХТ-ийг хоёр компани болгож хуваах шийдвэр гарсан. Гэхдээ энэхүү шийдвэрт эргэж харах шаардлага бий. Манай хорооны дэргэдэх Үнэт цаасны бодлогын зөвлөл дээрх асуудлаар нэлээд сайн хэлэлцээд өөрсдийн зөвлөмжөө Сангийн яам болон Засгийн газарт хүргүүлсэн. Үнэт цаас, төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс Хадгаламж бүртгэлийнх нь байгууллагыг тусад нь гаргаж байгаа. Төлбөр тооцооных нь асуудлаар тусдаа хуулийн этгээд байгуулах асуудал яригдсан. Төлбөр тооцооных нь хувьцаа эзэмшигчээр Хөрөнгийн биржийг сонгосон байсан. Төлбөр тооцооны асуудал өөрөө зардал ихтэй байдаг. Үүнийг дан ганц Хөрөнгийн биржийн төлбөр тооцооны төв гэхгүйгээр хөдөө аж ахуйн биржийн төлбөр тооцоо хийдэг, биржийн бус зах зээл үүсэх юм бол түүний тооцоог ч мөн хийхээр хуульчлах хэрэгтэй. Нэг ёсондоо хувьцаа эзэмшигч нь ганц хөрөнгийн бирж биш энэ талын үйлчилгээ авч байгаа хэн ч үүнд оролцох боломжтой хувилбар дэвшүүлж байгаа.

**-“Голомт” болон “Худалдаа хөгжлийн банк” кастодианы үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан. Цаашдаа бусад арилжааны банкуудад кастодианы үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох уу?**

-Хуулийн хүрээнд нээлттэй. Гэхдээ энэ нь өндөр хариуцлагатай үйлчилгээ. Дурын нэг банк аваад хийж чаддаггүй юм билээ. Гадаадад ч гэсэн нөхцөл нь хатуу. Яагаад гэвэл үүнийг дагасан компанийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг хариуцлагын асуудал гарч ирдэг. Үнэт цаасыг хадгалах, ногдол ашгийг хуваарилах, төлбөр тооцоог гүйцэтгэх гээд олон талт үйл ажиллагаатай. Арилжааны банкны үйл ажиллагаанаас огт тусдаа учраас үүнийг их хариуцлагатай явуулах ёстой. Надад байгаа мэдээллээр уг зөвшөөрлийг мөн ХААН банк авахаар материалаа ирүүлсэн гэж сонссон. Зах зээл нь үнэт цаасны зах зээл дээр суурилагдсан бүтээгдэхүүн үйлчилгээ учраас шалгуур хангасан, санхүү болоод боловсон хүчний хувьд нэлээд сайн бэхжсэн банкууд авах ёстой.

**-Ирэх оны эхээр Хөрөнгө оруулалтын хоёр сан байгуулагдах гэж байгаа гэсэн. Мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагч бий болж байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд ямар нөлөө үзүүлэх вэ?**

-Хуулийн дагуу хөрөнгө оруулалтын менежментийн компани үүсгэн байгуулагдахаар манайхаас хоёр компани зөвшөөрлөө авсан. Тэд цаанаа хөрөнгө оруулалтын сан байгуулах зорилготой байгуулагдаж байгаа. Эхнийх нь аваад эхэлсэн учраас дараагийнх нь хүсэлтээ тавих байх гэж харж байна. Хөрөнгө оруулалтын сангийн хуулиар нээлттэй сангууд нь тусгай зөвшөөрөл авах, хаалттай сангууд нь бүртгэлээр явна гэж хуульчилсан. Ер нь харьцангуй чөлөөтэй эрх зүйн орчныг тавьж өгсөн. Хамгийн гол нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид мэргэжлийн байгууллагад хандвал сайн. Хоёрдугаарт, мэргэжлийн сангууд орж ирэх юм бол тэдгээр нь тодорхой зорилготой, сайн судалгаатай зах зээлд оролцдог учраас энэ нь зөв жишиг тогтооно. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу оролцогчдын мөнгө кастодиан банкинд байршина. Энэ нь цаанаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах томоохон дэд бүтцийн асуудлыг шийдэж буй юм. ■

2014 ОНЫ 11 САР.



# Д.Цэвээнжав: Жолоочийн даатгал санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалсан хохирогчгүй даатгал

*Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилт богино хугацаанд харьцангуй сайн байгааг иргэд олзуурхан ярьдаг. Өнгөрсөн жилээс хэрэгжиж эхэлсэн тус хуулийг эхэн үедээ жолооч нар сайн, муу янз бүрээр гоочилж байсан. Жолооч биш хүн ховор учраас өнөөдөр иргэдийн олонх нь даатгуулахын ач тусыг дээрх хууль хэрэгжих явцад гадарлахтайгаа болжээ. Бодит үр дүн гарч байгаа энэ хуулийн талаар Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжавтай ярилцлаа.*

*Үе үеийн Засгийн газарт Шадар сайд нарын зөвлөх, Гаалийн ерөнхий газар хэмээх их айлыг удирдаж байсан тэрбээр Жолоочийн хариуцлагын даатгалын хуулийн хэрэгжилтийг хангах ажилд бие, сэтгэлээ чилээн явна.*

**-Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль хэрэгжүүлэх ажлын явц өнөөдөр хэр байна вэ?**

-Жолоочийн даатгалын тухай хуулийг 2011 оны аравдугаар сарын 7-нд баталсан. Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжсэн. Уг хууль нь албан журмын даатгалын нэг төрөл юм. Энэ нь өмчийн эзэн ард иргэдэд учирсан хохирлыг тухай бүр барагдуулж байх агуулгаар батлагдсан хууль. Бусад улсад ийм хууль батлагдаж хэрэгжсэн нь олон жилийн түүхтэй.

Хууль батлагдаад үйлчилж эхлэхэд манайд хэрэгжилтийг хангах байгууллагууд бэлэн байсан уу гэвэл тийм биш. Ялангуяа даатгалын компаниуд энэ үйл ажиллагаа эрхлэхэд хүний нөөцийн талаасаа мэдээллийн баазын хувьд бэлтгэл хангагдаагүй байсан. Гэсэн ч хуулийг богино хугацаанд хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүйн яам, Сангийн яам, Зам тээврийн яам, Замын цагдаагийн газар зэрэг төрийн үндсэн чиг үүргийн байгууллагууд ихээхэн анхаарал тавьж, холбогдох журмуудыг батлан гаргаж, хуулийг хэрэгжүүлээд явж байна. Энэ хууль батлагдсантай холбогдуулж УИХ-аас тогтоол гаргаж сургалтыг шуурхай зохион байгуулах үүрэг өгөгдсөн. Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон даатгалын байгууллагууд хамтран бүх аймагт сургалт зохион байгуулж, зохих зөвшөөрөл олгосон. Түүнчлэн даатгалын компаниудад Жолоочийн хариуцлагын даатгалыг зохион байгуулах зөвшөөрөл олгосон байдаг.

Энэ үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой нэг шинэ байгууллага бий болсон. Энэ бол Албан журмын даатгагчдын холбоо юм. Тус холбоог

Санхүүгийн зохицуулах хороо зохих чиг үүргийнхээ дагуу байгуулж, эрх үүргийг олгож, дүрмийг баталж өгсөн. Үүний дагуу холбооны Удирдах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл нь Сангийн яам, Хууль зүйн яам, Зам, тээврийн яам, Замын цагдаагийн газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн байгуулагуудын төлөөлөлтэй байдаг. Удирдах зөвлөл холбооны гүйцэтгэх үүргийг маш богино хугацаанд тодорхой болгож, ажлын алба байгуулан ажилласан.

**-Өнгөрсөн онд хэчнээн мянган тээврийн хэрэгсэл даатгалд хамрагдав. Шинэ тутам байгуулагдсан танай байгууллага өнгөрсөн нэг жилийн хугацаанд ямар ажил хийж амжуулсан бэ?**

-2012 онд Монгол Улсын хэмжээгээр 360 мянган тээврийн хэрэгсэл албан журмын даатгалд хамрагдсан. Үүнийг улсын тоо бүртгэлтэй тулгаад үзэхээр нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 80 гаруй хувь даатгалд хамрагдсан гэсэн тоо бий.

2012 онд үйл ажиллагаа эхлэхэд тус холбооны санхүүжилтийг төвлөрүүлэх асуудал хүнд байсан. 2012 оны эцсээр холбооны үйл ажиллагаанд зээл авах тухай яригдаж байсан. Шинэ тутам байгуулагдсан байгууллагын боловсон хүчний чадавх мэдлэг, дадлага дутагдсан тал бий байх. Улсын Их Хурал төсөв хэлэлцэх үед төсвөө батлуулж чадаагүйгээс санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүй байсан. Гэсэн хэдий ч санхүүжилтийн нэг хэсэг болох даатгалын компаниудаас даатгалын хураамжийн орлогоос тодорхой хувиар хөрөнгө төвлөрүүлж, үйл ажиллагаагаа зохих түвшинд явуулж эхэлсэн. Өнгөрсөн онд эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлэх, ажлын албаа зохих ёсоор ажиллуулах, даатгалын компаниуд ажлаа жигдрүүлэх, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа төлөөлөгч нарт хуулийн талаар мэдлэг мэдээлэл олгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Даатгалын сан бүрдүүлэхийн тулд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогын 10 хувийг орон нутгийн төрийн байгууллагуудаас бүрдүүлэх томоохон ажил 2012 онд хэрэгжиж чадаагүй байсан. 2013 оны хувьд үүнийг хэрэгжүүлээд явж байна.Энэ орлогыг одоогийн байдлаар Дорнод, Хөвсгөл, Хэнтий Завхан гэсэн дөрвөн аймагт орлогоо зуун хувь төвлөрүүлээд байна. Мөн даатгагч нараас төвлөрүүлбэл зохих орлого бүрэн төвлөрөв. Даатгалын сангийн нөөц бүрдүүлэх ёстой. Энэ үүрэг ч биелэгдэж эхэлсэн.

**-Энэ онд танай байгууллагын хамгийн гол анхаарч ажилласан зүйл юу вэ?**

-Бид энэ онд жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулсан. Энэ сан бүрдсэнээр гурван үндсэн үүрэг гүйцэтгэх ёстой. Нэгдүгээрт, жолооч нарын түүхтэй холбогдсон мэдээллийн сан бүрдүүлэх. Ингэхийн тулд мэдээллийн программ хангамж, сүлжээ, зохих серверийг бий болгох ажил байсан. Одоогийн байдлаар энэ ажлыг бүрэн бүрдүүлсэн. Мэдээллийн сан бүрдүүлэхийн тулд маш олон байгууллагатай сүлжээгээр холбогдсон байх ёстой. Юуны өмнө Монгол Улсын хилээр орж ирж байгаа тээврийн хэрэгсэл түүний арлын дугаар манай мэдээллийн санд байх шаардлагатай. Энэ хүрээнд Гаалийн байгууллагатай юуны өмнө холбогдох учиртай. Хоёрдугаарт, тээврийн хэрэслийг эзэмшихтэй холбоотой хоорондоо худалдах, бусдад шилжүүлэх хөдөлгөөн байна. Үүнийг бүртгэхийн тулд Зам тээврийн яамны бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон. Гуравдугаарт, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэл эзэмшиж байгаа өмчлөгчийн хөдөлгөөнүүдийг мөн бүртгэлд оруулах. Тэгэхийн тулд Улсын бүртгэлийн ерөнхий газартай бидний үйл ажиллагаа холбогдсон байх ёстой. Тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбоотой асуудлаар Замын цагдаагийн байгууллагатай холбогдох гэх мэтчилэн олон байгууллагатай манайх сүлжээгээ холбож байж нэгдсэн систем болж ажиллах юм. Уг ажил хараахан бүрэн дуусчихаагүй. Зарим байгууллагатай энэ ондоо багтаж холболт хийхээр ажиллаж байгаа.

**-Мэдээллийн сан бүрдүүлэхийн ач холбогдол юу байх вэ?**

-Энэ мэдээллийн санг зохих ёсоор бүрдүүлснээр тээврийн хэрэгсэл эзэмшигчийн түүх баяжиж даатгалын суурь хураамж дээр нэмж төлөх хэмжээ өсөх, суурь хураамжийн хэмжээ буурах нөхцөл бүрдэнэ. Ослын газарт шуурхай очиж гэм бурууг тогтоож хохирлын хэмжээг зөв тогтооход хяналт тавих шуурхай албыг зохих түвшинд байгуулж ажиллууллаа.

**-Та энэ байгууллагын удирдлагад хэзээ ирсэн бэ?**

-Би өнгөрсөн 2012 оны арванхоёрдугаар сарын сүүлчээр энэ ажилд ирсэн. Даатгалын сан бүрдүүлснээр ажлын албаны үйл ажиллагааг санхүүжүүлээд зогсохгүй хохирогчдод нөхөн төлбөрүүдийг олгож байна. Үүний зэрэгцээ дараагийн жилүүдэд нөхөн төлбөрт ашиглаж болох нөөц сан бүрдүүлж байгаа. Мөн бид мэдээллийн сангаа бүрдүүлээд авлаа. Үүнээс гадна Шуурхай алба бий болгосон. 2012 онд шуурхай албыг зохион байгуулж, нэг ээлжиндээ дөрвөн хүнтэй байсан бол энэ онд бид 24 цагаар даатгалын тохиолдлын мэдээллийг шуурхай авдаг, газар дээр нь очиж үйлчилгээ үзүүлдэг дөрвөн ээлжийн зохион байгуулалттай ажиллаж байна. Шуурхай албыг зөвхөн Улаанбаатарт биш, орон нутагт байгуулах ажил явж байна. Одоогийн байдлаар бид есөн аймагт Шуурхай алба байгуулаад зохих машин, техникээр бүрэн хангасан. Үлдсэн аймгуудад энэ ондоо багтааж байгуулна. Мэдээллийн сан бүрэн хэмжээгээр ажилладаг болсноор даатгалын компаниуд манай мэдээллийн санг ашиглаад даатгуулагчийн түүхийг харах боломж бүрдэж байгаа юм. Ингэснээр тухайн жолооч маш болгоомжтой ямар нэг осол гаргаагүй бол даатгалд төлөх хураамжийн хэмжээ багасаж байдаг. Хэрвээ даатгалын тохиолдол удаа дараа гаргасан бол тэр хэмжээгээр суурь хураамж нэмэгдээд явах юм. Ийм боломжийг зөвхөн Мэдээллийн нэгдсэн сан бий болсноор ашиглах боломжтой. Өмнө даатгалын компани дээр даатгуулагч очиход “та өмнө нь осол гаргасан байна. Таны даатгалын хэмжээ нэмэгдэх нь ” гэхэд “тэгвэл чамд даатгуулахгүй би өөр таньдаг мэддэг газраа даатгуулчих минь” гэх маягаар яваад өгдөг байсан. Тэгвэл одоо нэгдсэн сантай болчихоор тухайн жолоочийн мэдээлэл бүх даатгалын байгууллагад нэгэн зэрэг харагдаж байгаа учраас тухайн

Урьдчилан үйлдвэрлэсэн дэд өртөө

# Biosco B120T

## 24кВ хүртэлх хүчдэл, 2х1000кВА хүртэлх чадал бүхий трансформатор, 2х4 функц бүхий дунд болон нам хүчдлийн хуваарилах самбараас бүрдсэн иж бүрэн дэд өртөө




### Хэрэглээ

Уг урьдчилан үйлдвэрлэсэн, зөөврийн Biosco B120T маягийн трансформаторын дэд өртөө нь эрчим хүчний түгээх сүжээнд 24кВ хүртэлх хүчдэлийн түвшин бүхий бүх төрлийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахад ашиглагдана.

### Стандарт

Зураг төслийг IEC 62271-202-н дагуу
Үйлдвэрлэлтийг ISO 9001 ба ISO 14001-н дагуу




### Барилга

- Барилга нь төмөр бетон хийцлэлтэй, каблийн оруулгыг сууринд тусгаж өгсөн хялбар шийдэлтэй
- Суурийн хэсгийн тусад нь тээвэрлэх боломжтой
- 1х1000кВа чадал бүхий 2 дэд өртөөг тусдаа тээвэрлэж ажлын талбай дээр угсралт хийх боломж бүхий
- Хамгаалалтын түвшин:
  - IP 25 D (гадны биет болоод шингэн зүйл нэвтрэхээс хамгаалагдсан)
  - IK 10 (цохилтонд тэсвэртэй, механик эсэргүүцэл сайтай)
- Тос цуглуулах сав бүхий
- Нэг трансформатор бүхий дэд өртөөний эзлэх талбай 11м.кв-с 14.3м.кв
- Тоноглол бүхий дэд өртөөний дундаж жин ойролцоогоор 17тн
- Дэд өртөөний өндөр ойролцоогоор 2.68м

### Тоноглол

- Дунд хүчдлийн ячейк: 4хүртэлх функц бүхий RM6
- 50мм.кв хөндлөн огтлолтой кабель бүхий өндөр талын секц холбогч
- Трансформатор: 1000кВА хүртэлх чадал бүхий тосон трансформатор
- 240мм.кв хөндлөн огтлолтой кабель бүхий нам талын секц холбогч
- Нам хүчдлийн самбар: TUR, TIPI эсвэл OPUS маягийн гал хамгаалагч эсвэл таслуураар тоноглогдсон 6-с 8 хүртэлх гаралттай
- Газардуулга, дотоод гэрэлтүүлэг
- Нэмэлт тоноглол:
  - Алсын удирдлага SCADA систем: Easergy T200
  - Гэмтэл тодорхойлогч: Easergy Flair
  - Нийтийн хэрэгцээний гэрэлтүүлгийн самбар
  - LV metering

---

Schneider Electric

**Шнайдер Электрик Монголиа ХХК**
Моннис цамхаг, 3-р давхар,
Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 70009961; Факс: +976 70009962
И-мэйл: info_mn@schneider-electric.com
Вэб: www.schneider-electric.mn

Монгол дахь албан ёсны түнш

**Эрчим Инженеринг ХХК**
Гутал оффис, 3-р давхар,
Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 11 343256; Факс: +976 11 343255
И-мэйл: info@erchim.mn
Вэб: www.erchim.mn

жолооч дурааараа авирлах боломж хаагдсан. Энэ бол манай даатгалын үйл ажиллагаа шударга, шуурхай, ил тод явах боломжийг мэдээллийн сангаар бий болгосон гэсэн үг.

**-Их сонин юм байна. Жолооч нарын хувьд өнөөдрийг хүртэл даатгалаас хохирол барагдуулсан тохиолдолд даатгалын хураамж нэмэгдэнэ гэдгийг огт мэдэхгүй яваа нь олон байгаа байх. Жишээ нь нэг удаа ослын тохиолдол гаргасан суудлын тэрэгний жолоочийн даатгалын хураамж хэдэн төгрөг болж өөрчлөгдөх вэ? Та жишээ татаад тайлбарлаад өгвөл сайн байна.**

-Итгэлцүүрээр хураамжийн хэмжээг дээш, доош болгож тооцох журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталж гаргасан. Энэ итгэлцүүрээр есөн нөхцөл заажээ. Жолоочийн даатгал 50 хувь хүртэл багасаж болох, хоёр дахин өсөж болох нөхцөлтэй. Энэ тохиолдол бүр дээр программ үйлчилж байдаг. Түүнээс биш, даатгалын байцаагч, даатгалын ажилтны санаа зоргоос хамаарч хийх боломжгүй. Жишээлбэл, даатгалтай жолооч замын хөдөлгөөний зөрчил гаргаж, даатгалын үйлчилгээ авсан тохиолдол гаргасан байх юм бол А, В ангиллын машинд 5.0 сая хүртэл, С, D ангиллын машинд 10.0 хүртэл сая төгрөгийн хохирлыг даатгалаас төлж өгч болно. Суудлын тэрэг бол жолоочийн хариуцлагын даатгалын хураамж 33000 төгрөг төлнө. 33000-хан төгрөг төлөөд 5.0 сая хүртэл төгрөгийн хохирол нөхүүлэх боломжийг хуулиар нээж өгч байгаа. Хэрвээ ямар нэгэн тохиодол гаргахгүй болгоомжтой сайн жолооч байх юм бол энэ хүний суурь хураамж буюу 33000 төгрөг нэг жил болоход 31000, хоёр жил болоход 27000 гэх мэтчилэн 10 жил осол гаргахгүй явах юм бол суурь хураамжийн хэмжээ 16500 төгрөг болтлоо багасаж болно. Хэрвээ нэг удаа тохиолдол гаргасан жолоочийн 33000 төгрөгийн суурь хураамж 51150 төгрөг болж өснө. Хоёр дахь тохиолдол гаргасан бол 80850 болж өсөх жишээтэй. Итгэлцүүрийн хөдөлгөөнийг жолооч нар маань их анхаарах хэрэгтэй. Ийм хөдөлгөөн гардаг учраас жолооч нар өмнө нь танил талаа харж, хураамжаа өсгөхгүйгээр хийж болдог байсан бол одоо Мэдээллийн нэгдсэн санд даатгалын бүх компаниуд холбогдчихсон. Энэ тохиолдолд хүн худлаа хэлэх аргагүй болсон гэсэн үг. Тэгэхээр Мэдээллийн сан бий болгосон явдал асар их ач холбогдолтой зүйл.

**-Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдахын ач холбогдолыг хууль хэрэгжсэнээр иргэд гадарлахтайгаа болж байна. Мэргэжлийн байгууллагын хүний хувьд та даатгалд хамрагдахын ач холбогдолыг хэлж өгөхгүй юу?**

-2012 оноос өмнө зам тээврийн осол, зөрчил үүссэн тохиолдолд тухайн жолооч нар хэн нэгнийгээ буруутгаад, цагдаа дуудаж байж буруутнаа тодорхойлуулж, буруутан нь хохирол торгуулаа төлдөг байсан. Мэдээж энэ хугацаанд хоёр жолооч ямар их бухимдах нь тодорхой. Тэгвэл одоогийн хуулиар жолооч нар болзошгүй зүйл болсон үед юуны өмнө даатгалын компаниа дууддаг болсон. Даатгалын шуурхай алба газар дээр нь очоод, хэн нь буруутайг албажуулдаг. Үүний зэрэгцээ учирсан хохирлын хэмжээг үнэлдэг үнэлгээний 18 компани ажиллаж байна. Өөрт хамгийн ойр байгаа үнэлгээний компаниар хийлгэсэн үнэлгээг нь үндэслээд даатгалын компани, даатгалын сан хохирлыг шуурхай нөхөж олгодог болсон. Энэ агуулгаараа хоёр жолооч хоорондоо муудалцах ямар ч шаардлагагүй болсон. Зөвхөн даатгалын компаниа дуудаад, хохирлын хэмжээгээ үнэн зөв гаргуулах сайхан боломж бий болсон гэсэн үг. Энэ бол сэтгэл зүйн хувьд жолооч нарт маш таатай нөхцөлийг бий болгож өгсөн. Нөгөө талаар Замын цагдаагийн газрын ачааллыг хөнгөлж өгсөн. Өнөөдрийн байдлаар замын хөдөлгөөний зөрчил ослын тохиодлын 53 хувь нь шууд даатгалын байгууллагаар шийдэгдсэн байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, замын цагдаагийн ажлыг 53 хувиар хөнгөрүүлсэн гэж болно.

Хууль гарснаар хохирол амссан хүний хохирлыг гэм буруутай хүний өмнөөс даатгалын компани, даатгалгүй этгээд байвал Даатгалын сангаас шуурхай нөхөж өгч хохирогчийг хамгаалдаг болсон. Нөгөө талаар иргэд сэтгэл зүйн хувьд би даатгуулчихсан юм чинь миний өмнөөс хохирлыг төлөөд өгдөг байгууллагатай болсон гэдэгтээ сэтгэл ханамжтай байх болсон. Энэ бүгдийг аваад үзэх юм бол энэ хуулийн ач холбогдол асар их байна. Хамгийн чухал нь жолоочийн даатгалд та заавал хамрагдахыг онцгой анхаарах хэрэгтэй.

**-Жолоочийн даатгалаас бүрдэх төлөвлөгөөт орлого хэр бүрдэж байна. Мөн бүрдүүлсэн орлогоос даатгалын нөхөн төлбөрт өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хэр хэмжээний мөнгө зориулсан бэ?**

- 2012 онд нийт 326740 даатгалын гэрээ хийгдэж улсын хэмжээгээр 16 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс мөн онд 5151 даатгалын тохиолдол гарч, 2.1 тэрбум төгрөг буцаан олгосон байна. Гэтэл энэ оны эхний есөн сарын байдлаар 7519 даатгалын тохиолдол гарч, 3.7 тэрбум төгрөг олгоод байна. Эндээс харахад, жолооч нар даатгалд хамрагдаж сурч байгаа хэрэг. Нөгөө талаас хуулийн үр дүнгээр дээрх олон мянган хүн, түүний гэр бүл хохирлоо шуурхай нөхүүлж авч чадсан байна. Өнөөдөр даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, тэдний орон нутагт байгаа 213 салбар, даатгалын зуучлагч 18, хохирол үнэлгээний есөн компани манайтай холбоотой нэг баг болж хамтран ажиллаж байна.

**-Жолоочийн даатгалын энэ хуулийн хэрэгжилтийг цаашид хэрхэн сайжруулж болохоор санагдаж байна вэ?**

-Нэг тоо хэлэхэд, Монголд авто тээврийн ослоос болж жилд 300 гаруй хүн нас барж, 6000-7000 хүн тахир дутуу болж, тэр хэмжээгээр өрхийн орлого хомсдож байгаа гашуун туршлага бий. Тэгэхээр энэ байдлыг эрс багасгах боломж бол жолоочийн харицлагын даатгал юм. Ер нь энэ хуулийг сайн зохион байгуулбал үр дүн ач холбогдол нь гэгээлэг харагдаж байгаа.

Эцэст нь хэлэхэд, Жолоочийн хариуцлагын даатгалыг тээврийн хэрэгслийн даатгалтай нэг багц болгож даатгалын ажлыг зохион байгуулж үйлчилгээг хөнгөвчилж болох юм. Ер нь тээврийн хэрэгсэл эзэмшигч , иргэд жолооч нар даатгалд бүрэн хамрагдвал танд учирч болох эрсдэлээс найдвартай хамгаалах боломжийг бүү алдаарай гэж хүсье. ■

2013 ОНЫ 10 САР.


# НИЙТЛЭЛ

*Бид Монголын  эдийн засгийн өмнө тулгараад буй сорилтууд, учирч болох эрсдэл, хот хөдөөгийн  хөгжил, агаарын бохирдол, том, жижиг бизнесийн боломж, зах зээлийн  чиг  хандлагын талаар байнга бичдэг.*
*Мөн манай сэтгүүлд  дотоод, гадаадын нэртэй эдийн засагч, судлаач, шинжээчид, мэргэжлийн хүмүүс олон талын байр сууринаас бүтээл туурвих нь бий.*



АРГЕНТИН

# Модоо барьсан зуун жил



Нобелийн энхтайвны шагналт эдийн засагч Саймон Кузнетс “Дэлхийд дөрвөн төрлийн улс байдаг; Хөгжсөн, хөгжөөгүй, Япон тэгээд Аргентин”.

Өмнөд Америкийн гурав дахь том эдийн засаг дампуурлаа зарлахад тун ойр иржээ. Нэгэн цагт эдийн засгаараа тэргүүлэгч топ 10-т нэгдэж байгалийн баялаг, газар тариалан, төрөлжсөн аж үйлдвэрийн салбараараа “гайхуулж” байсан тус улс өдгөө алтан дээр суусан гуйлгачин болж хувирав. Найм дахь удаагаа дампуурлын ирмэгт ирээд буй аргентинчууд алдаанаасаа суралцдаггүй учир нэрт эдийн засагч Кузнетс дээрхийг хэлсэн буйз аа.

XX зууны эхний 10 жилд Аргентин улс өсөлт, хөгжлийн үлгэр жишээ болж байв. Тухайлбал, 1903-1913 онд тус улсын ДНБ жилийн 7.7 хувийн өсөлт үзүүлэхийн зэрэгцээ дэлхийн эдийн засгийн чадавхын 1.2 хувийг бүрдүүлж байлаа. Тус улс Бразил, Чили, Их Британи болон колони орнуудыг үхрийн мах, сайн чанарын буудай болон бусад газар тариалангийн бүтээгдэхүүнээр хангаж гадаад худалдаагаа чамгүй хөгжүүлжсэний ачаар 1890 онд тохиосон өрийн хямралаас бүрэн гарахын зэрэгцээ дэлхийн хөрөнгийн зах зээлд эргэн ирсэн юм. Гэвч Дэлхийн I дайн эхэлснээр дэлхийн төдийгүй Аргентинийн эдийн засгийн уналт эрчимжсэн. Бизнесийн хамгийн том түншүүд болох Бразил, Их Британи импортоо танаж, хөрөнгө оруулалтаа бүрэн зогсоосон нь Аргентин улсад хүнд цохилт болсон. Төд удалгүй АНУ, Европын санхүүгийн их хямрал нүүрэлснээр Аргентиний модоо барих зуун жил эхэлсэн гэж болох.

Өөрийн биш өрөөлийн хэтэвчээс хэт хамааралтай байхын горыг амсаж эхэлсэн нь ийм учиртай аж.

## Хэвлээд хүрэхгүй бол зээлээд хүргэнэ

Олон жил үргэлжилсэн санхүүгийн хүнд цохилтууд Аргентиний эдийн засгийг нам дарсан хэвээр байлаа. Зууны сүүлийн хагаст цэргийн дарангуйллаас ардчилсан чөлөөт зах зээл рүү шилжих үйл явц өрнөж, улмаар 1976 онд импортын бодлогоо зөөлрүүлж гадаад хөрөнгө оруулалтын хоригийг чөлөөлсөн. Зах зээлээ ийнхүү нээх нь эдийн засгийн өсөлт авчирна хэмээн тус улсын эрх баригчид найдаж байв. Харамсалтай нь импорттой өрсөлдөх чадамж, туршлага хийгээд хөрөнгө дутмаг байсан дотоодын компаниуд шат дараалан үүдээ барьж байлаа. Ингээд зогсохгүй Аргентин улс нэгэнтээ түнш гэгдэж байсан Их Британи улстай Фалкландын арлын төлөөх дайн эхлүүлсэн юм. Үүнийг шинжээчид газар нутгийн гэхээс илүүтэй эдийн засгийн уналтаа улс төрийн үймээнээр халхлах оролдлого байсан гэж үздэг. Гэвч тулаанд ялагдснаар Аргентиний улс төр хийгээд эдийн засгийн байдал улам дордсон. Үр дүн ийн гарахыг тооцоолоогүй тус улсын Засгийн газар мөнгө хэвлэх замаар алдаагаа засах гэсэн ч инфляциас өөр “өгөөж” байсангүй.

Зөв зарцуулваас зээл авах тийм ч муу зүйл биш. Харин зарлага нь орлогоосоо даваад ирвэл ямар үр дагавар авчирдагийг хэдэнтэй үзсэн аргетинчууд зээлсээр бас үрсээр байв. Өрийн дарамтыг хэтэрхий сайн мэдэх тус улсын удирдагчид төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл, хүний хөгжил гэх зэргээр буруу бодлого, болчимгүй үйлдлээ үргэлжлүүлсээр байсныг “улсаа хорлосон үйлдэл” хэмээн эдийн засагчид тодорхойлдог аж.


Бондын өрөө эргэн төлөх чадваргүй болж байсан ТОП 10 орон /давтамж/




Эх сурвалж: The economist

## Хэтэвчээ хуурсан аргентинчууд

1990-ээд онд гадаадын хөрөнгө оруулалт татах ажилд Карлос Мэнэмээр ахлуулсан тус улсын эрх баригчид анхаарлаа хандуулаад байлаа. Олон жил алдагдалтай ажиллаж байсан төрийн өмчит компаниудыг хувьчлах замаар хөрөнгө босгосноор нийт өрийнхөө нэлээдийг дараад байсан юм. Инфляци нэг оронтой тоо руу орж эдийн засаг нь ч сайжирч байсныг Олон улсын валютын сан тэргүүтэй байгууллагууд дуу нэгтэй магтаж байв. 1999 онд Аргентинийн Ерөнхийлөгч Карлос Мэнэм үүрэгт ажлаа хүлээлгэн өгсөн нь тус улсын эдийн засгийн түүхэн дэх хамгийн гүн уналтыг дагуулсан юм. Учир нь Мэнэмийн явуулж байсан песог (Аргентиний мөнгөн тэмдэгт) ам.доллартай тэнцүүлэх бодлого урагшгүй болж мөнгө үнэгүйдэж ам.доллар тэнгэрт хадаж эхэлсэн. Улмаар 1997 онд эхэлсэн Азийн санхүүгийн хямралаас үүдэн валютын урсгал хумигдсан нь




100 тэрбум ам.долларыг давж төлөх чадваргүйгээ зарласнаар дэлхийн эдийн засгийн түүхэн дэх хамгийн том уналт болсон юм.

“Өөх өгсөн хүнтэй өглөө босоод заргалдана” гэдэгчлэн энэ явдалд аргентинчууд гадаадын хөрөнгө оруулагчдыг буруутгаж байлаа. Тогтворгүй эдийн засгийн уршигаар улс төрийн байдал ч сайнгүй байв. Мэнэмийн ажлыг хүлээн авсан Фернандэ де ла Руа мөн ерөнхийлөгчийн суудлаас огцров. Ийн дээрээ суудлаа олохгүй тэвдэх улс төрчдийн үл ойлголцол тус улсыг элгээр нь хэвтүүлж орхисон.

Мифляцийн түвшин /жилээр

2




Эх сурвалж: INDEC

Аргентинийн эдийн засгийн уналтыг улам хурдасгасан. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин нийт хүн амын 50 хувьд хүрсэн нь 10 хүүхэд тутмын долоо нь засгийнхаа тарьсан балгийг бүх насаараа үүрч амьдрана гэсэн статистик гарч байв. Түүнчлэн тус улсын өрийн хэмжээ ДНБ-ий 45.8 хувийг эзлэхийн зэрэгцээ инфляци 20.8 хувьд хүрсэн юм. Авлигын түвшин хэрээс хэтэрч хөрөнгө оруулагчид ч дайжиж эхлэв. Улмаар валютын нөөцгүй болсон Аргентинийн засгийн газрын өр

## Өрийг өрөөр

Их хямралын дараахан буюу 2003 онд Нестор Кишнер ерөнхийлөгчөөр сонгогдон эдийн засгаа эрчимжүүлэх хэцүүхэн ажлыг хүлээн авсан юм. Тэрбээр 2005 онд өмнөх засгийн газрын өрийг дарах үүднээс ахин бонд гаргах санал хөрөнгө оруулагчдад тавьсан. Энэ нь өмнөх өрийн бичгээс 65 хувиар бага үнэлэгдэх бөгөөд өрийг өрөөр солих бодлого байсан гэж болно. Эл “солилцоо”-г нийт бонд эзэмшигчдийн дөрөвний гурав нь хүлээн зөвшөөрсөн юм. Иймхүү Аргентин нийт өрийн дийлэнхийг барагдуулж чадсан билээ. Эл бодлого үр дүнгээ өгч 2010 он гэхэд тус улсын Засгийн газар нийт өрийнхөө 93 хувийг барагдуулсан байв. Харин үлдсэн хөрөнгө оруулагчид хуучин бондын өрийг бүрэн төлөхийг шаардсаар байгаа нь 2014 оны дампуурлыг дуудаж байгаа юм. Олон улсын валютын сангаас гаргасан 2014 оны “Олон улсын өрийн тайлан”-д тус улс өдгөө 111.5 тэрбум ам.долларын нийт өртэй байгаа аж.

1998-2002 оны хямралаас хойш Аргентин улс гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд “шоовдорлогдсон” гэж болно. Одоо тэдэнд хөрөнгө татаж болох бүхнээ дэлхийн зах зээл дээр нийлүүлэх боломж бий хэмээн дэлхийн эдийн засагчид үзэж байна. Тухайлбал, Хятадын шар буурцаг болон бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлттэй холбоотойгоор Аргентин улс тус бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой гэжээ. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээхүйц бодлого явуулах нь нэн тэргүүний ажил юм. Ингэснээр мөнгөний урсгал нэмэгдэхийн зэрэгцээ олон улсын хөрөнгийн бирж дээр өрсөлдөх боломж нээгдэх аж. Гэвч олон улсын шинжээчдийн аминчлан захиж буй зүйл ч Аргентинийн засгийн газар зардлаа танаж хүний хөгжил зэрэг өгөөжгүй салбарыг өрийн мөнгөөр санхүүжүүлэхээ зогсоох хэрэгтэй гэнэ. Хавтгайрсан халамжийн уршигаар 2014 оны байдлаар тус улсын ажилгүйдлийн түвшин нийт хүн амын 20 хувьтай тэнцэж байна. Мөн албан тоогоор 13 хувьтай байгаа гэх инфляци хэдийнэ 25 хувьд хүрсэн хэмээн судалгааны байгууллагууд мэдээлж байгаа ажээ.

3

**1992** Инфляцийн өсөлтийг хазаарлах зорилгоор засгийн газар песо-ам. долларын ханшийг тэнцүүлэх бодлого хэрэгжүүлж эхлэв.

**1998** Азийн санхүүгийн хямралаас улбаалан Аргентиний эдийн засаг унаж эхэлсэн. Гадаадын хөрөнгө оруулалт зогсож долоо дахь өрийн хямралд орсноо зарлав .

**2001** Эдийн засгийн хатуу бодлого шаардан иргэд бослого гаргав. Аргентиний зээлжих зэрэглэлийг бууруулсан нь эдийн засагт хүнд цохилт болж олон улсын хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны ханш түүхэнд байгаагүйгээр буурсан.

**2002** Эдуардо Дуалдэ Аргентиний ерөнхийлөгчөөр сонгогдов. Тэрбээр песогийн ханшийг бууруулснаар ам.доллартай тэнцүүлэх бодлого зогссон. Түүнчлэн эдийн засгаа сүйрэхээс сэргийлэх үүднэс валютын болон банкны гадаад арилжааг бүрэн зогсоосон.

**2003** Аргентин улс Олон улсын валютын сантай зөвшилцөлд хүрснээр зээлийнхээ зөвхөн хүүг төлөхөөр болов.



УЗЭЛ БОДОЛ

# Монгол нүүрсний баялгаа “ногоон” нүүрс болгох боломжтой

*Аршад Саиед /“Пийбоди Энержи” компанийн Монгол, Энэтхэгийг хариуцсан ерөнхийлөгч/*

Монголын эдийн засгийн чуулганд дахин оролцох завшаан миний биед тохиосон юм.

Саяхан болж өнгөрсөн уг чуулганаар Монгол Улсын хөгжлийн хувьд ихээхэн чухал олон асуудлыг хэлэлцсэний дотор хоёр сэдэв анхаарлыг минь ихээхэн татсан билээ. Эдгээр нь Монгол Улсын эдийн засгийг хэрхэн ногоон болгох мөн тус улсын эрчим хүчний салбарын өрсөлдөх чадварыг улс орны хөгжил хийгээд ард олны сайн сайхны төлөө хэрхэн дээшлүүлэх тухай байв.

Чуулганд оролцогчид нүүрс болон эрчим хүчний бусад эх үүсвэрээр арвин баялаг Монгол орон хэтдээ “Эрчим хүчний диваажин” болох боломж байгаа тухай онцлон ярьж байлаа. Үүнийг бодит ажил болгоход дэлхийн хэмжээний томоохон компаниуд тус улсын эрчим хүчний салбарын цаашдын хөгжилд гар бие оролцох сайхан боломж бий болж байна. Дэлхийн хэмжээний компаниуд аюулгүй ажиллагаа, нийгмийн хариуцлага, байгаль орчны хамгаалал, технологийн шийдэл зэргээр Монгол Улсыг олон улсын хэмжээнд сайн жишиг улс болгоход ихээхэн хүчин чармайлт гарган, үр дүнд хүргэх чадвартай.

“Пийбоди Энержи” компани Монголын эдийн засгийн чуулганд энэ жил дахин оролцсондоо баяртай байна. Энэхүү чуулга уулзалтын цар хүрээ улам бүр тэлж, Монголын эдийн засгийн нэг тулгуур багана болох уул уурхайн салбарын өсөлтийн тоон үзүүлэлтүүдийг чанарын хувьд сайжруулахад ихээхэн тустай хэлэлцүүлгүүд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийнхний дунд боллоо.

Дэлхийн томоохон уул уурхайн компаниуд Монголын ашигт малтмалын салбарт олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлж, нутагшуулах онцгой боломжтой бөгөөд энэ хүрээнд Монголын Засгийн газар, бодлого тодорхойлогчидтой нягт хамтран Монгол Улсын нүүрсний үйлдвэрлэлийг эрчим хүчний жинхэнэ “диваажин” болгохын төлөө ажиллах үүрэгтэй.

Чуулганд оролцогчид Монгол Улсын хувьд нүүрс цаашдаа улам бүр өсөн нэмэгдэх эрчим хүчний хамгийн боломжит, найдвартай эх үүсвэр бөгөөд нийгэм эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч чухал хүчин зүйл байсаар байх болно гэсэн нэгдсэн ойлголттой байв. Үнэхээр ч нүүрс эдийн засгийн эрчимтэй өсөлтийг эрчим хүчээр хангахын зэрэгцээ ард түмний амьжиргааны түвшнийг дээшлүүлэх чухал эх үүсвэр юм.

Нүүрсний хэрэглээ болон эдийн засгийн өсөлтийн хооронд шууд уялдаа хамааралтай байдаг. Энэхүү хамаарлыг нүүрсний хэрэглээ өсөхөд дотоодын нийт бүтээгдэхүүн мөн өсдөг байдлаас илхэнээ харж болно. Хятад улс дэлхийн хамгийн хурдтай хөгжиж буй эдийн засагтай орон. Хятад эрчим хүчний хэрэглээ болон нүүрсний нийт хэрэглээгээрээ дэлхийд тэргүүлж байгаа нь тохиолдлын хэрэг биш юм.

Тус улсын ДНБ ирэх 20 жилд 275 хувиар өсөх бөгөөд мөн хугацаанд нүүрсний хэрэглээ нь үлэмж нэмэгдэнэ гэсэн тооцоолол бий. Үүнтэй адил Монголын эдийн засаг хурдацтай өсөх хэрээр асар их хэмжээний эрчим хүч шаардагдах болно. Өсөн нэмэгдэх энэхүү хэрэгцээг хамгийн боломжит бага өртгөөр хангаж чадахуйц эх үүсвэрүүдийн нэг нь яах аргагүй нүүрс мөн. Ингэснээр эрчим хүчний хангамжийг орлогын ялгаатай байдлаас үл хамааран бүх иргэдэд ижил тэгш хүргэж, улмаар нэмэгдүүлэх бололцоотой.

Сүүлийн жилүүдэд маш ихээр өсч байгаа нүүрсний экспорт Монголын эдийн засагт ихээхэн үр өгөөжийг авчрах нь тодорхой. 2008 онд 9.8 сая тонн байсан нүүрсний олборлолт 2011 онд 30.9 сая тонн болж өссөн бол 2020 онд 100 сая тонн нүүрс олборлох төлөвтэй байна.

Монголын эдийн засгийн чуулганаар хүрэн эдийн засгийг ногоон эдийн засаг болгох арга замуудын талаар нухацтай хэлэлцүүлгүүд өрнөсөн. “Пийбоди Энержи” Монгол Улсад хамгийн дэвшилт технологид суурилсан, нүүрснээс гарах хорт ялгаралтыг бараг бүрмөсөн тэглэх “ногоон нүүрсний” үйл ажиллагааг хэрэгжүүлж, ингэснээр тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна хэмээн төлөвлөж байна.

Манай компани нүүрснээс гарах ялгаралтыг бууруулах, карбоныг багасгах төслүүдийг АНУ, БНХАУ, Австрали зэрэг оронд эрчимтэй хэрэгжүүлж буй билээ. БНХАУ-д хэрэгжиж буй 650 МВт хүчин чадалтай цахилгаан станц, карбон судалгааны төвөөс бүрдэх “Грийнжен” төсөлд хөрөнгө нийлүүлэгч цорын ганц гадаад түнш нь “Пийбоди Энержи” юм. Өнөөдөр энэ төсөл туршилт хийх, мөн 250 МВт хүчин чадал бүхий эхний ээлжээ ашиглалтад оруулах шатандаа явж байгаа бөгөөд бүрэн дууссан цагтаа карбон ялган хураах мөн шингэн түлш боловсруулах технологи бүхий цогцолбор болох юм. Энэ төсөл амжилттай хэрэгжсэнээр ялгаралтыг бараг бүрмөсөн тэглэж чадсан бүрэн хүчин чадлаар ажиллах, дэлхийн хамгийн том дулааны цахилгаан станц (нүүрсний) болно. Эдгээр технологиуд нь нүүрсэнд суурилсан эрчим хүчний үйлдвэрлэлд эргэлт гаргаж, тогтвортой хөгжлийн ирээдүйг тодорхойлж чадна.

Нүүрсний олборлолт, түүний хэрэглээ ер нь нүүрс үйлдвэрлэлтийн бүхий л шатанд байгаль хамгаллын хамгийн шилдэг арга барилуудыг нэвтрүүлж, бодит үр дүнд хүрэх нь компанийн тэргүүн зорилго хэмээн “Пийбоди Энержи” үздэг. Манай компани Монгол Улс дахь нүүрсний уурхайн анхны цогц нөхөн сэргээлтийг Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Эрээний нүүрсний уурхайд хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн үр дүнд нүүрсний уурхай байсан газар хөрш зэргэлдээх газраас дөрөв дахин илүү өвсний гарцтай бэлчээрийн нутаг болсон. Энэхүү төслийг бид Байгаль орчин, аялал жуулчлалын яам, холбогдох бусад

байгууллага, их дээд сургуулиуд болон төслийн багт ажилласан инженерүүдтэй хамтран хэрэгжүүлсэн.

Бид уг нөхөн сэргээлтийг хийхдээ байгаль хамгааллын тал дээр дэлхийн хэмжээнд хуримтлуулсан тэргүүн туршлагаа ашиглахын зэрэгцээ тухайн газар нутагт Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран хийсэн судалгаанд тулгуурласан билээ. Уул уурхайн нөхөн сэргээлтийн шилдэг технологи, мэдлэгээ Монголд шилжүүлэх нэвтрүүлэх энэхүү оролдлого нь газрын нөхөн сэргээлтийн талаарх үндэстний мэрэгжилтнүүд болон орон нутгийн хүмүүсийн мэдлэг, туршлага, арга барилд хувь нэмэр оруулсан гэдэгт бид итгэлтэй байна.

Дэвшилт технологийг нэвтрүүлэх нь уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйл нь юм. “Пийбоди Энержи” нь өөрийн уурхайн ажиллагсад, тухайн нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн өртөг зардал бага, мөн карбон багатай эрчим хүч үйлдвэрлэх хамгийн оновчтой шийдлүүдийг нэвтрүүлж, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлдгээрээ дэлхийн тэргүүлэгч компани билээ.

Бид байгалийн баялгаа эдийн засгийн эргэлтэд үр ашигтайгаар оруулахыг зорьж буй Монгол Улсад дэмжлэг үзүүлэгч түнш нь болж буйдаа туйлын бахархалтай мөн хариуцлагатай хандаж байгаа билээ. Цэвэр, ногоон нүүрсний ирээдүйг ойртуулахын тулд аюулгүй ажиллагаа, уурхайн үндсэн үйл ажиллагаа, байгаль хамгаалал болон нийгмийн хариуцлагын чиглэлээр өөрийн эзэмшсэн тэргүүн туршлагуудаа Монголд зохистойгоор нэвтрүүлэх тал дээр цуцалтгүй ажиллах шаардлагатай байна гэдгийг ойлгож байна. Бидний энэ үзэл баримтлал үеийн үед үр өгөөжөө өгөх эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг монгол ёстой яв цав нийцэх учиртай.

Нүүрсний арвин их нөөц, газар зүйн байршил зэрэг нь олон улсын хэмжээний нүүрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний эх үүсвэрийн хөгжлийг нийгмийн хариуцлагатай хослуулсан дэлхийн сайн жишиг болох боломжийг Монгол Улсад олгож байна. Хамтдаа бид энэ эрхэм зорилгод хүрч чадах бөгөөд ингэсэн цагт эрчим хүчний диваажин болох нь лавтай. ■

2012 ОНЫ 04 САР.



ҮЗЭЛ БОДОЛ

# Төр гэдэг бизнес

*Л.Бямбаа /Судлаач, эдийн засагч/*

## Оршил

Төр гэдэг бизнес гэхээр монголчуудын дийлэнх нь төрийн өндөр албан тушаалд томилогдож, улмаар албан тушаалаа урвуулан ашиглаж өөртөө санхүүгийн болон санхүүгийн бус ашиг хонжоо олох гэж ойлгодог. Үнэн хэрэгтээ төр гэдэг нь шууд утгаараа тухайн улсын ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг бизнес. Төрийн үйлчилгээнд хууль тогтоох, зохицуулах, хэв журам сахиулах, ард иргэдээ эрүүл байлгах, суурь дэд бүтцээр хангах гээд олон тооны нийгмийг бүхэлд нь хамарсан үйлчилгээ багтана.

Нэгэнт бизнес юм бол тэгвэл төрд бизнесийн, өөрөөр хэлбэл ашигт, мөн үр ашигт ажиллагааны хуулиуд үйлчлэх ёстой. Улс төрч, төрийн албан хаагчид улс төр, тус бүрийн чиглэл салбарын мэдлэгээс гадна юуны өмнө менежер, бизнесмийн сэтгэлгээтэй байх ёстой. Тэгж үл чадваас төр дампуурна, төсвийн хямрал нүүрлэнэ. Учир нь улсын орлого татвараас бүрддэг, татварыг бид төлдөг, төр бидний мөнгийг аваад зөв, үр ашигтай зарцуулж үл чадваас төрийн функц доголдож бид төрийн үйлчилгээ авч чадахгүй болно. Төрийн бизнесийг амжилттай ажиллах үндсийг хувийн бизнесийн зарчмаар дүгнэн харъя.

## Бизнесийн зарчим-1. Стратеги

Аливаа бизнесийн амжилтын гол үндэс стратеги байдаг. Тийм ч учраас бүх хувийн компани өөрийн ерөнхий стратеги, алсын хараа, бизнес төлөвлөгөөг тодорхой боловсруулан ажилладаг. Нэгэнт баталсан хойно стратеги төлөвлөгөөг компанийн бүх шатанд ягштал мөрдөж дэвшүүлсэн зорилгод дор бүрнээ хүрэхийн төлөө ажиллаж байж үр дүнд хүрдэг.

Төрийн хувьд улс орны хэтийн хөгжлийн төлөвлөгөө нь үндсэн стратеги болох учиртай. Үндэсний хөгжлийн стратеги нэлээд урт хугацаагаар төлөвлөгдөж, түүнд нийцүүлэн харин намуудын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг гаргах ёстой.

Дэлхий нийтийн жишгээс харахад хөгжлийн стратеги төлөвлөлтөө сайн хийсэн улс орнууд онцгой амжилтад хүрсэн бодит жишээ олон байна. Тухайлбал, Сингапур, Өмнөд Солонгос, Макао зэрэг нь хэдхэн арван жилийн дотор гайхамшигт үсрэнгүй хөгжлийг хангаж чадсан байдаг. Эдгээр улсу үндэсний хөгжлийн стратегиа гаргаж түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө тууштай ажиллажээ. Улс орныхоо стратеги дээр суурилан компаниуд, муж улсууд, хотууд өөрсдийн стратегиа нийцүүлэн гаргасан байдаг. Жишээ нь, таван жилийн эдийн засгийн хөгжлийн стратегиа АНУ-ын Washington DC дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бизнест хамгийн таатай эдийн засаг
- Худалдааны шүүрэлтийг зогсоох
- Зүүн эрэг дэх технологийн хамгийн том төв
- Тухайн ангилалдаа хамгийн сайн эрүүл мэндийн төв
- Зорьж очдог сонголт болох
- Гадаад хөрөнгө оруулач, бизнес, жуулчдыг татах Хойд Америкийн тэргүүн хот болох
- 100,000 шинэ ажлын байр, нэг тэрбум ам.долларын татварын орлого

Монголын хувьд одоог хүртэл бүх нийтээр хүлээн зөвшөөрч, судалгаа шинжилгээн дээр тулгуурлан боловруулагдсан цогц бодлогын баримт бичиг алга. Тиймээс төр бүх нийтийн хүчийг нэгдсэн зорилго руу хөтөлж, чиглүүлж чадахгүй байгаа юм. Нам, яам, хувийн хэвшил, ард иргэд бүгд тус бүрийн үзэл бодол, хүсэл эрмэлзэл дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулж байгаа нь эцсийн нэгдсэн зорилгоо мэдэгхүй, ойлгоогүй, тул нэг алхам ахиж хоёр алхам ухарч байгаа мэт санагдана.

Саяхнаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төсөл яригдаж эхэлсэн бөгөөд уг хуулийн төсөлд Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн эрх зүйн үндсийг тодорхойлж, уялдааг хангах, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах зарчмууд багтаж байгаа аж. Энэ хууль батлагдвал цаашид нэгдсэн стратегиа боловсруулж батлах үүд нээгдэх нь.

## Бизнесийн зарчим-2. Харьцангуй давуу тал, өрсөлдөөн

Ширүүн өрсөлдөөн дунд бусдаас ялгаран гарах онцлог шинж, харьцангуй давуу тал бол бизнес удаан хугацаанд тогтвортой, ашигтай ажиллах үндсийг бүрдүүлдэг. Тэр нь үйлчилгээний чанар, үйлдвэрлэлийн үр ашигтай байдал, маркетингийн арга техник, найдвартай байдал гээд юу ч байж болно. Жишээлбэл, Apple компанийн давуу тал нь бүтээгдэхүүн болгон шинэлэг хэрнээ, энгийн, өндөр чанартай байлгаж чаддагт оршдог.

Тэгвэл Монголын давуу тал, бусад улс орноос ялгарах онцлог шинж чанар юу билээ? Үүнийг нарийн гаргаж ирж гадаад зах зээл дээр таниулснаар бид улсынхаа маркетингийг оновчтой хийж бусдаас илүү их хөрөнгө оруулалт татаж чадна. Монголын хувьд уудам газар нутаг, газар зүйн байршил, хоёр том зах зээлд ойрхон оршдог, залуу хүн амтай, зэвсэгт мөргөлдөөн, маргаан үгүй, ардчилсан нийгэм гээд тоочиж болно. Харин төрийн хувьд хувийн хэвшил болон хөрөнгө оруулагч нарт үйл ажиллагаа явуулахад таатай, шударга, тогтвортой орчин бүрдүүлэх нь ялгарах давуу тал бий болгох үндэс юм.

Монголын өрсөлдөх чадварын үнэлэн дүгнэсэн цөөнгүй судалгаа байдаг бөгөөд манай улс төдийлэн өндөрт жагсаж чадахгүй байгааг бид мэднэ. Тиймээс стратегиа тодорхойлчихоод дараагийн хийх ёстой алхам бол өрсөлдөх чадвараа дээшлүүлэх явдал юм.

## Бизнесийн зарчим-3. Санхүү, мөнгөн урсгал

Бизнесийн амжилтын дараагийн чухал үзүүлэлт бол мөнгө, санхүүтэй шууд холбоотой. Орлого хэрхэн төвлөрүүлэх үү, үйл ажиллагааны үр ашгийг хэрхэн хамгийн өндөрт байлгах үү, мөнгөн урсгалын менежментийг хэрхэн оновчтой хийх, хэдэн төгрөгний хөрөнгө оруулалт хийгээд хэдэн төгрөгний ашиг олох, өнөөдрийн ашиг уу эсвэл ирээдүйн тогтвортой байдал уу зэрэг олон асуудал үүнд хамаарна. Мөн эдгээр асуудлыг хэрхэн шийдсэнээс компанийн ирээдүй үлэмж хамаарна. Монгол компаниуд орлого, зардлын асуудлыг харьцангуй сайн шийдэж чаддаг ч мөнгөн урсгалын төлөвлөлт, мөн хөрөнгө оруулалтын удирдлагад алдаа гарах нь их.

Төрийн хувьд санхүүгийн менежментийг ямар түвшинд хийж байгааг төсвийн гүйцэтгэл, төлбөрийн балансыг статистикаас харж болно.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн нэгдсэн систем ч гүйцэд бүрэлдээгүй байна. Төрийн хөрөнгө оруулалтыг

**Санхүүгийн өгөөж авчрах төслүүд**

Санхүүгийн өгөөж өгөхгүй төслүүд гэж ангилж болох бөгөөд санхүүгийн өгөөж өгч чадахгүй төслүүдийн хувьд нийгэм эдийн засгийн үр өгөөж асар өндөр байх ёстой. Санхүүгийн болон эдийн засгийн үр ашгийг тооцооны үндсэн дээр хамгийн өндөр өгөөжтэйг авч хэрэгжүүлэх нь төрийн мөнгөөр шийдэгдэх төслүүдээс хамгийн сайныг сонгох боломж бүрдэнэ.

## Бизнесийн зарчим-4 Хүний нөөц

Бизнесийн хөдөлгөгч хүч, хамгийн чухал капитал нь хүний нөөц байдаг. Хүний нөөцийн удирдлага нь менежментийн урлагийн салшгүй нэг хэсэг мөн. Ажиллах хүчний тухайд үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлдэг. Энэ тогтолцоогоор дамжуулан цалин, урамшуулал, мөн үүрэг хариуцлагын асуудлыг тухайн ажилтны гүйцэтгэлтэй шууд уяж болдог. Жишээ нь, Америкийн том банкуудын захирлууд өндөр цалин, урамшуулал авдаг ч, банкны гүйцэтгэл муу байвал зохих хариуцлагаа шууд хүлээдэг.

Манай төрийн албан хаагчдын хувьд цалин бага гэдэг нэрийдлээр ажил үүргээ сайн хийх, цаашилбал хариуцлага хүлээх соёл бараг байдаггүй. Ингэснээр үр ашиггүй зардал өндөр, ажлын гүйцэтгэл ч сул байна. Төр нэг төгрөг зарцуулаад хэдэн төгрөг олж байгаагаас нь төрийн албаны үр ашигт ажиллагааг тодорхойлж болох байх, харамсалтай нь сүүлийн жилүүдэд төсөв алдагдалтай гарч байгааг бид мэднэ.

## Дүгнэлт

Иймэрхүү байдлаар бизнес, хувийн салбараас авч хэрэгжүүлэх зарчим олон бий. Тухайлбал, манлайлал, харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүний шийдэл зэргийг нэрлэж болно. Эдгээрийг авч хэрэгжүүлж чадвал “төр муу менежер” гэдэг ойлголтоос салж чадна.

Харамсалтай нь гэх үү, эмгэнэлтэй нь гэх үү дэлхий нийтийн давамгай сонгож хэрэгжүүлж буй зах зээлийн эдийн засагт үнэгүй юм гэж байдаггүй. Хэн нэгэн хэзээ нэгэн цагт заавал төлж таардаг. Төр биш бол татвар төлөгч төлж таарна, одоо үе биш бол хойч үе төлнө. Тиймээс бизнесийн үр ашиг, ашигт ажиллагааны зарчмыг төрийн салбарт түлхүү нэвтрүүлбэл хямралаас зайлсхийж, ухаалаг төрийн үндэс зөв тавигдаж, урт хугацаанд тогтвортой эдийн засагтай болох болов уу. ■

2014 ОНЫ 03 САР.



ҮЗЭЛ БОДОЛ

# Монголын төр хаанаас эхэлдэг вэ

*Ч.Отгочулуу /Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал/*

Улс төрийн хувьд “бүс нутагтаа үлгэр жишээ, ардчилсан” хэмээн тооцогдох болсон хэдий ч “зах зээлийн бус эдийн засагтай”, “эдийн засаг нь чөлөөт бус”, “төрийн бодлого нь тогтворгүй” гэх зэрэг цолноосоо Монгол Улс хэзээ салах вэ. Улстөрчид ч, судлаачид ч, хэвлэл мэдээллийнхэн ч сонгуулиас сонгуулийн хоорондсэтгэдэг хэвшилтэй болох нь. Энэ бол аюул. Иймд, гадна дотноос өгч буй дохио санамжийг авч, шинэ цагийн Монгол төрийн мөн чанар, түүний зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн талаар авч үзсэнээ толилуулж байна.

АНУ-ын төрийн үүсэл, зарчим. АНУ-ын тусгаар төрийн түүх Британийн колончлолыг эсэргүүцсэн “Үндэстний эцгүүд” хэмээх хувьсгалчдын тэмцлээс эхтэй. Чөлөөт иргэнээс эхлэх төрийн эрх мэдлийг ардын төлөө хэрэгжүүлэх нь тэдний үндсэн уриа байв. Анхны Ерөнхийлөгчид нь Хаан болох боломж байсан ч татгалзаж чадсанаараа Францын Наполеоноос ялгарч байв. Филаделфи хотноо эрх чөлөөний тунхагаа бичсэн нь Үндсэн хуулийнх нь эхлэл болсон бөгөөд төслийг нь бие даасан 13 муж улсууд руу илгээж батлуулсан байдаг. Зарим нэг жижиг муж улсаас ирэх хариуг хоёр жил хүлээсэн гэдэг. Уг нь бол татвар төлөгч иргэд буюу ард түмнээс асуулгүйгээр, шууд конгрессээс батлах боломж байсан ч, ардчилсан зарчмыг сонгосон нь энэ төрийн нэгэн гайхамшиг болжээ.

Үндсэн хуулиндаа Холбооны болон Муж улсын засаг, захиргаа ямар үүрэг хүлээх төдийгүй эрхийг нь ч тодорхой зааглаж өгсөн байдаг. Суурь зарчим нь Эрх мэдэл дороосоо дээшээ өгсөн хэрэгжих гэж болно. Холбооны түвшинд Соёлын яам, Үндэсний хөгжлийн яам гэх зэрэг байгууллага байхгүй. Харин шүүх, батлан хамгаалах болон мөнгөний бодлого гэх зэрэг цөөн тооны чиглэлд төр нь үүрэг хариуцлагаа авсан шиг аваад даацтай хэрэгжүүлдэг. Ингэхдээ сонгуулиас сонгуульд савладаггүй бөгөөд урт хугацааны бодлогыг хэрэгжүүлдэг, ардчилал шударга ёс, бизнесийн тогтвортой орчинг хангадаг Шүүх, Төвбанк зэрэг хүчирхэг байгууллагуудын хөгжилд гойд анхаарсан байдаг.

Америкийн төртэй харьцуулах нь. Манай төрийг Америкийнхтэй харьцуулж үзвэл орооцолдсон эрх мэдэл, бүхнийг төвлөрүүлсэн буюу орон нутгийн ардтүмэндээ итгэдэггүй зөвлөлт маягийн тогтолцооны ул мөр гүнзгий ажиглагддаг. Монгол төрийн байгууламжийн үндэс болсон үндсэн хууль, засаг захиргааны нэгжийн зохицуулалт нь Герман-Франц-Зөвлөлт системийн хольц юм. Тэгсэн хэрнээ улс төрийн чөлөөт сонгууль бүхий системээ харахаар Америктэй төстэй ч юм шиг. Ард түмний амьжиргааг тэтгэх учиртай төсвийн системээ харахаар Шинэ-Зеландын хуулийн загвар байх жишээтэй. Шинэ Зеланд нь огт өөр хуулийн системтэй, газар нутгаар хамаагүй жижиг улс. Гэтэл энэ загварт түшиглэснээр Монголын орон нутгийн удирдлага нь мөнгө санхүүгийн хувьд кассчинаас хэтрэхгүй эрх мэдэлтэй болсон. Өнөөдөр нэг сумын сургуулийн засварын зардлыг Их хурлын гишүүн шийдэж байна. Гэр хорооллын нэг хороонд хэн ажилгүй, хэн архидаад байгааг хороон дарга маш сайн мэднэ. Гэтэл түүнд татвар болон урамшууллын ямар ч эрх мэдэл үгүй. АНУ-д бол манайхаар хороо, сум харьцангуй их эрх мэдэлтэй. “Сумын засаг дарга” буюу Говернер эвсэл майорууд нь ажлын байр бий болгох хувийн хөрөнгө оруулалтыг татахын төлөө хоорондоо өдөр шөнөгүй өрсөлддөг.

БНХАУ-ын төрийн үүсэл, өнөөдөр баримталж буй зарчим. Хятадын төр яг хэзээ үүссэн нь тодорхойгүй. Хятадын төрийг байгуулагч гэх хүн эсвэл хүмүүсийн тухай баримт олдоогүй, харин салж бутарсан төрийг эргүүлэн нэгтгэсэн нэгэн айхтар Шар эзэн хааны тухай домог байдаг. Домгоос үзэхэд, домог үүсэхээс ч өмнө нэг төр байж байгаад тэр нь задарсан гэдэг нь илт. “Эртний Хятадын дайны урлаг” хэмээх нэг номонд Хүннү нарын ов мэхийн талаар олонтаа дурдсан байдаг. Түүхээсээ асар их сургамж авдаг энэ гүрэн цагтаа өөрсдөөсөө илүү хүчирхэг нүүдэлчдийн олон төрийг өөрсдөдөө уусгаж байв. Ердөө 100-200 жилийн өмнө “Улаан үст зэрлэгүүд” (барбарууд) буюу Европчуудын түрэмгийлэлд шаналж байсан энэ улс өнөөдөр үйлдвэрлэл, мөнгө санхүүгийн хувьд дэлхийн эзэнт гүрэн болон өндийж буй нь олон мянган жилийн турш тасралтгүй сайжирч ирсэн төрийнх нь хөгжилтэй холбоотой биз ээ.

Америкаас эрс ялгаатай зарчим гэвэл эрх мэдэл нь дээрээсээ доош явна. Нэг төлөвлөөд түүндээ бүх хүчээ хаях нь манай туулаад гарсан социалист системтэй төстэй. Гэхдээ БНМАУ болон ЗХУ-д хүчээ авч байсан социалист догматикаас илүү уламжлалт прагматик хандлагадаа тулгуурлаж иргэддээ эдийн засаг, санхүүгийн боломжийг бүрдүүлж өгснөөр илүү амжилтад хүргэжээ.

Төр гэж ер нь юу юм бэ. Барууны хайрцгаар мэдээлэл хүлээж авдаг, сэтгэдэг, харьцдаг хүмүүст бол энэ нь чөлөөт иргэдийн нэгдэл. Төрийн гишүүн байх нь эс байхаас илүү дээр. Татвараа өгчихнө, хэн тэр татварыг юунд захиран зарцуулахыг сонгоно. Коммунист онолд, ядуу ажилчин анги хувийн өмчгүй, ангигүй нийгэм байгуулахад төр хэрэгтэй. Дорнын уламжлалт ухаанд тэнгэр, бурхнаас өгсөн эрхийг газар дээр хэрэгжүүлэх хэрэгсэл нь төр болно.

Төр ямар эрхтэй, ямар үүрэгтэй, иргэн ямар эрхтэй, ямар үүрэгтэй

байх талаар ул суурьтай бодох нь монголчуудын асуудал. Учир нь, бид одоо гадаадаас нэмж хуулах зүйл хомс. Харин одоо бидний өмнө байгаа ороолцолдсон, данхайсан төрийг яаж олон нийтийн үйлчилгээний алба болгох вэ гэдэг нь зөвхөн бидний л хийх ажил болно. Иймд суурь мөн чанар руу эргэн орж, төрийг эрх үүргийн солбилцол гэх өнцгөөс харж эхлэх нь зүйтэй.

Жирийн нэг иргэний эрх, хүслээр жишээ авъя. Жирийн иргэн инфляци багатай, тогтвортой орчинг хүсч байна. Хэрэв Улаанбаатарт амьдардаг бол гудамжинд буй онгорхой нүхнүүдийг тагтай байлгах нь төрийн аль байгууллагын үүрэг вэ гэдгийг мэдэх эрхтэй. Хөдөөний суурингийнхан халуун устай, тогтой, чанартай орон сууц, сургууль, эмнэлгийг хүсч байна. Тэд илүү их санхүүгийн эрх мэдэл, өөрсдийнхөө орон нутгийг хөгжүүлэх эрх, хариуцлагаа Улаанбаатараас салгаж авахыг хүсч байна. Гэвч улс төрчид (УИХ) маань даахгүй нохой булуу хураана гэгчээр УБ-ын хэдэн яаманд хэт ахадсан эрхийг нийслэлийн хэдэн албан хаагчдад хадгалсаар байгаа юм.

Дүгнэлтийн оронд. Америк юм уу Хятад маягийн төрийн тогтолцоог харьцуулан харахад аль ч улсын төр бол “Эрх үүргүүдийн зах (супермаркет)” гэдэг нь ил болж ирж байна. Гол нь өөрийн түүх, соёлд тохируулсан загвар буюу хэлбэршлийг хэрхэн олсноороо л ялгагдана.

Манайд төрийн засаглал нь улс төр, хууль эрх зүй, төсөв мөнгө гэсэн гурван түвшиндээ өөр өөр системээс хуулаад бантагнуулчихжээ. Дан бидний буруу ч бас биш ээ. Сүүлийн зуунуудад гаднын эрхшээлд явж ирсэн, мөн уламжлалт төрт ёсны суртал нь аж үйлдвэржилтээр тодорхойлогдох цаг үед тэр бүр тохирохгүй байсан зэрэг бэрхшээл бий.

Бидний буруу бас байна. Өөрийгөө танин мэдэх бололцоогүйгээр гаднын системийг хүчээр болон дурандаа авч ирсний үр дүнд Монгол төр өнөөдөр өөрийгөө ч танихаа болтлоо харьжжээ. Хятадын төрийн гаднаас суралцах чадвар бол гайхамшигтай. Хэдий хятад соёл, хятад онцлог гэж ярьдаг ч энэ орон Монголоос ч илүү орчин үежсэн гэдэгтэй маргах хүн гарахгүй биз. Америкийн төр нь иргэндээ итгэх итгэлээс эхэлдэг бол Хятадынх төрт уламжлалдаа итгэх итгэлээс эхэлдэг. Харин Монголын төр хаанаас эхэлдэг вэ? ■

2012 ОНЫ 01 САР .



*Найжил Финч /Австралийн Сиднейн Бизнесийн их сургуулийн профессор, Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн/*

ҮЗЭЛ БОДОЛ

# “Монголыг нөмөрч буй төсвийн хямрал”

Улсын төсвийг гаргана гэдэг гарын дор хийчих ажил гэж хэн ч хэлж байгаагүй. Эдийн засаг агшиж, тэлж байдаг. Тиймээс ч дараа жилийн төсөв энэ жилийн бодит төсөв рүүгээ буцаад эргэдэг тул аль болох эртнээс тооцоо хийх нь боломж муутай байх талтай. Тухайн орлогын гол эх үүсвэр нь уул уурхай гэх мэт урьдчилан тааварлахад бэрх, маш хувьсамтгай хүчин зүйлсээс хамааралтай байгаа тохиолдолд татварын орлогоос Засгийн газарт төвлөрүүлэх хуримтлалыг тооцоход маш хүндрэлтэй байдаг.

Австралийн Сангийн сайд Вэйн Максвэлл Свон тус улсын зөрчилдөөн ихтэй “Ашигт малтмалын түрээсийн татвар” (АМТТ)-аас татан төвлөрүүлсэн хуримтлал нь төлөвлөснөөс гайхмаар бага байгаа тухай ярьдаг нь эргэлзээгүй үнэн. Татвар нь тааварын үнэ болон биржийн ханшаас маш их хамааралтай байдаг. Хэврэгхэн, хувьсамтгай зүйлст суурилсан “амбицтай” татварын үр дүн ямар байхыг тааварлахад бэрхтэй. Үүний балгаар Австралид ашигт малтмалын түрээсийн татвар хоёр тэрбум австрали долларааар гэнэт дутсан бөгөөд энэ нь төсвийн илүүдэл мөнгийг дэмий үрж, бодит алдагдлыг улам доройтуулж байна.

Бүхэлд нь авч үзвэл ашигт малтмалын түрээсийн татварын хоёр тэрбум австрали доллар олох гэсэн Сангийн яамны хэт өөдрөг төсөөлөл нь тус улсын нийт хуримтлал болох 360 тэрбум австрали доллартай харьцуулахад ач холбогдолгүй бага тоо. Гэхдээ төсөөллийн үр дүн тийм хол зөрүүтэй гарах ёсгүй. Энэхүү зөрүү нь бодит алдагдлыг хэдэн тэрбум австрали долларааар ч нэмэгдүүлэх эрсдэл өндөр. Гэвч тогтоогдсон нөөцийн зээлийн төлбөрийн чадвар сайтай болох нь мэдэгдэж буй тус улсын эдийн засгийн хувьд иймэрхүү тааламжгүй гэнэтийн зүйлийг зохицуулах чадвартай байх шаардлагатай.

Гэхдээ уул уурхайгаас ихээхэн хамааралтай, тогтвор муутай, хэврэгхэн эдийн засгийг жолоодож буй Австралийн Сангийн сайдын хүндэн байдлыг бодолцох хэрэгтэй. Монгол Улсын шинээр гарч ирж буй эдийн засаг Австралийн эдийн засгийн хэмжээтэй харьцуулахад бутархай тоо төдийхнөөр яригдана. Монгол Улсыг үр дүнтэй удирдан жолоодох чадварыг мохоох улс төрийн тогтвортой байдлын талаарх асуудал санаа зовоож буй. Монголын Засгийн газар 3.5-4 тэрбум австрали долларын татвар хуримтлуулдаг нь Австралийн төрийн өмчийнх нь нэг гаруйхан хувьтай тэнцэж байна. Гэхдээ Монголд хөгжилтэй орнуудын эдийн засагт байдаг “жийргэвч” дутагдаад байгаа хэрэг.

Монгол Улсад Австралид мөрдөгддөг АМТТ гэж байдаггүй. Гэхдээ энэ нь ард иргэддээ зориулсан найдвартай орлогын эх үүсвэрийг бий болгоход шаардагдах үр өгөөж гэхээс илүүтэйгээр сонгуулийн тойрогт дахин санал авах зорилгоор татварын үр дүнгүй бодлогоос зайлсхийсэн гэсэн үг биш. Монгол Улсын татварын хуримтлал ашигт малтмалаас ихээхэн хамааралтай бөгөөд уул уурхайн салбараас хуримтлуулсан

роялти, ногдол ашиг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гуравны нэгийг эзэлж байна. Эдгээрийн дунд хамгийн том нь Тавантолгой нүүрсний орд, Оюутолгой зэс, алтны орд юм.

Монгол Улсын Засгийн газрын зуун хувь эзэмшилд байдаг Тавантолгой дэлхийн хэмжээнд ашиглагдаагүй байгаа хамгийн том нүүрсний орд газруудын нэг бөгөөд БНХАУ-ын хилд ойрхон байрладаг. Монгол Улсын нийт экспортын тэн хагасаас ч илүү хувийг нүүрс эзэлдэг бөгөөд эдийн засгийн өсөлтөд өндөр хувь нэмэр оруулдаг. Энэ нь улсын төсвийг улам томруулж, аль болох эрч хүчтэй, өөдрөг харагдуулах нөхцөл болж буй хэрэг. Гэвч Засгийн газрын татварын орлогыг хуримтлуулах сайхан боломжид уул уурхайтай холбоотой аюул заналхийлсэн асуудал ар араасаа цуврах болов.

Туршлагагүй менемжент, үр ашиг муутай практик, авлигын сүлжээ зэрэг нь уул уурхайн үйлдвэрлэлийг 50 хувиар бууруулжээ. Бас нэг таагүй хүчин зүйл бол БНХАУ-ын “Чалко” компанитай холбоотой сунжирсан зөрчилдөөн. Энэ нь Монгол Улсын нүүрсний импортын хэмжээг ихээр бууруулж байна. Үүний зэрэгцээ нүүрсний үнэ ихээр унах болсон нь Засгийн газарт хуримтлагдах татварт цаашид сөргөөр нөлөөлөх аюултай.

Энэ зуур уул уурхайн татвар төлөгч Англи-Австралийн хамтарсан “Рио Тинто” компанийн гүйцэтгэгч Оюутолгойн үйл ажиллагаа хойшлох болов. Энэ нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой улс төрийн хөндлөнгийн оролцоотой холбоотой. Оюутолгойн уурхай мөн л БНХАУ-ын хилтэй ойрхон байрлах бөгөөд дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайнуудын нэг.

Уурхай дээр үйлдвэрлэл хараахан эхлээгүй байгаа ч Монгол Улсын Засгийн газар болон эдийн засаг аль хэдийнэ 6.6 тэрбум ам.долларын өгөөж хүртсэн. Уурхайн хөгжлийг эхний шатанд оруулах үүднээс барилгын ажилд хөрөнгө оруулалт хийжээ. Засгийн газар тус уурхайн 34 хувийг, үлдсэн хувийг Рио Тинто эзэмшдэг. Гэвч шинэчлэлийн Засгийн газрын зүгээс байгалийн баялгийг хэт үндсэрхэг болгохыг дэмжиж буй нь үйлдвэрлэл хойшлоход хүргээд байгаагийн зэрэгцээ илүү их хувьцаа эзэмшиж, татварын орлогоо нэмэгдүүлэхийг Засгийн газраас шаардах болов. Талуудын хоорондох маргаан дууссан ч Монгол Улсын хувьд одоо үргэлжилж буй барилгын ажлын дараах үр шимийг хүртэх боломж бага байхын зэрэгцээ энэхүү маргаан нь Оюутолгой бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед авч эхлэх цаашдын татварын хуримтлалыг хойшлуулж буй хэрэг юм.

Монголын төр уул уурхай, ашигт малтмалын экспортоос маш их хамааралтай эдийн засгаараа, үймээн самуун дундах хоёр том төслөөрөө өөрийн төсвөө гаргах томоохон сорилттой тулгараад байна. 2013 онд татварын хуримтлалаа жил бүр 31 хувиар нэмэгдүүлэх “амбицтай” өсөлтийг төсөвлөсөн нь одоогийн нөхцөл байдалд маш тохиромжгүй харагдаж байгаа юм. Зардал ихээр шаардагдах сонгуулийн амлалтын сунжирсан жагсаалтыг тооцоод үзвэл саналаа алдахгүйгээр Засгийн газар зардлаа бууруулж харагдах нь юу л бол. Айсуй төсвийн хямрал бол Монголын хэврэг эдийн засгийн тогвортой байдлыг цаашид алдагдуулах, санхүүжилтгүй алдагдал юм.

Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа баталсан бөгөөд 2013 оны улсын төсвийг уг хуулийн хүрээнд баталсан нь шинэчлэлийн Засгийн газрын анхны төсөв болж байгаагаараа онцлог. Уг хууль Засгийн газрыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүйгээр төсвийн алдагдлыг дээд түвшинд тооцох арга замаар санхүүгийн менемжентийг маш чамбай хийхэд зориулсан хууль юм. Гэхдээ энэхүү дээд түвшин алдагдах магадлал өндөр байгаа бөгөөд Дэлхийн банкнаас гаргасан төсөөллөөр төсвийн алдагдал ДНБ-ий зургаан хувиас хэтрэх шинжтэй байна. Энэ томоохон алдагдлыг зогсоосон ч энэ нь Засгийн газрын хувьд сонгуульд саналаа өгөх ард иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдад санхүүгийн чадвартай менежер гэдгээ харуулах сайны тэмдэг болж чадахгүй юм.

Монгол оронд нүүрлэж буй төсвийн хямрал гэдэг нь Засгийн газар өөрийн хөрөнгөө санхүүжүүлэх мөнгө олохын тулд арга зам хайх болно гэсэн утгатай бөгөөд хамгийн сайн эх үүсвэр нь өнгөрсөн арванхоёрдугаар сард босгосон 1.5 тэрбум ам.долларын Чингис бонд байх болно. Уг бондын зориулалт нь эдийн засгийн хувьд дэд бүтцийн чухал төслүүдийг санхүүжүүлэх явдал. Гэвч Засгийн газар бүтэлгүйтэж буй төсвөө хөшүүрэгдэхийн тулд бондын хөрөнгийн санхүүжилтийн зориулалтыг өөрчлөхөд хүргэж, “Өгөөш ба өөрчлөлтийн бонд” гэсэн нэр зүүлгэж, бүх зүйл талаар өнгөрөх вий дээ. Иймэрхүү тактик уг бондын үнэ цэнийг алдагдуулж, Монгол Улсын эрсдлийн талаарх гадаадын хөрөнгө оруулагчдын мэдрэмтгий байдлыг улам дордуулж, зээлийн төлбөрийн чадварын түвшин буурахад хүргэж болзошгүй.

Хамгийн томд тооцогдох зарим татвар төлөгчийн өнөөгийн байдал ямар байгаа нь нэгэнт тодорхой учраас Монголын Засгийн газар төсвийн алдагдлаа зогсоох зорилгоор Чингис бондыг зарцуулах гэж байна гэж харж болохоор байна. Гэхдээ үүгээр оролдох нь Засгийн газрын хувьд банкны салбараа дэмжих ямар нэг материаллаг дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадвараа хязгаарлаж байна гэсэн үг. Энэ нь цаашдаа эдийн засгийн чадавхиас хол давсан ханшийн уналт, Засгийн газрын зардлын асуудалтай тулгарч, аюултай байдалд оруулах төлөвтэй байна. Банкны салбар дахь аливаа хямрал нь Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг маш түргэн хугацаанд үнэ цэнээ алдахад хүргэх бөгөөд хөрөнгийн үнийг дахин бууруулахад маш хүндрэлтэй болох юм.

Монголд хэт өөдрөг олон эдийн засагч цаашдаа эдийн засгаа Голланд өвчинд нэрвэгдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар удаан хугацаанд бясалгаж, хоосон цэцэрхэлд автан суух зуур зарим нэг эдийн засагч төсвийн бодит төсөөлөл гаргаж, Засгийн газрын санхүүгийн менемжентийг чамбайруулахын тулд прагматик талаас нь түлхүү харахад анхаарлаа хандуулж байна. ■

2013. 04 САР.



ҮЗЭЛ БОДОЛ

# Герман-Монголын эдийн засгийн харилцааны боломж

*Штефан Хансельманн, /ГОУХАН-ийн "Эрдэс баялаг, түүхий эд иж бүрэн санаачилга хөтөлбөр"-ийн захирал/*

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн энэ оны гуравдугаар сард ХБНГУ-д хийсэн төрийн айлчлал Герман-Монголын бат бэх харилцааны баталгаа болсон билээ. Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Монгол улс хоёрын хоорондын техникийн хамтын ажиллагаа энэ онд 20 жилийн ойн баяраа тэмдэглэж байна. Түүнчлэн ХБНГУ-ын канцлер Ангела Меркель өнгөрсөн онд Монгол улсад айлчилж, түүхий эд, аж үйлдвэр, технологийн салбарт хамтарч ажиллах Засгийн газар хоорондын гэрээг үзэглэсэн нь хоёр орны түншлэл өргөжиж буйг илтгэх аж. Монголын байгалийн баялаг, Германы хамгийн сүүлийн үеийн технологи гэсэн бүтцийн өөрчлөлт нь хоёр үндэстний нэгнийгээ нөхөх суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн хамтын ажиллагаа, герман компаниудын оролцоо нь хүлээлт болон боломжоос доогуур байгаа нь ажиглагдаг. Европын холбооны орнуудаас Герман нь Монголын хамгийн чухал худалдааны түнш юм. Манай хоёр орны худалдаа өнгөрсөн оны байдлаар 156 сая евро байгаа нь дэлхийн хоёр дахь том экспортлогч орон болох Герман, байгалийн баялаг арвинтай Монгол улсын хувьд чамлалттай үзүүлэлт юм. Тодруулбал, Герман улс Монгол руу нийт 145 сая еврогийн өртөгтэй бараа бүтээгдэхүүн экспортолж, Монгол тус орноос 10.4 сая еврогийн бараа импортолжээ. Монгол улс Германы хувьд 122 дахь экспортын зах зээл нь байхад (2010), Германы импорт хийдэг орнуудын хувьд авч үзвэл 154 дэх нь Монгол (2010) билээ. Харин Монголын импортлогч орнуудын жагсаалтад Герман зургадугаар байр эзэлдэг. Германаас Монголын экспортолсон бараа сонирхуулахад, 2010 онд нийлүүлсэн хамгийн гол бүтээгдэхүүн нь машин механизм 34.2 хувиар, цахилгаан болон тээврийн хэрэгсэл 12.1 хувь, хүнс 9.5 хувь байна.

## Хоёр талын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх суурь нөхцөл

Хэдийгээр Герман, Монгол хоёр улсыг хэдэн арван жил дотно, найрсаг харилцаа холбож байгаа ч Монголд үйл ажиллагаа явуулж байгаа герман компаниудын идэвх сул байна. Энэ нь олон шалтгаантай. Жишээлбэл, Герман улс жинхэнэ утгаараа уул уурхайн орон биш. Гэхдээ ирээдүйд герман компаниуд, хөрөнгө оруулагчид уул уурхайн төрөл бүрийн төсөлд хамтарч ажиллах бүхий л боломжийг сайтар судлах хэрэгтэй. Уул уурхайн төсөл, хөтөлбөрт оролцохын тулд заавал өөрөө энэ салбарын аж ахуйн нэгж байх албагүй. Германы талаас бие даасан компани, консорциумаар дамжуулж санхүүжилтийн асуудлыг шийдэх боломжийг хангалттай хэмжээнд авч үзээгүй байгаа (ялангуяа хувьцааны санхүүжилт).

Хоёр орны хамтын ажиллагаа олон жилийн түүхтэй, мөн Германд мэргэжил эзэмшсэн олон мэргэжилтэн мэдээллээр хангаж болох атал ихэнх тохиолдолд герман компаниуд Монголын тухай төдийлэн сайн мэддэггүй. Энэ нь Германы талаас мэдээлэл, өгөгдлийн зөв эсэхийг хангалттай хэмжээнд шалгалгүйгээр төсөл хөтөлбөр эхлүүлэхэд хүргэдэг. Ийм төсөл нь соёлын ялгаа, бэлтгэл тааруугийн улмаас урагшаа явдаггүй, эсхүл хэрэгжилтийн шатандаа амжилтгүй болдог. Улмаар германчуудын дунд Монголд төсөл хэрэгжүүлэхэд төдийлэн амжилттай болдоггүй гэсэн ташаа ойлголт байдаг нь харамсалтай. Учир нь Германы компанийнхан хуучинсаг үзэлтэй бөгөөд урт хугацааны, тогтвортой түншлэлийг зорьдог. Иймд тэд өөрсдийн сонгосон төслийнхөө найдвартай түнш нь болж чаддаг. Нөгөө талаас Монголын хууль, засаг захиргааны нөхцөл байдал төдийлэн нээлттэй, урьдчилан таамаглах боломжгүй байдаг нь консерватив герман компаниудад тустай биш. Ихэнх тохиолдолд стратегийн томоохон төслүүдэд зохицуулалт тааруу байдаг. Монголын хууль тогтоомжийн том сул тал бол хууль батлахдаа үр дагаварт нь үнэлгээ хийдэггүй, хийсэн ч хангалттүй байдаг талтай.

## Хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн боломж

Герман, Монголын ирээдүйн хамтын ажиллагаа Германы ноу-хауг нэмүү өртгийн сүлжээ бий болгоход чиглүүлэх хэрэгтэй. Ингэснээр Монголд тогтвортой үнэ, ашиг болон бүтээмж нэмэгдэж, нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулна. Үүнд түүхий эд боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэг, хоёр жижиг төсөл дээр тогтож, урт хугацаанд хэрэгжүүлнэ. Энэхүү төсөлд тусгай нөхцөл байдал (татварын хөнгөлөлт, урт хугацааны гэрээ, баталгаа) үйлчлэхээр хийж болох аж. Эдгээр төсөл нь загвар байх тул төрийн зүгээс эрчимтэй хамтарч ажиллах хэрэгтэй (жишээ нь Монгол улсын Эдийн засгийн яамны хэлбэрээр). Санхүүгийн түншлэл эсхүл төрийн байгууллагын эхний үед түр зуурын хамтын ажиллагаа байх боломжтой юм. Эдгээр төслийг дэс дараалалтай, сайн бэлдэх нь чухал. Энэ нь эхлээд хэдэн сая ам.долларын өртөгтэй судалгаа хийх хэрэгтэй гэсэн үг биш. Харин эхний ээлжинд гол асуудалд хариулт өгч, хөрөнгө оруулагчийн сонирхлыг татсан төслийн баримт бэлтгэвэл зохистой.

Сонгосон төслийг системчлэн боловсруулж, үүнийхээ дагуу Германтай харилцаа тогтооно. ГОУХАН-ийн "Эрдэс баялаг, түүхий эд иж бүрэн санаачилга" ЭТИС хөтөлбөрийн зүгээс эдгээр үйл ажиллагааг дэмжих эрхийг

Германы талаас авсан. Хэрвээ төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх төсөл байгаа тохиолдолд Эдийн засгийн яаманд гурваас дөрвөн мэргэжилтэнтэй ажлын хэсэг зохион байгуулж, ЭТИС хөтөлбөртэй хамтарч ажиллах боломжтой.

Эдгээр төслүүд харин технологитой холбоотой, ирээдүйд чиглэсэн Монгол улсад урт хугацаанд үр ашгаа өгөхөөр байх ёстой. Германы эдийн засгийн хувьд төслүүд стратегийн ач холбогдол бүхий мөн л урт хугацаанд хэрэгжүүлнэ. Хамтрах герман түнш байгууллагаа сонгохдоо дунд хэмжээний аж ахуйн нэгжид хандах хэрэгтэй. Монгол улсад эдийн засгийн чадамж дээрээ суурилсан "German Mittelstandsofensive" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Үүний зэрэгцээ мэдээж Нүүрс шингэрүүлэх үйлдвэр, Коксжуулсан нүүрс хэмээх томоохон төсөл мөн байх шаардлагатай гэж бодож байна. Энэ тохиолдолд ажлын байранд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр, ажлын байрны тоо доогуур байна. Германы эдийн засгийг зөвхөн томоохон үйлдвэрүүд болох "Siemens", "Daimler", "ThyssenKrupp" авч явдаггүйг хэлэх нь зүйтэй байх. Нийт герман ажиллагсдын 75 хувь нь жижиг, дунд үйлдвэрт ажилладаг. Германд дунд аж ахуйн нэгж нь 250 хүртэл ажилтантай, жилийн 50 сая еврогийн эргэлтийн хөрөнгөтэй байдгийг дурдья. Германы эдийн засгийн хөгжлийн түлхүүр нь жижиг, дунд компаниуд юм. Тэдгээр нь дээд зэргийн уян хатан, инновацитай бөгөөд хэрэглэгчдээ хамгийн их үр ашиг санал болгодог. Тэдний дунд тухайн салбартаа технологи, туршлагаараа тэргүүлдэг олон "Нууц аваргууд" ("Hidden Champions") байдаг. Монголын компаниуд эдгээртэй хамтарч ажиллах нь ихээхэн тохиромжтой гэж үзэж байна.

Герман улс уул уурхайн техник, нүүрс, коксжуулсан нүүрс, зэс болон бусад эрдэс баялгийг боловсруулахдаа дэлхийд тэргүүлэх ноу-хау ашигладаг. Эдгээр технологийг Монголд нэвтрүүлэхийн тулд Германы талын тусламжтайгаар орчин үеийн олон улсын норм норматив, стандартад нийцсэн тогтолцоог боловсруулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэхүү стандартыг хэрэгжүүлээгүй тохиолдолд өрсөлдөөн зөвхөн үнээр тодорхойлогдоно. Тухайн бүтээгдэхүүний чанар болон баталгаа нь Хятадаас орж ирсэн хямд импортын барааны дарагдана. Үүнээс гадна өнөөгийн байдлаар сул байгаа Монголын стандартын тогтолцоо нь Австрали, Канад, Герман, Япон зэрэг улсаас стандарт оруулж ирэхэд улам асуудалтай болно. Монгол улс энэ тал дээр ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахаар харагдаж байгаа. Техникийн дүрэм журам, стандарт нь эдийн засгийн хөгжлийн зайлшгүй тавигдах ёстой суурь учраас ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөр тус сэдвийг олон жил дэмжсээр ирсэн. Орчин үеийн норм, стандартын тогтолцоо нь зөвхөн томоохон техникийн төслүүд дээр биш, түүнээс гадна Монгол улсын шинэчлэлд мөн хувь нэмрээ оруулах юм. Жишээлбэл, ажлын байрны хамгаалал, баталгаанд ч гэсэн олон норм, стандартыг баримталдаг.

Уул уурхайн төслийн тоо зах зээлд олширохоод цаг хугацаа шаардана. Оюутолгой, Тавантолгой гэсэн томоохон төслүүдийг оруулсан ч хэрэгжилтийн шатандаа явж байгаа уул уурхайн бизнес харьцангуй жижиг. Германы ханган нийлүүлэгчдийн хувьд Канад юм уу Австралийн уул уурхайн төсөлтэй хамтрахад бэрхшээлтэй. Яагаад гэвэл "Рио Тинто" гэхчлэн компаниуд үйлчлүүлэгчийнхээ техникийн асуудлыг олон жилийн турш хариуцсан. Өсөн нэмэгдэж байгаа уул уурхайн төслүүд харин Германы уул уурхайн ханган нийлүүлэгчидтэй хамтрах суурийг бий болгох бөгөөд үйл ажиллагааны чиглэлээр төрөлжин Монголд байрлах болно (Жишээлбэл, Германы тэргүүн туршлага төв дэх "Voith" компани). Энэ нь ажлын байр, технологийн ноу-хауг бий болгоно.

Герман, Монгол хоёр орон эдийн засаг, технологийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй байдгаа олонтаа илэрхийлсэн. Монголд өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц хурдацтай явагддаг, мөн эрдэс баялийн арвин нөөцөөрөө дэлхийн олон орны сонирхлын төвд буйг Герман болон тус улсын бизнесийнхэн бусдын адил анхааралтай харж байх ёстой. Нөгөө талаас Монгол гуравдагч түнш орны бодлого хийгээд Герман улстай хамтрах эдийн засгийн хамтын ажиллагааг тодорхой болгох шаардлагатай байна. ■

2012 ОНЫ 04.

ГАДНЫН ХЭВЛЭЛД



*Ханс-Вернер Зинн ХБНГУ-ын эдийн засгийн судалгаа, шинжилгээний "Ifo" институтын ерөнхийлөгч, Мюньхен хотын их сургуулийн профессор. Тэрбээр 2013 оны аравдугаар сард Монголд лекц уншсаныхаа дараа Германы сэтгүүлд уг нийтлэлийг бичжээ.*

# Бухимдуулсан параллель

Грек, Монгол улсууд юугаараа нийтлэг вэ? Эдгээр нь хоёулаа хөгжиж буй улс орон, Голланд өвчинд нэрвэгдсэн бөгөөд дотоодын эдийн засаг нь сул аж. Түүнчлэн эдгээр орнуудын нийгмийн дээд давхарга нь ард түмнийхээ эрх ашгийг хохироож баяжсан байна.

Монгол Улсад айлчилсныхаа дараа тус орныг Гректэй харьцуулмаар санагдлаа. Эдгээр нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтын дагуу дэлхийн хөгжилтэй орнуудын тоонд багтаагүй хөгжиж буй улс орнууд юм. Аль алинд нь эмх замбараагүй байдал ноёрхдог. Хотод хувийн орон сууцнууд ар араасаа цувран сүндэрлэх нь хот төлөвлөлт хэрэгждэггүйн улмаас засаг захиргааны тогтолцоо авлигад автсаныг илтгэх аж. Амьдралын стандартыг ихээхэн анхаардаг ч түүнийгээ гажуудуулан гуйвуулсан. Тухайлбал, орчин үеийн хийц загвар бүхий автомашин, iPad (айПэд), хавтгай дэлгэц, хиймэл дагуулын таваг болон Луи-Уитоны дэлгүүрээр дутаагүй. Харин зам харгуй болон нийтийн тээврийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд хэрэгцээтэй байна. Хөдөө аж ахуйг эс тооцвоос зөвхөн төр, худалдаа арилжаа ба олон улсын байгууллагууд л ажлын байр санал болгох аж.

## Өвдсөн эдийн засаг

Үйлдвэрлэлийн салбар гэж алга. Газар тариалангаас гаралтай бүтээгдэхүүнд суурилсан нэмүү өртөг шингээсэн сүлжээ ч хөгжиж амжаагүй байна. Асар их хэмжээний буюу 40 сая мал сүрэгтэй, 2.9-хөн сая хүн амтай Монгол Улс нь Шинэ Зеландаас хөлдөөсөн сүү импортлох юм. Тэгвэл Грек нь Голландаас улаан лооль, Германаас оливийн тос оруулдаг. Үзэсгэлэнтэй байгаль, нээлттэй агаад нөхөрсөг ард түмэнтэй. Харьцуулж буй хоёр орон хоёулаа гайхамшигтай сайхан нутаг, зочломтгой хүмүүстэй ч аялал жуулчлал бүрэн утгаараа зөвхөн Грект л хөгжсөн. Түүнчлэн хоёр орны дотоодын эдийн засаг сул. Тиймээс импортын дийлэнх хэсгийг үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ экспортолж олсноос ангид мөнгөөр санхүүжүүлдэг. Монгол нь газар доорх байгалийн баялгаа, Грек харин өрийн бичгээ экспортлон амьжиргаагаа залгуулж байна. Үүнээс олж буй орлого амьдралын баталгааг бэхжүүлж байгаа ч өрсөлдөх чадвар бүхий аж үйлдвэр бий болгох хэмжээнд хүрэхгүй цалин хөлсийг үүсгэсэн.

Хоёророн хоёулаа Голландөвчинд нэрвэгдсэн. Эл үзэгдлийг анх Голланд улсад байгалийн хий олдсон 1960-аад оны үед ажигласан байдаг. Байгалийн хийн борлуулалтаас олсон ашиг орлого нь Голланд улсад ихээхэн хэмжээний мөнгө оруулсан. Үүнийгээ хувийн хэвшил болон төрийн албаны цалинг өсгөхөд ашигласан аж. Улмаар улс орны эдийн засгийн өрсөлдөх чадвар доройтсон. Вассенаарын гэрээ хэлэлцээрийг 1982 онд байгуулснаас хойш л балаг тарьсан цалингийн чиг хандлагыг зогсоож, эдийн засгаа аварсан гэдэг. Мөнгөний урсгалын хор уршигтай үр дагавар юунаас үүдэж тохиох нь ямар ч ялгаагүй аж. Үүнд, Монгол Улс ашигт малтмалаа борлуулах, Грек гадаадаас зээл авах, Европын Холбоонд шилжүүлэх, мөнгө хэвлэгч машины шуурхай үйл ажиллагаа, евро тогтолцооны бусад Төвбанкууд өрийн үнэт цаастай болохыг дурдаж болно. Ийм аргаар урсан орж ирэх мөнгө нь цалингийн хэм хэмжээг нэмэгдүүлдэг. Энэ нь боловсруулах аж үйлдвэрийн салбарыг сүйрэлд эсхүл бууруулахад хүргэнэ.

Грекийн Эдийн засгийн сайд Михалис Хрусохойдис “FAZ” сонинд өгсөн ярилцлагдаа ЕХ-ны эдгээр арга барил түүний улсынх нь өрсөлдөх чадварыг аль хэдийнээс дордуулсан гэж оновчтой тэмдэглэжээ. Тэрхүү санхүүгийн тусламжийн мөнгийг авсны эцэст “үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд хаалга барьж, оронд нь харин импортын компаниуд байгуулах болсон. Учир нь илүү их орлого олох боломж нээгдсэн. Эл явдал тус улсад жинхэнэ гамшгийн уршиг тарьсан билээ” хэмээв. Сайдыг залуу байхад экспортоос ашиг олохын тулд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж ажилладаг байжээ. Гэтэл ЕХ-ны санхүүгийн тэтгэлгийн нөлөөгөөр хөлсөө урсгаж хөдөлмөрлөх шаардлагагүй болсон аж.

Улс төрийн хүчнүүд, нөлөө бүхий эдийн засгийн сонирхлын улмаас тус улсыг ЕХ-нд хөдөлгөхгүй бариад байгаа нь Грект гамшиг үргэлжилсээр байгааг илтэнэ. ЕХ-ноос гарч, мөнгөнийхөө ханшийг бууруулж, өрсөлдөхүйц цалингаар эдийн засгаа сэргээн босгохын оронд хиймэл шалтгааны улмаас евро хэмээх мөнгөн тэмдэгтээс зуурсаар л байна.

## Хямдхан зээл

Грекийн банкууд дампуурлаа зарлаваас тус улсын Төвбанк мөнгөний үнэлэмж бууруулснаас гарах алдагдлыг бүх ЕХ-ны гишүүн орнуудын нуруун дээр үүрүүлэх бодлоготой. Өөрөөр хэлбэл, эл дампуурлаас урьдчилан сэргийлж еврог аврах боломжийг гаргасаар л байна. Үүний үр дүнд Грекийн төр зөвшөөрөгдөх хэмжээний зээлийн хүүний өрөнд орсоор байх нөхцөл бүрдүүлжээ. Учир нь Европын Төвбанк нь Грек улсын бондыг эргүүлэн худалдаж авахад шаардлагатай мөнгөн тэтгэлгээр банкуудыг санхүүжүүлдэг. Цаашилбал, евро нь Грекийн болон гадаадын зээлдүүлэгчдэд Грекээс ул мөргүй арилж, мөнгөө гадаадад гаргах боломжтой хямдхан зээлийг үүсгэж байна. Баян грекчүүд хамгийн багадаа 100 тэрбум еврог Швейцарь дахь дансандаа хав дарсан гэж таамаглах аж.

Энэ ч гэсэн Монголтой жишиж үзэх түгшээсэн параллель мөн. Монголын хөрөнгө мөнгөтэй чинээлэг гэр бүлүүд хуулийн дагуу болон хууль бусаар газрын баялгаас олсон орлогын дийлэнх хувийг гадаад руу гаргах болжээ. Тэд оршин суух газраа гадаад руу шилжүүлж, өмнө нь хураасан хөрөнгөөрөө амьдрах тэрхүү Х өдөртөө зэхэж сууна.

Амьдралын стандартыг ихээхэн анхаардаг ч түүнийгээ гажуудуулан гуйвуулсан. Тухайлбал, орчин үеийн хийц загвар бүхий автомашин, iPad (айПэд), хавтгай дэлгэц, хиймэл дагуулын таваг болон луи-уитоны дэлгүүрээр дутаагүй. Харин зам харгуй болон нийтийн тээврийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд хэрэгцээтэй байна. Хөдөө аж ахуйг эс тооцвоос зөвхөн төр, худалдаа арилжаа ба олон улсын байгууллагууд л ажлын байр санал болгох аж.

Монгол Улсад айлчилсныхаа дараа тус орныг Гректэй харьцуулмаар санагдлаа. Эдгээр нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлолтын дагуу дэлхийн хөгжилтэй орнуудын тоонд багтаагүй хөгжиж буй улс орнууд юм. Аль алинд нь эмх замбараагүй байдал ноёрхдог. ■

2014 ОНЫ 9 САР.

**ОДООГИЙН СБД VII ХОРООЛОЛ, ИРЭЭДҮЙН “БИЗНЕСИЙН ШИНЭ ДҮҮРЭГ”**






Чингисийн талбайгаас чанх хойшоо 1 км

Ердөө 10 минут 4 минутын зайтай

## ОФФИС ТҮРЭЭСЛЭГЧДИЙН СУДАЛГАА /2013, 2014 он/

### ОФФИС ТҮРЭЭСЛЭГЧДЭД УЧИРДАГ ХҮНДРЭЛ ЮУ БАЙВ?

- ☑ Хотын төвөөс хол
- ☑ Автомашины зогсоол хүрэлцээгүй
- ☑ Худалдан авахад өндөр үнэтэй
- ☑ Оффисын талбайн хэмжээ тохирдоггүй
- ☑ СӨХ-ийн үйлчилгээ хангалтгүй
- ☑ Цахилгаан шатны хүрэлцээ муу
- ☑ Үйлчилгээний байгууллагууд хангалтгүй

### PRO ONE ОФФИС ХЭРХЭН ШИЙДСЭН БЭ?

- ☑ “Бизнесийн шинэ дүүрэг”-т буюу хотын төвд
- ☑ 150 машины зогсоолтой
- ☑ Худалдаалж буй үнэ 1мкв 2.8-3.6 сая
- ☑ 4-16 давхарт 40-120 мкв бүхий талбайтай
- ☑ “Master property” менежмент компани
- ☑ 8-16 хүний даацтай 3 цахилгаан шат
- ☑ 1-р давхарт банк, ресторан, мини маркет

Улаанбаатар хотын “Бизнесийн шинэ дүүрэг”-т байрлалтай ProONE оффисын төсөл нь Улаанбаатар хотын оффис түрээслэгчдийн 3 удаагийн бодит судалгаанд үндэслэн хэрэгжүүлж байгаа төсөл юм. Та яг одоо худалдан авах шийдвэрээ гаргаснаар 13 сарын дараа 75%-ийн өгөөж хүртэх боломжтой. Бид эхлээд зөвлөдөг . . .

*Бодит судалгаанд үндэслэн бүтээв.*

### ҮЙЛЧИЛГЭЭ CONCIERGE SERVICE

- ОФФИСЫН НЭГДСЭН ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛЧИЛГЭЭ
- ЗОЧИД ХҮЛЭЭН АВАХ, ЗОХИЦУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ
- ХУРЛЫН ЗААЛ, VIP ӨРӨӨ ЗАХИАЛГА
- ГАРАЖ, ЗОГСООЛЫН ЗОХИЦУУЛАЛТ
- ОФФИС ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ
- БИЧИГ ХЭРЭГСЛИЙН ЗАХИАЛГА, ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ SAFETY

- АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТЫН СИСТЕМ
- ХОЛБОО ДОХИОЛОЛЫН ХЯНАЛТЫН СИСТЕМ
- ДУЛААН ХЯНАЛТЫН СИСТЕМ
- АГААР СЭЛГЭЛТИЙН СИСТЕМ

Төсөл хэрэгжүүлэгч:

MASTER PROPERTIES

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХУДАЛДАА

Утас:

**9990-0181**

**9990-0184**



ҮЗЭЛ БОДОЛ

# Герман-Монголын эдийн засгийн харилцааны боломж

*Д.Жаргалсайхан /МІН группийн ерөнхийлөгч/*

# Тулгын гурван чулууны загвар

Нийгмийн өмнө тулгарсан олон асуудал иргэдийг бухимдуулж, тэдгээрийг шийдвэрлэх арга замын эрэлд хэн хүнгүй л гарчихаад буй. Миний бие ч гэсэн нийгмийнхээ нэг эд эс нь болохоороо бас санаа нэмэрлэх ёстой хэмээн энэхүү нийтлэлийг зориг гарган мутарлав.

“Тулгын гурван чулуу шиг туждаа хамт явах юмсан” ... гээд бид дуулдаг. Тулгын гурван чулуу гэхээр монгол хүний дотор юуны түрүүнд ахуй амьдралд маань хэзээд хэрэг болдог түшиг тулгуур, суурийн тухай санаа буудаг. Түүний дараа аливаа юмыг түшихэд , тулахад хэрэг болдог түшиг тулгуурын тэнцвэртэй байдал, суурийн бат бэх байдал санаанд ордог. За тэгээд гурав гэдэг тоонд бас их томоохон философи агуулагдаж байдаг юм уу даа. Хүн орчлон хорвоог, амьдралыг ойлгохын тулд яах ч аргагүй хэмжээс, шалгуур бий болгосон. Халуун, хүйтэн, урт, богино, хурдан удаан, өнгөрсөн цаг, ирээдүй цаг, зовлон, жаргал гэх мэтээр дурьдаад байвал дуусахгүй. Энэ олон , хязгааргүй хэмжээсээр орчлон хорвоог танихын тулд хүн өөртөө ойлгомжтой тоолуурын эхлэл цэгийг бий болгох зайлшгүй шаардлагатай тулгарсан. Жишээлбэл, ус шингэн төлөвөөс хатуу төлөвт шилждэг хэмийн / температурын / төлөв байдлыг тэг / О / градус гэж, Есүс Христийн төрсөн жилийг цаг хугацааны тооллын эхний тоолуурын цэг болгож авсан байх юм. Танин мэдэхүйн шаардлагын үүднээс бий болгосон дээрх хэмжээсийн тогтолцоо нь ийнхүү гурван үндсэн төлөв байдлаас бүрэлдэх болжээ. Нийгмийн амьдралыг танин мэдэх, тэрхүү мэдлэгээ амьдралд хэрэглэхэд мөн л гурван төлөв байдлын хэмжээс хэрэгтэй. Ялангуяа нийгмийн баялаг, нөөц боломж цаг хугацаанд хэрхэн шилжин, өөрчлөгдөж байгааг шинжиж судалж, зүй тогтлыг нь танин мэдэх нь маш чухал бололтой.

Аливаа нийгэм оршин тогтож байна гэдэг тэрхүү нийгэм тэнцвэртэй нөхцөл байдлын төлөвт байгаа гэсэн үг юм. Тэгвэл тэрхүү тэнцвэр юун дээр тогтож байна вэ? Түших тулах юм байна л гэсэн үг. Тэгвэл тэр тулгуур нь юу юм бэ гэдэг асуулт өөрийн эрхгүй гарч ирнэ. Энэ асуултад өгөх хариултын эрэл манай монголчуудын сайн мэдэх тулгын гурван чулууны тухай ойлголт руу хөтөлсөн юм. Тулгын гурван чулуу бол тэнцвэртэй, тогтвортой байх, бас тэнцвэртэй, тогтвортой байлгахын билгэдэл, загвар юм . Энэхүү энгийн мөртлөө аугаа философийг агуулж буй Монгол түмний маань өргөн хэрэглэдэг ойлголт та бидний ирээдүйд оршин тогтнох мөн өсөн дэвжих их үйлсийн загварыг заах мэт. Учрыг доор өгүүлье.

Хүн төрөлхтний түүх бол хүмүүс хоорондын тэмцлийн түүх. Тэмцэлд хэнийг дайсан, хэнийг нөхрөө гэж үзэхэд тодорхой шалгуур хэрэгтэй. Тийм ч учраас аливаа нийгмийг бүрдүүлж буй хүн амыг ангилдаг олон шалгуур, ангилал хүн төрөлхтөн бий болгож амжсан. Арьс өнгө, шашин шүтлэг, гарал угсаа , хөрөнгө чинээ , хэл ус, соёл, үзэл бодол гээд мөн ч олон шинж тэмдгээр хуваагдана даа. Түүгээрээ бие биенээ ялгаварлана, хоорондоо нанчилдана, дайтана, нэгнээ хөнөөнө. XX зууны жишээнээс харахад л хүмүүс хөрөнгөтэй, хөрөнгөгүйгээрээ талцаж нэг хэсэг биенээ хядаж, хүйтэн дайныг оролцуулаад дэлхийн хэмжээний гурван ч дайн гарч дайтаад амжив. Тэгээд ямар ч шинж тэмдгээр ялгарч, талцаж хуваагдсан бай эцэст нь үр дүн нь нийгмийн нөөц боломжийг хуваарилах, захиран зарцуулах тал дээр л өөрчлөлт гардаг. Захиран зарцуулах, хуваарилах эрхийг эдэлж байгаа тал ямар ч сайхан арьсны өнгөтэй байсан, удам угсаа, ямар ч сайхан шашинтай, ямар ч их хөрөнгөтэй байсан ялгаагүй тийм эрхийг хүсэмжлэх нөгөө хэсгийнхээ эсэргүүцэл тэмцлийн улмаас доройтож дараагийн тэмцлээр дарагдан мөхнө. Хүн нийгмийн боломжоос хүртэх эрх нь ерөөсөө арьсны өнгөнд, аль эсвэл шашинд, гарал үүсэлд байгаа юм биш. Хүн бүр хүн шиг явах эрхтэй төрдөг юм байна гэх ойлголт түгэх болжээ.

Тэгвэл хүн төрөлхтний түүхийг нөөц боломжийн төлөөх тэмцлийн түүх гэж үзэж болох мэт. Хүний нийгмийн хөгжлийн олон шат дамжлага бүр өөр өөрийн онцлогтой ч нийтлэг шинж чанар бас ажиглагдаж байна. Аль ч нийгмийн үед нэг хэсэг нь нийгмийн нөөц, боломжоос гишүүдийнхээ дийлэнх олонхид хүртээмжтэй хүртээхийг шаарддаг / цаашид хүртээмжийнхэн гэж нэрлэе/ байхад нөгөө хэсэг нь нийгмийн нөөц боломжийг /цаашид боломжийнхон гэж нэрлэе/ тухайн гишүүний бүтээсэн хэмжээгээр хуваарилахыг шаарддаг. Энэ хоёр хандлага хоорондоо байнга зөрчилдсөөр ирсэн.

Хүний нийгэм анх бий болсон цагаасаа эхлээд л дээрхи зөрчилдөөнийг хүчирхийлэлгүйгээр шийдчихдэг тогтолцоог бий болгох мөрөөдөлдөө хөтлөгдөж мөн ч олон засаглалын хэлбэрийг бий болгосон, Иргэд битгий хэл улс орнууд бий болгосон тогтолцооныхоо золиос болон алга болсон түүх бий. Нийгмийн нөөц боломжоос аль болох их хүртэх эрмэлзэлдээ захирагдан дээрх бүлгүүдийн аль аль нь хүчирхийллийн аргыг хэрэглэхээс буцдаггүй. Тийм ч учраас хүчирхийллээс өөрсдийгөө хамгаалах хүсэл хэрэгцээндээ захирагдаж Төр хэмээх институцийг бий болгосон. Иргэд өөрсдийгөө, өөрсдийнхөө өмч хөрөнгийг бусдын хүчирхийллээс хамгаалуулах сэдлээр Төр оршин тогтнохыг хүлээн зөвшөөрсөнтэй адил Төр нийгмийн гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд хүчирхийлэл хийх эрхийг нь мөн хамтад нь

хүлээн зөвшөөрдөг юм байна. Энэ хүчирхийлэл хийх эрхийг хүлээн зөвшөөрөх нь энгийн ойлгомжтой мэт боловч тэрхүү эрхээ Төр нь нийгмийн гишүүдийгээ захиран дарангуйлах зорилгоор хэрэглэхээс сэргийлэх баталгаатай шийдлийг хүн төрөлхтөн өнөөг хүртэл олоогүй л байна. Чухам ийн учраас энэхүү институци нь нийгмийн гишүүдийг бусдын хүчирхийлэлээс хамгаалах нь битгий хэл өөрөө нийгмийн гишүүдийн зарим нэг хэсгээс нөгөө хэсгээ дарангуйлан захирах, хүчирхийлэх хэрэгсэл болсон. Энэ нь олон улс орны түүхэнд элбэг тохиолдсон төдийгүй 21-р зуунд ч Төр нь дарангуйлал, хүчирхийллийн хэрэгсэл, зэвсэг болсоор байна.

Төрийг сайхан төгсгөлтэй үлгэрт ард олноо жаргааснаар гардаг сайн хаан шиг болгох гэсэн оролдлого хүний нийгмийн түүхэнд олонтаа гарч байсан. Цаашид ч энэ эрэл эцэс төгсгөлгүй үргэлжлэх төлөвтэй. Шашины үзэлдээ суурилан сайн засаглал тогтоох гэсэн оролдлого бүтэлгүйтэв. Арьсны өнгө, шашин шүтлэг аль эсвэл яс үндэстний ялгаанд суурилсан засаглал урт насгүй гэдэг нь тодорхой болов.

Төр нь иргэдээ хөрөнгөтэй, хөрөнгөгүйгээр нь ялган барууны эсвэл зүүний хэмээн талцаж тэднийг хооронд нь зөрчилдүүлж, хагаралдуулж хэсэг туршилт хийв. Төрийн дарангуйллаар бусдыгаа захирч, түүгээрээ өөрсдөдөө давуу байдал олгож талцдаг хэсэг нь ноёлдог байсан нийгэм тухайн нийгмийнхээ нөөц боломжоос хүртэж чадахгүй байгаа хэсгийнхээ байнгын тэмцэл, сөргөлдөөний улмаас нуран унав. Улмаар нийгмийн боломжоос ахиухан хүртээж, хуваарилахыг шаарддаг хэсгийг төлөөлсөн Төр бий болж хөрөнгө мөнгөтэй, ажилтай, овсгоотой хэсгийгээ золиосолж нэг үзээд бас л барсангүй.

Ийнхүү хүний нийгэм мөнхийн гурван тоглогчтой болсон. Одоо ч байгаа, цаашид ч энэ гурван гол оролцогчид байсаар байх шинжтэй. Хүн төрөлхтний урт хугацааны түүхээс харвал эдгээр гурван оролцогчид хоорондын харилцаа хэр тогтвортой, тэнцвэржсэн байх вэ гэдгээс шалтгаалан тухайн улс, нийгэм оршин тогтнох , мандан бадрах, бууран доройтох нь хамаарч байгааг ажиглаж болно. Хүн бүр өөр өөрийн онцлогтой, хүн бүр өөр хоорондоо адилгүй болохоор тэдний хийж, бүтээж чадах зүйл бас харилцан адилгүй байх нь ойлгомжтой. Адаглаад л нэг айлын, нэг эцэг эхийн хүүхдүүд хүртэл хоорондоо харилцан адилгүй байдаг. Иймээс хүн бүр өөрийнхөө хийж бүтээсэн хэмжээгээрээ нийгмийн нөөц боломжоос хүртдэг байх нь шударга ёсонд нийцэж байгаа мэт.

Гэтэл өөрийн болон нийгмийн тогтолцооноос хамаарч нийгмийн нөөц боломжоос хүртэж чадахгүй, наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа хэсэг байна. Тэд бол нийгмийн нөөц боломжоос хүртэх эрхтэй байхыг шударга ёс гэж үзнэ. Ингээд хоёр тал хоёулаа шударга ёсыг тогтоохын төлөө гэдэг ариун уриатай болж “нанчилдаж” өгнө дөө. Түүнийг хувьсгал, дайн, төрийн эргэлт, бослого, жагсаал цуглаан хэмээн нэрлэх.

Гэтэл бас ч үгүй урт хугацаанд оршин тогтноод уналгүйгээр тэсээд байгаа нийгмийн тогтолцоонууд байна. Хэдийгээр тэдгээр нийгмүүдийн хэлбэр нь өөр хоорондоо ондоо , элдэв өөрчлөлтүүдийн давалгааг ажрахгүй оршин тогтноод байгаагийн дотоод учир шалтгаан нь ялгаатай ч тэднийг нэгтгэж байгаа хэв шинж нэг байна. Энэ нь аливаа шинэ бий болсон нөхцөл байдалд дасан зохицох чадвар юм уу даа. Энэхүү чадвар л байхгүй бол нийгмийн тогтолцоо, коммунист, капиталист, дарангуйлагч, хаант, бүгд найрамдах, бүгд дайсагнах гээд ямар ч нэр, дарга, үзэлтэй байсан ялгаагүй мөхөн унах тавилантай. Шинээр бий болсон нөхцөл байдал гэж юуг хэлээд байна вэ?

Энэ бол даяарчилалын үйл явц , геополитикийн бодлогын өөрчлөлт, дэлхийн цаг агаар, хүрээлэн байгаа орчны өөрчлөлт, технологийн дэвшил, хүн амын өсөлт, түүний хэрэглээний өөрчлөлтийн давалгаагаар бий болж буй шинэ сорилт, шийдлээ хүлээж буй асуудлууд юм. 200 гаруй жилийн түүхтэй Америкийн ардчилсан нийгэм аль эсвэл хагас зуун жилийн настай Хятад дахь коммунист засаглалыг унана гээд, эсвэл хөгшин Европын тогтолцоог мөхнө, сүйрнэ хэмээн зөгнөж, элдэв янзын онол, таамаг дэвшүүлсэн ном, бүтээлүүд интернэтээр дүүрэн байна. Тэгвэл тэдгээр нийгмийн тогтолцоо оршин тогтносоор байгаагийн учир юунд байна вэ?

Яагаад, юуны учир XX зууны дэлхийн хамгийн том Коммунист хоёр орны хувь заяа өнөөдөр хоёр янзаар эргэсэн байна вэ?

ЗХУ. Нийгмийн нөөц боломжийг тэгш хүртээж хуваарилах зарчимд суурилсан коммунист үзэл суртлыг бодитойгоор, хүчээр амьдралд хэрэгжүүлж манлайлагч болж өөрсдийн үзлээ бусдад тулгадаг болсны харгайгаар аливаа амьд организмд байдаг өөрийн сул талаа олж тогтоох, засаж залруулах чадвараасаа сайн дурааараа хагацсан. Дээр нь дэлхийд хамгийн олон хүний амь насыг авч одсон дайнд хамгийн олон иргэнийхээ амь насыг золиослон байж ялсан нь тэр их гүрний удирдагчдын төдийгүй иргэдийн нийгмийн сонор сэрэмжийг алдагдуулсан биз ээ. Нийгмийн нөөц боломжийг оновчтой, үр ашигтай зарцуулж баялаг бүтээдэг хэсгээ хөөн зайлуулж, устгаснаар хөдөлгүүргүй хөлөг онгоц адил болж нөөц боломжоо хуваарилсаар сүүлдээ төрийн албан тушаалаас өөр хуваарилах ч нөөцгүй болов. Нийгмийн тулгын гурван чулууны нэг нь дутаж, ЗХУ нуран унав.

БНХАУ. Нийгмийн нөөц боломжийг хүртээж хувварилах ёстой хэмээх үзэл суртлаараа ЗХУ-тай ижил боловч дэлхийд ноёрхох сурталтай, зэр зэвсэг, хүчирхэг армитай ЗХУ-аас байнга учруулж байсан дарамт, аюул занал, мөн ЗХУ-тай үзэл суртлаар өрсөлдөж мөн л хүчирхэг зэр зэвсэг, армитай АНУ болон түүний холбоотнуудын зүгээс учруулж байсан өрсөлдөөн, заналхийлэл болон дотоод эдийн засгийн хүндрэлүүд нь БНХАУ-ын удирдлагын сонор сэрэмжийг байнгын өндөр түвшинд байлгаж, улмаар цаашид оршин тогтнох арга замаа байнга өөрчилж шинэчлэх шаардлагыг бий болгосон бололтой. Иймээс ч учраас ЗХУ хэмээх аварга том гүрэн нуран унаснаас хойш БНХАУ нуран унасангүй. Харин ч улам хөгжин тэлж, улмаар улс төр, эдийн засгийн асар хүчирхэг гүрэн боллоо. Үүний зэрэгцээ энэхүү коммунист гүрний нуран унахыг мөрөөдөгчдийн итгэл найдвар улам бүр замхарсаар.

Нийгмийн нөөц боломжийг хамгийн оновчтой ашиглаж үнэ цэнийг бүтээдэг хэсгийг дахин бий болохыг хүлээн зөвшөөрч нийгмийнхээ нөөц боломжийг нэмэгдүүлж чадсанаар дутагдаж байсан тулгуураа бий болгож мөхлөөс зайлж чадав. Гэсэн хэдий ч олон том сорилттой нүүр тулсан хэвээр л байна. Нийгмийн тулгын гурван чулуу нь нийгмээ тулж чадаж байна, гэвч энэ тулгуур хэр тогтвортой, тэнцвэртэй байх бол.

Тэгвэл Барууныхан гэж бидний нэрлэдэг ертөнцөд юу болж байна ?

АНУ. Хүн бүрд ижил тэнцүү боломжийг олгосон нийгмийн тогтолцооны жишиг. Ядуу хоосон хүнд хэцүү амьдралыг туулж улс төр,




бизнесийн өндөрлөгт гарсан түүх, амьд жишээ олонтой. Билл Геитс, Барак Обама, Зукерберг гээд олны танил болсон хүмүүсийн түүх бол тэдний амьд нотолгоо. Түүгээрээ ч тэд бахархдаг. 2009 онд АНУ-д эхэлж улмаар дэлхийн эдийн засгийг сүйрлийн ирмэгт аваачсан санхүүгийн системийн хямралын улмаас ардчилсан нийгмийн тогтолцоонд итгэх итгэл ганхаж, АНУ-ыг нуран унахыг хүсэн хүлээгчдэд итгэлийн оч найдвар төрөв. Нийгмийнхээ гишүүдийн эрхийг дээдэлдэг нийгмийн суурь тогтолцоотой АНУ-аас өөр ямар ч улсад тийм хэмжээний гамшиг нүүрэлсэн бол тэр улс орон задран унаж оршин тогтнохоо больсон байх биз ээ. Харин АНУ-ын аварга том нийгэм өөрийнхөө өвчин эмгэгийг оношлож, улмаар илааршуулах чадвартай болохоо батлан харуулж, эдийн засаг нь тогтвортой өсөх хандлагатай боллоо. Хүний эрхийг дээдэлдэг үзэл баримтлалаа огоорч эд мөнгийг амьдралын гол зорилго, хэрэгсэл болгосноор тулгын гурван чулууны тэнцвэр алдагдсан байлаа. Тэнцвэрийг дахин бий болгох нөр их аянд мордов.

**Европ.** Далайн чанадаас халдварласан санхүүгийн хямрал, хэрээс хэтэрсэн нийгмийн халамжийн бодлогоо даахгүй “өвдөж” улмаар мөхлийн ирмэгт очсон мэт байсан нь саяхан. Дээр нь хөгжиж байгаа орнуудаас хямдхан авдаг байсан түүхий эдийн үнэ ихээхэн өссөн нь нэрмээс болсон биз. Ийм том сорилтыг даахгүйгээр Европын холбоо задрана, нэгдсэн мөнгөн тэмдэгттэй байхаа болино гэсэн таамгууд ар араасаа гарч байлаа. Тэгтэл тэсээд гарлаа. Ямар нэг хүчирхийлэл, үймээн самуун аль ч гарсангүй. Яагаад ? Нийгмийн болох, болохгүй бүхий л асуудлаа нээлттэй ил тод ярилцдаг, зөвшилцдөг, шийддэг нь тэр нийгмийн хамгийн том давуу тал юм. Үүнийхээ үр дүнд гаргасан алдаагаа залруулж, алдаа давтагдахгүй байх хамгаалалт, дархлаагаа бий болгож чадлаа. Хүртээмжийнхний бүлэгт таалагдах гэсэн төрийн популист бодлогын улмаас нийгмийн гол хөдөлгүүр болсон баялаг бүтээгчдийн суурь ганхаж, улмаар ЗХУ-ын хувь заяаг давтан алдав.

Хөгшин Европын улс болгонд нөхцөл байдал өөр өөр байгаагийн дотор Монголд үлгэр жишээ болж чадах хэд хэдэн загварууд байгааг бас нэмж хэлэх нь зүйтэй. Үүнд би Скандинавийн орнууд болон Швецарийг хамруулан ойлгож байгаа юм. Нийгмийн нөөц боломжийг байнга өсөн нэмэгдүүлж, түүнийхээ

боломжинд тохирсон нийгмийн хуваарилалтын тогтолцоог бий болгож чадсан нь тэдгээр орны тогтвортой хөгжлийн суурь болжээ.

Зөвлөлт гүрний буурин дээр шинээр бий болсон улс орнуудад байдал ямар байна вэ ? Эдгээр оронтой бид өөрсдийгөө байнга харьцуулж байх нь нэн ашиг тустай санагдана. Учир нь бид ижил төстэй гараанаас өөр өөрийн жороор тодорхойлсон замаар замнаж байгаа билээ. Тэдний гаргасан алдаа, олсон амжилт бүрийн учир шалтгааныг мэдэж байх нь монголчууд бидний хувьд маш үнэ цэнэтэй сургамж болох юм. Тэдгээр орноос Казахстан зэрэг зарим орон нь эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангаж чадсан боловч Тажикстан, Туркменистан гэх мэт орнууд эдийн засаг, улс төрийн хувьд хаалттай, дотоод зөрчил ихтэй, төрийн эрх барьж буй бүлгийн дарангуйллын тогтолцоо руу орсон. Эдгээр орны аль алинд нь Ерөнхийлөгч нэртэй дарангуйлагчийн тогтолцоо нэгэнт баттай бэхжиж нийгмийнхээ аливаа өвчин эмгэгийг мэдрэх чадвар, дархлаа нь үгүй болж хөгжил нь хэдэн арван жилээр хоцорчээ.

Төрийн эрх мэдлээр зэвсэглэсэн давхарга өөрсдийн ашиг сонирхлын төлөө нийгмийн бусад хэсгээ дарангуйлан өөрсдөдөө үйлчлүүлж байгаагаас тулгын гурван чулууны хоёр нь түшиг тулгуур болохоо нэгэнт өнгөрчээ.

Монгол улсынхаа түүхийн тодорхой үе шатуудыг аваад үзье. Хүний нийгмийн янз бүрийн засаглалын хэлбэрүүдийг дамжин өнгөрдөг бусад улс орны адил хаант төр , коммунист засаг гэвд нэг хүнээс хамаараалтай, түүний эрх ашигт үйлчилдэг нийгмийн байгууллын аль алийг нь өөрийн онцлогтойгоор туулан өнгөрүүлсэн. Монголын их эзэнт гүрний үед ч, Манжийн төрийн үед ч, коммунист засаглалын үед ч төр нь иргэдийн амьдралд шийдвэрлэх үүрэгтэй оролцож ирсэн. Хамгийн сонирхолтой нь эхний тохиолдолд нийгэм нь баялаг, нөөц боломжоо нийгмийн бүх гишүүдийн оролцоотойгоор бусад улс орон, иргэдийг байлдан дагуулалт хэмээх хүчирхийлэлийн аргаар албадан хөдөлмөрлүүлж бий болгож, өсгөн нэмэгдүүлж байсан бол Манж гүрний үед өөрийн төр ч гэж байхгүй байлаа.

Монголын эзэнт гүрэн, дараа нь Манж гүрэн, дараа нь коммунист засаглал гэвд монголчууд бид хэдэн зуун жил төрийг дээдэлсэн, төрийг тахьсан нийгэмд амьдарч ирсэнийх юм уу өнөө хүртэл монголчуудын оюун санаанд нийгмийн гишүүдийг захирдаг, бүхний өмнөөс шийдвэр гаргадаг төрийн дүр төрх баттай оршсоор л байна.

Гадаадын оронд улс төрийн намуудын хоорондоо ялгарах гол ялгаа нь нийгмийн нөөц, боломжоос иргэд хэрхэн хүртэж байвал зохих талаарх тэдгээрийн байр суурь байдаг. Улс төрийн намууд нь үзэл бодлоороо уралдаж, төрийн эрхийг тодорхой хугацаанд барих эрх, мандатыг иргэдээсээ авдаг нь чухамдаа бол нийгмийн нөөц боломжийг хуваарилдаг тухайн үеийнхээ тогтолцоог улам боловсронгуй, тэнцвэртэй болгох арга замуудын талаар ухаан бодлоо уралдуулж, улмаар хэрэгжүүлэх эрхээ олж авч буй хэрэг. Зүйрлүүлж хэлбэл цагийн эрхээр тулгын гурван чулууны тэнцвэр алдагдсаныг засаж залруулж байгаа мэт.

Тэгтэл Монголын улс төрийн намуудын бодлогод төрийн оролцооны талаар тусгасан бодлого нь хоорондоо зарчмын ялгаагүй, тэр ч бүү хэл заримд нь энэ талаар бодлого гэж нэрлэгдэх юм алга байх юм. Тийм учраас сонгууль болох бүрд улс төрийн намууд төрийн эрхэнд гарахаараа төрийн эрх мэдэлд дулдуйдан хийх элдэв гоё үгээр далдалсан хөтөлбөрөөр уралддаг, бид ч тэрэнд нь хууртдаг. Төрийг удирдах үйл хэрэгт шууд оролцох эрхийг Үндсэн хуулиар иргэнд олгосон байтал өөрсдийгөө нам, намын гишүүн гэж гоёж гоодсон бүлэг хүмүүс удирдах эрх эдлээд иргэдийн эрхийг хааж байгаа нь гэнэтийн хууль, шийдвэрүүдийг иргэдтэйгээ зөвлөлдөхгүйгээр гаргадаг гаж зуршил тогтсоноос баттай харж болно. Ялангуяа иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд , гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд улсын төсвийн орлого үлэмж нэмэгдсэн үеэс төр, төрийн эрхэнд гарсан намууд хаант засагтай нийгмийн хаан шиг, коммунист дэглэмтэй нийгмийн төв хороо, улс төрийн товчоо шиг бүх эрх мэдлийг өөрсдөдөө төвлөрлүүлэн алдаатай, алдаагүй элдэв бодлого, шийдвэрээр Монголын нийгмийг сандчаан, тогтворгүй болгож байна. Мөнгө ихтэй, нийгмийн хяналтаас гарсан төр рүү тэмүүлэгсдийн тоо өдөр бүр эгнээгээ тэлж , тэр хэмжээгээр иргэд та бидний эрх мэдэл хумигдаж байна. Тэнд гарч чадсан нь хүүхдийн мөнгө, гэрлэлтийн мөнгө, оюутны мөнгө хуваарилж хуваарилалтын бүлгээс дэмжлэг авч боломжийн бүлгээс элдэв аргаар, заримдаа бүр хүчирхийлж байдгийг нь сорно. Зүйрлэж хэлбэл тулгын гурван чулуу тэнцвэргүй болжээ. Болж бүтэхгүй зүйл гарахаар нэг бол төрөөс төрсөн олигархиуд гэж нэр хайрлаад хөрөнгө мөнгөтэй нэг хэсгийгээ буруутгачихна, эсвэл Монголын баялгийг сорж байгаа гэвд гадаадынхныг буруутгачихна. Нөгөө хөрөнгө мөнгөтэйгээр нь эсвэл гадаад дотоодоор нь ялгаварладаг сонгодог арга мөн байгаа биз. Энэ төрийн толгойд гарсан улс төрчдийн ийм сөрөг хандлагыг засаж залруулахгүй бол нэг л өдөр улсын эрх ашиг, төрийн эрх ашиг хэмээх гарт баригддаггүй, нүдэнд үзэгдэггүй зүйлээр хаацайлж нийгмийн хяналтгүй болсон Монголын улс төрчид бидний юуг ч худалдсан байж мэдэх юм шүү. Уг нь 1990 оноос өмнөх монголчуудын туулж ирсэн нийгмийн бүхий л салбарт иргэд нь төрдөө үйлчилж ирсэн бол 1990 оны хувьсгалаас хойш төр нь иргэддээ үйлчилдэг тогтолцоог бид сонгосон билээ. Улсын эрх ашиг гэдэг бол та бидний эрх ашиг билээ. Төрийн эрх ашиг гэдэг бол иргэдийн эрх ашиг. Иргэнийхээ эрх ашгийг хохироодог, эсвэл зөрчилддөг төрийн эрх ашиг,улсын эрх ашиг гэж байж яавч болохгүй. Төрд Үндсэн хуулиар ногдуулсан үүргийг төр хэрхэн хэрэгжүүлж байгаад та бидний төлөөлөл болгоно гээд сонгосон Их хурал эсвэл Үндсэн хуулийн цэц хяналт тавина хэмээн горьдон суусаар байвал бухын доодхыг харж үнэг турж үхэв гэгч болох нь ээ.

Тулгын гурван чулууны нэг чулуу нь хэт том болж нөгөө хоёр чулуундаа халтай, дарж унаж магадгүй болжээ. Том төрийг ухаантай төр болгох санаачилга чухамхүү үүнийг хэлээд байгаа бус уу.

Өнөөгийн ярвигтай, хүндхэн нөхцөл байдалд Тулгын гурван чулуу шиг бие биенээ тулж , түшиж байж тулгамдсан асуудлуудаа зөв шийдвэрлэх гарцаа олох юм.

Уг нь иргэн бүр баялаг бүтээгч байж, түүнийхээ үр шимийг хүртэх эрхтэй хэмээн Үндсэн хуулиндаа тусгасан юмсан. ■

2014 ОНЫ 11 САР.



*Ногоон эдийн засгийн талаар судалдаг цөөхөн эрдэмтний нэг БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Т.Чулуунтай "Ногоон соёл иргэншил" гэх ойлголтын талаар ярилцлаа. Гэхдээ энэ удаа уламжлалт ярилцлагаас зайлсхийж бодит баримтад тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй Монголын улс төр, нийгэм, эдийн засаг ногоон хөгжлийн замаар явах боломж болон эрсдэлийн талаар мэргэжлийн хүний дүгнэлтийг сонсохыг зорилоо.*

# Шинэ соёл иргэншил

## Сэтгүүлч: Муу дүн

***Тогтвортой хөгжлийг хэмждэг шалгуур үзүүлэлтээр Монгол Улс муу дүн авдаг. Энгийн жишээ дурдахад л Нийслэлийн агаарын бохирдол гамшгийн хэмжээнд буюу тоосонцор хэвийн хэмжээнээс 10-25 хувиар их, нэг шоо метр агаар дахь PM-10 бодисын хэмжээ 279 милиграмм буюу 13.95 дахин их. Нийт нутгаар цөлжилт ихэссэн. Баян, ядуугийн ялгаа нэмэгдэж, ядуурал хамгийн сүүлийн байдлаар 30 орчим хувьд хүрсэн. Эдийн засгийн өсөлт өндөр байгаа ч иргэддээ наалдахгүй, байгаль орчны асуудал хурцаар тавигдаж байна. Мөн усны нөөц багасч, хүнсний аюулгүй байдал алдагдаж байна гээд дурдаад байвал дуусахгүй. Тэгвэл тогтвортой хөгжил гэж юу вэ.***

## Т.Чулуун: Бидэнд хоёр дэлхий хэрэгтэй

Тогтвортой хөгжил гэдэг нь "Ногоон" буюу бүх талын тогтвортой хөгжлийг хэлнэ. Гэхдээ байгаль орчны асуудлыг арай түлхүү авч үздэг. Дэлхий нийт яг өнөөдрийнхөөрөө 2030 он хүртэл явах юм бол бидэнд хоёр дэлхий хэрэгтэй болно. Гэтэл хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй шүү дээ. Тийм учраас л дэлхий нийт "Ногоон" хөгжлийг ярих болсон юм. "Ногоон" хөгжлийг ярихын тулд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гэх гурван хүчин зүйлийг авч үздэг. Өнгөрсөн 20 жилд Монгол Улс ардчилалын замналаар явсан нь маш том ахиц дэвшил болсон уу болсон. Гэхдээ нийгмийн бүтэц буюу засаглал өөрчлөгдөж байгаа учраас янз бүрийн алдаа гарч ирсэн. Монгол Улс байгаль орчин болон нийгмийн хувьд сүйрэл рүүгээ явж байна. Сүйрэл рүүгээ явж буй хөгжлийг "хүрэн" эдийн засаг буюу буруу тогтолцоо гэдэг. Тиймээс энэ замаар удаан явах нь улс үндэстнийг мөхөөж ч магадгүй. Харин монголчуудын хүрэх ёстой оргил бол "Ногоон" хөгжил юм. Зорилгодоо хүрэхийн тулд Монгол Улс ардчилалд шилжихэд ард иргэдийнхээ үзэл бодлоос аваад, улс төр, эдийн засаг гээд бүх зүйлээ 360 градус эргүүлсэн шиг асар том өөрчлөлт хийх хэрэгтэй. Бид зүгээр нэг бүтцийн өөрчлөлт хийгээд хол явахгүй харин эдийн засаг, улс төр, нийгмийн гээд бүх талын бүтцийг эргүүлэх учиртай. Үүнийг шинжлэх ухааны талаас нь Кузинецийн муруй гэдэг. Энэ нь өөрийн гэсэн хэд хэдэн хөгжлийг

эргүүлэх аргатай шинжлэх ухааны нэр томъёо. Тухайлбал, аливаа улс байгаль орчны асуудлаа умартан эдийн засгийн өсөлтөд анхаардаг. Тэгвэл эдийн засгийн өсөлтийг хөгжил болгохын тулд эргээд байгаль орчиндоо анхаарах хэрэгтэй. Ингэснээр нөгөө ногоон хөгжлийн үндсэн гурван хүчин зүйлийн нэг болох байгаль орчин нь сэргэдэг. Мэдээж байгаль орчноо сэргээх, хайрлан хамгаалахын тулд нийгмийн буюу хүний үзэл бодлыг байгальдаа ээлтэй буюу ногоон боловсролоор хүмүүжүүлдэг. Ингээд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн гурван хүчин зүйл харилцан уялдаатай хөгжих учиртай юм. Гэхдээ улс төрийн хүсэл зориг ногоон хөгжлийн асар том хөшүүрэг.

## Сэтгүүлч: Антропоген гэх геологийн шинэ эрин

***Хүний үйл ажиллагаа дэлхийн тогтолцоонд нөлөөлөх болсноор хүн төрөлхтөн Антропоген гэх геологийн шинэ эринд орсныг эрдэмтэд хүлээн зөвшөөрөх болов. Дэлхийн газрын гадаргын 30-50 хувь нь хүний үйл ажиллагааны улмаас өөрчлөлтөд орсон байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн болон төрөл зүйл устаж, азотын эргэлт дэлхийн ашуулгүй тогтолцооноос давсан өнөөгийн нөхцөлийг бүрдүүлсэн аж. Гэсэн хэдий ч өдгөө капитал цэцэглэж, дээд боловсролтой хүний тоо өсөж, бодит ба хүмүүн капиталын нөлөөгөөр нэг хүнд ноогдох орлого өссөөр байна. Үүний үр дүнд хүний хөгжлийн индекс ч сайжирдаг. Хүн төрөлхтөн үүнийг хүсээгүй гэж үү.***

## Т.Чулуун: Доголон тогтолцоо

Хүн төрөлхтөн хүн байгаль хоёрын уялдааг мартчихаад нэг хэсэг эдийн засаг гэж хошуурсан. Ямар ч хамаагүй аргаар эдийн засгаа л хөгжүүлэх гээд байдаг. Харин байгаль дэлхийгээ анхааралагүйн улмаас экологийн сүйрэл нэгэнтээ дагуулчихаад байна. Энэ нь хүний хөгжил өндөр ч, экологийн сүйрэл дагуулсан “доголон” тогтолцоо юм. Дэлхий байхгүй бол хүн оршин байхгүй гэдгийг санах хэрэгтэй. Харин хүнтэй хүнгүй эх дэлхий хэдэн сая жил наслаж чадна.

Тиймээс хүн, улс үндэстэн бүр байгаль орчны өөрчлөлтөд зохицон амьдрахаас өөр аргагүй. Тэгвэл байгальдаа зохицсон хэрнээ эдийн засаг нь өсөлттэй, хүн ам нь жаргалтай хэрхэн хөгжих вэ. Асуултын хариулт нь таван харилцан үйлчлэх хэсгээс бүрдэх учиртай. Үүнд улс төрийн хувьд байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, хууль батлах. Эдийн засгийн хувьд сэргээгдэх эрчим хүч тэргүүтэй байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж түүнээсээ ашиг олох. Нийгмийн хувьд адаглаад ард иргэд нь хогийн савандаа хогоо хаядаг. Аль болох ус, хүнсний хэрэглээндээ хямгатай хандах учиртай. Мөн тухайн ард түмний соёл, ёс заншлыг сэргээх нь чухал. Энэ үед байгаль орчин, эдийн засаг, соёл уламжлал бүгд сэргээд ирнэ. Байгаль орчин нь сэргэх тутам цэнхэр гаргийн нас уртсаж, хүний аюулгүй ажиллаж, амьдрах орчин баталгаатай болдог.

## Сэтгүүлч: Сөрөг байр суурь

***Экологийн сүйрлийг арилгахын тулд хөрөнгө оруулалт ихээр хийх нь бодит капиталд оруулах хөрөнгө оруулалтыг бууруулж улмаар нэг хүнд ногдох орлого буурна гэх хэсэг бий. Хүмүүс эргээд “зэрлэгшиж”, Адам смит тэргүүтэй эдийн засагчдын онол үнэгүйдэж, ардчилалын үнэ цэнэ алдагдах гэж үү гэх нь ч бий. Товчхондоо ногоон хөгжил гэх нэрийн дор хүн төрөлхтөн өнгөрсөн рүүгээ ухрах вий.***

## Т.Чулуун: Сэргэн хөгжихүйн загвар

Ямар ч хөгжил эхэн үедээ хүчээ авч цаашлаад хөгжлийн чадамж, санах ойтой болдог. Харин дараа нь ямар нэг алдаанаас шалтгаалж хямралд ордог. Үүнийг “Resilience” гэдэг. Эл загвар нь улс үндэстний болон дэлхий дахины гэх харилцан хамааралтай. Энэ нь даяаршилтай холбоотой юм. Том гүрний хямрал дэлхий дахинд нөлөөлөх гэдэг ч юм уу. 2008 оны Америкаас улбаатай санхүүгийн хямралыг дурдаж болох юм. Тэгвэл хямралд өртөхгүй байх ямар арга байна вэ. Хямралд өртөхгүйн тулд хөгжлийн явцад бий болсон санах ойгоо ашиглах хэрэгтэй. Тэнд алдаа, онооны аль аль нь бий. XXI зуунд хүн төрөлхтөн хөгжих аргаа “Ногоон” гэж тодорхойлсон. Гэхдээ аливаа зүйлд сул тал байх нь зайлшгүй. Ямар ч алдаагүй Супер санаа гэж хаа ч үгүй. Үргэлж сайжирсаар л байдаг.

Зарим судлаачдын хэлдгээр ногоон хөгжил өнгөрсөн рүүгээ ухрах алхам гэдэг ч юм уу сөрөг байр суурийг хүлээж авах хэрэгтэй. Дээрх онолын дагуу “Ногоон” хөгжил ч гэсэн ялгаагүй хямралд өртөж магадгүй. Тиймээс бид өөрсдийн уламжлал, ёс заншлаа буюу санах ойгоо эргээд харах хэрэгтэй. Монголчуудад гайхалтай боломж бий. Бид байгальдаа зохицоод улс орноо өдий хүртэл хөгжүүлж чадсан нүүдэлчин соёл иргэншилтэй. Тиймээс тэр санах ойд байгаа зүйлсийн сайныг аваад мууг нь хаях хэрэгтэй.

## Сэтгүүлч: Ногоон сорилт ногоон боломж

Монгол түмний олон мянган жил амьдарч ирсэн дадал заншил нь байгальтайгаа ойр, хамгийн бага хэрэглээтэй, байгаль орчноо тогтвортой ашигладаг тийм л ард түмэн байсаар ирсэн. Энд яриад байгаа ногоон хөгжил тэнд агуулагдсан байжээ гэдгийг хүнээр хэлүүлж, баримтаар баталгаажуулаад байхааргүй бодитой зүйл. Тиймээс БОНХЯ-наас “Ногоон хөгжлийн стратегийн төсөл 2030” тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр болжээ. Уг төсөлд Монгол Улсын нутаг дэвсгэрийг зан заншил болоод түүхийн гээд таван хэсэгт хуваан хөгжүүлэх санаа дэвшүүлсэн байна. Үүнд, Нүүдлийн соёл иргэншлийн өв газар, Их говийн өв газар, Хангайн нурууны өв газар, Цагаан зээрийн өв газар, Тулгар төрийн өв газар багтаж байгаа аж. Тус яамны мэргэжилтэн Б.Доржготов “Монголчууд үндэсний брэнд бий болгох талаар ярьдаг болжээ. Тэгвэл төслийн хүрээнд дэлхий нийтийн чиг хандлага болох ногоон сэтгэхүйд тулгуурлан Монгол Улсын цоо шинэ нэр хүндийг бий болгож болох юм” гэв. Яагаад болохгүй гэж.



Үндэсний буюу бүс нутгийн брэнд нь тухайн үндэстний давуу талыг тодорхойлох хүчирхэг нэр хүнд байдаг. Өнөөдөр Швейцарь орны нэрийг сонсоход л хүмүүст худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, амьдрах газраа солих эсвэл аялал жуулчлалаар явах шийдвэрт нөлөөлөх дүр зураг буудаг шиг Монгол гэх нэрийг сонсоод л онгон зэрлэг байгаль, түүх соёл, ногоон эдийн засгийн талаар төсөөлдөг байж яагаад болохгүй гэж. Гэхдээ энэ мөрөөдлийг биелүүлэхийн тулд багагүй ажил хийх хэрэгтэй аж. Адаглаад байгаль орчин, эдийн засаг, нийгэм, засаглалын гээд харилцан уялдааг хангах. Өөрсдийн өвөрмөц давуу талыг маркетингийн болон бусад аргаар дэлхий нийтэд таниулах. Өндөр үр ашигтай технологи, ногоон стандартыг нутагшуулах гээд хийх ажил их. Т.Чулуун “Монголын цоо шинэ нэр хүндийг бий болгох “Ногоон” хөгжилд хөл тавихын тулд таван чиглэлээр найман зорилго, 45 зорилтыг дэвшүүлээд байгаа. Эдгээр нь бүгд хэмжиж болдог хэрэгжих боломжтой зорилго, зорилтууд юм” гэв. “Ногоон хөгжлийн стратегийн төсөл”-д зааснаар бол монголчууд хоёр үндсэн үе шаттайгаар ногоон соёл иргэншилд хүрэх аж.

Нэгдүгээрт, 2013-2020 он хүртэлх буюу шилжилтийн үе. Хоёрдугаарт, Ногоон соёл иргэншлийг цоцлоон бүтээх үе ба 2020-2030 он юм. Харин уг зорилгод хүрэхийн тулд 2020 онд эрчим хүчний хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах. Байгалийн гамшгийн жилийн хохирлыг 2020 он гэхэд 2010 оны түвшнээс 10 хувь, 30 он гэхэд 15 хувь хүртэл бууруулах гээд олон зорилтыг дэвшүүлсэн байна. Харин эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрх шинжлэх ухааны болон эдийн засгийн аргыг хэрэглэж гэмээнэ тодорхой үр дүнд хүрэх учиртай ажээ.

Дэлхий нийт нэгэнт “Ногоон” хөгжлийн зүг хөлгийн жолоо залсан энэ үед монголчууд ч гэсэн хөгжлийн галт тэрэгнээс хоцрох учиргүй. “Ногоон” гэх тодотголтой галт тэргэнд суух тасалбар Монголын халаасанд бий. ■

2013 ОНЫ 03 САР.

СЕКТЕХ

Аюулгүйн технологи

Security technology






- Камерийн хяналтын иж бүрэн систем (1-20 мегапиксель)
- Сүлжээний өгөгдөл хадгалах төхөөрөмж (NAS, SAS, iSCSI)
- Дохиоллын хяналтын иж бүрэн систем
- Тусгай хэрэгсэл

Факс: 976-11-316864
Утас: 77316864, 77416864, 99006216
Вэб: www.sectech.mn
Email: info@sectech.mn
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг,
4-р хороо, Партизаны гудамж,
24-р байр "Security shop"